

## СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Соёлын өвийн үндэсний төвийн захиралтай 2018 оны 2 дугаар сард байгуулсан үр дүнгийн гэрээ, Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж байна.

Үр дүнгийн гэрээнд тусгагдсан Таван үндсэн бүтээгдэхүүний ангид хамаарах 17 нэр төрлийн ажил хийж гүйцэтгэсний 1 нь тусгай арга хэмжээ, 16 нь үндсэн арга хэмжээнд хамаарч байна.

### **1.0. "СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ГАЗАР"-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:**

#### **1.1. Улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2018 оны улсын тооллогын ажилд хамтран оролцох. /ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ/**

*Тооллого хийхэд зориулан цаасан болон цахим суурьтай бүртгэл хөтлөлт хийх, мэдээллийг боловсруулахад зориулан мэргэжил, арга зүйн арга зүйн зөвлөгөө, удирдамжаар хангана.*

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу музейн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл хөтлөлтийг сайжруулахад өмнөх 2017 онд музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн цахим хэлбэр "Register" програм хангамжид үндэсний төвийн төсөв хөрөнгийн байдалд тохируулан хоёр төрлийн нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн юм.

2018 оны 10 дугаар сард улсын тооллоготой холбогдуулан "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн Register" програмын нэмэлт хөгжүүлэлт болон өмнөх саруудад хийгдсэн хөгжүүлэлтийн талаар музейнүүдээс ирүүлсэн саналын дагуу засах сайжруулах арга хэмжээг Сайберандро-меда ХХК-тай ярилцан, шийдвэрлэсэн. Бүртгэлийн програмд хийгдсэн нэмэлтүүдийг Монголын үндэсний музей, Байгалийн түүхийн музей, Дүрслэх урлагийн музейд update суурилуулан тооллогын туршилтыг зохион байгуулав.

Музейн үзмэрийн ерөнхий бүртгэл баримтжуулалтаас үзэхэд уг "Register" програм хангамжид 2018 оны музейн тооллогын үед нэмж сайжруулалт хийх зайлшгүй шаардлагатай байна. Энэ ажлын хүрээнд ахлах мэргэжилтэн Д.Нарантуяагаар ахлуулсан баг уг программын "Төрөл зүйл", "Он цаг"-ийн сонголтыг сайжруулах бодлогын даалгаврыг боловсруулан бэлтгэсэн.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн "Төрөл зүйл"-ийн бодлогын даалгаврыг боловсруулахдаа Соёл, урлаг судлалын хүрээлэн, төрөлжсөн музей тухайлбал, орчин цагийн дүрслэх урлагийн бүтээлүүдийн талаар Уран зургийн галлерейгээс, тайз, дэлгэцийн урлагийн холбогдолтой өвийн талаар Монголын Театрын музейгээс, бурханы шашны судар номын талаар Монголын Үндэсний номын сангаас, палеонтологийн холбогдолтой байгалийн өвийн дурсгалын талаар ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгээс, байгалийн өвийн дурсгалын талаар Байгалийн түүхийн музейгээс тус тус түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн олон төрөл зүйлийн талаарх саналыг албан бичгээр авсан.

Төрөл зүйлийн ангиллыг шинэчлэн боловсруулахдаа одоо ашиглаж байгаа төрөл зүйлийн 6-н ангиллаа баримтлан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нэр томъёо, Сангийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалаар батлагдсан "Түүх, соёлын дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт"-д дэлгэрэнгүй оруулсан төрөл зүйлийн ангилал, нэр томъёо зэргийг баримтлан ангиллыг нэмэгдүүлсэн.

Улсын тооллогын бэлтгэл хангах хүрээнд: Register цахим бүртгэлийн хөгжүүлэлтийг музейд турших, тооллогод хамрагдах үзмэрийн тоог дүнгийн судалгааг авах, бүх музейн register бүртгэлийн программын сүүлийн датаг татаж "Түүх, соёлын үзлэг, тооллого хийх журам"-эы 1.6 заасны дагуу үзлэг, тооллогод хамрагдвал зохих дурсгалын бүртгэлийн дэвтэр, улсын тооллогын арга зүйн сургалтын гарын авлага хэвлэх бэлтгэх ажлуудыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Улаанбаатар хот, орон нутагт улсын тооллогын арга зүйн бүсчилсэн сургалтыг зохион байгуулж байна. 2018 оны 12-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хотод, 12 дугаар сарын 4-ний өдөр Өвөрхангай аймгийн Хархорин суманд, 12 дугаар сарын 6-ны өдөр Завхан аймгийн

Улиастайд, 12 дугаар сарын 9-ний өдөр Эрдэнэт хотод, 12 дугаар сарын 14-нд Дундговь аймгийн Мандалговьд, 12 дугаар сарын 16-нд Дорнод аймгийн Чойбалсанд хотод тус тус бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулаад байна.



*Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын Улаанбаатар хот дахь сургалтын үйл ажиллагааны зургаас.*

## **1.2. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр бүртгэх, баримтжуулах ажил.**

*Богд хааны ордон музей 20 ширхэг, Дүрслэх урлагийн музей 11 ширхэг, Чойжин ламын сүм музей 12 ширхэг, ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн 23 ширхэг түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл хамрагдана.*

*Чойжин ламын сүм музей:* 2018 оны Үр дүнгийн гэрээнд төлөвлөсний дагуу Чойжин ламын сүм музейн хосгүй үнэт 12 ширхэг үзмэрийг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах ажлыг видео зураглаач Т.Даваа-Очир, ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа нар тус музейн бүртгэл, мэдээллийн санч Э.Ганбат, сан хөмрөгч Ж.Сувд-Эрдэнэ, Гол сүмийн үзмэр харгалзагч Ш.Бадамтуяа нарын хамт 2018 оны 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 5-ныг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Засгийн газрын шийдвэрээр 1995-2013 онд Чойжин ламын сүм музейн 38 дурсгал түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд хамрагдсан байдаг. 2016 онд тус музейн 26 хосгүй үнэт дурсгалын 600 минутын дүрс бичлэг хийгдэж баримтжуулсныг музейн бүртгэл, мэдээллийн сан (БМС)-д хүлээлгэн өгсөн.

Дүрс бичлэг хийхдээ тус музейтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ба ажлын явцад өдөр тутмын тэмдэглэл хөтөлсөн. Эдгээр 12 хосгүй үнэт дурсгалт зүйл нь Бурхадын лойлин, хот мандал зэрэг зөөж хөдөлгөх боломжгүй суурин үзмэр, иж бүрэн цамын баг, өмсгөл зэрэг нарийн төвөгтэй дэглэлт бүхий үзмэрүүд байлаа.

Хосгүй үнэт 12 үзмэрийн нийт 26.4 GB хэмжээтэй дүрс бичлэг хийж баримтжуулсан бөгөөд ондоо багтаан дүрсний монтаж хийгээд тус музейн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгнө.

*Дүрслэх урлагийн музей:* Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа түүх, соёлын хосгүй үнэт 11 дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг хоёр тал “Түүх, соёлын

дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулсан” тухай 07/04 тоот гэрээ байгуулан 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр гүйцэтгэлээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ш.Энхтуяа /Соёлын өвийн Үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан мэргэжилтэн/

Т.Даваа-Очир /Соёлын өвийн Үндэсний төвийн Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын Зураглаач/

Т.Энхжаргал /Дүрслэх урлагийн музейн Бүртгэл, мэдээллийн санч/

Г.Лхагвадулам /Дүрслэх урлагийн музейн Сан хөмрөгийн эрхлэгч/

Д.Уранчимэг /Дүрслэх урлагийн музейн Сан хөмрөгийн эрхлэгч/

Р.Чинзориг /Дүрслэх урлагийн музейн Сэргээн засварлагч/

Б.Оюунчимэг /Дүрслэх урлагийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан/

Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр баримтжуулах ажил 2015 оноос эхлэн үе шаттай хэрэгжиж ирсэн бөгөөд энэ ажлын хүрээнд Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа 71 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээс 60 дурсгалыг баримтжуулсан. Үлдсэн 11 дурсгалыг энэ онд баримтжуулж дуусгахаар Соёлын өвийн Үндэсний төвийн захирлын “Үр дүнгийн гэрээ” тусгасан дагуу энэ удаагийн баримтжуулах ажлаар 7 дурсгалын дүрс бичлэгийг хийв. Баримтжуулалтад хамрагдаагүй 4 дурсгал нь 10.5-аас 14 метр өндөртэй том хэмжээний зээгт наамлын бүтээлүүд бөгөөд дэлгэх зай багтаамж байхгүй, камерын хүчин чадал хүрэхгүйн улмаас энэ удаад дүрс бичлэг хийгээгүй болно.

#### Дүрс бичлэгээр баримтжуулсан 7 бүтээл

№	Үзмэрийн нэр, товч тодорхойлолт	Бичлэг хийсэн хугацаа	Бичлэг хийсэн минут
1	Б. Шарав “Лхас хот” Давуу, шороон будаг. Хувийн дугаар 70.55.02	10:45-11:25	36 мин 21 сек
2	Н.К.Рерих “Улаан хөлөгт баатар” Давуу, шороон будаг. Хувийн дугаар 78.02.01	11:55-14:10	23 мин 41 сек
3	Б.Шарав “VIII Богд Жавзандамбын хөрөг” Давуу, шороон будаг. Хувийн дугаар 70.55.01	14:13-15:00	13 мин 04 сек
4	“Хүрэл илд” хүрэл цутгамал. Хувийн дугаар 67.18.2	15:00-15:23	10 мин 28 сек
5	Ерэнтэй дархан “Хэт хутга” ган сийлбэр. Хувийн дугаар 68.32.52	15:25-16:00	04 мин 51 сек
6	Дэмбэрэл дархан “Хэт хутга” ган төмөр. Хувийн дугаар ДҮМ1976.11.2	16:00-16:50	11 мин 22 сек
7	Ерэнтэй дархан “Сангийн бойпор” мөнгөн сийлбэр. Хувийн дугаар 69.42.25	16:50-17:05	08 мин 47 сек
Нийт 7 үзмэр		1 цаг 48 мин 37 сек	

Дүрс бичлэгийг Соёлын өвийн үндэсний төвийн зураглаач Т.Даваа-Очир Sony HXR-MC2500 камераар 7 үзмэрийн нийт 1 цаг 48 мин 37 сек-ийн дүрс бичлэгийг хийв.

Дүрс бичлэгийн дундуур бүтээлүүдийн тайлбарыг яриагаар оруулсан ба тайлбарыг Дүрслэх урлагийн музей Бүртгэл, мэдээллийн санч Т.Энхжаргал, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Оюунчимэг нар уншиж бичүүллээ.

Цаашид хийх ажлын санал:

**Нэг.** Дүрс бичлэгт хамрагдсан “Лхас хот” бүтээл нугалж байснаас үүдэлтэй босоо болон хэвтээ хагарч, цуурсан гэмтэл ихтэй байна. Үүнийг сэргээн засварлуулах, улмаар уг бүтээлийн хуулбарыг хийлгүүлж “Эх бүтээл”-ийг сан хөмрөгтөө горимын дагуу хадгалах шаардлагатай нь харагдлаа.

**Хоёр.** Дүрс бичлэгт хамрагдаагүй Монголын хамгийн том зээгт наамал болох Жалба Сэнгий раа 76.16.680 / 10500x16000 см/, Очирваань 76.16.678 /11200x14500 см/, Цагаан дара эх 76.16.679 /10400x14000 см/, Аюуш 76.16.681 /10000x14500 см/ дурсгалт зүйлийн дүрс бичлэгийг нисдэг камер ашиглан хийх ажлыг тусгайлан зохион байгуулах нь зүйтэй юм.

*Богд хааны ордон музей:* Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8, 21.2.7 дэх заалтуудыг үндэслэн Соёлын өвийн Үндэсний төвийн захирлын Үр дүнгийн гэрээний 1.2-т тусгагдсаны дагуу Богд хааны ордон музей, Соёлын өвийн үндэсний төв 2018 оны 06 дүгээр сарын 13-ны өдөр Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах тухай №09/46 тоот гэрээ, Богд хааны ордон музейн захирлын А/ 40 тоот тушаалыг тус тус үндэслэн Богд хааны ордон музейд хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан 20 үзмэрийг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 21-ний өдрүүдэд дүрс бичлэгээр баримтжууллаа.

Дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг Соёлын өвийн үндэсний төвөөс Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын зураглаач Т.Даваа-Очир, Бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа, Богд хааны ордон музейгээс сан хөмрөгийн эрхлэгч Д.Алтаннавч, бүртгэл, мэдээллийн санч Ц.Гүнчин-Иш, сэргээн засварлагч Н.Энхманлай нар гүйцэтгэв. Дүрс бичлэгийг Соёлын өвийн үндэсний төвөөс Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын зураглаач Т.Даваа-Очир Sony HXR-MC2500 камераар хийсэн.

2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Соёлын өвийн үндэсний төвөөс дүрс бичлэгийн тоног төхөөрөмжөө Богд хааны ордон музейн хурлын танхимд байрлуулж дүрс бичлэгийг хийсэн.

Дүрс бичлэгийн ажил 06 дугаар сарын 14-ны өдөр 10:20 цагт эхлэж музейн сан хөмрөгийн эрхлэгч Д.Алтаннавч, бүртгэл, мэдээллийн санч Ц.Гүнчин-Иш, сэргээн засварлагч Н.Энхманлай нар Богд хааны ордон музейн Өвлийн ордны үзүүллэгт байсан дараах үзмэрийг дүрс бичлэгт хамруулсан.

1. БОМ1924.2.1942 хувийн дугаартай Лам Лувсанцэрэнгийн хөрөг
2. БОМ1942.2.1943 хувийн дугаартай Лам Лувсандондовын хөрөг
3. 24-6-73 хувийн дугаартай Дондогдулам хатны сувдан хээтэй тоорцог
4. 24-6-74 хувийн дугаартай Дондогдулам хатны малгай
5. 24-6-40 хувийн дугаартай Дондогдулам хатны дээл
6. 24-6-30 хувийн дугаартай Дондогдулам хатны торгон дээл
7. 24-6-22 хувийн дугаартай Дондогдулам хатны хантааз

Баримтжуулалтын үеэр Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа БОМ1924.2.1942 хувийн дугаартай Лам Лувсанцэрэнгийн хөрөг болон БОМ1942.2.1943 хувийн дугаартай Лам Лувсандондовын хөрөгт гэмтлийн нарийвчилсан тодорхойлолт бичлээ. Дээл хувцасыг баримтжуулахдаа гадар, дотор, бүхий л хэсэг, нарийн арга ажиллагаа хээ, чимэглэлтэй хэсэг, дэлгэмэл бүтээлүүдийн ар талын хэсгийг нэг бүрчлэн дүрс бичлэгт буулгав. Энэ өдөр 7 үзмэрийн дүрс бичлэгийг хийж, ажил 17:30 цагт дуусаж Богд хааны ордон музейхэн үзмэрүүдээ үзүүллэгтээ буцаан дэглэв. Үлдсэн дүрс бичлэгийн ажлаа 6 дугаар сарын 19-ний өдөр үргэлжлүүлэхээр тогтов. Учир нь Соёлын өвийн үндэсний төвийн зураглаач Т.Даваа-Очир дүрс бичлэгийн боловсруулалт, монтажны ажил болон Богд хааны ордон музейд Австрийн Вена хотын хэрэглээний урлагийн их сургуулиас Катрина Кохлер ирж Монголын сэргээн засварлагч нар сургалт 6 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд явагдах болсонтой зэргээс хамаарч дүрс бичлэгийн ажил хойшилсон.

2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр музейн хурлын танхимд дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах ажил 10:40 цагт эхлэв.

Өвлийн ордны үзүүллэгээс:

8. 24-6-11 хувийн дугаартай VIII Богдын хүрэм
9. 24-6-62 хувийн дугаартай VIII Богдын алтан очирт хар үнэгэн титэм
10. 24-6-42 хувийн дугаартай Дондогдулам хатны шар магнаг дээл
11. 24-6-60 хувийн дугаартай VIII Богдын сувдан хээтэй хүрэм
12. 24-6-40 хувийн дугаартай VIII Богдын сувдан шигтгээтэй шашир хоргой титэм

Сан хөмрөгийн өрөөнөөс:

13. 24-6-31 хувийн дугаартай Дондогдулам хатны торгон дээл
14. 24-6-13 хувийн дугаартай Дондогдулам хатны хантааз
15. 24-6-37 хувийн дугаартай VIII Богдын шашир хоргой шавь дээл үзмэрийг дүрс бичлэгт хамрууллаа.

Титэм, малгайн бичлэгийг хийхдээ тусгай эргэдэг тавцан дээр байрлуулж, эргүүлэн гадна, дотор талыг нь нэг бүрчлэн авсан. Дүрс бичлэгийн ажил 17:30 цагт дуусч, Богд хааны ордон музейн ажилтнууд үзмэрүүдээ үзүүллэгт буцаан дэглэв. Үлдсэн үзмэрийн дүрс бичлэгийг

6 дугаар сарын 21-ний өдөр үргэлжлүүлэхээр тогтов.

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр ажил 11:00 цагт эхлэж, Богд хааны ордон музейн үзэсгэлэнгийн танхимд дүрс бичлэгээ хийсэн.

Зуны ордны үзмэр үзүүллэгээс,

16. 24-8-102 хувийн дугаартай Өндөр гэгээн Занабазарын тамга

Богд хааны өвлийн ордны үзмэр үзүүллэгээс,

17. 24-6-52 хувийн дугаартай Өндөр гэгээн Занабазарын жанч

18. 24-6-07 хувийн дугаартай VIII Богдын булганы годон хүрэм

19. 24-6-34 хувийн дугаартай VIII Богдын булган дотортой дээл гэсэн

үзмэрүүдийг зөөж тээвэрлэх журмын дагуу зориулалтын сав баглаа боодолд хийн авч ирж дүрс бичлэгээр баримтжууллаа.

20. 24-7-161 хувийн дугаартай Өндөр гэгээн Занабазарын сандал.

Уг үзмэр зөөж тээвэрлэхэд гэмтээх магадлал өндөр тул өвлийн ордон дотор уг байсан газар нь эргүүлж тойруулан дүрс бичлэгээр баримтжуулсан болно.

Дүрс бичлэгийн ажил 16:30 цагт дуусаж, зураг авсан үзмэрүүдийг үзмэр үзүүллэгт буцаан дэглэснээр энэ удаагийн ажил дуусав.

Дүрс бичлэгээр баримтжуулсан хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт

Д/д	Нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг, хэмжээ	Материал	Тогтоолын дугаар
1	Занабазарын тамга	24-8-102	1ш. Өр: 5.2 см, Өн: 10 см, Жин: 275 гр,	Зандан мод, гууль, зэс мөнгө	МУ-ын ЗГ-ын 2011 оны 214-р тогтоол. №594
2	Лам Лувсанцэрэнгийн хөрөг	БОМ1924.2. 1942	1ш. Өн: 80,8 см, Өр: 59,5 см	Шороон будаг	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №143
3	лам Лувсандондовын хөрөг	БОМ1924.2. 1943	1ш. Өн: 80 см Өр: 59,5см	Шороон будаг	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №142
4	Дондогдулам хатны сувдан	24-6-73	1ш. Өн: 17.9см, Жин: 265гр	Сувд, хоргой	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №97
5	Дондогдулам хатны малгай	24-6-74	1ш. Өр: 41.4см, Өн: 11.3см, Жин: 320гр,	Хоргой сувд	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №149
6	Дондогдулам хатны дээл	24-6-40	1ш. Өр: 125см, Өн: 147см	Торго, хоргой, хар хилэн	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №148
7	Дондогдулам хатны торгон дээл	24-6-30	1ш. Өр: 120см, Өн: 150см	Торго	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №98
8	Дондогдулам хатны хантааз	24-6-22	1ш. Өр: 39.5см, Өн: 73см, Жин: 595гр,	Хоргой, пүүсүү, алт, сувд	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №100
9	Өндөр гэгээн Занабазарын Сандал	24-7-161	1ш. Өр: 93см, Өн: 156см	Сум мод	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №102
10	VIII Богдын хүрэм	24-6-11	1ш. Өр: 81.5см, Өн: 71см	Шашир хоргой	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №152
11	Өндөр гэгээн Занабазарын жанч	24-6-52	1ш. Өр: 700см, Өн: 170см	Хар үнэгний арьс, шүр сувд	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №101
12	VIII Богдын алтан очирт хар үнэгэн титэм	24-6-62	1ш. Өн: 20см	Шашир хоргой, хар үнэг	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №94

13	VIII Богдын булганы годон хүрэм	24-6-07	1ш. Өр: 73см, Өн: 8см	Булга	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №93
14	VIII Богдын булган дотортой дээл	24-6-34	1ш. Өр: 117см, Өн: 142см	Булга, шашир хоргой	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №92
15	Дондогулам хатны шар магнаг дээл	24-6-42	1ш. Өр: 113см, Өн: 134см	Торго, хоргой	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №91
16	VIII Богдын сувдан хээтэй хүрэм	24-6-01	1ш. Өр: 88см, Өн: 75см	Шашир хоргой, сувд	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №89
17	VIII Богдын сувдан шигтгээтэй шашир хоргой титэм	24-6-60	1ш. Өн: 18см	Хар хилэн, шашир хоргой, мөнгө	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №90
18	VIII Богдын дээл	24-6-31	1ш. Урт: 143см, Өр: 72см	Хоргой	МУ-ын ЗГ-ын 2002 оны 118-р тогтоол. №153
19	VIII Богдын морин хүрэм	24-6-13	1ш. Урт: 112см, Өр: 84см	Хоргой	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №95
20	VIII Богдын шашир хоргой шавь дээл	24-6-37	1ш. Урт: 135см, Өр: 100см	Шашир хоргой	МУ-ын ЗГ-ын 1998 оны 126-р тогтоол. №87

Дүгнэлт, цаашид хийх ажил:

1. Богд хааны ордон музейд түүх, соёлын хосгүй үнэт 79 дурсгалт зүйл хадгалагддаг бөгөөд үүнээс 39 үзмэрийг 2015, 2016 онд дүрс бичлэгээр баримтжуулсан.

2. Энэ удаагийн дүрс бичлэгээр баримтжуулах ажлаар тус музейн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан 20 үзмэрийн дүрс бичлэгийг Sony HXR-MC2500 камераар хийж нийт 48.7 GB-ийн бичлэг хийв.

3. Дүрс бичлэгт хамрагдсан 20 үзмэрийн тайлбарыг уншиж хоолой бичүүлэх ажлыг зураглаач Т.Даваа-Очирын ажлын боломжоор Богд хааны ордон музейгээс ирж хийлгүүлэн, бичлэгт оруулан монтажлуулахаар хоёр тал харилцан тохиролцлоо.



### 1.3. Улс, аймгийн музей, соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд үзлэг хийж, арга зүйн зөвлөлгөө өгөх.

*Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Эрдэнэ Зуу, Хархорум, Хөшөө Цайдам музей хамрагдана.*

#### **Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд аймагт ажилласан тухай**

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2-т тусгагдсаны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/10 тоот тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн музей дээр 2 дугаар сарын 22-ноос 3 дугаар сарын 4-ны өдрийг хүртэл 10 хоногийн томилолттой ажиллаж музейн соёлын өвийн бүртгэл, мэдээлэл сангийн бүрдэл, үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалтын орчны судалгаа хийх, мэргэжил арга зүйн

зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэсэн. Томилолтын хугацаанд нийт 3592 км замыг 29-59 УБЕ улсын дугаартай Land-100 машинаар туулсан байна.

Ажлын хэсгийг Ш.Энхтуяа /Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан мэргэжилтэн/ ахалж, Ж.Насанжаргал /Соёлын өвийн үндэсний Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн/, П.Чинбат /Соёлын өвийн үндэсний төвийн Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын Ажилтан/, С.Даваадарь /Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын Сэргээн засварлагч, судлаач/, Т.Даваа-Очир /Соёлын өвийн үндэсний Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын Зураглаач/ нар ажиллав.

Музейн соёлын өвийн бүртгэл, мэдээлэл сангийн бүрдэл, үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалтын орчны судалгааг “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”, “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5634:2006 Монгол Улсын стандарт, “Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэм”, “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”, “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар” –ийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалтай танилцаж зорилгоор дараах дөрвөн төрлийн маягтыг боловсруулж музейнүүдээс судалгаа авлаа.

Судалгаа №1. “Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан суурьтай баримтын бүрдэл”

Судалгаа №2. “Музейн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан суурьтай баримтын бүрдэл”

Судалгаа №3. “Бүртгэл, мэдээллийн сангийн цахим мэдээллийн хадгалалтын байдлын судалгаа”

Судалгаа №4. “Музейн гадаад болон доторх орчны судалгаа”

Эдгээр 4 төрлийн судалгаан дээр нэмж тодруулах шаардлагатай зарим мэдээллийг авсан. Үүнд, 2017 оны СӨУНБСангийн баяжилтын тайлангийн зарим мэдээлэл, хулгайд алдагдсан үзмэрийн судалгаа болон “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын 6.3-т заасан 10 хавтасны бүрдэл болон музейн захирал, БМСанчийн товч судалгааг нэмж авсан.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцооны дагуу орон нутгийн музей дээр байгууллага аймгийн бүртгэл мэдээллийн сан төвлөрч, /Соёлын өвийг хамгаалах тухай хууль 20.2/ Соёлын өвийн бүртгэлийг хөдлөх дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгал, утга соёлын өв гэж ангилж, цаасан баримт бичгийн болон цахим хэлбэрээр мэдээллийн санг бүрдүүлэх /Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам 3.4/ -ээр заасан байдаг.


Музейн бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалуудын ихэнх нь Бүртгэл, мэдээллийн санч Б.Сүхбаатарын хүндрүүлэгтэй том сейфэнд хадгалагдаж байв. Баримт, материалуудыг музейн болон аймгийн бүртгэл, мэдээллийн сан хэмээн ангилж ялгаагүй, сум бүрээр нь хавтас нээсэн боловч дотор нь үл хөдлөх, хөдлөх, соёлын биет өвийн материалуудыг хамтдана хийжээ. Сейфэнд бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэл, баримтнаас гадна байгууллагын гэрэл зургийн аппарат хэрэгсэл бусад ажлын болон хувийн эд зүйлс нь байсан. Сан бүртгэл, мэдээллийн санд байх ёстой хуучны үзмэрийн карт музей сан хөмрөгийн өрөөнд, байсан нь Бүртгэл, мэдээллийн сангийн материал нэгдмэл цогц хадгалагдах зарчим хэрэгжээгүй байна.



*Музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл.* Үзмэрийн хуучин карт, бүртгэл. Музейн үзмэрийн 1995 оноос өмнөх карт, паспортууд болон 1996 оноос хойшхи “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” маягтаар хийсэн үзмэрийн бүртгэл, Соёлын өвийн төвөөс 2000-2006 оны үед үзмэрийг гэрэл зургаар бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд хийгдсэн үзмэрийн бүртгэлүүд байсан.

1995 оноос өмнөх үзмэрийн карт, паспортууд, гэрэл зургууд нь тус музей сан хөмрөгт саланга хадгалагдаж байсныг Бүртгэл, мэдээллийн санч Б.Сүхбаатар 2014 оны 10 сараас ажил орсны дараагаар сан хөмрөгчийн хамт цэгцлэх ажлыг хийж 1500 орчим үзмэрийн карт, паспортыг гэрэл зурагтай нэгтгэн хадгаламж үүсгэсэн байна.

Эдгээр баримтуудийг архивын горимын дагуу бор цаасан хавтаслан үлдэж “Дотоод товъёог”, “Баталгааны хуудас” хийж 15 ширхэг “Хадгаламжийн нэгж” үүсгэсэн нь сайшаалтай ч эдгээрийг бүртгэл, мэдээллийн сандаа биш сан хөмрөгийн өрөөндөө шургуулгатай шүүгээнд цэгц муутайхан хадгалжээ.



*Ховд аймгийн музейн үзмэрийн хуучин бүртгэлийн хадгалалт*

*Музейн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл, баримт.* Үзмэрийн ерөнхий бүртгэлийн дэвтэр тус музейд /2007 оноос хойш “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” нэртэй болсон ба өмнө нь янз бүрээр нэрлэгдэж ирсэн байна/ 1995 оны 1 ширхэг, 2002 оны 1 ширхэг, 2008 оны 4 ширхэг, 2012 оны 4 ширхэг нийт 10 ширхэг, мөн 2008 болон 2012 оны улсын тооллогын тайлан, тэмдэглэл байна.

2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод аймгийн музей болон сумдын ОНСТанхимууд хамрагдаж үзмэрийн бүртгэлийг register программд оруулах ажлыг тухайн үед бүртгэл, мэдээллийн санч байсан Ч.Бат-Эрдэнэ гүйцэтгэсэн байна. Ингэхдээ зөрүүгүй байх ёстой цаасан хэлбэрийн “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”, цахим хэлбэрийн Register программд, Үзмэрийн хувийн дугаар, материал зэргийг зөрүүлсэн, дэсийн дугаарыг давхардуулсан зэргээр багагүй алдаанууд гаргасан байдаг байна. Эдгээр алдаа, зөрүүг залруулах ажлыг одоогийн бүртгэл, мэдээллийн санч Б.Сүхбаатар одоо болох улсын тооллогоор хийхээр төлөвлөж байгаа аж.

*Музейн сан хөмрөгийн байгууллагын тооллогын улсын бүртгэл, баримт.* Байгууллагын тооллогыг тус музей хөрөнгийн тооллоготойгоо хамт хуульд заасны дагуу жилд 2 удаа хийдэг байна. Ингэхдээ “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-дээ “Тоолов” тэмдэг дардаггүй, тооллогын баримт материалаа байгууллагынхаа бичигт хэрэгт шилжүүлдэг байна.

*Бусад материалын хувьд.* Шинээр авсан үзмэрийн баримтууд, үзмэрийн хөдөлгөөний акт зэргийг “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу бүрдүүлдэг ч эх хувийг нь захирлын тушаалтай хамт байгууллагын бичигт хэрэгт шилжүүлдэг гэсэн ба байгууллагын бичиг хэрэг биднийг очиж үед байхгүй байлаа. Эдгээрийн зарим хуулбар хувь нь сан хөмрөгчид цэгц муутай хадгалагдаж байсныг бидэнд үзүүллээ.

*Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл.* Музей дээр төвлөрч байгаа аймгийн БМСан нь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн баримтуудыг өмчийн хэлбэр харгалзахгүй бүрдүүлэх ёстой.

*Хөдлөх дурсгал.* Ховд аймгийн музей 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор 13 сумдынхаа ОНС танхимын үзмэрийг тоолж “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийг үйлдсэн. Эдгээрийн эх хувийг тухайн ОНС танхимд нь үлдэсэн. Тооллогын



тайлан, бүртгэлийн хуулбарыг А4 хэмжээтэй хувилж сандаа авсан байна.

*Шашны байгууллагын* хувьд аймгийн Ганданпунцагчойлон хийдийг 2012 оны улсын тооллогод хамруулж 50 дэсийн 323 ширхэг шүтээн, эд өлгийн зүйлийг нь тоолж бүртгэл үйлдэн RCH программд оруулсан гэсэн боловч дата нь манайд ирээгүй байна.

*Иргэний өмчлөлд* байгаа түүх, соёлын дурсгалыг бүртгэх ажил хийгдээгүй.

*Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл.* 2015 оны үзлэг, тооллогоор 1205 дурсгалт газрыг бүртгэн баримтжуулж, бүртгэлийг RICH3.0 программд оруулах ажлыг бүрэн хийсэн байна. Ингэхдээ программд оруулсан бүртгэлээ хэвлэж гаргаагүйн улмаас цаасан бүртгэл байхгүй байсан. Тооллогын тайлан болон тооллогын үеэр авсан гэрэл зургууд, зарим дурсгалд хийгдсэн дүрс бичлэг /Хойт цэнхэрийн агуу, Нүхэн өтгө хадны зураг, Дарви сумын Чулуутын олторго/ зэргээ CD болон компьютер дээр хадгалсан байна. Тооллогын үеэр хийгдсэн гар бичмэл тэмдэглэлүүд мөн байсан.

*Аймгийн нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа малтлага судалгааны* бүх ажлын тайланг аймгийн бүртгэл, мэдээллийн сан авах, тухайн иргэн, байгууллага өгөхөөр хууль, журамд тусгасан байдаг. Үүний дагуу Ховд Их сургууль малтлага судалгааны ажлын тайлан, Тахилтын хотгорын Хүннү булшны олдворын зураг, “Урд улаан үнээтийн тайлан”-г Үндэсний музейгээс Ж.Баярсайхангаас хүлээн авсан байна. Дашрамд тэмдэглэхэд Ховд Их сургууль малтлага судалгааны ажлын тайлангаа сүүлийн жилүүдэд аймгийн бүртгэл, мэдээллийн санд тогтмол ирүүлдэг болоод байгаа аж.

Тус аймгийн бүртгэл, мэдээллийн санд Сөртийн Хүн чулуу, Баянбулагийн Хүн чулуу болон Зостын хадны зураг зэрэг 13 үл хөдлөх дурсгалын хуулбар, дардасыг авч хадгалж байна. Гэвч эдгээр хуулбар, дардсаа тэнийлгэж ороож биш эвхэж нугалан хадгалсан нь нугалаасаараа урагдах магадлалтай байна. Цаашдаа үл хөдлөх дурсгалын хэв, хуулбар, дардас авах түүнийгээ хадгалах талаар заавар зөвлөмж шаардлагатай юм.

*Соёлын биет бус өвийн бүртгэлийн бүрдэл.* 2014 онд батлагдсан Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу Ховд аймгийн Боловсрол соёл, урлагийн газарт хийгдэж байсан Соёлын биет бус өвийн бүртгэл, судалгааны ажил 2015 оноос Ховд аймгийн музейд шилжиж ирсэн байна. Одоогийн байдлаар цаасан суурьтай өвлөн уламжлагчдын 2010, 2011 оны материал Үл хөдлөх дурсгал, Хөдлөх дурсгалын хамт нэг хавтсанд хадгалсан.

Соёлын биет бус өвийн бүртгэлийг өвийн нэр, жагсаалтаар сумдаас ирүүлсэн өвлөгчдийн материалыг үндэслэн гаргадаг ба нарийвчлан судлах, нийтлэг өвийн төрөл зүйлийг өөрийн орон нутгийн онцлогоор тодорхойлж гаргасан бүртгэл хийгдээгүй байна.

Цахим бүртгэл нь бүртгэл, мэдээллийн сангийн компьютер дээр хадгалагддаг. Сумдаас ирүүлсэн цахим болон цаасан бүртгэлийг нэгтгэн Соёлын өвийн үндэсний төвд ирүүлдэг байна. Цахим бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэлийн хувьд 2017 Ховд аймагт болсон Бий биелгээний наадмын бичлэг, Туульч Дамдиндоржийн “Наран хаан хөвгүүн”, “Аргил цагаан өвгөн” тууль зэрэг улсын чанартай уралдаан, наадмын бичлэгийг хийж санд хадгалсан байна.

Ховд аймгийн 17 сумын 2 сум нь аппараттай байдаг боловч бүртгэл гэрэл зураг, дүрс бичлэг хийгдэж ирдэггүй, бүртгэл хийх арга зүй дутмаг, судалгаа, бүртгэлийн ажил хийх төсөв байдаггүй учраас зэрэг олон хүчин зүйлээс сумдын соёлын биет бусын бүртгэл доривтой хийгддэггүй, сургалт хийх талаар дээд шатны байгууллагад санал гаргасан боловч дэмжигддэггүй талаар ярьсан. Бүртгэл, мэдээллийн сангийн ажил үүргийн хувиарийн хувьд Үл хөдлөх дурсгал, Хөдлөх дурсгал, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчдын бүртгэл, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх, урилгын эх бэлтгэх, техник хэрэгсэлтэй холбоотой ажлуудыг давхар хариуцан гүйцэтгэдэг тул ачаалал ихтэй ажилладаг талаараа мэдэгдэж байсан.

*Цахим бүртгэлийн бүрдэл, хадгалалт хамгаалалтын байдал.* Бүртгэл, мэдээллийн сангийн компьютерт байгаа файлууд харьцангуй цэгцтэй, түүнийг программууд болон гэрэл зургийн аппараттай ажиллах чадвар хангалттай, сайн байв.

Музей нь гэрэл зургийн Canon 80D, Canon 200D аппараттай, ажиллагаа хэвийн. Мөн Зөөврийн 3 ширхэг компьютер байдаг байна.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2012 оны улсын тооллогын Register программд аймгийн музейн 892 дэсийн 2977 ширхэг 5007 иж үзмэр, 13 сумдын ОНСТанхмын нийт 738 дэсийн 1356 ширхэг 1356 иж бүрдэл үзмэрийг, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэг, тооллогын RICH3.0 цахим бүртгэлд 1205 дурсгалт газрын 7165 дурсгалын бүртгэлийг тус тус бүрэн оруулсан байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын RCH2.0 цахим бүртгэлд тус музей 192 дэсийн 192 ширхэг үзмэрийн бүртгэл буюу нийт үзмэрийн 21%-ийг оруулсан боловч энэ ажил 2012 оноос зогсонго байдалтай байгаа аж. Учир нь register программд байгаа алдаа, зөрүүг залруулсны

дараа программд оруулах ажлаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаагаа бүртгэл, мэдээллийн санч бидэнд хэлсэн.

Эдгээр программууд бүгд бүртгэл, мэдээллийн санчийн компьютерт байдаг боловч биднийг очих үед компьютер нь форматлагдснаас программууд устсан байсныг П.Чинбат дахин суулгаж өгсөн.

Цахим файлуудаа 3% буюу компьютер, зөөврийн хард, CD-д бичиж хадгалсан. CD-гээ /архивын зориулалтын бус/ зөөврийн хатуулагтай саванд хийж, хаяг тайлбарыг макро үзгээр бичсэн.

Компьютерын програм хангамжийн аюулгүй байдлыг хангах тог тохируулагч, вирусны программ байхгүй байв.

*Алдагдсан, солигдсон үзмэрийн талаар тодрууллаа.* Манайхаас 1990 оноос хойшх “Алдагдсан, дутагдсан, солигдсон үзмэрийн судалгаа”-г шинэчлэх зорилгоор 2017 оны 9 дүгээр сард музейнүүдээс судалгаа авсан ба уг судалгаагаар тус музейгээс 43 үзмэр алдагдсан жагсаалт ирүүлсэн. Уг жагсаалтыг газар дээр нь нягтлахад: Алдагдсан 43 үзмэрээс 40 үзмэр нь музейн ерөнхий бүртгэлд байхгүй байна. Энэ жагсаалтыг 2008 оны тооллогоор гаргасан бөгөөд тухайн үеийн тооллогыг 1996 оны Ерөнхий бүртгэлийн дэвтрийг болон хуучин үзмэрийн картыг барьж тоолсон учир гарсан байна. Картад байгаа үзмэр нь 1996 оны бүртгэлд байхгүй, 1996 оноос өмнөх музейн бүртгэлд байх магадлалтай ч бүртгэлийн дэвтрүүд байхгүй, архивт шилжсэн байх магадлалтай аж. Эдгээрийн дотор хүмүүсийн сайн мэддэг Ойрдын Жүдэв хамбын арслан бариултай мөнгөн цутгамал Тамга, Хөөрөгнүүд, алт шармалтай “Дун” зэрэг ховор үзмэр байжээ.

Жагсаалтад орсон алдагдсан, солигдсон 3 үзмэр нь: 1/ “Музан хөшөө” тосон будгийн зураг 2008 оны бүртгэлд байсан ч 2012 оны тооллогоор тоологдоогүй, 2/ Халх эхнэрийн толгойн гоёл 2012 онд тоологдсон ч нэг ширхэг “шүр” унасан, 3/ “Хүрэл тамга” 2012 оны тооллогоор модон тамга болж солигдсон байна.

Музейн гадаад, дотоод орчны байдлын судалгаа. Тус музейн барилга 1961 онд номын сангийн зориулалтаар баригдсан. Цутгамал бетон суурьтай, чулуун ханатай, модон хучилттай, шувуу нуруу, төмөр дээвэртэй 2 давхар. 2008, 2013, 2016 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас “их засварын ажлыг нэн дариу хийлгүүлэх”, “цахилгааны кабель утас ... солих, аюулгүй ажиллагааг хангах”, “цахилгааны хэрэглэл, монтажны иж бүрэн шинэчлэл хийх” шаардлагатай дүгнэлтүүд гарсан байна. Музейн барилгыг шинээр бариулахаар барилгын зураг төсөл гарсан ба 2011 онд газрын асуудал шийдвэрлэгдсэн.

Бид барилгын гадаад, дотоод ерөнхий байдалтай танилцахад, Музейн барилгын гадна хаалга, цонхны бэхэлгээ муу, бэтүүлсэн байдал нь хангалтгүй ялангуяа музейн ар талын хэсэг орхигдсон байдалтай. Барилгын суурийн хэсэг чийгд идэгдсэн, хананд цууралт үүссэн нь харагдаж байсан ба хавар, намартаа дээврээс нь ус гоождог тухай ярьж байсан. Музейн ар талд барилгын ханатай тулгаж нүхэн жорлон хийсэн нь хуучин барилгад суулт өгөх эрсдэлийг нэмэгдүүлсэн байлаа.



музейн байрлалын нүүрэн тал




музейн байрлалын ар талын хэсэг



музейн байрлалтай тулгаж нүхэн жорлон ухсан байдал

Музейн барилгын ар талд уран чамин хээ дүрс бүхий 2 ширхэг боржин чулуун дурсгал цас бороо, шороо, шаварт дарагдсан байдалтай, барилгын сууринд тулгаж хэвтүүлсэн байна. Энэ нь барилгадаа болон дурсгалдаа муугаар нөлөөлөх нь дамжиггүй. Уг чулуун дурсгал нь алдартай Өөлдийн Шар сүмийн гэрэл хөшөө аж. Хөшөөн дээрх бичээсийг “Эрдэний эрхи” сударт тэмдэглэн үлдээсэн байна.

1970 оны дундуур уг дурсгалыг трактороор зөөж музейд авчирсан гэдэг ба ингэхдээ чулууны бичээстэй хэсгээр нь чирснээр бичиг, дүрслэл нь бүдгэрч харагдахгүй болжээ. Уг дурсгалууд одоо хүртэл музейн бүртгэлд байхгүйн дээр хадгалалд хамгаалалтын найдваргүй орчинд оршиж иржээ.



Музейн гадна байгаа чулуун дурсгал

**Музейн камер, дохиололын систем.** Музейд нийт 23 камер байдгаас 6 камер нь ажилладаг, 17 камер нь ажилладаггүй. Камерын дэлгэцийг үүдэнд болон захирлын өрөөнд суурилуулсан маш бүдэг, муу харагддаг. Дохиоллын систем 20 байдаг ч ихэнх нь ажилладаггүй. Харуул хамгаалалтад ээлжийн манаач ажилладаг байна.

**Тогцахилгаан, сантехник.** Цахилгааны монтажнаас шалтгаалсан барилга байгууламжийн галын аюулгүй байдал өндөр эрсдэлтэй, үүнээс шалтгаалж үзүүлэгийн танхимд 3 ч удаа гал гарч байсан тухай ажилтнууд нь ярьсан. Тогны хэлбэлзлээс шалтгаалж гэрэл шатах явдал их байдал нь овоолсон өдрийн гэрлээс харагдаж байсан. Сантехникийн системийн норм, номатив хангагдаагүйгээс паарны олон газраас ус шүүрч, абро, дандил зэрэг цавуугаар тагласан бөглөсөн байдал их харагдаж байлаа.



Музейн паар цоорч нааж, тогтоосон байдал



Ховд аймгийн музейн цахилгааны шит



Ховд аймгийн музейн гаднаас орж байгаа цахилгааны холболт




Ховд аймгийн музейн цахилгааны хэлбэлзлээс болж шатсан гэрлүүд

**Музейн сан хөмрөг.** “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5634:2006 стандарт “Үзмэрийн хадгалалт, сан хөмрөгийн өрөө нь барилгын хулгай дээрэм, үер, гамшигт өртөхөөргүй хэсэгт байрлуулах”-аар заасан байдаг ч тус музейн сан хөмрөгийн өргөө 2 давхартаа болон мансартны хэсэгтээ дамнан байрласан, дээврээс нь ус гоождог, цонхнуудыг төмөр болон фанер хаалтууд нь найдваргүй, додомдсон зэрэг нь “хулгай дээрэм”, “бороо, ус”, “газар хөдлөлтөд”

өртөх магадлал ихтэй байна. Түүнчлэн сан хөмрөгийн өрөөний модон шалны даац олон улсын стандартад зааснаар хамгийн багадаа 1500 кг/м<sup>2</sup> байх даацад хүрэхгүй нь тодорхой байна.

*Музейн үзүүлэгийн танхимийн үзмэр дэглэлт хэт ил задгай.* Тухайлбал, ховор нандин угсаатны зүй, шашны үзмэр, түүнчлэн тодорхой горим шаарддаг галт зэвсэг музейн хананд давуун утсаар мөчидхөн тогтоож байрлуулсан зэрэг нь хулгайн сэдэл төрүүлэх, алдагдах, унах зэргээс үүдэх хохирол их юм. Гэтэл агаарын солилцоо их шаардлагатай амьтны чихмэлүүдийг битүү шилэн хоргон байрлуулсан зэрэг оновчгүй байдал их байна.



*Ил залгай, мөчидхөн өлгөсөн буу зэвсгийн үзмэр*



*угсаатны зүйн үзмэр*



*Битүү хоргонд хийсэн шувууны чихмэл*

Музей нь жилд 2 удаа буюу хавар, намартаа хортон, шавьжны устгал, ариутгал хийлгэдэг ч дээврийн хэсэгт тагтаа үүрлэсэн, тагтааны сангаснаас унасан шавьж үзэсгэлэнгийн тааснаас унаж ирдэг мөн шалны дор хулгана байдаг тухайгаа ч ярьж байсан.



*Тагтааны сангаснаас унасан шавьж*

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө бидний явсан 4 музейгээс Ховд аймгийн музейд ганцхан байхгүй байв.

Говь-Алтай аймгийн музей. Говь-Алтай аймгийн музей дээр бид 2 дугаар сарын 28-ны өдөр ажилласан. Бидэнтэй музейн захирал Ц.Оюунзул /уг албан тушаалд 2008 оноос ажилласан/, Бүртгэл, мэдээллийн санч О.Нэргүй /уг албан тушаалд 2011 оноос ажилласан/, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Гэрэлтуяа, Сан хөмрөгч Б.Сарангэрэл нар хамтран ажиллаа.


*Бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалууд* Бүртгэл, мэдээллийн санч О.Нэргүйн хариуцдаг 2 сейф, 1 бичгийн шүүгээнд Музейн бүртгэл, мэдээллийн сан, Аймгийн бүртгэл, мэдээллийн сан хэмээн ангилж ялгаагүй хадгалсан байх ба эдгээр сейф, шүүгээ БМС,

ЭША, Сан хөмрөгч хамт суудаг жижиг өрөөнд байрласан байв. Сум бүрээрээ хавтас нээсэн боловч дотор нь үл хөдлөх, хөдлөх, соёлын биет өвийн материалуудыг хамтдана хийсэн. Хуучин сейфэнд, Музейн зарим хуучин бүртгэлүүдтэй хамт байгууллагын гэрэл зургийн аппарат, CD, тэмдэглэлийн дэвтэр бусад эд зүйлс, Хүндрүүлэгчдээ сейфэнд, Аймаг, сумын тооллогын бүртгэлүүд, Бичгийн шүгээнд, Сумдын хавтаст материал, үзмэрийн хуучин бүртгэл зэргийг хадгалсан. Бүртгэл, мэдээллийн сангийн баримтууд ажилтнуудын хэт жижиг өрөөнд хадгалалт хамгаалалтын горимд хийцээгүйн дээр төрөлжүүлэн сан бүрдүүлэх боломж нөхцөл муутай байна.



Говь-Алтай аймгийн музей БМСангийн материалууд

Музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл. Үзмэрийн хуучин карт, бүртгэл. Үзмэрийн 1980 онд хийгдсэн хуучны карт, паспортууд байх агаад тухайн үед хийсэн бололтой утсаар үзэж, тугалган лац хийсэн 15 хэсэг үзмэрийн картууд байсан ба он нь тодорхойгүй үлдэж нэгтгээгүй задгай карт, паспортууд мөн байсан. 1996 оноос хойшх “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” маягтаар хийсэн үзмэрийн бүртгэл, Соёлын өвийн төвөөс 2003-2004 онуудад “Музейн үзмэрийг гэрэл зургаар бүртгэн баримтжуулах ажил”-аар хийдэж байсан үзмэрийн бүртгэлүүдийг хавтаслан хадгалагдсан. Эдгээрийг бүртгэн цэгцлэх “Хадгаламжийн нэгж” үүсгэх ажил хийгдээгүй байв.



1980 оны үеийн үзмэрийн үдэж дэвтэрлэсэн болон задгай карт паспортууд

2003 оноос хойшх музейн үзмэрийн бүртгэлийг “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” маягтаар хийж төрөлжүүлсэн Урлаг, уран сайхны 57 үзмэр, Шашны холбогдолтой 66 ширхэг үзмэр, Угсаатны зүйн 133 ширхэг үзмэрийн бүүртгэл, 2004 онд түүх, угсаатны зүйн 124 үзмэр, 2005 онд 204 үзмэрийн бүртгэл, 2012 оноос хойш RCH программд 780 бүртгэл оруулж цаасан хэвлэн гаргаж, төрөлжүүлсэн бүртгэлүүдийг тус музейн Эрдэм, шинжилгээний ажилтан хийж иржээ. Ийнхүү RCH программд бүртгэл оруулах ажлыг музейн Эрдэм шинжилгээний ажилтан хариуцан гүйцэтгэдэг нь бүртгэл, мэдээллийн сангийн ачааллыг хөнгөлөх ажил үүргийн зөв хуваарлалт болох нь харагдаж байв.

Эдгээр төрөлжүүлсэн цаасан бүртгэл дотор тус музейн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл болох “Хүрэл морь”-ны бүртгэл байхгүй байсан. РСН дээр бүртгэсэн гэх боловч цаасан хэлбэрээр хэвлэж гаргаагүй нь бүртгэл, мэдээллийн сангийн материалыг нэгдмэл цогц байдлаар хадгалах заалт хэрэгжээгүй байна. /Соёлын өвийг хамгаалах тухай хууль 21.3/ Тодруулбал, 2013 онд Засгийн газрын тогтоолоор орон нутгийн музейгээс анх удаа 9 үзмэр түүх, соёлын “Хосгүй үнэт” дурсгалт зүйлээр батлагдсны нэг нь тус музейн дурсгал юм. Хосгүй үнэт үзмэрийн хадгалалтын байдалтай танилцахад, Үзмэрийн эх хувь сан хөмрөгийн өрөөндөө хүндрүүлэгчтэй сейфэнд тусгай саванд хийсэн байдалтай хадгалагдсан ба хуулбар хувиа үзүүлэгтэй байрлуулсан. Уг үзмэрийн хуулбарыг 2008 онд Соёлын өвийн төвөөр зохих зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хийлгүүлсэн байна.



*Музейн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл, баримт.* Музейд үзмэрийн ерөнхий бүртгэлийн дэвтэр 1980 оны 5 ширхэг дэвтрээс эхэлдэг. Тэдгээр 1986 оны 2 ширхэг, 1991 оны 1 ширхэг, 1992 оны 4 ширхэг, 1998 оны 3 ширхэг, 2000 оны 3 ширхэг, 2001 оны 1 ширхэг, 2004 оны 7 ширхэг, 2008 оны 3 ширхэг, 2012 оны 5 ширхэг нийт 34 ширхэг бүртгэлийн дэвтэр хадгалагдах ба 2008 он, 2012 он улсын тооллогын тайлан, тэмдэглэл бүрэн хадгалагджээ.

Музейн сан хөмрөгийн байгууллагын тооллогыг хуульд заасны дагуу хоёр жил дутамд явуулж баримт материалуудаа бусад музейн адил бүртгэл, мэдээллийн сандаа биш байгууллагынхаа бичигт хэрэгт шилжүүлдэг байна.

*Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл. Хөдлөх дурсгалын бүртгэл.* Говь-Алтай аймгийн музей 2012 оны Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор 18 сумдын ОНС танхимын үзмэрийг тоолж “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн 1x1 хуулбар, сумд бүрийн тооллогын тайлан хадгалагдаж байна.

2007 онд Сангийн сайд, соёлын асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан шийдвэрээр Улс, орон нутгийн музейд “Бүртгэл, мэдээллийн сангийн орон тоо”-г батласан шийдвэр гаргасан. Үүнийг үндэслэн болгон Говь-Алтай аймгийн БСГ-ын даргын 2007 оны 245 тоот тушаал гарч сумдын Соёлын төвүүддээ “Орон нутаг судлах танхимын ажилтны орон тоог батласан” байна. Энэ нь бусад аймгуудад байхгүй анхны орон тооны ажилтантай болж чадсан ч уг орон тооны давуу тал нь төдийлөн харагдахгүй байгааг ажилтнууд ярьж байсан. Иймээс тус аймаг энэхүү орон тооны давуу талыг мэдэрч сумдын ОНС Танхимын ажлын сайжруулах, хөгжүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллан зүйтэй юм.

*Шашны байгууллагын бүртгэл* Говь-Алтай аймгийн музейд хэдэн онд хийсэн нь тодорхойгүй аймгийн Дашпэлжээлэн хийд болон Эрдэнэ, Баян-Уул, Бигэр, Тонхил, Чандмань сумын хийдэд хадгалагдаж байгаа бурханы шашны холбогдолтой эд өлгийн зүйлийн материалууд байлаа.

*Эрдэм шинжилгээ судалгааны болон бусад байгууллагад* хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл байхгүй байна. Гэхдээ байгууллага дээр хадгалагдаж байгаа нь Говь-Алтай аймгийн чуулга дээр гарсан хэргээс тодорхой байна. Тодруулбал, Аймгийн чуулга дээр монгол эхнэрийн 6 ширхэг “Шүрэн шигтгээтэй мөнгөн толгойн боолт” олон жил тоглолтод хэрэглэгдэн хадгалагдаж ирсэн байна. Гэтэл үүнийг хариуцдаг чуулгийн хувцасны нярав 2014 онд тэтгэвэрт гарснаас хойш хуучны эд өлгийн зүйл болох эдгээр толгойн боолтнууд шуналтай хүмүүсийн харцанд өртөх болж 1 иж бүрэн толгойн боолт нь алдагдаж, үлдсэн зарим нь тоногдсон хэрэг гарсан байна. 2013 онд тухайн аймгаар явж байсан Тооллогын төв комиссын ажлын хэсэг аймгийн чуулгаар орж уг толгойн боолтуудыг баримтжуулахыг үүрэг болгосны дагуу музейн БМСанч О.Нэргүй гэрэл зургийг нь авч хадгалсан байна.

*Иргэний өмчлөлд байгаа дурсгалын* “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” маягтаар хийгдээгүй байна. Харин хэзээ хийсэн нь тодорхойгүй хувь хүний эд зүйлийн жагсаалт байсан ба үүнийг хувь хүний бүртгэл гэж болох уу, цаашдаа хэрхэн хадгалах тухай биднээс лавлаж байв.

*Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл.* Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэг, тооллогын тайлан, бүртгэл, дурсгалын гэрэл зургийг CD болон компьютер дээр хадгалсан, мөн тооллогын үеэр бичсэн гар бичмэл тэмдэглэлүүд бас байсан. Үзлэг тооллогоор

1135 дурсгалт газрыг бүртгэн баримтжуулж бүртгэлийг RICH 3.0 программд оруулсан ч хэвлэж гаргаагүйн улмаас дурсгалын цаасан бүртгэл байхгүй зөвхөн цахим хэлбэрээр компьютерт хадгалагдаж байна.

*Аймгийн нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа малтлага судалгааны ажлын хувьд* 2014 онд явагдсан Археологийн хүрээлэнгийн Н.Батболд нар оролцсон Монгол, Солонгосын хамтарсан “Монголын соёлын өв” төсөлд тус аймгийн музейгээс БМСанч О.Нэргүй, ЭШАжилтан Б.Гэрэлтуяа нар оролцсон байна. Төслийн тайланг эмхэтгэл болгон “Говь-Алтай аймгийн Жаргалант сумын археологийн дурсгалууд” нэртэй ном хэвлэгдсэн нь бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байна.

*Соёлын биет бус өвийн холбогдолтой бүртгэл.* Соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа ажил 2010-2013 хооронд музейн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаад 2013-2015 онд аймгийн Боловсрол, соёл урлагийн газар хариуцаж 2015 оноос хойш буцаж музейд шилжиж ирсэн байна. Одоогийн байдлаар цаасан суурьтай өвлөн уламжлагчдын материалын 70 орчим хувь нь цээж болон 9x12 хэмжээтэй гэрэл зурагтай тусдаа хавтсанд нийт сумдын өвлөгчдийн бүртгэл он оноор хадгалагдаж байна.

Тус аймаг нь 18 сумтай бөгөөд бүх сумд интернет сүлжээтэй, орон нутаг судлах танхимын ажилтнуудын орон тоотой ба бүртгэл судалгааг хариуцдаг ажилтантай боловч компьютер, аппарат, бичиг хэргийн зардлын төсөв байдаггүй байна.

Соёлын биет бус өвийн бүртгэлийг өвийн нэр, жагсаалтаар сумдаас ирүүлсэн өвлөгчдийн материалыг үндэслэн гаргадаг ба нарийвчлан судлах, нийтлэг өвийн төрөл зүйлийг өөрийн орон нутгийн онцлогоор тодорхойлж гаргасан бүртгэл хийгдээгүй байна.

*Цахим бүртгэлийн бүрдэл, хадгалалт хамгаалалтын байдал.* Бүртгэл, мэдээллийн сангийн компьютерт байгаа файлууд харьцангуй цэгцтэй байсан. Сангийн программууд дээр ажиллах чадвар болон гэрэл зургийн аппаратыг ашиглах чадвар “хангалттай” байсан. Музей нь гэрэл зургийн Canon 600D аппараттай, зөөврийн I5 компьютертай үйл ажиллагаа нь хэвийн.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогын Register программд аймгийн музейн 2489 дэсийн 2489 ширхэг үзмэрийг, Сумдын 18 ОНСТанхмын 1380 дэсийн 1380 ширхэг үзмэрийг бүрэн бүртгэсэн. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын RICH3.0 цахим программд 1135 дурсгалт газрын 5631 ширхэг дурсгал бүрэн орсон байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын RICH2.0 бүртгэлийн программд 1704 дэсийн 1854 ширхэг үзмэрийн бүртгэл буюу нийт үзмэрийн 68% орчмыг оруулсан байна.

Цахим файлаа 3% буюу 1-т Бүртгэл, мэдээллийн сангийн компьютерт, 2-т Зөөврийн харданд, 3-т CD-д бичиж хадгалсан. CD-ний зарим хэсгийг музейн лого бүхий нүүр, тайлантай зориулалтын хатуу хайрцагт хийж хадгалсан, зарим хэсэг нь худалнаараас ирсэн дугуй том савтайгаа байсан ба товч тайлбарыг макро үзгээр бичжээ.

Компьютерын програм хангамжийн аюулгүй байдлыг хангах тог тохируулагч, вирусны программ байхгүй байв.

*Музейн гадаад, дотоод орчны байдлын судалгаа.*

Говь-Алтай аймгийн музейн барилга 1958 онд аж ахуйн тооцоогоор баригджээ. Чулуун суурьтай, чулуу, дутуу шаталттай болон түүхий тоосгоор хийсэн ханатай, модон дам нуруу савх модон шавардлагатай таазтай, модон шувуу нуруу, төмөр дээвэртэй, 2 давхар. 1959 оны газар хөдлөлтийн улмаас ан цав гарснаас “акт” тогтоосон, 2008, 2012 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас “газар хөдлөлтөд даацын хана нурах магадлалтай” дүгнэлтүүд гарсан байна. Музейн барилгыг шинээр бариулахаар барилгын зураг төсөл хийгдсэн.

Музейн барилгын баруун, зүүн талд залгаж барилгууд барьсан ба үүний нэгэнд ваар цэнгээний газар ажилладаг байна. Музейн дээврээс ус гоождог, музейн тааз, ханын шавар байнга унадаг байна.

Говь-Алтай аймгийн музей 2011 онд гэмт халдлагад өртсөний дараагаар 2012 оноос камер, дохиоллын системийн бүрэн шинэчлэл хийгджээ. Одоо 16 камертай, камерын 32 инчийн 3 дэлгэц харуулын дэргэд суурилуулсан. Хөдөлгөөн, утаа мэдрэгч дохиоллын систем 32 ширхэг, бүрэн ажилладаг. “Бүрэн дуулга-Алтай” гэрээт харуулын компанитай гэрээтэй ажилладаг. 2015 онд 50 сая, 2016 онд 130 сая төгрөгний техникийн шинэчлэл хийгдсэн байна.





Музейн урд хэсэг



Музейн урд үүдний хэсэг



Музейн арын хэсэг

Музейн сан хөмрөг 2 давхартаа ажилтнуудын өрөөний цаана байрласан, давхар хаалгатай, бүх цонхнууддаа гайгүй төмөр сараалж хийсэн боловч ашиглалтгүй цонхнууд ихтэй байдал нь ямарваа эрсдэлд өртөх магадлалтай.

Үзүүллэгийн танхимын алга цоог болсон таазаа халхлах зорилгоор дүүжин тааз хийсэн боловч дүүжин таазны дээрээс шавар нурж унаснаар уг тааз хүндэрч цөмөрч нурах аюул үүсжээ.



Таазны шавар унасан байдал



Дүүжин таазны дээрээс шавар унж хүндэрснээр нурах эрсдэл үүссэн байна

Хортон шавьжны устгалыг хавар, намартаа жилд 2 удаа хийлгэдэг. “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулж батлуулсан. Аймгийн Онцгой байдлын газартайга гэрээтэй хамтран ажилладаг ба жилд нэгээс доошгүй удаа гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулдаг байна.


**Баянхонгор аймгийн музей.** Баянхонгор аймгийн музей дээр бид 3 дугаар сарын 02-ны өдөр ажилласан. Бидийг очиход музейн захирал А.Мандах эзгүй, хот явсан байв. Бидэнтэй музейн Бүртгэл, мэдээллийн санч Б.Эрдэнэхуяг, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Насантогтох, сан хөмрөгч ... Бадамаа нар ажлаа танилцуулан хамтран ажилласан.

**Бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалуудын хадгалалт.** Сангийн ихэнх материалууд Бүртгэл, мэдээллийн сангийн 2 бичгийн шүүгээнд байсан. Уг шүүгээнүүд ажилтнуудын өрөөний хажуугийн амралтын маягтын өрөөнд байрласан байх агаад шүүгээнүүдэд бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэл, баримтнаас гадна байгууллагын гэрэл зургийн аппарат хэрэгсэл, бичгийн цаас бусад ажлын болон хувийн эд зүйлс мөн байсан. Бүртгэл, мэдээллийн сангийн гол баримт болох “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл”-үүдийн зарим нь музейн ажилтнуудын өрөөнд байсан шургуулгатай жижиг шүүгээнд байсан нь сангийн баримтыг .... нэгдмэл цогц байдлаар хадгалах зарим хэрэгжээгүй байна.

Бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалуудыг музейн болон аймгийн бүртгэл, мэдээллийн сан хэмээн ерөнхийд нь ангилж ялгаагүй. Харин түүх, соёлын үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус өвийн материалуудыг тус бүрээр нь хавтас нээсэн боловч төрөлжүүлэн байршуулах, хадгаламжын нэгж болох ажил бүрэн хийгдээгүй.

**Музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл.** Үзмэрийн хуучин карт, бүртгэл. Үзмэрийн 1995 оноос өмнөх хуучин карт, паспортууд тодорхой хэмжээ байгаа ч “Хадгаламжийн нэгж” болгоогүй шүүгээнүүдэд задгай байдалтай хадгалагдсан, 1996 он, 1998 он, 1999 он, 2000 оны “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-үүдийг АЗ /ууттай/ том хэмжээтэй хавтсанд хийж хадгалсан.






Баянхонгор аймгийн музейн 2003 оны үзмэрийн бүртгэлийн хадгалалт

*Музейн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл, баримт.* Тус музейд 1974 оны “Байгалийн хэсгийн бүртгэл” 1975, 1982, 1986 оны “Үзмэрийн бүртгэл”, 1986 оны “Жилийн эцсийн тооллогын бүртгэл”, 1986 оны “Бүртгэл”, 1989 оны “Ажил хүлээлцсэн тооллогын бүртгэл” 1989, 1993, 1996 оны “Үзмэрийн бүртгэл”, 2002 оны “Тооллогын материал” 2007 оны “Үзмэрийн тооллогын бүртгэл” ВНМ 0073, 0074, 0140, Үзмэрийн бүртгэл 6 ширхэг, 2012 оны “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” 7 ширхэг нийт 27 ширхэг бүртгэл байна.

*Музейн сан хөмрөгийн байгууллагын тооллогын улсын бүртгэл, баримт.* Байгууллагын тооллогыг хуулийн дагуу 2 жил дутамд хийдэг байна. Ингэхдээ Музейн ерөнхий бүртгэлийн Excel программд оруулсан жагсаалтыг хэвлэн гаргаж, түүнийгээ барьж тооллогоо явуулдаг ба “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-дээ “Тоолов” тэмдэг дардаггүй, тооллогынхоо протокол, тайланг журам, зааврын дагуу үйлддэг ч байгууллагын бичиг хэрэгт хадгалагдаж улмаар архивт шилждэг байна. Энэ нь “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д заасан 21.2.4-т заасан бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлд хамаарах “үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт” материал байхгүй, “Түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллого явуулах журам”-ын 13е-д заасан “улсын болон ...байгууллагын тооллогоор үндсэн бүртгэлд “тоолов” тэмдгийг ... тавих” заалтууд хэрэгжихгүй явж ирсэн байдал харагдаж байна.

*Бусад материалын хувьд,* Музейн БМСанд сэргээн засварласан үзмэрийн тайлан, шинээр авсан үзмэрийн баримтууд, үзмэрийн хөдөлгөөний актуудыг журам зааврын дагуу хийгддэг боловч бүртгэл, мэдээллийн сандаа бус түүнийг дагалдан гардаг тушаалуудын хамт байгууллагын бичиг хэрэгт шилждэг байна. Тус аймгийн музейн хувьд аймгийн архивтай гэрээ байгуулан хамтран ажилладаг ба музейн ажилтнууд өөрсдийн хариуцаж шинээр авсан үзмэр, үзэсгэлэн гаргасан, хөдөлгөөний акт зэрэг ажлын тайлан, баримтуудаа оны эцэст архивын горимын дагуу дотоод товъёог, баталгааны хуудсыг хийж жилийн эцэст байгууллагынхаа бичиг хэрэгтээ өгч заншсан ба байгууллагын бичиг хэрэг “Архивын хууль”-ийн дагуу 5 жил дутамд аймгийн архивт шилждэг байна.



Музей дээр хийгдсэн ажлуудын тайланг оны эцэст төрөлжүүлэн нэгтгэж “хадгаламжийн нэгж” болгон бичиг хэрэгтээ шилжүүлдэг байна.

**Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл.** Музей дээр төвлөрч байгаа аймгийн БМСан нь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн баримтуудыг өмчийн хэлбэр харгалзахгүй бүрдүүлэх эрх зүйн зохицуулалттай.

**Хөдлөх дурсгалын бүртгэл.** Баянхонгор аймаг 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор 18 сумдынхаа ОНСТанхимыг тоолж “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийг 1x1 хэмжээтэй хуулбарлан хадгалсан байна. Мөн ОНСТанхимын үзмэрийн “Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг хийж, эх хувийн тухайн сумын бүртгэл, мэдээллийн санд, хуулбар нь аймгийн бүртгэл, мэдээллийн санд байна.

**Шашны байгууллага, эрдэм шинжилгээ судалгааны болон бусад байгууллагын хөдлөх дурсгалын бүртгэл** тус аймгийн бүртгэл, мэдээллийн санд байсангүй.

**Иргэний өмчлөлийн түүх, соёлын дурсгалт зүйлийг** бүртгэн баримтжуулах ажил Баянхонгор аймгийн музей дээр нилээд санаачлагатай хийгдэж “Нэг цэгийн үйлчилгээ” явуулж иргэний өмчлөлийн түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэж бүртгүүлсэн хүмүүсдээ тусгай “Батламж” өгч байна. Одоо тус санд 69 иргэний “Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл”, гэрэл зургийн хамт хадгалжээ. Гэвч энэхүү ажилд алдаа, оноотой зүйлүүд байсан. Тухайлбал, “өмчлөл”-ийн гэдгийг “эзэмшил” гэж бичсэн, “батламж”-д аймаг биш музейн тамга дарсан зэрэг зүйл байсан. Хэдийгээр уг ажлын хувьд эрх зүйн зохицуулалтад шийдвэрлэх шаардлагатай олон асуудлууд байдаг ч тус музейн хувьд өөрийн боломжоороо шийдвэрлэх оролдлого хийж байгаа нь сайшаалтай юм.




**Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл.** Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэг, тооллогын 20 сумын 337 дурсгалт газрын 7558 дурсгалыг бүртгэн баримтжуулж RICH бүртгэлийн программд оруулах ажил бүрэн хийгдэж, бүртгэлээ хэвлэж цаасан хэлбэрээр төрөлжүүлэн хавтаслан хадгалсан байв. Мөн тооллогын тайлан, дурсгалын гэрэл зураг, дүрс бичлэгийн хамт CD болон компьютерт хадгалсан.

**Аймгийн нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа малтлага судалгааны ажлын тайланг** аймгийн бүртгэл, мэдээллийн сан авах, тухайн иргэн байгууллага өгөх ёстой хуулийн

зохицуулалттай. Тус аймгийн бүртгэл, мэдээллийн санд Бөмбөгөр сумын хадны оршуулгын тайлан, Шинэ жинст сумын хадны оршуулгын тайлан байгаа ба аймгийн хэмжээнд явагдсан бусад малтлага, судалгааны ажлын тайлан байна, бусад тайлан ирээгүй аж.

*Соёлын биет бус өвийн холбогдолтой бүртгэл.* Соёлын биет бус өвийн холбогдолтой бүртгэлийн материал нь 2010 оноос хойш музейн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа. Одоогийн байдлаар цаасан суурьтай өвлөн уламжлагчдын материал тусдаа хавтсанд гэхдээ нийт сумдын өвлөгчдийн бүртгэл бүгд нэг хавтсанд хадгалагдаж байна.



Тус аймаг нь 20 сумтай бөгөөд бүх сумд интернет сүлжээтэй, орон нутаг судлах танхимын ажилтнуудын орон тоо байхгүй ба бүртгэл судалгааг хариуцдаг ажилтан нь бүжгийн багш, бичиг хэрэг, соёлын төвийн эрхлэгч зэрэг албан тушаал хашдаг хүмүүс давхар гүйцэтгэж байна.

Аймгийн бүртгэл, мэдээллийн санч нь бичиг хэргийн ажлыг давхар хийдгээс ачаалалтай байдгаа ярьсан.

Соёлын биет бус өвийн бүртгэлийг өвийн нэр, жагсаалтаар сумдаас ирүүлсэн өвлөгчдийн материалыг үндэслэн гаргадаг ба нарийвчлан судлах, нийтлэг өвийн төрөл зүйлийг өөрийн орон нутгийн онцлогоор тодорхойлж гаргасан бүртгэл хийгдээгүй байна.

Цахим бүртгэл мэдээллийн санд байгаа гэрэл зураг, дүрс бичлэгийн тоо, хэмжээ тодорхойгүй байсан.

Сумдад бүртгэл хариуцсан ажилтан буюу хөгжим, бүжгийн багш нар нь орон нутаг судлах танхим, нярав, үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийн бүртгэл, бичиг хэргийн ажлыг давхар хийж гүйцэтгэдэг тул ачаалал ихтэй ажилладаг. Соёлын биет бус өвийн бүртгэлийг номын санч нь хариуцаж байгаа сумдын хувьд ирүүлж байгаа бүртгэл нь илүү цэгцтэй, сайн ирүүлж байна.

*Цахим бүртгэлийн бүрдэл, хадгалалт хамгаалалтын байдал.* Бүртгэл, мэдээллийн санчийн компьютерт байгаа файлууд цэгцтэй, ур чадварын түвшин тогтоох товч судалгааг авахад программууд дээр ажиллах, шүүлт хийх чадвар, гэрэл зургийн аппараттай ажиллах чадвар хангалттай байв.

Музей нь гэрэл зургийн EOS 200D аппараттай, Notebook i5 зөөрвийн компьютертай ба эдгээр нь хэвийн ажиллагаатай.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор Register программд аймгийн музейн 4074 дэсийн 10522 ширхэг үзмэр, Орон нутгийг судлах 18 танхимын нийт 2370 дэсийн 3111 ширхэг дурсгал, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH3.0 цахим бүртгэлд 2015 оны үзлэг, тооллогоор бүртгэн баримтжуулсан 809 дурсгалт газрын 7885 дурсгал тус тус бүрэн шивэгдсэн байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын RICH2.0 бүртгэлийн программд аймгийн музейн 1846 дэсийн 6932 ширхэг үзмэр бүртгэл буюу нийт үзмэрийн 45%-ийг уг программд оруулжээ. СӨТ-тэй байгуулсан гэрээний дагуу RICH2.0 программд жилд 800 үзмэр оруулах ёстой ч 2012-2013 онд улсын тооллого явагдсан, 2017 онд байгууллагын засварын ажил хийгдсэн зэрэг шалтгаанаас уг ажил завсарлажээ.

Программын дата, гэрэл зураг бусад цахим файлуудаа Бүртгэл, мэдээллийн санчийн



компьютер, зөөврийн хард, CD-д бичиж хадгалсан. CD-гээ зориулалтын хатуу хайрцагт хийж, мэдээллийн гарчгийг шивж “дотоод товъёог” маягаар хийж цэгцлэжээ.

Компьютерын програм хангамжийн аюулгүй байдлыг хангах тог тохируулагч, вирусны программ бусад музейн адил байхгүй.

*Музейн гадаад, дотоод орчны байдлын судалгаа.* Баянхонгор аймгийн Түүх, угсаатны зүйн музейн барилга 1971 онд аж ахуйн тооцоогоор чулуу, тоосгоор баригдсан, Байгалийн түүхийн музейн барилгыг 1980 онд үзмэр, үйлчилгээний зориулалтаар блок, тоосгоор барьсан байна. Музейн барилга дотор байрласан “Бага хүчин чадлын зуух”-ыг 2015 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас “Барилгын дулаацуулгын зуухны техник ашиглалтын дүрэм”-д заасан норм зөрчигдсөн “эрсдэлтэй”, мөн музейн барилга нь “их, дунд эрдэлтэй”, “цахилгаан эрчим хүчний үйл ажиллагаа их эрсдэлтэй” хэмээн тус тус дүгнэгдсэн байна. Музейн барилгыг шинээр бариулахаар барилгын зураг төсөл, газрын асуудлыг шийдвэрлэгдсэн. Баянхонгор аймгийн Түүх, угсаатны зүйн музейн барилга нь аймгийн стадионы нэг хэсэг болж баригдсан нь ч эрсдэл дагуулж байна.

*Музейн камер, дохиололын систем.* Баянхонгор аймгийн түүх, угсаатны зүйн музей 21 камертай, хөдөлгөөн мэдрэгч, гал, усны дохиололын систем 29 ширхэг байдаг, 4 ээлжийн харуултай. Байгалийн музей нь 12 камертай, дохиололын систем 10 ширхэг байдаг ч бүрэн ажилладаггүй. Харуул хамгаалалтын ажилтан байхгүй. Камер, дохиололын систем нь хуучирсан, дэлгэц нь бүдэг шаардлага хангахгүй болсон байна.



*Музейн барилгын урд хэсэг*



*Музейн барилга стадионы нэг хэсэг*




*Музей доторх бага оворын зуух*

Музейн үзүүлэлийн танхим тэр дундаа Байгалийн музей нь том цонхтой, байгалийн гэрлийн шууд тусгалыг хаадаггүйгээс үзмэр дээр нар тусдаг. Мөн шинээр хийж байрлуулсан хоргоны шил хэт урт хийгдснээс хотойж хугарах, шилэн хоргоны ирмэг хурц засагдаагүйгээс зэрэг нь музейн ажилтан, үзэгчдэд аюул учруулж болохоор байна. Үүнээс үзэхэд музейн хорго, савны стандартыг тогтоох, хийх аргачлалаар хангах асуудал зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.



*Баянхонгор аймгийн музейн хоргоны шилний урт болон үзүүр ирмэг үзэгчдэд аюул учруулахаар байна.*

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй. Чийг, дулааны хэмжигч байдаг, сард нэг удаа хэмжилт хийж тэмдэглэл хөтөлдөг, хортон шавьжны устгалыг жилд 4 удаа хийлгэдэг.





Баянхонгор аймгийн музейн нарны гэрэл шууд тусах газар үзмэрээ байруулжээ

Өвөрхангай аймгийн музей. Өвөрхангай аймгийн музей дээр бид 3 дугаар сарын 03-ны өдөр ажилласан. Бидэнтэй музейн захирал Д.Тогтох, Бүртгэл, мэдээллийн санч Н.Гантулга, Сан хөмрөгч Т.Цэрэндулам, Эрдэм шинжилгээний ажилтан ...Бат-Эрдэнэ нар байлцаж, ажил байдлаа танилцуулсан.

Бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалуудын хадгалалтын байдал. Бүртгэл, мэдээллийн сангийн баримт, материалууд Бүртгэл, мэдээллийн санч Н.Гантулгын 1 хүндрүүлэгчтэй сейф, 2 бичгийн шүүгээнд байсан. Бичгийн 2 шүүгээг ажилтнуудын өрөөнд хоёр газар байрлуулсан бол сейфиийг ажилтнууд суудаггүй өөр нэг өрөөнд дангаар нь байршуулжээ. Бүртгэлийн дэвтрийг галаас хамгаалагдсан байранд, цоож бэхэлгээ бүхий шүүгээнд хадгалах. горимын дагуу хүндрүүлэгчтэй сейфэнд Музей болон сумдын тооллогын бүртгэлийн дэвтрүүдээ хийсэн. /"Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага" стандартын 12.4.17/ Бичгийн шүүгээнүүдэд үзмэрийн бүртгэл, хөдлөх, үл хөдлөх, биет бус өвийн бүртгэлээ хадгалжээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу аймгийн музей дээр музей болон аймгийн бүртгэл, мэдээллийн гэсэн ялгаатай 2 санг бүрдүүлэх ёстой ч музейдүүдийн сангийн материалууд тодорхой зааг ялгаа байхгүй байсан.



Музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл. Үзмэрийн хуучин карт, пастортаас тус музейд 1973 оны Сангийн сайд, Соёлын сайдын баталсан "Түүх дурсгалын болон урлагийн үнэт ховор зүйлсийг бүртгэх дэлгэрэнгүй карт" маягтаар бүртгэсэн 1988 оны 1 хавтас бүртгэл, "Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл" маягт болон түүнийг хялбаршуулсан маягтаар хийсэн 2002-2005, 2009, 2010 оны бүртгэлүүдийг шашны зан үйл, түүх угсаатан, сийлбэр зэргээр төрөлжүүлэн хавтаслаж хадгалсан. Эдгээр хавтаснуудын дотоод товёог хийгдээгүй, жагсаалтыг гаргасан байлаа.

*Музейн ерөнхий бүртгэлийн дэвтэр* 1962 оноос эхлэсэн байна. “Өвөрхангай аймгийн ОНСМузейн 1962 оны жилийн эцсийн эд аж ахуй, үзмэрийн тооллогын бүртгэл, акт баримтууд” нэртэй уг дэвтэр сүүлд материал дотроос гарч ирсэн байна. Үүний дараа 1970, 1975, 1977, 1980, 1981, 1986, 1993, 1996, 1999, 2001, 2003, 2004 оны тус бүр 1 ширхэг бүртгэл, 1990 оны төрөлжсөн 3 бүртгэл, 1992 оны 2, 1993 оны 2, 2004 оны төрөлжсөн 5 бүртгэл, 2000 оны үзмэрийн карт, 2007 оны Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл, 2008 оны Богд, Бүрд, Төгрөг, Тарагт, Хархорум сумын ерөнхий бүртгэл, 2011 оны төрөлжсөн 4 бүртгэл, 2012 оны үзмэрийн карт, 2012 оны Улс, аймгийн сан хөмрөгийн улсын тооллогын бүртгэл 4 ширхэг нийт 46 бүртгэл хадгалагдаж байна. Мөн 2008, 2012 оны тооллогын тайлан, акт баримтууд байсан.

*Музейн сан хөмрөгийн байгууллагын тооллогыг* тус музей бусад музейтэй адил хөрөнгийн тооллоготой хамт хуульд заасны дагуу 2 жилд дутамд явуулдаг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-дээ “Тоолов” тэмдэг дардаг ба 2011, 2015 онд байгууллагын тооллогын баримтууд байлаа.

*Бусад материалын хувьд*, Сэргээн засварлуулсан нийт 27 үзмэр байдгийн сүүлийн жилд сэргээн засварлуулсан 6 үзмэр баримт “Сэргээн засварласан үзмэрийн маягт” үйлдэж ирүүлсэн ба өмнөх онуудынх зөвхөн хүлээлцсэн актаараа байдаг байна. 2012 оны тооллогоор “Яаралтай сэргээн засварлагдсан үзмэрийн жагсаалт”-аар 52 үзмэр гарсны 9 үзмэр нь сэргээн засварлуулаад байгаа аж.

Музейд шинээр авсан үзмэрийн баримтууд, үзмэрийн хөдөлгөөний актуудын хавтас нээсэн боловч цэгц муутай, товёог бүртгэлгүй хадгалсан.

*Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэл.* Хөдлөх дурсгалын бүртгэл. Өвөрхангай аймаг 2012 оны Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор 17 сумдынхаа ОНСТанхимыг тоолж “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийг хуулбар, тооллогын тайлагуудыг хадгалсан.

*Шашны байгууллагын хувьд* мөн 2012 оны улсын тооллогод хамрагдсан Өвөрхангай аймагт Шанхын баруун хүрээ хийд, Төвхөн хийдийн тооллогын бүртгэл, тайлан байсан.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хадгалдаг *Эрдэм шинжилгээний байгууллага бусад газрын бүртгэл байхгүй.*

*Иргэний өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн хувьд* 2011 онд хийсэн “Ард иргэдийн гар дээрх ховор нандин дурсгалын бүртгэл” жагсаалт байсан ба маягтаар хөтөлсөн бүртгэл байхгүй.

Бид нэмж 2017 оны Бүртгэл, мэдээллийн сангийн баяжилтийн тайланд 2 иргэний 13 ширхэг дурсгалыг бүртгэсэн мэдээ байсан талаар тодруулахад, Музей дээр гарсан үзэсгэлэн оролцсон дурсгалыг зааврын дагуу ББЗ Маягт 33 “Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт”-аар хүлээлцээд буцааж өгсөн бөгөөд үүнийгээ баяжилтыг судалгаанд оруулсан ба эдгээрийн маягтаар хийсэн бүртгэл байхгүй байна.

*Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл.* Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын материалд зориулан тусгай шүүгээ гаргаж 2015 оны үзлэг, тооллогын нэгдсэн тайлан, бүртгэлээ хийсэн. Үзлэг, тооллогоор бүртгэн баримтжуулсан 566 дурсгалт газрын бүртгэлийг RICH бүртгэлийн программд бүрэн оруулсан ба цаасан хэлбэрээр хэвлэн гаргаж төрөлжүүлэн хавтаслан хадгалсан, тооллогын үеэр хийгдсэн дурсгалын гэрэл зураг CD болон компьютер дээр байсан.

*Аймгийн нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа малтлага судалгааны ажлын тайланд* 2005-2013 онуудад Хархорум хотын тууринд хийгдсэн Герман-Монголын хамтарсан археологийн малтлагын тайлангууд байв.

*Соёлын биет бус өвийн бүртгэлийн бүрдэл.* 2014 онд батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу Боловсрол, соёл урлагийн газраас 2014 онд аймгийн музейд шилжүүлсэн байна. Одоогийн байдлаар цаасан суурьтай өвлөн уламжлагчдын материал нь тус тусдаа хавтсанд сумдын өвлөгчдийн бүртгэл нь мөн тусдаа хавтсанд хадгалагдаж байна.

Тус аймаг нь 18 сумтай бөгөөд бүх сумд интернет сүлжээтэй, орон нутаг судлах танхимын ажилтнуудын орон тоо байхгүй ба бүртгэл судалгааг хариуцдаг ажилтан нь бүжгийн багш, бичиг хэрэг, соёлын төвийн эрхлэгч зэрэг албан тушаал хашдаг хүмүүс давхар гүйцэтгэж байна.

Соёлын биет бус өвийн бүртгэлийг өвийн нэр, жагсаалтаар сумдаас ирүүлсэн өвлөгчдийн материалыг үндэслэн гаргадаг ба нарийвчлан судлах, нийтлэг өвийн төрөл зүйлийг өөрийн орон нутгийн онцлогоор тодорхойлж гаргасан бүртгэл хийгдээгүй байна.

Цахим бүртгэл мэдээллийн санд орон нутгийн телевиз нь 11 өвлөгчийн танилцуулга нэвтрүүлгийг 38 GB буюу 6 цагийн бичлэг хийж музейн бүртгэл мэдээллийн санд хүлээлгэн өгсөн байна. Цаасан хэлбэрээр ирүүлсэн гэрэл зургийг сканердаж цахим болгон бүртгэл, мэдээллийн

санд оруулан ажиллаж байна.

Цахим бүртгэлийн бүрдэл, хадгалалт хамгаалалтын байдал, Бүртгэл, мэдээллийн санчийн компьютерын файлууд цэгцтэй, Бүртгэл, мэдээллийн санчийн программууд болон гэрэл зургийн аппараттай ажиллах чадвар “хангалттай” байсан.

Музей нь гэрэл зургийн EOS 450 болон 2017 онд яамнаас өгсөн EOS 200D гэрэл зургийн аппараттай ба уг аппаратаа ашиглаагүй, хайрцаг савтайгаа байв.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын Register программд аймгийн музейн 1209 дэсийн 2388 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл, 17 сумын ОНСТанхимын нийт 564 дэсийн 1138 ширхэг үзмэрийн бүртгэлийг бүрэн оруулсан байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH3.0 программд 2015 оны үзлэг, тооллогоор бүртгэсэн 566 дурсгалт газрын 6619 дурсгалт газрын бүртгэлийг бүрэн оруулсан.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын RICH2.0 программд 598 дэсийн 1076 ширхэг үзмэрийн бүртгэл буюу нийт үзмэрийн 50%-ийг уг программд оруулсан байна.

Цахим файлууд бүртгэл, мэдээллийн сангийн компьютертоос гадна зөөврийн хард, CD-д давхар бичиж хадгалсан. CD-нүүд хатуу, зөөлөн хайрцаг саванд хийж цаасан хайрцагт бөөндөнө хийж хадгалсан нь хадгалалтын горимын шаардлагад нийцэхгүй байна.

Компьютерын программ хангамжийн аюулгүй байдлыг хангасан вирусны программ байхгүй, бүртгэл, мэдээллийн санчийн компьютерт зөвхөн тог тохируулагчтай байсан.



*Музейн гадаад, дотоод орчны байдлын судалгаа.* Музейн барилга 1978 онд, Занабазарын дурсамж музейн барилга 1957 онд аж ахуйн тооцоогоор чулуу, тоосго, блокоор барьсан. 2014 онд аймгийн музейн барилгад цахилгаан, сантехникийн засвар хийгдсэн, 2015 онд Занабазар музейд сантехникийн засвар хийгдсэн. 2017 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас музейн “Барилгын зураг төсөл хийлгэх”, “Агааржуулалт, дээврийн бүрэн засвар хийлгэх” шаардлагатай дүгнэлт гарсан байдаг. Үүний дагуу Занабазарын дурсамж музейн дээврийн төмрийг солих ажил хийгдсэн. Барилгын шинэ зураг төсөл гаргах ажил хийгдээгүй байна.

Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5634:2006 стандартад /7.1.1/, “Соёлын тухай хууль”-д /20.2/ “Музейн барилга, байгууламж нь барилгын норм, дүрэм соёлын өвийг хадгалах, нийтэд үйлчлэх шаардлага хангасан байх”, “Музейн ... эзэмшил газарт музейн үйл ажиллагаанд харшлах үйл ажиллагаа явуудаггүй” байх гэсэн заалтууд байдаг. Гэтэл уг музейн ар талд барилгатай тулгаж хашаа барьж 2 ч айл буусан байдалтай байсан. Барилгын зүүн талд баар цэнгээний зориулалттай барилга тулгаж барьсан ба харин одоогоор үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж. Барилгын баруун талд “Занабазарын музей”-н барилга мөн үргэлжлэн баригдсан ба уг музейн барилгын ард том машины граштай байсан.

Өвөрхангай аймгийн музей 22 камертай, хөдөлгөөн, утаа мэдрэгч дохиололын систем 60 ширхэг суурилуулсан, музейн ажилтнууд харуул манаагаа хийдэг. 2015 онд 9.5 сая, 2017 онд 600.000 төгрөгний техникийн шинэчлэл хийгдсэн гэх боловч камерийн хүчин чадал муу, камерийн дэлгэц бүдэг, дохиололын систем нь бүрэн ажилладаггүй асуудал гардаг бөгөөд шинэчлэх шаардлагатай гэж музейгээс үзэж байна.

Музейн үзүүлэлийн танхим тэр дундаа Байгалийн музей нь том цонхтой ба байгалийн гэрлийн шууд тусгалыг хаадаггүйгээс үзмэр дээр нарны гэрэл шууд тусаж байлаа. Тухайлбал, манай байгууллагаар 2009 онд сэргээн засварлуулсан модон эх биетэй, арьсан цартай 2 хэнгэрэгний нэг нь сан хөмрөгт, нөгөө нь тус музейн үзүүлэлийн танхимд цонхны хажууд нарны шууд тусгал тусах газар байрлуулснаар хэнгэрэгний арьсан цар агшилт өгч цуурч

хагарсан байдалтай байсан нь тус музейн үзүүллэгийн танхимын хадгалалтын түвшин тодорхой харагдлаа.



Өвөрхангай аймгийн музейн нар шууд тусах цонхны хажууд байрлуулсан Хэнгэрэгийн арьсан цар нар туссан хэсэгтээ хагарсан

Тус музей гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй. Чийг, дулааны хэмжигч байдаг ч буруу заадаг. Сард нэг удаа хэмжилт хийж тэмдэглэл хөтөлдөг, хортон шавьжны устгалыг жилд 2 удаа хийлгэдэг.

Өвөрхангай амйгийн музей үзүүлэлг дэглэлтэй сайжруулах зорилгоор олон тооны шилэн хорго хийсэн байна. Эдгээрийн бүх хоргоны шилний ирмэн хурц засагдаагүйн улмаас хүмүүс гэмтэх аюул хамгийн их байна.

Өвөрхангай аймгийн музей сан хөмрөгийн байр мөн музейн 2 давхартаа байрлажээ. Гэхдээ бусад 3 музейгээс сан хөмрөгийн өрөөний хадгалалт, хамгаалалтын байдал харьцангуй сайн байсан ба олон жил ажилласан сан хөмрөгч Цэрэндулам үзмэрүүдээ битүү хайрцаг саванд хийж, тавиур шүүгээндээ төрөлжүүлэн эмх цэгцтэй байрлуулжээ.

*Музейнүүдийн гэрэл, харьцангуй чийг, дулаан болон хортон шавьж, агаарын бохирдлын байдал.* Музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтын хамгийн гол хүчин зүйл бол гэрэл ба хэт ягаан туяа, харьцангуй чийг, дулааны тогтвортой байдлыг хангах явдал юм. Үүний хэв хэмжээг “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”, “Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” MNS Монгол Улсын стандарт бусад холбогдох баримт бичигт заасан байдаг.

Музейн гэрэл ба хэт ягаан туяаг Custom Lux meter LX-1332 хэмжилтийн багажаар, харьцангуй чийг, дулааныг Thermk Recorder TR-72wf хэмжилтийг багжаар сэргээн засварлагч Даваадарь хийв.

*Гэрэл, хэт ягаан туяа* “... мэдрэмтгий үзмэр бол 50 люкс буюу түүнээс доош, гэрэлд тэсвэртэй бол 500 люкс түүнээс доош” байхаар зааварт заасан байдаг ба хэмжилт хийхэд:

- Ховд аймгийн музейн Шашны танхимд 207 люкс, Археологийн танхим 247 люкс, Монгол ахуйн танхим 233 люкс, Галданбошигтын танхим 209 люкс дунджаар 170 люкс байна.

- Говь-Алтай аймгийн музейд хамгийн их нь Ч.Лодойдамбын танхимд 287 люкс, дунджаар 107 люкс.

- Баянхонгор аймгийн музейд үзүүллэгийн хэд хэдэн танхимд хэмжилт хийсэн ба дунджаар 62 люкс, тус аймгийн Байгалийн музейн цонхны хаалт хөшиг байхгүйгээр хэт ягаан туяаны хэмжээ өндөр гарах байсан ч хэмжилт хийж амжсангүй.

- Өвөрхангай аймгийн музейд Эртний түүхийн танхимд 219 люкс, Сийлбэрийн танхим 220 люкс, Алдартны танхимд 202 люкс, Занабазарын дурсамж музейн гэртэй танхимд 320 люкс, соёмботой танхимд 583 люкс, дунджаар 140 люкс байгаа хэмжигдэв.

Музейнүүд үзүүллэгийн танхим доторх гэрлийн ялгал байхгүйн дээр цонхондоо хөшиг хаалт хийдэггүйн улмаас байгалийн гэрэл тэр чигтээ орж үзмэр дээр туссаж гэмтээж байна. Ер нь аймгийн музейхэн стандарт, заавраа уншиж судлаагүй, мэдэхгүй, барилгын нөхцөл байдал муу байдаг зэргээс гэрлийн горим зөрчигдсөөр байна.

*Харьцангуй чийг, дулаан* “...холимог материалтай үзмэрүүдэд харьцангуй чийг 35-65%, үзмэрийн танхимын дулааныг 200 С түвшин барих ёстой байхаар зааварт заасан байдаг. Хэмжилт хийхэд:

Ховд аймгийн музейд дулаан дунджаар 220С,  
дунджаар чийгшилт 20 %,

Говь-Алтай аймгийн музейн дулаан дунджаар 20.50С,  
дунджаар чийгшилт 24 %,

Баянхонгорын аймгийн музейн дулаан дунджаар 170С,



дунджаар чийгшилт 22 %,
   
Өвөрхангай аймгийн музейн дулаан дунджаар 160С,
   
чийгшилт дунджаар 24 % тус тус байна.

*Агаарын бохирдол* үзмэрт муугаар нөлөөлөх хүчин зүйлийн нэг. Агаарын бохирдол хаалга, цонхны завсар зааг, хана дээврийн ан цаг, музей доторх утаа тортог зэргээр үүдэлтэй. Музейнүүд чийгтэй цэвэрлэгээ хийх, сан хөмрөгийн үзмэрээ бүтээх хайрцаг саванд хийх зэрэг арга хэмжээ авдаг ч ялангуяа Өвөрхангай аймгийн музейд маш их хэмжээний тортог музейн үзүүлэгийн тахимуудаар үүссэн байв. Уг тортог яг хаанаас орж ирээд байгааг бид нарийн тогтоож чадсангүй. Ховд болон Баянхонгор аймгийн музейд үзмэрийн урд арц асааж байсан бололтой бойпор байрлуулсан харагдав.

Сүүлийн үед агаардын бохирдол Улаанбаатар хот төдийгүй хөдөө орон нутагт их байгаа ба улмаар хуучны эд өлгийн зүйл хадгалагддаг музейнүүдэд радиов зэрэг хорт хийн агууламж өндөр гарч байгаа анхааралдаа авч мэргэжлийн байгууллагуудаас хэмжилт хийлгэх, лекц яриа авах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

	ГЭРЭЛ 50-500 Люкс /үзүүлэгийн танхимуудын дундаж/	ЧИЙГ 35%-65%	ДУЛААН 20°C
<b>ХОВД АЙМГИЙН МУЗЕЙ</b>	170-247 люкс	20%	22 °C
<b>ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН МУЗЕЙ</b>	107-287 люкс	24 %	20.5 °C
<b>БАЯНХОНГОР АЙМГИЙН МУЗЕЙ</b>	62 люкс	22 %	17 °C
<b>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МУЗЕЙ</b>	140-220 люкс	24 %	16 °C

 Хэвийн  Дунджаас их болон бага

Үүнээс харахад музейнүүдэд гэрлийн хэмжээ харьцангуй өндөр, харьцангуй чийг бага хуурайшил ихтэй гормын бус орчинд музейн үзмэрүүдээ хадгалагдаж байна. Санал, дүгнэлт.

1. Музейн аюулгүй байдал, барилга цахилгаан сүлжээний бүрэн бүтэн байдлын үзлэгийг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагатай хамтран хийж байх тухай “Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5634:2006 стандарт /17.1, 17.5/ -ын заалтыг хэрэгжүүлэх. Үүн дээрээ үндэслэн музейдээ илэрсэн эрсдлийг бууруулах, үзмэрийн хамгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг өөрсдийн хүч боломжоороо болон холбогдох байгууллагатай хамтран хийж хэрэгжүүлэх.

2. Музейн шинэ барилгын асуудал олон музейд яригдах болсон. Иймээс шинэ барилгын зураг төсөлд музейн стандарт, норм хир тусгагдсан байдалд музейн зүгээс анхаарал хандуулж байх. Түүнчлэн шинэ барилгад найдаж музейн барилга, үзмэрийн хадгалалт хамгаалалтын асуудалдаа анхаарал сулруулахгүй байх. “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03-д зааснаар: Барилгын урсгал засварын ажлыг 2-3 жил тутамд, их засварын ажлыг 10-15 жил тутамд хийж байх ёстой”-г анхааран ажиллах,

3. Музейн хоргоны талаар орон нутгийн музейнүүд судлах, аргачлал, зөвлөмжөөр хангах асуудлыг холбогдох байгууллагууд анхааралдаа авах.

4. Улмаар музейн үзүүлэг дэглэлтийг стандартад заасны дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй, ойлгомжтой, төгс гүйцэтгэл бүхий дизайнтай хийх. ....үзүүлэгийн агуулга, бүлгийн бүтцийг тодорхойлсон үндсэн чиглэлийг\* батлуулан хэрэгжүүлэх шаардлага байна. Үзүүлэг дэглэлтийн талаар тусгайлсан аргачлал, зөвлөмж боловсруулахад холбогдох байгууллагууд анхааралдаа авах.

5. Аймгийн музей дээр төвлөрч байгаа Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан, Аймгийн бүртгэл, мэдээллийн санг хоёр тусад нь салгаж бүрдүүлэх,

6. Бүртгэл, мэдээллийн сангийн баримтыг /ажилтнуудын шүүгээ саванд бус/ тусгайлсан өрөө, тасалгаанд зориулалтын шүүгээ, тавиурт төрөлжүүлэн ангилан горимтын дагуу хадгалах,

7. Сумын бүртгэл, мэдээллийн санг чадавхжуулж байж Аймгийн бүртгэл, мэдээллийн

сангийн бүртгэл бүрдүүлэлтийн чанар сайжирна. Иймээс юуны өмнө байгууллага болон сум, аймгийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, архивлан хадгалах заавар, зөвлөмжөөр хангах нь чухал байна.

Дээрх музейнүдээс авсан судалгаан дээрээ үндэслэн дараах зөвлөмжийг Аймгийн Засаг дарга нарт болон музейн захирлуудад хүргүүлсэн болно.

**Эрдэнэ-Зуу музей, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Хархорум музей, Хөшөө Цайдам музейд ажилласан тухай**

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний 1.3-т заасны дагуу 2018 оны 09 дүгээр сарын 12-наас 15-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин суман дахь ЭрдэнэЗуу музей, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Хархорум музей, Архангай аймгийн Хашаат суман дахь Хөшөө Цайдам музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд үзлэг хийх ажлыг гүйцэтгэлээ.

№	Ажилласан хугацаа	Байгууллага
1	2018.09.12 /үдээс хойш/	Дэлхийн өв-ОХСДГХамгаалалтын захиргаа
2	2018.09.13	Эрдэнэ Зуу музей
3	2018.09.14 /үдээс өмнө/	Хөшөө Цайдам музей
4	2018.09.14 /үдээс хойш/	Хархорум музей

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, “Музейн үйл ажиллагаандтавих шаардлага Монгол Улсын стандарт /MNS5634:2006/”, “Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм”, “Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар”, “Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”, “Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын холбогдох заалтуудыг мөрдлөг болгон Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан удирдамжийн дагуу үзлэг хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Ажлын хэсгийн ахлагч М.Цэцэнбилэг /Үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга/, Д.Нарантуяа /Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын шинжээч/ нар соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн, Б.Мягмарсүрэн /Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч/, О.Оюунчимэг /Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч/ нар музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын чиглэлээр тус тус ажиллав.

**1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн талаар:**

1.1. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны БМСан бүрдүүлэлт дараах байдалтай байна. /Хавсралт№1/ Үүнд:

- Тус захиргааны орон тоо, бүтцэд “Бүртгэл, мэдээллийн санч” албан тушаал байхгүй, ажилтнууд хариуцсан өвийнхөө хүрээнд БМСангаа тус тусдаа хариуцан ажилладаг.

- Дэлхийн өвийн хамгаалалтын бүс дэх (Өвөрхангай аймгийн Хархорин, Бат-Өлзийт, Хужирт сум, Архангай аймгийн Хашаат, Хотонт сум) үл хөдлөх дурсгалын бүртгэл, мэдээллийг бүрдүүлсэн./Хавсралт №1.1 Зураг 1-7/

- Хамгаалалтын бүс дэх соёлын биет өвийг өвлөн уламжлагчдын талаарх мэдээллийг тойм судалгааны түвшинд цуглуулсан ба “Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягтын дагуу бүртгэл хийгдээгүй байна. /Зураг8/

- Хамгаалалтын бүс дэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг хийгээгүй байна.

- Тус БМСанд цуглагдсан цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдийг эмх цэгцтэй хадгалан мэдээллийн сан бүрдүүлэхэд архивын хууль дүрэм, журмын дагуу товъёогжуулалт хийгдээгүй, хийх шаардлагатай байгааг;

- Цуглагдсан бүртгэл, мэдээллийг ил задгай хадгалахгүй, зориулалтын лац, ломбо бүхий цоожтой, төмөр сейф шүүгээтэй болгож, эмх цэгцтэй хадгалах шаардлагатайг хэлж, зөвлөмж өгөв. /Зураг 9/

- ДӨОХСДГХЗахиргааны зүгээс дараах 2 зүйл дээр санал, хүсэлт уламжилав. Үүнд:

- Хамгаалалтын бүсэд байрлуулах Дэлхийн өвийн танилцуулга самбар, тэмдэг тэмдэглэгээний стандарт загварыг шийдвэрлэхийг удирдах дээд байгууллагад уламжилах;

- Тус захиргааны ажилтнуудыг Соёлын өвийн үндэсний төв дээр БМСан бүрдүүлэх талаар дадлагажуулах сургахад хамтран ажиллах хүсэлт тавьсан.

1.2. *Эрдэнэ Зуу музейн БМСан бүрдүүлэлт дараах байдалтай байна. /Хавсралт №2/ Үүнд:*

- Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дэх заалт, Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлүүдийг үйлдсэн байна. /Хавсралт №2.1 Зураг 1-13/

- Өрөө тасалгааны зай талбайгаас хамааран тус музейн БМСан тусгайлан өрөө байхгүй, сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн санчийн албан өрөөнд төмөр шүүгээ сейфэнд бүртгэл, мэдээллээ хадгалж байна. Өрөөний багтаамжаас шалтгаалан илүү шүүгээ сейф байрлуулах боломжгүй байна. Сейфний түлхүүрийг тусгай хайрцагт хадгалдаг./Зураг 14-15/

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH програмын бүртгэл бүрдүүлэлтэд сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байх.

- RCH програмд оруулсан бүртгэлүүдээ хэвлэн, цаасан суурьтай ХН үүсгэн хадгалах.

- БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмындагуу товъёог хийсэн байна. Цахим хэлбэрийн бүртгэл, мэдээллүүдийн товъёогжуулалтыг улам бүр сайжруулах.

- БМСангийн сейф шүүгээнд төрөлжүүлэн хадгалсан бүртгэл, мэдээллээ эмх цэгцтэй хадгалах шаардлагатайг зөвлөсөн.

1.3 *Хөшөө Цайдам музейн БМСан бүрдүүлэлт дараах байдалтай байна. /Хавсралт №3/ Үүнд:*

- Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дэх заалт, Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлүүдийг үйлдсэн байна. /Хавсралт №3.1 Зураг 1-7/

- Тус музей нь БМСангийн бүртгэл, мэдээллүүдийг тусгайлсан өрөөнд, төмөр шүүгээ сейфэнд хадгалдаг. Сейфний түлхүүрийг тусад нь шүүгээнд хадгалдаг./Зураг 8-9/

- Тус музей байрлах Хөшөө цайдам орчимд интернет сүлжээгүй учраас RCH програмд бүртгэгдсэн бүртгэлээ интернет сүлжээтэй газар зөөвөрлөн дамжуулдаг онцлогтой.

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH програмын бүртгэл бүрдүүлэлтэд сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байхыг;

- RCH бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах шаардлагатайг;

- БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт бүрэн бус хийгдсэн байх тул Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2 дахь заалтууд; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 4.1-д заасны дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эмх цэгцтэй хадгалахад бүртгэлийн товъёог хийх шаардлагатайг тус тус зөвлөсөн.

1.4 *Хархорум музейн БМСан бүрдүүлэлт дараах байдалтай байна. /Хавсралт №4/ Үүнд:*

- Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дэх заалт, Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлүүдийг үйлдсэн байна. /Хавсралт №4.1 Зураг 1-5 ба Зураг 7-9/

- Тус музей нь орон нутгийн буюу Орхоны хөндий дэх Хархорин, Бат-Өлзийт, Хужирт сумын соёлын биет өвийг өвлөн уламжлагчдыг дүрс бичлэгээр баримтжуулан бүртгэж, СББӨ-ийн мэдээллийн сан бүрдүүлж байна./Зураг6/

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH програмын бүртгэл бүрдүүлэлтэд сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байхыг;

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2.5 дахь заалт “дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт”; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 6.3.9 дэх

заалт “Музейгээс гадаад, дотоодод гаргасан үзэсгэлэн” хавтасыг музейн БМСанд бүрдүүлэхийг;  
- БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт бүрэн бус хийгдсэн байх тул Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2 дахь заалтууд; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 4.1-д заасны дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эмх цэгцтэй хадгалахад бүртгэлийн товъёог хийх шаардлагатайг тус тус хэлж зөвлөсөн.

## *2. Музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын талаар:*

Эрдэнэ Зуу музей, Хөшөө Цайдам, Хархорум музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын талаар доорхи үзлэгүүдийг хийлээ.

- Барилга байгууламжийн гадна орчин-аюулгүй байдал хангасан эсэх. Камер, дохиолол, харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, ус зайлуулах хоолой, усны шугам, дээвэр хана, хаалга цонх

- Барилга байгууламжийн дотор орчин-аюулгүй байдал хангасан эсэх. Камер, дохиолол, харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, хаалга цонх, дулааны шугам шүлжээ, хортон шавьж, хана тааз, чийг дулаан.

- Сан хөмрөг, үзүүлэгийн танхим- Хадгалалт хамгаалалт, тавилга төхөөрөмж

## *Дүгнэлт:*

### *Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтийн хүрээнд:*

Эрдэнэ Зуу музей, Хөшөө Цайдам, Хархорум музей, Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны БМСангийн бүрдүүлэлтийн байдалд үзлэг хийж дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

Дээрх нэр бүхий байгууллагууд явуулах үйл ажиллагаа, музейн төрөл чиглэлийн хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дэх заалт, Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлүүдийг үйлдэн, БМСан сан бүрдүүлэлтийг ханган ажиллаж байна.

Эдгээр байгууллагуудад БМСанд цуглагдсан бүртгэл, мэдээллүүдээ архивын дүрэм журмын дагуу товъёогжуулаагүйгээс үзлэгийн үеэр бүртгэл, мэдээллүүдээ эрж хайх асуудалнийтлэг маш ихгарч байлаа.

Соёлын өвийн БМСан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах, аюулгүй найдвартай хадгалах орчин нөхцөлийг бий болгох, зохион байгуулах, цуглуулсан бүртгэл, мэдээллээ албан ажилд ашиглах, олон нийтийн хүртээл болгох зэрэгт архивын дүрэм, журмын дагуу БМСангийн дотоод бүртгэл, товъёогжуулалтыг хийх зайлшгүй шаардлагатай юм.

Иймээс БМСангийн бүрдүүлэлтийг сайжруулахад дараах зөвлөмж, шаардлагыг эдгээр байгууллагуудад хүргүүлэх, хуульд заасан шатлалын дагуу бүртгэл, мэдээллээ дамжуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр Соёлын өвийн үндэсний төвийн захиргаанд хүргүүлэх нь зүйтэй гэж ажлын хэсгээс үзэж байна.

### *Зөвлөмж, шаардлага:*

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага Монгол Улсын стандарт /MNS5634:2006/, Монгол Улсын музейн сан хөмрөгийн дүрэм, Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар, Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд бүртгэх журам, Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааварт тус тус заасан соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой заалтуудын хэрэгжилтийг хангах, хангуулахад дараах зөвлөмж, шаардлагыг Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Эрдэнэ Зуу музей, Хөшөө Цайдам, Хархорум музейн захиргаа удирдлага, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн санч нарт хүргүүлж байна.

- “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH бүртгэлийн програмд тухайн ондоо сэргээн засварлагдсан, хуулбарласан, үзэсгэлэнд оролцсон зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг бүртгэлд цаг тухай бүрд нь нэмж оруулж байхыг;

- Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Хөшөө Цайдам музей, Хархорум музейн БМСангийн бүртгэлүүдэд архивын дүрэм, журмын дагуу товъёогжуулалт хийгдээгүйбайх тул Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2 дахь заалт; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 4.1-д заасны дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд цуглагдсан бүртгэл, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эмх цэгцтэй

хадгалахад архивын дүрэм, журмын дагуу БМСангийн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэл, мэдээллүүдийн товъёог хийхийг;

- Эрдэнэ зуу музейн БМСан нь бүртгэл, мэдээллүүдээ архивын дүрэм, журмын дагуу товъёог бүртгэл хийсэн сайн талтай байна. Цаашид музейн удирдлага, сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн санч нар бүртгэл, мэдээллийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах, цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа бүртгэл, мэдээллийн товъёогжуулалтыг сайжруулахыг;

- Хөшөө Цайдам музей РСН програмын хэвийн үйл ажиллагааг хангахыг, БМСангийн компьютерийн хэвийн үйл ажиллагааг хангаж гэнэтийн цахилгааны саатал, эрсдлээс сэргийлж тог баригчтай болгохыг;

- Хархорум музейн захиргаа удирдлага, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн санч нарт Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2.5 дахь заалт “дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт”; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах зааврын 6.3.9 дэх заалт “Музейгээс гадаад, дотоодод гаргасан үзэсгэлэн” хавтасыг музейн БМСанд бүрдүүлэхийг;

- Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны удирдлага, ажилтнуудад БМСанд цуглагдсан бүртгэл, мэдээллийг ил задгай хадгалахгүй, зориулалтын лац, ломбо бүхий цоожтой, төмөр сейф шүүгээтэй болгож, эмх цэгцтэй хадгалах зөвлөмж, шаардлагыг тус тус хүргүүлж байна.

*Шийдвэрлэх шаардлагатай асуудал:*

Дээрх нэр бүхий 4 байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлтэд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны соёлын өвийн бүртгэл бүрдүүлэлтийн бүрдлийн хүрээнд:

- “Соёлын өвийн” гэдэг өргөн агуулгын хүрээнд ДӨОХСДГХЗахиргаа нь хамгаалалтын бүсэд дэх музей /ЭрдэнэЗуу, Хөшөө Цайдам, Хархорум/, Сумдын ОНСТанхим /Хархорин, Бат-Өлзийт, Хужирт, Хашаат, Хотонт/-уудын үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мөн хувийн өмчлөлийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлээр БМСан бүрдүүлэх.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1; 20.4; 20.6; 23.2 дахь заалтын хэрэгжилтийг Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, ЭрдэнэЗуумузей, Хөшөө Цайдам, Хархорум музей нь хэрхэн хангах тухайд. Үүнд:

- Одоогийн байдлаар Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Эрдэнэ Зуу музей, Хөшөө Цайдам музей, Хархорум музей нь бүртгэл, мэдээллээ “Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, уг санд бүртгэх тухай журам”-ын 4.10.2-т заасны дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шууд ирүүлж байгаа билээ.

- СӨХТХуулийн 20.1-д заасан шатлалын дагуу байгууллагын БМСан нь харьяалах сумын болон аймгийн БМСанд бүртгэл, мэдээллээ дамжуулах ёстой. Тус сумын БМСан бий болж үйл ажиллагаа нь төлөвшөөгүй байна. Дээрх байгууллагууд соёлын өвийн бүртгэл, мэдээллээ аймгийнхаа БМСанд дамжуулж дээрх хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

*Музейн орчны хадгалалт, хамгаалалтын хүрээнд:*

- Эрдэнэ Зуу, Хөшөө Цайдам, Хархорум музейн орчны хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын үзлэгийг хийснээр дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Эрдэнэ зуу музей нь 1586 онд сүм хийдийн зориулалтаар баригдсан барилга бөгөөд хундамент байдаггүй тул цаг уурын өөрчлөлтөөс дээвэр, хана, тааз муудаж суулт өгч цуурсан байна. Харуул хамгаалалт сайтай. Сан хөмрөгийн өрөөний хадгалалт хамгаалалт болох сав баглаа боодол, тавиур шүүгээ дутмаг.

- Үзүүлэгийн танхим дахь үзмэр дэглэлтэнд анхаарах зүйлс байна. Үзмэрийн шилэн хорго солих шаардлагатай. Цэвэрлэгээ хийх, авч зөөх боломжгүй, үзмэрийг сольж амраадаггүй, үзмэрүүд тоос шороонд дарагдан гандсан байна.

- Хөшөө цайдам музей нь харуул хамгаалалт сайтай. Барилгын хана тааз цуурсаныг харвал дээвэр асуудалтай байх магадлалтай. Мөн үүдний хэсгийн дээвэр дээр том хэмжээтэй усны сав байрлуулсан нь эрсдэлтэй байна.

- Хархорум музей нь музейн зориулалтаар баригдсан барилга байгууламжтай мөн Япон, Герман улсаас хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сав баглаа боодлын тусламж авдаг нь бусад музейд үлгэр дуурайлал болохоор харагдаж байна..

- Орчны хэмжилтын судалгааг Япон улсын судлаачдтай хамтран хийж байгаа. Музейн барилгын дээврийг хучсан чулуун хавтангууд борооны усанд гэмтэж үйрч бутарч байгаа тул анхаарах хэрэгтэй.




Дэлхийн өв- орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдал

Хавсралт №1


ДЭЛХИЙН ӨВ- ОРХОНЫ ХӨНДИЙН СОЁЛЫН ДУРСГАЛТ  
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

Огноо: 2016.09.12


№	Хөтлөгдөж байгаа бүртгэлийн жагсаалт	Хамрах хүрээ /он/	Бүртгэл, баримтжуулалт /+,-/		Тайлбар
			Цаасан суурьтай	Цахим хэлбэр	
<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.6; 20.8; 21.2.1; 21.2.2; 21.2.3; 21.2.4; 21.2.5; 21.2.6; 21.2.7;21.2.8; 21.2.9;21.2.10;21.2.11;</i>					
1	Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл -RICH програм хангамж		+	±	ТСҮХДБүртгэл(маягт№2)-д бүртгэсэн огноо, албан тушаалтны нэр бичээгүй. RICH цахим бүртгэлд гэрэл зураг дутуу орсон байна.
2	Үл хөдлөх дурсгалын гэрэл зургийн баримтжуулалт	2012-2017	+	+	
3	Үл хөдлөх дурсгалын дүрс бичлэгийн баримтжуулалт	2012-2017		+	
4	Археологийн малтлага судалгааны ажлын тайлан		+		Тайланг ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төвийн СӨУНБМСангаас хуулбарлан авсан.
5	Үзэсгэлэнгийн материал	2015-2017	+	+	
6	Соёлын биет өвийн уламжлагчдын тойм судалгаа	2015-2018	+	+	
7	Нүүдлийн соёл иргэншлийн судлан, сурталчлах үйл ажиллагааны тайлан		+	+	
<b>Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалтын байдал</b>					
2	БМСангийн бүрдүүлэлт		Хангагдсан эсэх /+,-/		Тайлбар
<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.10;21.3; 21.4; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.4.11</i>					
2.1	Цаасан суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН		-		
2.2	Цахим суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН		-		
2.3	БМСангийн өрөө тасалгаатай эсэх		-		
2.4	Соёлын биет ба биет бус өвийн бүртгэл, мэдээллүүдийг бүртгэлүүдийг лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээнд хадгалдаг эсэх		-		Ил задгай модон тавиурт бүртгэл, мэдээллийг хадгалдаг.
2.5	Төмөр шүүгээний түлхүүрийг тусгай сейфэнд хадгалдаг эсэх		-		
2.6	ХН-ийн хавтас, сав хангагдсан эсэх		+		
2.7	Төрөлжүүлэн хадгалсан эсэх /БМСангийн бүртгэлийг сэдэв, төрөл зүйл, он цагаар г.м/		±		Цуглагдсан бүртгэлийг үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвөөр төрөлжүүлэн ХН үүсгэн хадгалсан.



Зураг1-6. ДӨОХСДГХЗ-ны БМСангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл бүрдүүлэлтийн байдал



Зураг7. ДӨОХСДГХЗ-ны БМСанд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH-ийн дэд програм ажиллаж байна.



Зураг8. ДӨОХСДГХЗ-ны БМСанд хийгдсэн орон нутгийн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын судалгаа



Зураг9. ДӨОХСДГХЗ-ны БМСангийн бүртгэл, мэдээллүүдийн хадгалалтын байдал.

Хавсралт №2

ЭРДЭНЭ ЗУУ МУЗЕЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ





Огноо: 2018.09.13

№	Хөтлөгдөж байгаа бүртгэлийн жагсаалт	Бүртгэл, баримтжуулалт /+,-/		Тайлбар
		Цаасан суурьтай	Цахим хэлбэр	
1	<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.6; 20.8; 21.2.1; 21.2.4; 21.2.5; 21.2.6; 21.2.7; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.4.1; 12.4.5; 12.4.10; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 1.4.1; 6.3</i>			
1.1	Эд өлгийн зүйлийг хүлээн авах: -ББЗМаягт1-ээс ББЗМаягт8			2008 оноос хойш үзмэр баяжилт хийгдээгүй.
1.2	Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл	+	+	1966, 1997, 2003, 2007, 2012 оны ерөнхий бүртгэл
1.3	Үндсэн сан хөмрөгийн төрөлжсөн бүртгэл: 1.Шашны зан үйлийн 2.Сүм дуганы чимэглэлийн 3.Хөгжмийн зэмсгийн 4.Оёмол /зээгт наамал/ бүтээлийн 5.Танка зургийн 6.Сийлбэрийн 7.Баримал, шуумлын 8.Цутгамал, хөөмлийн 9.Шашны хувцас, хэрэглэлийн 10.Бусад /шаазан, сэнтий, гуу г.м/ <u>Түүх, соёлын үл хөдлөх дурсгал:</u> 11.Сум хийдийн барилга 12.Чулуун дурсгал	+	+	2003 оноос төрөлжсөн бүртгэл хийгдсэн.  Эрдэнэн Зуу музейн сүм хийдийн барилгууд, хашаан доторх чулуун дурсгалууд "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл"-ийн маягтаар хийгдсэн.
1.4	Судалгааны сан хөмрөгийн бүртгэл			Байхгүй
1.5	Сургалт, сурталчилгааны сан хөмрөгийн бүртгэл			Байхгүй




1.6	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл маягтын дагуу RCH– Registration of Cultural Heritage” програм хангамж (тоо, хувь)	±	+	1823 дэсийн 7464 үзмэрээс 1775 дэс буюу 97% RCH-д орсон. Хосгүй үнэтийн бүртгэл хэвлэсэн.
1.7	Үзлэг тооллого хийхэд хөтөлсөн баримт, бүртгэл, тайлан	+	+	
1.8	Дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт	+	+	
1.9	Судалгаа шинжилгээний ажлын тайлан	+		Эрдэнэ Зуу хийдийн барилгуудыг сэргээн засварласан хэмжилтийн зураг төсөл, ажлын тайлангууд “байнга”-д бий.
1.10	Үзмэр, эд өлгийн зүйлийн Гэрэл зургийн бүртгэл	+	+	
1.11	Үзмэр, эд өлгийн зүйлийн Дуу, дүрс бичлэгийн бүртгэл		+	
1.12	Үзмэр, эд өлгийн зүйлийн карт	+		ББЗМАЯГТ№30 Гар бичмэл карттай.
1.13	Үзүүллэг, үзэсгэлэнгийн байршлын хяналтын жагсаалт	+	+	ББЗМАЯГТ№31
1.14	Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт	+		ББЗМАЯГТ№33
1.15	Үзмэр эд өлгийн зүйлийн ашигласан байдлын бүртгэл	+	+	ББЗМАЯГТ№38
1.16	Сан хөмрөгийн өрөөнд орсон хүмүүсийн бүртгэл	+		Гар бичмэл бүртгэл
2	<b>Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалтын байдал</b>			
	<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.10; 21.4; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага)12.4.11; 12.4.18; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 4.1; 4.4</i>			
	<b>БМСангийн бүрдүүлэлт</b>	<b>Хангагдсан эсэх /+,-/</b>	<b>Тайлбар</b>	
2.1	БМСангийн өрөө тасалгаатай эсэх	-		
2.2	Бүртгэл хийхэд зориулагдсан: -компьютер, -гэрэл зургийн аппарат хэрэгсэл -Хэмжилтийн шугам, жин г.м	+		
2.3	ХН бүрдүүлэх хавтас, сав хангагдсан эсэх	+		
2.4	Үзмэр эд өлгийн зүйлийн актууд, Ерөнхий бүртгэл, Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлүүдийг: -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээтэй эсэх, -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээнд хадгалдаг эсэх	+	Энгийн төмөр шүүгээнд хадгалдаг. Өрөө тасалгааны талбай багтаамжаас шалтгаалж төмөр шүүгээ сейф нэмж байрлуулах зай талбай хүрэлцдэггүй.	
2.5	Төмөр шүүгээний түлхүүрийг тусгай сейфэнд хадгалдаг эсэх	+		
2.6	Төрөлжүүлэн хадгалсан эсэх /БМСангийн бүртгэлийг сэдэв, төрөл зүйл, он цагаар г.м/	+	БМСангийн 2 сейфэнд төрөлжүүлэн хадгалсан.	
2.7	Цаасан суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН	+	ЭрдэнэЗуу музейн БМСангийн бүртгэл, мэдээллийн товъёогжуулалт	
2.9	Цахим суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН	+	архивын дүрэм, журмын дагуу хийгдсэн бэйна.	

Эрдэнэ зуу музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдал




Зураг 1-5. Тус музейн БМСангийн бүртгэл, мэдээллүүдийн бүрдүүлэлтийн байдалаас.



Зураг 6-7. Тус музейн үзмэр, эд өлгийн зүйлийн гэрэл зураг, бүртгэл



Зураг 8-9. Тус музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн цахим мэдээлэл /нард диск, DVD-CD/



Зураг10-13. Тус музейн сүм хийдийн барилгын сэргээн засварлалтын ажлын тайлан бүрдүүлэлтийн байдал /сэргээн засварласан барилгын хэмжилт судалгааны зураг төсөл, тайлан зэрэг/



Зураг14-15. Тус музейд БМСангийн өрөө тасалгааны зай талбайгаас шалтгаалан бүртгэл, мэдээлэл хадгалах төмөр шүүгээ нэмж байрлуулах боломжгүй байна.

**ХӨШӨӨ ЦАЙДАМ МУЗЕЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН  
БҮРДҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ**



Огноо: 2018.09.14

№	Хөтлөгдөж байгаа бүртгэлийн жагсаалт	Бүртгэл, баримтжуулалт /+,-/		Тайлбар
		Цаасан суурьтай	Цахим хэлбэр	
1	<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.6; 20.8; 21.2.1; 21.2.4; 21.2.5; 21.2.6; 21.2.7; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.4.1; 12.4.5; 12.4.10; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 1.4.1; 6.3</i>			
1.1	Эд өлгийн зүйлийг хүлээн авах: -ББЗМаягт1-ээс ББЗМаягт8	±		Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг хүлээж авсан акт ББЗМаягт№7 үйлдэгдсэн.
1.2	Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл	+	+	
1.3	Үндсэн сан хөмрөгийн төрөлжсөн бүртгэл: 1.Археологийн, 2.Гэрэл зургийн, 3.Бүртгэлд тусгагдаагүй эд зүйлсийн,4.Туслах хэрэглэгдэхүүний сан хөмрөгийн.	+	+	
1.4	Судалгааны сан хөмрөгийн бүртгэл	+	+	
1.5	Сургалт, сурталчилгааны сан хөмрөгийн бүртгэл			байхгүй
1.6	Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл маягтын дагуу RCH Reigsitration of Cultural Heritage" програм хангамж (тоо, хувь)	+	+	145 дэсийн 175 үзмэр, 100 % програмд оруулсан./биднийг үзэх үед програм нээгдэхгүй байв./ "Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл"-ийн маягтын дагуу гар бичмэл бүртгэлтэй.
1.7	Үзлэг тооллого хийхэд хөтөлсөн баримт, бүртгэл, тайлан	+	+	
1.8	Дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт	+	+	
1.9	Судалгаа шинжилгээний ажлын тайлан	+		Түүх, археологийн хүрээлэн зэрэг газруудаас Билгэ хааны тахилын онгонд хийгдсэн малтлага хайгуулын судалгааны ажлын тайланг хувилан авч хадгалсан.
1.10	Үзмэр, эд өлгийн зүйлийн Гэрэл зургийн бүртгэл	+	+	
1.11	Үзмэр, эд өлгийн зүйлийн Дуу, дүрс бичлэгийн бүртгэл		+	
1.12	Үзмэр, эд өлгийн зүйлийн карт	+		ББЗМАЯГТ№30 Гар бичмэл карттай.
1.13	Үзүүллэг, үзэсгэлэнгийн байршлын хяналтын жагсаалт	+	+	ББЗМАЯГТ№31
1.14	Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт	+		ББЗМАЯГТ№33
1.15	Үзмэр эд өлгийн зүйлийн ашигласан байдлын бүртгэл	+	+	ББЗМАЯГТ№38

1.16	Сан хөмрөгийн өрөөнд орсон хүмүүсийн бүртгэл	+		Гар бичмэл бүртгэл
1.17	Орхоны хөндий дэх Хархорин, Бат-Өлзийт, Хужирт сумын Соёлын биет өвийг өвлөн уламжлагчдын бүртгэл, дүрс бичлэг	+	+	
2	<b>Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалтын байдал</b>			
	<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.10; 21.4; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.4.11; 12.4.18; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 4.1; 4.4</i>			
	БМСангийн бүрдүүлэлт	Хангагдсан эсэх /+,-/		Тайлбар
2.1	БМСангийн өрөө тасалгаатай эсэх	+		
2.2	Бүртгэл хийхэд зориулагдсан: -компьютер, -гэрэл зургийн аппарат хэрэгсэл -хэмжилтийн шугам, жин г.м	+		
2.3	ХН бүрдүүлэх хавтас, сав хангагдсан эсэх	+		
2.4	Үзмэр эд өлгийн зүйлийн актууд, Ерөнхий бүртгэл, Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлүүдийг: -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээтэй эсэх, -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээнд хадгалдаг эсэх	+		Энгийн төмөр шүүгээнд хадгалдаг.
2.5	Төмөр шүүгээний түлхүүрийг тусгай сейфэнд хадгалдаг эсэх	+		
2.6	Төрөлжүүлэн хадгалсан эсэх /БМСангийн бүртгэлийг сэдэв, төрөл зүйл, он цагаар г.м/	+		
2.7	Цаасан суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН	±		
2.8	Цахим хэлбэрийн бүртгэлийн товъёогжуулалт, ХН	±		

Хөшөө Цайдам музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдал





Зураг 1-5. Тус музейн БМСангийн бүртгэл, мэдээлүүдийн бүрдүүлэлтийн байдлаас.



Зураг 6-7. Тус музейн БМСангийн үзмэр, эд өлгийн холбогдолтой бүртгэлүүд цахим хэлбэрээр



Зураг 8-9. Тус музейн БМСангийн бүртгэл, мэдээлэл хадгалах сейф ба бүртгэн баримтжуулалтын материал хэрэгслээ хадгалдаг тавиур



Зураг10. Хөшөө Цайдам музей нь үүдний амрах хэсэгтээ үзэгчдэд зориулан ил номын сан байгуулсан нь монголын түүх, соёлын өвийн талаарх мэдлэг, мэдээллийг үзэгчдэд хүргэх, тэдний таашаалд нийцсэн үйлчилгээ болсон байна.

Хавсралт №4

### ХАРХОРУМ МУЗЕЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ

Огноо: 2018.09.14

№	Хөтлөгдөж байгаа бүртгэлийн жагсаалт	Бүртгэл, баримтжуулалт /+,-/		Тайлбар
		Цаасан суурьтай	Цахим хэлбэр	
1	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.6; 20.8; 21.2.1; 21.2.4; 21.2.5; 21.2.6; 21.2.7; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.4.1; 12.4.5; 12.4.10; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 1.4.1; 6.3			
1.1	Эд өлгийн зүйлийг хүлээн авах: -ББЗМаягт1-ээс ББЗМаягт8	+	+	
1.2	Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл	+	+	
1.3	Сан хөмрөгийн төрөлжсөн бүртгэл: 1.Археологийн олдворын, 2.Дүрслэх урлагийн бүтээлийн, 3.Түүх, соёлын хосгүй үнэт үзмэрийн, үнэт металл, үнэт эрдэнийн чулуу бүхий үзмэрийн, 4.Туслах сан хөмрөгийн,	+	+	
1.4	Судалгааны сан хөмрөгийн бүртгэл	+	+	
1.5	Сургалт, сурталчилгааны сан хөмрөгийн бүртгэл	+	+	
1.6	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл маягтын дагуу RCH Reigstration of Cultural Heritage” програм хангамж (тоо, хувь)	±	+	698 дэсийн 1324 үзмэртэй. RCH-д 734 дэсийн үзмэр бүртгэгдсэн байна. Зөрүүг нягтлах тулгах шаардлагатай. RCH -ээс зөвхөн хосгүй үнэт хэвлэгдсэн.
1.7	Үзлэг тооллого хийхэд хөтөлсөн баримт, бүртгэл, тайлан	+	+	

1.8	Дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт			СӨХТХуулийн 21.2.5 дахь заалт, "Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар"-ын 6.3.9 дэх заалтыг хангаагүй.
1.9	Судалгаа шинжилгээний ажлын тайлан	+		
1.10	Үзмэр, эд өлгийн зүйлийн Гэрэл зургийн бүртгэл	+	+	
1.11	Үзмэр, эд өлгийн зүйлийн Дуу, дүрс бичлэгийн бүртгэл		+	
1.12	Үзмэр, эд өлгийн зүйлийн карт	+		ББЗМАЯГТ№30 Гар бичмэл карттай.
1.13	Үзүүлэлт, үзэсгэлэнгийн байршлын хяналтын жагсаалт	+	+	ББЗМАЯГТ№31
1.14	Үзмэр, эд өлгийн зүйлийг түр гаргах, буцаах акт	+		ББЗМАЯГТ№33
1.15	Үзмэр эд өлгийн зүйлийн ашигласан байдлын бүртгэл	+	+	ББЗМАЯГТ№38
1.16	Сан хөмрөгийн өрөөнд орсон хүмүүсийн бүртгэл	+		
2	<b>Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалтын байдал</b>			
	<i>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.10; 21.4; МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.4.11; 12.4.18; Музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар 4.1; 4.4</i>			
	БМСангийн бүрдүүлэлт	Хангагдсан эсэх /+,-/		Тайлбар
2.1	БМСангийн өрөө тасалгаатай эсэх	-		
2.2	Бүртгэл хийхэд зориулагдсан: -компьютер, -гэрэл зургийн аппарат хэрэгсэл -Хэмжилтийн шугам, жин г.м	+		
2.3	ХН бүрдүүлэх хавтас, сав хангагдсан эсэх	+		
2.4	Үзмэр эд өлгийн зүйлийн актууд, Ерөнхий бүртгэл, Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлүүдийг: -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээтэй эсэх, -лац ломбо, цоож бүхий шатдаггүй төмөр шүүгээнд хадгалдаг эсэх	+		Өрөөний зай талбайгаас шалтгаалж БМСангийн бүртгэл, мэдээллүүдийг 2 хэсэг газарт төмөр шүүгээнд хадгалдаг.
2.5	Төмөр шүүгээний түлхүүрийг тусгай сейфэнд хадгалдаг эсэх	+		
2.6	Төрөлжүүлэн хадгалсан эсэх /БМСангийн бүртгэлийг сэдэв, төрөл зүйл, он цагаар г.м/	+		
2.7	Цаасан суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН	±		
2.8	Цахим суурьтай бүртгэлийн товъёогжуулалт, ХН	±		



Хархорум музейн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн байдал



Зураг 1-2. Тус музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлүүдээс.



Зураг 3-5. Үзмэр, эд өлгийн зүйлийн цахим бүртгэлээс -цахим бүртгэлийн товъёог ба хаягжуулалт



Зураг 6. Орон нутгийн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын бүртгэл, мэдээлэл



Зураг 7-9. Тус музейн БМСангийн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, мэдээлэл ба хадгалалтаас.

## ЭРДЭНЭ ЗУУ МУЗЕЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Сөн хөмрөгийн өрөө

Огноо: 2018.-9-13

№	Асуулга	Хангасан +/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.		-	Хоёр талын хана өвөлдөө хөлдөж хөлөрдөг тул толботсон
1.2	Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа музейн захирал удирдах байгууллагатай барилга эзэмших, хамгаалах талаар гэрээ байгуулна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.2	+		
1.3	Сан хөмрөг, үзүүллэгт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)10.3	+		Дамждаг өрөөнд байрладаг
1.4	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		
1.5	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага) 17.4; 17.5	+		
1.6	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага) 17.6	+		
1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага) 17.7	+		Дохиолол хамгаалалтын хэрэгсэл сайтай
<b>2</b>	<b>Сан хөмрөгийн өрөөний орчин</b>			
2.1	Сан хөмрөгийн өрөө нь барилгын хулгай дээрэм, үер, гамшигт өртөхөөргүй хэсэгт байрлана. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага) 12.9.2	+		

2.2	Сан хөмрөгийн өрөө нь давхар хаалга, цоожтой, ашиглалтгүй илүү хаалга цонхгүй, бэхлэгээтэй цонхтой салхивч агааржуулагчтай байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		
2.3	Сан хөмрөгийн өрөө нь зориулалтын тавиур шүүгээтэй, үнэт зүйл хадгалах хүндрүүлэгч бүхий сейфтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		Тавиур, шүүгээ дутмаг
<b>3</b>	<b>Үзүүлэлт ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
3.1	Музейн үзүүлэлт ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.4	+		14 хоног тутамд цэвэрлэгээ хийдэг
3.2	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.6	+		
3.3	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэлтийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7	+		Чийгшил хэмжигч багажны цаасыг сар бүр сольдог
3.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9	+		
3.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/	+		дунд
3.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		Жилд 2 удаа Хавар, намар
3.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		

Сан хөмрөгийн өрөөний хадгалалт, хамгаалалт-Нэмэлт тэмдэглэл

Хосгүй үнэт үзмэрүүд хүндрүүлэгч сейфтэй, орчин үеийн цацдаг галын хортой 3ш, харуулууд тодорхой цаг тутамд үзэг дарж уншуулдаг хамгаалалтын төхөөрөмжтэй.


Анхаарах зүйлс



Том хэмжээний зээгт наамалууд танка зурагнууд торгондоо ороолгоостой давхарлан тавьсан



Үзмэрүүдийг дээр дээр нь давхарлан тавьсан



Өгсөн зөвлөмжүүд:

- хоргонд байрлуулсан хосгүй үнэт үзмэр /дээл/-ийг бүтээх
- төрөл зүйлээр ялган байрлуулах тавиур нэмж хийх
- Сав баглаа боодол хийх \ялангуяа металл бурхад\
- Үзмэрүүдийг давхарлан тавихгүй байх
- Үзмэр боох цаасны хүчил шүлтийг шалгах

Хавсралт №5.1

ЦАМБА, АЮУШИЙН СУМИЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-13

№	Асуулга	Хангасан +/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.		-	Дээр үеийн барилга тул хундамент байдаггүй тул улирал бүрд өөрчилөлт өгч цууралт үүссэн
1.2	Сан хөмрөг, үзүүллэгт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)10.3	+		Аюулгүй байдлыг бүрдүүлсэн /хамгаалалтын систем/
1.3	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		

1.4	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.4; 17.5	+ + +		
1.5	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.6		-	
1.6	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 17.7	+		
<b>2</b>	<b>Үзүүлэгийн танхимын орчин</b>			
2.1	Үзүүлэгийн орчин тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 14.7		-	
2.2	Гэрлийн гэмтлээс хамгаалах арга хэмжээ /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 1.4/ цонх хаалт хөшигтэй эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрэл бага хоргонд байрлуулсан эсэх үзэгчгүй үед үзмэрийн танхимын гэрэл унтраадэг эсэх гэрэл мэдрэмтгий үзмэр, бөс даавуу эдлэл зэргийн өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгадаг эсэх, хугацаа гэрэлд эмзэг, мэдрэмтгий үзмэр байнга тавихгүй үе үе солих, орлуулах буюу хуулбар байрлуулах арга хэрэглэдэг эсэх үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулж байгаа эсэх	+ + + + +	-	Хаалга онгорхой үед байгалийн гэрэл ихээр ордог  Шилэн хорго шаардлага хангахгүй  Солих үзмэрүүдийг сэргээн засварлуулах шаардлагатай
<b>3</b>	<b>Үзүүлэг ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
3.1	Музейн үзүүлэг ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.4		-	Жилд 1 удаа боловч цэвэрлэхэд хүндрэлтэй
3.2	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага) 12.9.6		-	Шинэчилэн байрлуулахаар төлөвлөж байгаа

3.3	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэгийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7		-	Хийхээр төлөвлөж байгаа
3.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9		-	
3.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/		-	
3.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		

Цамба, Аюушийн сүмийн орчны хадгалалт, хамгаалалт-Нэмэлт тэмдэглэл

Анхаарах зүйлс:



Өгсөн зөвлөмж:

- Планшеттай зургандаа тулгуур хийх
- Зээгт наамлуудын дэглэлтийг засах
- Хананд хадаасаар хадаж тогтоосон үзмэрийг горимын дагуу зөв өлгөх
- Үзмэрийн танхим зохих ёсны дагуу биш, шилэн хаалт авч тавих цэвэрлэгээ хийх

боломжгүй тул заавал солих шаардлагатай

- Үзмэрүүдийг амраах, сэргээн засварлалтанд оруулах
- Байгалийн гэрлээс хамгаалж хаалгыг байнга хааж байх

БАРУУН ЗУУ, ГОЛ ЗУУ, ЗҮҮН ЗУУГИЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ


Огноо: 2018-9-13

№	Асуулга	Хангасан +/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.	+		
1.2	Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа музейн захирал удирдах байгууллагатай барилга эзэмших, хамгаалах талаар гэрээ байгуулна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.2	+		
1.3	Сан хөмрөг, үзүүллэгт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)10.3	+		Аюулгүй байдлыг сайн хангасан.
1.4	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		
1.5	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.4; 17.5	+	- -	Гал унтраах хэрэгсэл сайтай
1.6	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.6		-	
1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.7	+		Дохиолол камераас гадна харуул хамгаалагчид тогтмол хугацаанд үзэг дардаг төхөөрөмж ашигладаг
<b>2</b>	<b>Үзүүллэгийн танхимын орчин</b>			
2.1	Үзүүллэгийн орчин тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)14.7	+		Энгийн шилэн хорготой

2.2	Гэрлийн гэмтлээс хамгаалах арга хэмжээ /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар1.4/ цонх хаалт хөшигтэй эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг цонхноос хол байрлуулсан эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрэл бага хоргонд байрлуулсан эсэх үзэгчгүй үед үзмэрийн танхимын гэрэл унтраадаг эсэх гэрэл мэдрэмтгий үзмэр,бөс даавуу эдлэл зэргийн өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгадаг эсэх, хугацаа гэрэлд эмзэг, мэдрэмтгий үзмэр байнга тавихгүй үе үе солих,орлуулах буюу хуулбар байрлуулах арга хэрэглэдэг эсэх үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулж байгаа эсэх	+		Тойрч гороолдог хэсгийн цонх гэрэл бууруулагчтай, дотор талын цонх гэрэл бууруулагчгүйгээс гадна Гол зуугийн нэг цонх шилгүй гялгар хулдаасаар хаасан байсан. Хөшиггүй.
3	<b>Үзүүлэлт ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
3.1	Музейн үзүүлэлт ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.4	+		Жилд 1 цэвэрлэгээ хийдэг
3.2	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.6	+		
3.3	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэлтийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7	+		
3.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9	+		
3.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/		-	
3.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		
3.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		

Баруун, Гол, Зүүн зуугийн орчны хадгалалт, хамгаалалт-Нэмэлт тэмдэглэл

Анхаарах зүйлс



Цонхны хаалтыг гялгар уутгаар орлуулсан



Сумын барилгын ирмэгээр ургамал ургасан





Хадаасаар хадаж тогтоосон, сэмэрч урагдсан, баганы чимэглэл зураг урагдаж ховхорсон. Бадам, жанцан их урагдаж муудсан тул сэргээн засварлаж амрах шаардлагатай.

Хавсралт № 5.3

ДАЛАЙ ЛАМЫН СҮМИЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-13

№	Асуулга	Хангасан +/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.	+		
1.2	Сан хөмрөг, үзүүллэгт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага)10.3	+		
1.3	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		
1.4	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.4; 17.5	+	-	
1.5	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.6		-	
1.6	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.7	+		Дохиолол хамгаалалт сайтай
<b>2</b>	<b>Үзүүллэгийн танхимын орчин</b>			
2.1	Үзүүллэгийн орчин тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)14.7	+		Стандартын дагуу шинэчилэн тохижуулсан

2.2	Гэрлийн гэмтлээс хамгаалах арга хэмжээ /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар1.4/ цонх хаалт хөшигтэй эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг цонхноос хол байрлуулсан эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрэл бага хоргонд байрлуулсан эсэх үзэгчгүй үед үзмэрийн танхимын гэрэл унтраадэг эсэх гэрэл мэдрэмтгий үзмэр,бөс даавуу эдлэл зэргийн өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгадаг эсэх, хугацаа гэрэлд эмзэг, мэдрэмтгий үзмэр байнга тавихгүй үе үе солих,орлуулах буюу хуулбар байрлуулах арга хэрэглэдэг эсэх үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулж байгаа эсэх	+		
<b>3</b>	<b>Үзүүлэлт ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
3.1	Музейн үзүүлэлт ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.4	+		
3.2	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.6	+		
3.3	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэлтийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7	+		
3.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9	+		
3.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/		-	
3.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		
3.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		


*Далай ламын сүмийн орчны хадгалалт, хамгаалалт-Нэмэлт тэмдэглэл*

Үзмэр дэглэлт \танка\ буюу бурхадуудын дараалал буруу байсныг засах зөвөлөгөөг өгсөн.

## ХӨХ СҮМИЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-13

Хөх сүм музейн хадгалалт, хамгаалалтын горим нь дээрхи сүмүүдтэй ижил байлаа. Үзмэрийн танхим дахь эд өлгийн зүйлийн дэглэлт нь бусад сүм музейнүүдээс харьцангуй сайн байсан. Шилэн хорго нь хаалгатай тул дотор талыг цэвэрлэх боломжтой.



Хөх сүмийн үзмэрийн хорго доторхи эмх цэгцтэй, сэргээн засварлагдсан том хэмжээний рамтай танка зургуудыг тулгуур хийж хөдөлгөөнгүй бэхлэж өгсөн. Гомбогүр бурханыг бүтээлээс хөндий стандартын дагуу жаазлан байрлуулсан.

## ЖАНРАЙСЭГ СҮМИЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-13.

Жанрайсиг сүмийн хадгалалт, хамгаалалтын горим нь дээрхи сүмүүдтэй ижил байлаа. Сүмийн дээвэр засварт орсон.



*Шилэн хорго нь хаалгатай тул цэвэрлэгээ хийхэд давуу талтай*

*Гадна хана дээр зурж гэмтээсэн*

*Орчны өвс ургамлыг цэвэрлэх шаардлагатай.*



*Рамтай зурганд тулгуур бэхлэгээ хийх, танка зурагний дээд дог модыг солих хэрэгтэй.*

## ЛАВИРАН МӨРГӨЛИЙН СҮМ ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-13

Хадгалалт, хамгаалалтын ямар ч горим байхгүй, барилга нь муудаж засварт орохоор төлөвлөгдөж байгаа. Дээврээс ус гоождог. Лавиран сүмд Эрдэнэ Зуу музейн үзмэр бүтээлүүд өлгөөтэй байх ба Лавирангийн дээд давхаруудад 1965 оны үед бүтээгдсэн шуумал барималууд хадгалагдаж байна. Шашны хурал, номонд ашиглагдаж байсан зарим танка зургуудын хадгалалтын горим алдагдсан тул Эрдэнэ Зуу музейн захиргаа татан авч сан хөмрөгтөө байршуулсан.



*Хэмжээ таараагүй жаазанд хийсэн, тоос шороо, утаа тортогонд харласан бохирдолтой байна.*



*Дээд давхаруудад хадгалагдаж буй 1965 онд бүтээгдсэн цаасан шуумал бурхдууд*



*Дээвэрээсээ ус гоожсоны улмаас дээвэр голоороо суулт өгсөн. Тулгуур багана ба хана цуурсан, цонхнууд хөшиг хаалтгүй онгорхой байлаа.*

## ХӨШӨӨ ЦАЙДАМ МУЗЕЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018-9-14.

	Асуулга	Хангасан +/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.	+		
1.2	Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа музейн захирал удирдах байгууллагатай барилга эзэмших, хамгаалах талаар гэрээ байгуулна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.2			
1.3	Сан хөмрөг, үзүүлэлт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)10.3			
1.4	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		
1.5	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.4; 17.5	+		
1.6	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.6		-	Халуунаар үлээх кондиншэнтэй. Түүнийг ажилуулдаггүй
1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.7	+		
<b>2</b>	<b>Сан хөмрөгийн өрөөний орчин</b>			
2.1	Сан хөмрөгийн өрөө нь барилгын хулгай дээрэм, үер, гамшигт өртөхөөргүй хэсэгт байрлана. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.2	+		

2.2	Сан хөмрөгийн өрөө нь давхар хаалга, цоожтой, ашиглалтгүй илүү хаалга цонхгүй, бэхлэгээтэй цонхтой салхивч агааржуулагчтай байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		
2.3	Сан хөмрөгийн өрөө нь зориулалтын тавиур шүүгээтэй, үнэт зүйл хадгалах хүндрүүлэгч бүхий сейфтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		
<b>3</b>	<b>Үзүүлэгийн танхимын орчин</b>			
3.1	Үзүүлэгийн орчин тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)14.7	+		
3.2	Гэрлийн гэмтлээс хамгаалах арга хэмжээ /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар1.4/ цонх хаалт хөшигтэй эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг цонхноос хол байрлуулсан эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрэл бага хоргонд байрлуулсан эсэх үзэгчгүй үед үзмэрийн танхимын гэрэл унтраадаг эсэх гэрэл мэдрэмтгий үзмэр,бөс даавуу эдлэл зэргийн өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгадаг эсэх, хугацаа гэрэлд эмзэг, мэдрэмтгий үзмэр байнга тавихгүй үе үе солих,орлуулах буюу хуулбар байрлуулах арга хэрэглэдэг эсэх үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулж байгаа эсэх	+	-	Даавуу зөөлөн эдлэл байхгүй
<b>4</b>	<b>Үзүүлэг ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
4.1	Музейн үзүүлэг ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.4	+		
4.2	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.6	+		
4.3	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэгийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7	+		
4.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9	+		
4.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/		-	

4.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		
4.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		

Хөшөө Цайдам музейн орчны хадгалалт, хамгаалалт-Нэмэлт тэмдэглэл


Анхаарах зүйлс:



Үзүүлээгийн танхимын тааз цуурсан



Сан хөмрөгийн өрөөний тааз цуурсан



Шилэн хоргонд шавьжтай.



Билгэ хааны бичээсийн тайлбартай самбар харлаж  
бүдгээрсэн.

Хавсралт №7

ХАР ХОРУМ МУЗЕЙН ОРЧНЫ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Огноо: 2018.09.14

№	Асуулга	Хангасан /+/	Хангаагүй -/	Тайлбар
<b>1</b>	<b>Музейн барилга ба аюулгүй байдлын шаардлага</b>			
1.1	Музей барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, соёлын өвийг хадгалах нийтэд үйлчлэх шаардлага хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.1.	+		
1.2	Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж байгаа музейн захирал удирдах байгууллагатай барилга эзэмших, хамгаалах талаар гэрээ байгуулна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)7.1.2	+		

1.3	Сан хөмрөг, үзүүллэгт тохирсон байр, төхөөрөмжтэй, аюулгүй байдлыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)10.3	+		
1.4	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалыг 2 жил тутамд шалгадаг эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.1	+		
1.5	Музей нь: Галын хор Утааны мэдрэгч Аврах шат, хаалга, байршлын тойм зураглал Яаралтай мэдээ дамжуулах цахилгаан холбоотой эсэх. 2 жил тутамд аюулгүй байдлын үзлэг хийдэг эсэх. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.4; 17.5	+ + + + +		
1.6	Музейн барилга агааржуулалтын системтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.6	+		
1.7	Музейн барилга байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт хадлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)17.7	+		
<b>2</b>	<b>Сан хөмрөгийн өрөөний орчин</b>			
2.1	Сан хөмрөгийн өрөө нь барилгын хулгай дээрэм, үер, гамшигт өртөхөөргүй хэсэгт байрлана. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.2	+		
2.2	Сан хөмрөгийн өрөө нь давхар хаалга, цоожтой, ашиглалтгүй илүү хаалга цонхгүй, бэхэлгээтэй цонхтой салхивч агааржуулагчтай байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		
2.3	Сан хөмрөгийн өрөө нь зориулалтын тавиур шүүгээтэй, үнэт зүйл хадгалах хүндрүүлэгч бүхий сейфтэй байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.3	+		
<b>3</b>	<b>Үзүүллэгийн танхимын орчин</b>			
3.1	Үзүүллэгийн орчин тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)14.7	+		



3.2	Гэрлийн гэмтлээс хамгаалах арга хэмжээ /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар1.4/ цонх хаалт хөшигтэй эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг цонхноос хол байрлуулсан эсэх гэрэл мэдрэмтгий дурсгалт зүйлийг гэрэл бага хоргонд байрлуулсан эсэх үзэгчгүй үед үзмэрийн танхимын гэрэл унтраадэг эсэх гэрэл мэдрэмтгий үзмэр,бөс даавуу эдлэл зэргийн өнгө нь алдагдаж байгаа эсэхийг шалгадаг эсэх, хугацаа гэрэлд эмзэг, мэдрэмтгий үзмэр байнга тавихгүй үе үе солих,орлуулах буюу хуулбар байрлуулах арга хэрэглэдэг эсэх үүсмэл буюу цахилгаан гэрлийн хэмжээг зохих горимын дагуу тохируулж байгаа эсэх	+		
<b>4</b>	<b>Үзүүлэлт ба Сан хөмрөгийн нийтлэг шаардлага</b>			
4.1	Музейн үзүүлэлт ба сан хөмрөгийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журамтай эсэх МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.4	+		
4.2	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө дулаан, чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл, агааржуулах, чийгшүүлэх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.6	+		
4.3	Үзүүлэлтийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дуулан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэлтийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.7	+		
4.4	Дулаан, чийг хэмжигч хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байна. МУ-ын стандарт (MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавихшаардлага)12.9.9	+		
4.5	Агаарын бохирдолтоос хамгаалж байгаа эсэх /Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 3.2/	+		
4.6	Хортон шавьжнаас хамгаалж байгаа эсэх / Музейн үзмэрийг хадгалж хамгаалах заавар 4.1,4.2,4.3,4.4,5.2/	+		
4.7	Сэргээн засварлагдсан үзмэрийн хадгалалтын байдал	+		

#### Хархорум музейн орчны хадгалалт, хамгаалалт- Нэмэлт тэмдэглэл

Тус музейн сан хөмрөгийн өрөө хадгалалт, хамгаалалт үлгэр жишээ сайн байлаа. Япон улсын Нарагийн институтээс орчны судалгаа хийгдэж байгаа. Сан хөмрөгт Япон болон Герман улсуудаас хайрцаг сав баглаа боодлын тусламж үзүүлж байна. Дулаан чийгшлийг өдөрт 2 удаа хэмжиж тэмдэглэл хөтөлдөг.

Анхаарах зүйлс:



Дээвэр дээрхи чулуун тавцан хучлага борооны усанд элэгдэж бутарч байгаа.



Чийг дулаан хэмжигч, галын хор газар байрласан.



Чийг дулаан хэмжигч, галын хор газар байрласан.



Үзүүлэгийн танхимын хоргон доторхи металл үзмэр эзвэнд идэгдэж байгаа.

ЭРДЭНЭ ЗУУ, ХӨШӨӨ ЦАЙДАМ, ХАРХОРУМ МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГИЙН  
ТАНХИМ, САН ХӨМРӨГИЙН ӨРӨӨНИЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ,  
ДУЛААН, ЧИЙГШЛИЙН ХЭМЖЭЭ

/MNS: 5634-2006. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. 12.9.11; 12.9.12

№	Үзмэр, эд өлгийн зүйлийн материал	Гэрэлтүүлэг /Люкс/	Дулаан °C/	Чийгшил %/
1	Даавуу, усан будгийн зураг, цаас, будсан арьс, хуучирсан эд зүйлс	50 люкс хэтрэхгүй	15-18 °C	50-55 %
2	Тосон болон темпр зураг, арьс, лак, ноос, яс, төмөр	200 люкс хэтрэхгүй	15-18 °C	50-55 %

Огноо: 2018.09.13-14

№	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө болон үзмэрт	Дулаан °C/	Чийгшил %/	Тайлбар
1	Эрдэнэ зуу музейн сан хөмрөг	18-17C	50-57%	Хэвийн
2	Эрдэнэ зуу музей	20C	60%	Чийгшил их /сүмийн хаалга үзэгчтэй үед онгорхой байдагтай холбоотой байна.
3	Хөшөө цайдам музейн сан хөмрөг	10C	35%	Чийгшил багатай, хүйтэн
4	Хөшөө цайдам музейн үзүүлэгийн танхим	10C	55%	Үзүүлэгийн танхим хүйтэн сэрүүн

5	Хар хорум музейн сан хөмрөг	20С	55%	Бага зэргийн дулаан, чийгшил хэвийн, сайн тохируулдаг.
6	Хар хорум музейн үзүүлэгийн танхим	20С	50%	Бага зэргийн дулаан, чийгшил хэвийн, сайн тохируулдаг.

#### 1.4. Соёлын биет бус өвийн бүртгэл, програм хангамж бий болгох.

*СББӨ-ийн бүртгэлд нэмэлт баяжуулалт хийх, СББӨ-ийн бүртгэлийн програм хангамжийн техникийн өгөгдөл, бодлогын даалгаврыг шинэчлэн боловсруулах.*

Соёлын өвийн үндэсний төвийн захиралын 2018 оны 11 дүгээр сарын А/85 тоот тушаалын дагуу СББӨ-ийн бүртгэлийн программын техникийн өгөгдөл болон бодлогын даавгаврыг боловсруулж Сайберандро-меда ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр веб програмыг хүлээн авсан.

*ich.monheritage.mn* веб програм нь Улс, аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд ямар нэгэн програм суурилуулахгүйгээр интернет орчинд шууд ажилладаг байхаар бүтээгдсэн ба програмд оруулсан мэдээллийн тоон дүн, 5 ай сав, төрөл, зүйл, өвлөгчдийн болон өвийн тархалтын газрын зургийг гаргах, гэрэл зураг, дүрс бичлэгийн санг баяжуулах, бүртгэлийг төрөлжүүлэх, мэдээллийг богино хугацаанд боловсруулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Энэхүү програм нь Засгийн газрын 541 тоот Бүртгэл батлах тухай тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” маягтай уялдуулан бүртгэлийг хийх ба өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн мэдээллийг өгөгдөл (тоон дүн, 5 ай сав, төрөл, зүйл, нас, хүйс, тархалт)-ийн дагуу цуглуулж нэгтгэн боловсруулах, улсын хэмжээнд төвлөрүүлэх давуу талтай.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН БҮРТГЭЛИЙН ПРОГРАММ:

##### Зорилго:

Монгол улсын хэмжээнд байгаа Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн нэгдсэн бүртгэлийг тоон системд оруулах, өгөгдлийн дагуу мэдээлэл цуглуулах, цуглагдсан мэдээллийг богино хугацаанд нэгтгэн боловсруулахад энэхүү веб програмын зорилго оршино.

##### Зорилтууд:

- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчийн бүртгэлийн мэдээллийг нэгдсэн тоон системд оруулах
- Улсын хэмжээнд СББӨ-ийн мэдээллийг өгөгдөл (5 ай сав, төрөл, зүйл, тархалт)-ийн дагуу цуглуулах
- Өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн мэдээллийг өгөгдөл (тоон дүн, 5 ай сав, төрөл, зүйл, нас, хүйс, тархалт)-ийн дагуу цуглуулах
- 21 аймаг, 9 дүүргийн өвлөгчдийн болон өвийн тархалтын газрын зургийг гаргах
- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчийн бүртгэлээр дамжуулан гэрэл зураг, дүрс бичлэгийн санг баяжуулах
- Веб програмд бүртгэгдсэн СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн тоон дүн, тархалт зэрэг өгөгдлийг богино хугацаанд гаргах, боловсруулах
- СББӨ-ийн болон өвлөн уламжлагчдын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах.

### Веб програмын ерөнхий зарчим

- Бүртгэлийн програм нь ich.monheritage.mn хаяг бүхий веб-сайт (веб-програм) хэлбэртэй байна.
- Интернет орчинд ажиллана.
- Энэхүү програм нь Аймаг, нийслэл, сум дүүрэгт орших СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн мэдээллийг тусгайлан бэлдсэн өгөгдлийн дагуу авч хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, тоон дүнг богино хугцаанд гаргах, тархалтыг газрын зурагт буулгах, тоон дүнг график, хүснэгт, хувь хэмжээгээр гаргахад зориулагдсан.
- Энэхүү програмыг СББӨ болон өвлөн уламжлагч, өвлөн суралцагчыг бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага /аймгуудын БСУГ, музей, соёлын төв, нийслэлийн СУГ, дүүргүүдийн соёлын төв/ ашиглаж бүртгэлийг хийнэ.
- Веб програм нь гэрэл зураг, дүрс бичлэгийн өгөгдөл оруулах боломжтой.
- Бүртгэл хийх техникийн үзүүлэлт: Фонт: Arial, үсэг, тооны хэмжээ: 12, гэрэл зураг: татаж оруулахаар, дүрс бичлэг: татаж оруулахаар байна.
- Веб програм нь ирээдүйд нэмэлт, өөрчлөлт хийгдэх боломжтой байхаар хийгдэнэ.
- Аймаг, нийслэл тус бүр өөрсдийн нэвтрэх нэр, нууц үгтэй байна. Нэвтрэх нэр, нууц үгийг Соёлын өвийн үндэсний төвөөс олгоно. Тухайн хэрэглэгч зөвхөн өөрийн харьяаллын /21 аймаг, 9 дүүрэг/ өвлөн уламжлагчийн бүртгэлийг оруулах ба гадны хэрэглэгч нэвтрэх боломжгүй байхаар хийгдэнэ.

### Програмын ач холбогдол:

- Энэхүү програм нь монгол улсын хэмжээнд СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийг бүртгэх бүртгэлийн нэгдсэн тоон систем бий болно.
- Энэхүү програм нь Аймаг, нийслэл, сум дүүрэгт орших СББӨ, өвлөн уламжлагч, өвлөн суралцагчийн мэдээллийг тусгайлан бэлдсэн өгөгдлийн дагуу авч хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, тоон дүнг богино хугцаанд гаргах, тархалтыг газрын зурагт буулгах, тоон дүнг график, хүснэгт, хувь хэмжээг гаргах
- СББӨ утсан тохиолдолд түүнийг сэргээхэд шаардлагатай бүхий л баримт мэдээлэл, онцлог шинжийг бодитой авсан гэрэл зураг, дүрс бичлэг нь бүртгэлийн програмд хадгалагдан үлдэх ач холбогдолтой.

## **1.5. "Рашаан хад" соёлын өвийн дурсгалт, түшиц газар бий болгох судалгаа**

*Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дэвсгэрт Соёлын өвийн дурсгалт газар бий болгох тандалт судалгаа хийх СББӨ-ийн төрөл зүйл болох буриад угсаатны "Ёохор" бүжгийн уламжлалыг судлах (Батширээт, Биндэр, Дадал) Эрдэм шинжилгээний бага хурлыг "Рашаан хад" соёлын өвийн дурсгалт газар зохион байгуулах. -СББӨ-ийн төрөлжсөн бүртгэн баримтжуулалт хийх*

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/46 тоот тушаал, Соёлын өвийн үндэсний төв, Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёл, Урлаг Судлалын Хүрээлэн хооронд 2018 оны 02 дугаар сарын 08-ний өдөр байгуулсан "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн "2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"- ний 6 дугаарт заасан "Ёохор бүжгийн олон улсын наадам, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах" ажлын хүрээнд тус төвийн мэргэжилтнүүд Соёл, урлаг судлалын хүрээлэн, Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг Даргын Тамгын Газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Соёлын төвтэй хамтран "Ёохор бүжгийн өнөөгийн байдал, хэтийн төлвийг тодорхойлох нь" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, судалгааны ажлыг Батширээт сумын иргэд, Буриад зоны дунд 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулав.

Энэхүү эрдэм шинжилгээний хурал, судалгааны ажлын зорилго нь Буриад

зоны дуут бүжиг Ёохор-оор дамжуулан залуу хойч үед Соёлын биет бус өвийн мэдлэг, ойлголтыг өгөх, Ёохор бүжгийг уламжлалт хэлбэрээр ахмад үеэс залуу хойч үед өвлүүлэн уламжлуулахад орон нутгийн иргэд, холбогдох албан тушаалтны оролцоог тодорхойлох, Ёохор бүжгийн нутаг нутгийн хувилбар, дууны урын сангийн судалгаанд хэрэглэгдэхүүн цуглуулах, Соёлын Өвийн Улсын Нэгдсэн Бүртгэл Мэдээллийн санд хадгалах байв.

Эрдэм шинжилгээний бага хурал, судалгааны ажлыг зохион явуулах баг Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 07 дугаар сарын 4-ний өдөр баталсан “Удирдамж”-ийн дагуу Батширээт суманд ажиллав /хавсралт 1/. Багийн бүрэлдэхүүнд, Соёлын өвийн үндэсний төвөөс Ц.Цолмон гадаад харилцаа, олон нийт хариуцсан мэргэжилтэн, Ж.Насанжаргал Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн, П.Чинбат Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын техникч, С.Сайнзолбоо (нярав, жолооч) нар ажиллав. Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгээс тус хүрээлэнгийн захирал Ш.Эрдэнэцэцэг нар ажиллав.

Эрдэм шинжилгээний бага хурал, судалгааны ажлыг доорхи хөтөлбөрийн дагуу Батширээт сумын “Иргэний Танхим”-д зохион явуулав. Хурлыг нээж Хэнтий аймгийн Батширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Гансүрэн, Монгол Улсын Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал Ш.Эрдэнэцэцэг нар үг хэлэв.

Тус хуралд Батширээт сумын иргэд, сумын ЗДТГ, ИТХ, Ёохор наадмын ерөнхий ивээн тэтгэгч “Батширээт нутгийн хөгжлийн сан” ТББ-ын төлөөлөл нийт 16 хүн оролцов.



Зураг 1. Хуралд оролцогчидын зарим төлөөлөл

Хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүд:

Бага хурлын эхний илтгэлийг “Соёлын өвийн үндэсний төвийн СӨУНБМС дахь Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээлэл- Батширээт сумын жишээн дээр” сэдвээр Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал хуралд оролцогчидод тавив. Илтгэлээр, соёлын өв, соёлын өвийн ангилал, соёлын биет бус өвийн хэлбэрүүд, Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенци, Монгол Улсаас ЮНЕСКО-д бүртгэгдсэн өвийн талаар ерөнхий мэдээллийг хуралд оролцогчидод өгснөөс гадна Батширээт сумаас соёлын өвийн УНБМС бүртгэгдсэн соёлын биет бус өв тээгчдийн мэдээллийг танилцуулав.



Зураг 2. “Соёлын өвийн үндэсний төвийн СӨУНБМС дахь Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээлэл-Батширээт сумын жишээн дээр” Илтгэгч Ж.Насанжаргал

Хурлын хоёр дахь илтгэлийг “Монгол үндэстний язгуур бүжгийн төрөл зүйл, онцлог” сэдвээр Монгол Улсын Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал Ш.Эрдэнэцэцэг оролцогчидод тавилаа. Илтгэлээр Соёл, урлаг судлалын хүрээлэнгээс зохион явуулсан “Монгол бүжгийн өв уламжлал, төрөл зүйл”-ийн судалгааны явц, үр дүнг Монгол Ойрадын бий, Буриадын Ёохор, Хорчин Андай, Шинжаан Савардан, Халимаг бий, Ордос бүжгийн онцлог тус бүр дээр ярьж, таницуулав.



Зураг 3. “Монгол үндэстний язгуур бүжгийн төрөл зүйл, онцлог” илтгэгч Ш.Эрдэнэцэцэг

Тус хурлын сүүлийн илтгэлийг “Ёохор бүжгийн уламжлал, түүний өнгөрсөн, өнөө, ирээдүй” сэдвээр Соёлын өвийн үндэсний төвийн гадаад харилцаа, олон нийт хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон хуралд оролцогчидод тавьсан. Ёохор бүжгийн уламжлалыг Монгол Улс, ОХУ-ын Буриад улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны Шинэхээн Буриад зон хэрхэн тодорхойлж байгааг, өнөөдөр Ёохор бүжгийн Буриад зоны амьдрал ахуйд үзүүлж байгаа ач холбогдол, үүрэг роль ямар байгааг судалсан судалгааны ажлын үр дүн, тухайлбал бүжгийн дууны шүлэг, хөгжмийн аялгуу, хөдөлгөөний анализ, өмнө хийгдсэн сурвалж судалгаа, зэрэгт тулгуурлан Ёохор бүжгийн уламжлал хэрхэн өөрчлөгдөж, хувирч байгааг хуралд оролцогчидод танилцуулав. Өнөөдөр Буриад зоны Ёохор бүжгийн уламжлалт хэлбэр мартагдаж, өөрчлөгдсөн нь 1600-аад оны сүүл үеэс Орос, Манж Чин гүрний газар нутгаа тэлэх бодлого, 1930-аад оны сүүл үед Сталины ОХУ-ын Буриад улсад явуулсан орослох бодлого, Зөвлөлтийн зүгээс Монголд улсад явуулсан улс төрийн хэлмэгдүүлэлттэй шууд холбоотойг тус судалгааны үр дүнд

тогтоосон юм. 1690 оноос 1980 оны сүүл хүртэлх хугацаанд явагдсан энэхүү нийгэм, улс төрийн өөрчлөлт, зориудаар явуулсан бодлоготой холбоотойгоор Буриад хэл аялга, соёл уламжлал арчигдан мартагдахад хүрч, 2010 онд Буриад хэл / аялга ЮНЕСКО-ийн Устаж буй Дэлхийн хэлний атласт багтсан юм. Буриадын дуут Ёохор бүжиг нь хэл аялга, хөгжим, хөдөлгөөний цогц илэрхийлэл болсон зан үйлийн бүжиг байсан хэдий ч өнөөдөр энэ уламжлал хэл аялга, холбогдох зан үйлийн хамт мартагдаж байгааг тус илтгэлд судалгааны үр дүнд тулгуурлан танилцуулсан юм.

“Ёохор бүжгийн уламжлал, түүний өнгөрсөн, өнөө, ирээдүй”

Эрдэм шинжилгээний бага хурал хөтөлбөрийн дагуу явагдаж, үдээс хойш Батширээт сумын Буриад зоны Ёохор бүжгийн хэв намбыг судлах судалгааны ажил хийх байсан хэдий ч Батширээт сумын баяр наадмын бэлтгэл ажил давхцсан, амралтын үе таарсан зэрэг шалтгаанаас Ёохор бүжгийн өвлөгчид тус хуралд төдийлөн идэвхитэй оролцож чадаагүй юм.



Зураг 4. “Ёохор бүжгийн уламжлал, түүний өнгөрсөн, өнөө, ирээдүй” илтгэгч Ц.Цолмон

Тиймээс хөтөлбөрийн дагуу “Ёохор” бүжгийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох; 2019 онд зохион байгуулагдах “Ёохор” наадамд Соёлын өвийн үндэсний төв, СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэн, Батширээт сумын Засаг Даргын Тамгын Газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хамтын ажиллагааг тодорхойлох хэлэлцүүлгийг хийв.

Өнөөдөр Батширээт суманд Ёохор наадмаас бусад үед Ёохор хатирах боломж бололцоо, орчин байхгүй, мөн Ёохор бүжгээ уламжлалт хэлбэрээр дуулж бүжиглэдэг хүн тун цөөн, залуу хойч үед өвд өвлүүлж уламжлуулах ажил зохион байгуулагддаггүйг хуралд оролцсон иргэд хэлж байв. Тиймээс Батширээт нутгийн иргэдийг Ёохор наадамд үлгэр үзүүлж, өөрсдөө Буриад хэлээрээ дуулж бүжиглэх, тус наадмаас өмнө Батширээт сумын багийн наадам, сургуулийн урлагийн үзлэг, уул, овооны тахил тайлгад Ёохор хатрах уламжлалыг бий болгох, зарим уламжлыг сэргээх шаардлагатай гэсэн саналыг сумын иргэдийн зүгээс сумын удирдлагад хэлж байв.

Мөн хэлэлцүүлгийн үеэр Ёохор бүжгийн олон улсын хурлыг Улаанбаатар хотод 2018 ондоо багтаан Соёлын өвийн үндэсний төв, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулах санал санаачлагыг Батширээт сумын ИТХ-ын төлөөлөлийн зүгээс гаргасныг “Батширээт нутгийн хөгжлийн сан” ТББ-ын төлөөлөл дэмжиж ажиллах боломжтойгоо илэрхийлсэн юм.

Хурлын төгсгөлд 2019 онд болох Ёохор наадамд дараах зөвлөмжийг Батширээт сумын иргэд Буриад зон, Батширээт сумын ИТХ, Соёлын өвийн үндэсний төв, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгээс дараах зөвлөмжийг “Ёохор” наадмын зохион байгуулагчид болон Батширээт сумын ЗДТГ, ИТХ-д хүргүүлэхээр болов.

Нийт оролцогчдын зүгээс “Ёохор” наадмын удирдамжинд оруулах буюу наадмын зохион байгуулагчид хүргүүлэх санал, зөвлөмж

1. Заавал Буриад хэл аялгаараа дуулж бүжиглэх гэдэг шалгуурыг наадмын “уламжлалт” хэлбэрээр бүжиглэх ангилалд оруулах.
2. Буриад хэл / аялгаар дуулж, бүжиглэж байгааг шалгах сайн Буриад хэлтэй хүмүүсийг шүүгчээр суулгах.
3. Булган, Сэлэнгэ, Дорнод, Хөвсгөл аймгуудад амьдарч байгаа Буриад зоныг “Ёохор” наадамд оролцуулах, уриалах .
4. Буриадын өв соёлыг хамгаалах чиглэлээр ажилладаг судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагуудтай “Ёохор” наадмын зохион байгуулалт дээр хамтарч ажиллах.
5. Наадмын хугацааг 2 хоног биш 5 өдөр болгож, эрдэм шинжилгээний хурал (судалгааны ажлын хэлэлцүүлэг), бүжгийн уралдаан зохион явуулахаас гадна, мөн наадамд оролцогчид туршлага судлах буюу “Соёлын солилцоо” явуулах нөхцөл бололцоог бий болгож өгөх.

Сумын иргэдээс Батширээт сумын Засаг даргын тамгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх санал, зөвлөмж

1. Батширээт сумын ЗДТГ, ИТХ “Ёохор” наадмын зохион байгуулалтыг хариуцахдаа идэвхи санаачлагатай оролцох /тухайлбал наадмын баримтжуулалтыг хийх, оролцогчдын жагсаалтыг гаргах гэх мэт/
2. Батширээт сумын Буриад зон “Ёохор” наадамд үлгэрлэл үзүүлж, Буриад хэл аялгаараа дуулах, бүжиглэх
3. Ёохор наадмын өмнө сургуулийн урлагийн үзлэг, багуудын наадам, овоо тахилга дээр Ёохор хатирах уриалгыг гаргах
4. Буриад хэл / аялга устаж байгааг зохих шатны байгууллагад уламжлах, ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн хичээлд угсаатны онцлогийг тусгасан хөтөлбөр оруулах.

**1.6. СББӨ, Соёлын олон төрөл зүйлийг хамгаалах судалгаа.**

*СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагддаг төрөлжсөн наадам, баяр ёслолыг судлах, баримтжуулах, “Мөнгөн шагшуурга 2018”, Ховд аймагт, “Бүргэдийн баяр” Баян-Өлгий аймагт, “Цайны зам”, Ховд аймагт, Суль, Сульхарын гурил боловсруулан уламжлалт арга технологийг судлах, баримтжуулах, Говь-Алтай аймаг, Хөхторьт, Баян-Уул сумдад*

Соёлын өвийн өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А/10 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг Ховд аймгийн Жаргалант, Буянт, Манхан сумд ажиллаж Ховд аймгийн угсаатны бүлгийн соёлын биет бус өвийн зарим төрөл зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан.

Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл судалгааны газрын мэргэжилтэн Ж.Насанжаргал, Мэдээлэл технологи, аюулгүй байдлын газрын техникч П.Чинбат, зураглаач Т.Даваа-Очир нар 2018 оны 2 дугаар сарын 24-нөөс 2 дугаар сарын 27-ны өдрийг дуустал ажилласан.

СББӨ-ийн зарим төрөл зүйлсийг баримтжуулах баг удирдамжид заасны дагуу Ховд аймгийн угсаатны бүлгийн онцлог, төрөл зүйлийг харуулсан 304.8 минутын /монтажлаагүй/ дүрс бичлэг, 918 ширхэг цахим гэрэл зургаар баримтжуулан УНБМСанд 46 гэрэл зургийг сонгон авч архивлан хадгалав.

Ховд аймгийн нутаг Жаргалант сумын нутагт орших Жаргалант уулын өвөр хатан Хар ус нуурын эрэг дээр 2018 оны 2 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Мөнгөлөг шагшуурга 2018” мөсний баярын үйл ажиллагаанд Ховд аймгийн 8 угсаатны 18 сумдын 700 орчим төлөөлөл түүх соёл, ёс заншил, өв уламжлалаа сурталчилсан ба нийт 15000 мянган хүн уг үйл ажиллагааг үзэж сонирхсон байна.

2 дугаар сарын 24-ны өдөр

Баримтжуулах баг 2 дугаар сарын 24-ны өдөр тус үйл ажиллагааны нээлт,



Урианхайн мөсөн сурын ганцаарчилсан төрлийн харвааны үйл явцын гэрэл зураг, дүрс бичлэгийг хийж мөсөн сурын харвааны талаар өвлөн уламжлагч Б.Эрдэнээс яриа сурвалжлага авсан.

## 2 дугаар сарын 25-ны өдөр

09-14 цагийн хооронд Хар ус нуурын эрэгт үргэлжилсэн Урианхайн мөсөн сурын багийн төрлийн харвааг гэрэл зургаар баримтжуулсан.

Алтайн Урианхайн уламжлалт тоглоом болох 100 цааст хэзрийг баримтжуулах талаар Ховд их сургуулийн багш доктор М.Ганболдтой урьдчилан зөвлөлдсөн байсан тул 2 дугаар сарын 25-ны өдрийн үдээс хойш буюу 17 цагт Ховд хотоос 25км-ийн зайтай Буянт сумын 5-р баг /норжин хайрхан/-ийн Шаргын тохоо гэх газарт амьдардаг малчин Төрбатын Энхтайван гэх айлд 18 цагт ирэв. М.Ганболд багш урьдчилан мэдэгдэж бэлдүүлсэн ч тус тоглоомыг 14 хүний бүрэлдэхүүнтэй тоглодог тул зарим саахалт айлын хүмүүс хонь малаа хотлуулж амжаагүй байсан тул хараахан ирээгүй байлаа.



100 цааст хэзрийг баримтжуулахад орой болж нэмэлт гэрэл тавих шаардлага гарч машин асааж 12 ватт-ыг 220 ватт-руу хөрвүүлэгчээр дамжуулан 4 цаг орчим гэрэл асаав.

Т.Энхбайваныд 10 айлын гэр бүлийн нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй тоглож үзүүлэв. Эдгээр хүмүүс нь хуучнаар алтайн баруун амбан буюу Дархан бэйсийн хошууны уугуул урианхайчууд буюу одоогийн Баян-Өлгий аймгийн Алтай сумаас нүүдэллэн Ховд аймгийн Буянт суманд ирж сууришсан Алтайн урианхайчууд юм.

Тус нутгийн өндөр настан Буяндэлгэрийн Чулуун-Очир 100 цааст хэзрийн тайлбар, дүрмийг хэлж дүрс бичлэгт бичүүлсэн.

100 цааст хөзөр. Тус хэзрийг мөрийтэй тоглодог. Мөрий нь ирэг, сэрх, бусад зүйл байж болно. Мөрийгөө авсан тал нь таваг, идээтэй очино. Алдсан тал нь хоол ундаа хийгээд хүлээж авна. Хүмүүс 100 цааст хэзрийг айл гэрийнхээ сүлд хийморийг сэргээх зорилгоор Зул сар болон цагаан сараар тоглодог. Гэртээ хүмүүс цуглуулаад тогловол сайн болно гэдэг. Хөзөр тоглохын өмнө айл саахалтын хүмүүст зар тараана. 100 цааст хөзрөөр 14 хүн хоёр тал болоод салаавчлан сууж наадна. Хөзөрт тамга, ноён, хатан (агь гэнэ), цэрэг (боол), китад (хятад), шивэг (зарц, шивэгчин) гэсэн зургаан хүн модноос гадна 2-20 хүртэл нүдэн хөзөр багтаж нэг нь 4 гэж үзэхэд нийтдээ 100 ширхэг хөзөр буюу мод болно. 100 хөзрөөр наадах учир ингэж нэрлэсэн бололтой. Хөзөр наадахдаа орчин цагийн хөзрийн бунданг Кызыл, Дөрвөлжинг Буйман, Гилийг Хөлт, Цэцэгийг Сархай гэнэ.



Тоглогчид тоглохын өмнө гараа угааж цэвэрлээд, хөзөрөөс адис авна. Тоглохдоо 1 хүнд 7 хөзөр хувааж, ажил хийсэн хүн хамгийн сүүлд өөрийн гарт үлдсэн ганц хөзрийг

эргүүлэн хөзөр гаргана. Тоглоом эхлэхэд хамгийн бага настай хүн эхлэж нар ургах зүгээс зөв тойруулан хуваана. Хуваахдаа эсрэг талын тоглогчдоо хөзөрөө дарж байгаад сугалуулна. Сугалуулна гэдэг нь хуваах хөзөрөө хоёр таслуулна, таслах гэсэн үг юм. Нэг удаагийн тоглолт 7 идээтэй. 14 хүн бүгдээрээ хуваана. Үүнийг Аш гэдэг. 49 идвэл хоёр тал тэнцэж 50 идсэн тал шүүнэ. Ажил хийсэн хүний дараагийн хүн тус эрнэ. Тус хайна гэж бас байна. Тус гэж хөзрийн тамгыг хэлнэ. Тухайн гарсан хөзрийнхээ хамгийн бага нүдээр тусыг ирнэ. Үүний дараа тус ирсэн хүн тусаа хаяна. Тус ирээгүй нөхцөлд тусаа хаявал хүчингүйд тооцно. Үүнийг түлэх, түллээ гэнэ. Тусыг ирэх газаргүй тохиолдолд хамгийн бага нүдэн модоо доош харуулан тавина. Үүнийг бүрхэх гэнэ. Муу модыг бурс мод гэнэ. Бүрхсэн тохиолдолд ажил хийсэн хүн гарынхаа модноос хүч өгч тусаа эрнэ. Хүч гэдэг нь бурсын тамга, ноён, хатан, цэрэг гэх мэтийг хэлнэ. Тамга ирсэн тал нь эсрэг талынхаа хүнд хүчээ өгнө. Хүчийг ажил хийсэн хүний дараагийн хүнээс эхлэн өгдөг. Хүч өгсөн тохиолдолд хөзрийн ноён байвал иднэ. Идэж чадахгүй бол идэг харилаа гэнэ. Хүчийг хөзрийнхөө дүү нүдээр идэх буюу тусгалдаж иддэг. Тусгалдаж идэх гэдэг жишээ нь цэцгийн ноён өгсөн бол цэцгийн тамгаар идэх гэх мэт. 2-3 идэг идсэний дараа 4-5 хөзөртэй хүн нүүр бүтнэ. Нүүр бүтсэн хүн өөрийнхөө талд өгсөн хүчийг идэж болно. Хөзрийн ноён ганцаараа ирвэл үүнийг эсрэг талынхаа хүнд харуулахгүй. Ийм ноёныг Бээжилсэн ноён гээд нүүрийг доош харуулан урдаа тавина. Энэ ноён амарч яваа гэсэн утгатай юм.

100 цааст хөзрийн тухай М.Ганболд (Ховд их сургуулийн профессор, доктор (Ph.D))-ын хээрийн судалгаа явуулж, удиртгал тайлбар хийсэн, Б.Баатархүү (СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D))-ийн эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн “Ойрад монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн - II”-ийн 206-208 талд тодорхой тэмдэглэсэн байна.

### 2 дугаар сарын 26-ны өдөр

Ховд аймгийн Жаргалант сумын бичигт багийн 9-57 тоотод оршин суух малчин, өндөр настан Тувагийн Донгак овогт Пинээгийн Эрднээ гэх айлд Тува угсаатны цагаан сарын ёс заншилын талаар сурвалжлах, дүрс бичлэг хийхээр Ховд их сургуулийн багш М.Ганболд багшаар газарчлуулан ирэв.

### Цагаан сарын ёс.

Бид бол урианхайн 7 хошуудын нэг Алтайн Тува урианхай гэдэг зарим нь хатуу хэлтэй ч урианхай ч гэдэг. Яагаад гэвэл олон хэлээр ярьдаг Урианхайчууд бол урианхай хэлээрээ ярьдаг харин бид хасаг, монгол, тува 3-ыг нийлүүлж ярьдаг учраас бусад Урианхайгаас хэл яриа, ёс заншилаар ялгаатай. Тийм учраас цагаан сарын шинэлэх ёс, битүүний талаар хийж үзүүлье.

Цагаан сар хийхийн тулд малаа гаргаад, банш бууз, ууцныхаа мах, бусад махыг намар мал тарган байхад үүцэлж мал төллөх үеэр үүцээ задалж иддэг.

Битүүний өдөр харьт чөмөг чанаад, хөшиглөөд бууз, банштайгаа айлуудаар явуулаад харьт чөмөгнийхөө хишиг чөмгөнд ордог талыг нь хагалаад битүү хагарлаа “битүү хагарч цагаан сар эхэллээ”, “золголт эхэллээ” гэж бэлгэддэг.

Харийн хүнд харьт чөмөг тавьдаггүй гэдэг нь бүтүүг цагаан сараар түүгээр задалж хийж өгсөн байн нь.



Шинийн нэгний өглөө эрчүүд нь балин, овоон /Хошууны овоо гэж ганц том овоо бий/ дээрээ үр хүүхэдтэйгээ гарч золгодог, эмэгтэйчүүд нь гэртээ үүдэндээ сан тавьж гэртээ мөргөдөг учиртай. Овоон дээр идээнийхээ дээжийг алтай дэлхийдээ өргөж гэртээ ирээд золгоцгоодог.

Шинийн гурванд цагаагаа мордуулж байна гэж ах дүүсээрээ цуглаад дэлгэсэн идээ, будаагаа хураадаг. Шинийн гурванаас цааш цагаа гэж байдаггүй, бид бөөгийн шашинтай учраас хураадаг. Гэрт байгаа идээнийнээ муу муухай зүйл байдаг бол алтай, дэлхийдээ өргөчхөөд сайн сайхан цагааныг нь авчирч гэртээ ах дүү төрөл саданд дэлгэж тавьж байна гэсэн үг.

Шинийн гурвандаа өндөр настан, авга, нагац нартаа багтаж золгоод дуусдаг онцлогтой.

Цагаан сараар мах, дээр үед бол “шанзай” гээд хавтгай, дөрвөлжин боов, урианхайчууд бол сүлжмэл боов тавьдаг байсан. 7-9 үеээр бол занги, тайж нар тавьдаг байсан. Одоо бол худалдааны хэвийн боов тавьж байна. Одоо хийе гэхээр цэцэрлэг, сургуулийн хүүхэд маллаж байна, хүүхдүүд ажилтай болхоор зав их муутай болсон байна.

Заавал ууц, сүүл тавих алба байдаггүй, ууц төлөөлдөг махнууд байна. Ууцыг үүрч явдаг сүүж, дунд чөмөг, нуруу нь байж байна, сүүл гэдэг бол гоёоны л юм.

Настай улсууд бол ууц тавидаг, ууц тавихааргүй залуу айл, дунд зэргийн айлууд бол сүүж, дунд чөмөг, цагаан мах тавидаг. Ууцанд өндөр настай хүн хөнддөг.

Мэндлэх, хүндлэх, цээрлэх ёсны хувьд бол Тува хэл болон бөөгийн шашингаараа өөр, ерөнхийдөө бусад үгсаатнуудтай адилхан. Цагаан сараар уурлаж уцаарладаггүй хүүхэд, нохой загнадаггүй, хараал хэлдэггүй юм бүхнийг цагаанаар бэлгэдэж байдаг.

Сээр хавс гэдэг нь залуучуудын хүч чадлыг үздэг. хавс гэдэг нь харцагаа чанаад ирсэн залуусын чадлыг шалгадаг нагац тал явуулдаг, Харцага бол ууц төлөөлдөг учраас нагац талд тавьж өгдөг. Мөн шагай чөмөг хугалдаг, хуга татдаг, гишгэж татах, эрт үед бол мундаг хүчтэй бөхчүүд шууд татдаг байсан.

Шагай чөмгийг ууцны баруун талд тавьдаг, гэрийн сүлд хийморийг хадгалж явдаг гэдэг утгаар, далийг бол нагац талаа хүндэлж ууцны зүүн талд тавьдаг.

Хишиг мах гэж байна. Хонинд явсан малчин хүнд залаа махтай нь баруун талаасаа 3 дахь уннд хадганд ороогоод хавчуулж хадгалдаг. Эсвэл хонинд явахдаа боогоод аваад явдаг. Яагаад хишиг мах гэхээр чөмөгний голд ясны завсар байгаа зайнд мод хавчуулаад тэр нь хоньчин байна гэдэг. Мар хариулж яваа хүнийг хишиг сайн уу гэж мэндэлдэг.

#### Үүц задлах:

Үүцийг эрэгтэй хүн задалж тогоонд хийж өгнө, эмэгтэйчүүд нь болгож тавьдаг. Айлаас орж ирсэн бэр гал дээрээ зүүн талыг эрхэлдэг, гэрийн эзэн баруун талыг эрхэлдэг. Ямар ч настай хүн байсан нагац талаа илүү хүндэлдэг, нас нь бага өлгийтэй балчир хүүхэд байсан ч очиж золгодог. Яагаад гэвэл хэвлий дагаж гарсан цусан төрөл учраас их хүндэлдэг ёстой.

Үүцээ хийхдээ малынхаа махыг гүзээнд нь хийж уринд идүүлэхгүйгээр хадгалж хавар төлийн баяраар гаргаж иддэгээрээ бусад угсаатнаас ялгаатай. Хавар мал төллөх үеэр үүцээ задалж иддэг. Залуу айлууд настангуудаа урьж үүцээ задлуулж хүндэтгэл үзүүлдэг.

Хэвтээ мах буюу өвчүүг бөхчүүд, эрэгтэй хүн иддэггүй яагаад гэвэл малын



гэдэс дотор, бүх махыг авч явдаг учраас.

Үүцэнд: Өвчүү, Сүвээ хавирга, Шагай чөмөг, Булчин мах, Сүвээний сүүл, дунд чөмөг, Сүүж, Дөрвөн өндөр, Харьт чөмөг, нуруу, Тойгтой мах, тойггүй мах гэх мэт хонины мах том жижгээсээ шалтгаалан бүгд гүзээндээ багтдаг.

Тува угсаатны Эрэгтэй дээл, Авгай, Эхнэр дээл, Гутал, Хүүхдийн дээл, хурганы арьсан малгайн тайлбарийг Буянт сумын 1-р багийн малчин Хэнзээ овогтой Буянхишиг хэлж бичүүлэв.

#### Хөөрөг тахилга:

Манайд байгаа энэ хөөрөг 9, 10-аад үе дамжаад ирсэн байдаг. Донгак гэдэг ястан энэ хөөргийг цахилгааны галаар энэ хөөргийг асаасан гэдэг түүх байдаг юм. Тува нарын Соёлын биет бус өвийн гол онцлог ялгарах шинж болсон Хөөрөг тахилгын зан үйлийн тухай М.Ганболд (Ховд их сургуулийн профессор, доктор (Ph.D))-ын хээрийн судалгаа явуулж, удиртгал тайлбар хийсэн, Б.Баатархүү (СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D))-ийн эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн “Ойрад монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн - I”-ийн 258-261 талд тодорхой тэмдэглэсэн тул энэхүү тайланд дурдсангүй.

#### Тоглоом наадгай:

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын харьяат 1962 онд төрсөн Даваажавын Чулуунбаатар. Одоо Ховд аймгийн жаргалант сумын “Баатар хайрхан” багт амьдардаг. Уламжлалт тоглоом наадгайг сонирхон цугцуулж яваа өвлөн уламжлагчыг дүрс бичлэгээр баримтжуулан авч 3-12 насны хүүхдүүдийг шагай тоглож байгаагаар зохиомжлон гэрэл зургаар баримтжуулсан.

#### Тууль, цуурын гэрэл зураг:

Баян-Өлгий аймгийн Сагсай харьяат Ховд аймгийн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч Туульч, цуурч Э.Мэндбаярын тууль хайлж байгаа, цуурдаж байгаа гэрэл зургийг Ховд хотоос баруун зүгт 5км зайд орших уулан дээр зохиомжлон авсан болно.



#### 2 дугаар сарын 27-ны өдөр

Сульхарын гурил боловсруулах уламжлалт арга технологийг баримтжуулах зорилгоор өвлөгчдийг сурвалжилан Манхан суманд нэг айл байна гэснээр өглөө 9 цагт Манхан суманд байгаа гэх айлруу хөдлөж 11 цагийн үед очив.

Ховд аймгийн Манхан суманд амьдардаг Аргалжийнхан овогтой Ядамсүрэнгийн Дарьжав гэх айлд ирцгээв. Я.Дарьжав Сурьхарын сурил боловсруулах уламжлалт арга технологи нь Хөх тарианы гурил хийх аргатай зарчимын хувьд адилхан, манай нутагт сульхарын гурилыг хүнсний хэрэгцээнд маш бага хэмжээгээр боловсруулж хэрэглэдэг. Сурьхар нь элсэнд ургадаг учраас манай нутагт бага ургадаг тул өргөнөөр хэрэглэдэггүй харин хөх тарианы гурилыг ээж ааваасаа өвлөн авч одоог хүртэл тариалан уламжлалт аргаар боловсруулан өөрсдийн болон сум орон нутгийн хэмжээнд нийлүүлэн худалдаалж байна.

#### Сульхарын гурил:

Дээр үед манай захчингууд Тооройн элсэнд ургасан сульхарыг түүж хүнсэндээ хэрэглэдэг байсан. Түүхдээ юм дэвсэж байгаад савуураар дээш нь хөдөлгөхөд сурьхар нь элстэйгээ ундаг. Элснээсээ ялгаж авахдаа савтай усанд хийхэд элс нь доош унаж сульхар нь дээрээ хөвж үлддэг. Ингэж ялгаж аваад хатаагаад тогоондоо хуураад дараа нь тээрэмдэж гаргаж авдаг. Сурьхар нь байгалаас ургасан учир олон талийн ач холбогдолтой. Хүний гэдэс, ходоод, бөөр, давсаг, цеститэнд их сайн гэж ярьдаг. Хэрэглэхдээ тосонд хийж уншилна /багсарах/ орой унтахаасаа өмнө багаар долоож хэрэглэдэг. Их хэмжээгээр хэрэглэдэггүй эмчилгээний журмаар хэрэглэдэг. Сульхар нь

хөх тарианы болон сулийн гурилаас өөр элсэн шаргалдуу өнгөтэй байдаг.

Хөх тарианы гурил:

Хавар тариалахаас өмнө газраа сайхан цэвэрлэн, гараар хагалдаг. Дараа нь үрээ 2 тийш нь талбайдаа цацаж хагалгаа хийж тариагаа булж өгдөг. 45 хоногийн дараа эхний усалгааг хийж тариа 5 устай гэж намар хурааж автлаа 5 удаа услахад сайхан өндөр ургадаг. Тариаг хураахдаа ишийг нь үлдээгээд түрүүг нь хуглаж авдаг. Үлдсэн ишийг нь хонь мал оруулахад ишийг нь идээд ирэх хавар гэхэд цэвэрлэгдсэн байдаг. Дээр үед берзинт дэвсэж байгууд мориор гишгүүлж цайруулдаг байсан. Одоо бол 200-ийг пошгин дээр тор тавиад гараараа үрж цайруулдаг. Цайруулсан тариагаа дараа нь хөдөө хээр газар аваачаад зөөлөн салхинд хийсгэж цэвэрлэхэд тариа нь үлдээд сүрэл, хог нь хийсдэг. Хүчтэй салхинд тариа нь хийсчдэг. Цэвэрлэсэн тариагаа гал дээр хуураад дараа нь тээрэмдээд л бэлэн болж эцсийн бүтээгдэхүүн болдог.

Хөх тарианы гурилыг хэдийд ч хэрэглэж болно. Манай аймгийнхан хотынхон ч бас захиж авдаг. Кальци, фосфорзэрэг олон төрлийн витаминууд газрын хөрснөөс агуулагдсан байдаг учраас байгалийн цэвэр бүтээгдэхүүн гэж үздэг.

Тариагаа асгаж, хаяж болохгүй, 1 ширхэг тариа байсанч авдаг. Тариа хуурч байхад хүн орж ирэхэд болсон бор идээнээс бүү буц гэж заавал амсадаг.



Хөх тарианы гурил боловсруулахад хэрэглэгддэг эд зүйлс:



Цэвэрлэсэн тариа



Тээрэм



Хуурч буй тариа



Хөх тариа



Тулам



Уур, нүдүүр

## Дүрс бичлэгийн жагсаалт

№	Үйл ажиллагаа, нэрс	Хаана	Хугацаа	Яс үндэс	хугацаа	хэмжээ
1	Мөнгөлөг шагшуурга үйл ажиллагааны нээлт	Хар ус нуурын эрэг	2018.02.24		00:13:28	2.10gb
2	Мөсөн сурын харваа		2018.02.24		00:23:01	3.61gb
3	Мөсөн сурын тухай өвлөгчийн тайлбар, яриа		2018.02.24	Урианхай	00:12:38	1.98gb
4	Хүлэгт ба оньсон тоглоом	Жаргалант сум	2018.02.25	Захчин	00:35:07	5.51gb
5	100 цаасны хөзөр тоглож буй байдал	Буянт сум	2018.02.25	Урианхай	00:25:27	3,99gb
6	100 цааст хөзөрийн тухай өвлөгчийн тайлбар, яриа		2018.02.25	Урианхай	00:14:09	2,22gb
7	Сар шинийн ёс	Жаргалант сум	2018.02.26	Тува	00:27:53	4,38gb
	Үүц задлах ёс				00:30:37	2,77gb
	Хөөрөг				00:19:09	3,00gb
	Дээж өргөх ёс				00:02:37	420mb
	Гомос хөгжим				00:04:25	711mb
	Үндэсний хувцас				00:13:51	2,17gb
8	Хөх тарианы гурил боловсруулах үйл явц	Манхан сум	2018.02.27	Захчин	00:57:26	9,0gb
9	Хөх тарианы гурил боловсруулах тухай өвлөгчийн тайлбар, яриа	Манхан сум	2018.02.26	Захчин	00:27:41	4,30gb
	<b>Нийт</b>				304.8 минут	

**“Цайны зам” өв соёлын наадмын үйл ажиллагаа, “Олон улсын хөөмэйн V наадам”, “Эрдэм шинжилгээний бага хурал”, Сульхарын гурилыг уламжлалт аргаар боловсруулах арга технологийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулсан ажлын тайлан.**

1728 оноос цайны замын үйл ажиллагаа тогтмолжиж, дэлхийн худалдааны нэг гол зам болж байсан түүхтэй. Хөх хотоос Оросын Бийск хот ордог цайны зам Ховд аймгаар дайран өнгөрдөг байсан юм. Энэ уламжлалыг сэргээж Ховд аймаг “Цайны зам” өв соёлын анхдугаар наадмыг 2018 оны 09 дүгээр сарын 24-30-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Ази, Европыг хуурай газраар холбосон эртний түүхт 2 замын нэг нь Торгоны зам, Цайны зам байсан түүхтэй. Аль алинд монгол жинчдийн гүйцэтгэсэн үүрэг үлэмж их гэлцдэг. Хүн төрөлхтөний түүхэнд Торгоны, Цайны, Хаш чулууны, Давсний, Дарсны гэх зэрэг худалдааны олон зам байсан ч цайны зам нь ачаа эргэлт, ач холбогдлоороо Торгоны замын дараа хоёрдугаарт ордог байжээ. 18-20-р дугаар зууны эх хүртэл 3 зууны туршид жингийн цуваа ер тасраагүй алдарт цайны зам нь Хятад, Монгол, Орос гурван орны ихээхэн газар нутгийн хамарч 150-иад хот суурингаар дамжин өнгөрдөг байлаа. Нэг удаагийн тэмээн жин 1000 орчим тэмээ ачаалдаг байсан нь хэр их хөдөлмөр шингэсэн нүсэр ажил байсан нь тодорхой байдаг.


Түүхэн утгаар нь авч үзвэл Хүннүгийн үеэс улбаатай Евразийн ард түмний дипломат харилцаа, худалда наймаа, соёлын харилцааны үргэлжлэл нь алдарт цайны зам юм. Ийнхүү цайны зам нь Хятадаас эхлэн Монголоор дамжин Европыг хүрснээр маш олон улс орон цайлах соёлтой танилцаж, цай бэлтгэх хэдэн зуун технологи бий болсон түүхтэй.

Уг наадмын хүрээнд Олон улсын Хөөмийн 5-р наадам, “Алтан хэлхээ 2018” уран нугаралтын наадам, Угсаатан бүрийн цай чанах үзүүлбэр, Цайны зам эрдэм шинжилгээний бага хурал, олон улсын хөөмийн эрдэм шинжилгээний бага хурал,

100 орчим тэмээ бүхий “Тэмээн жин” үзүүлбэр арга хэмжээ, Манхан суманд зохион байгуулагдсан нүүдэлчин Бэсгэр наадам, Буянт, Чандмань, Ховд, Булган сумдын соёлын өдрүүд, үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зэрэг томоохон үйл явдал арга хэмжээнүүд зохион байгуулагдсан.




Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 9 дүгээр сарын 18 өдрийн А/96 тоот тушаалаар багийн ахлагчаар Ж.Насанжаргал /Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн/, багийн гишүүнээр Т. Даваа-Очир /Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын зураглаач/ нар удирдамжын дагуу СӨУНБМ-санг баяжуулах, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах зорилгоор 2018 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 10 хоногийн хугцаагаар томилолтоор ажилласан.



9 дүгээр сарын 25-ны өдөр Ховд аймгийн Манхан сумын нутаг "Гурван сэнхэрийн агуй"-аас аймгийн төв хүртэлх 100 гаруй километр 100 тэмээгээр жин тээсэн “Тэмээн жин” үзүүлбэр арга хэмжээг баримтжуулан, Говь-Алтай аймгийн Баян-Уул, Хөхморьт сумдад Сульхарын гурилыг уламжлалт аргаар боловсруулах арга технологийг дуу, дүрс бичлэгээр 25, 26-ны өдрүүдэд баримтжуулав.

Олон улсын Хөөмийн 5-р наадам, шагнал гардуулах үйл ажиллагаа, Олон улсын хөөмэйн эрдэм шинжилгээний бага хурлыг 9 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.



Ховд аймагт хийсэн дүрс бичлэг, гэрэл зургийн мэдээлэл:

№	Үйл ажиллагаа, нэрс	Хаана	Хугацаа	Бичлэгийн хугацаа	Бичлэгийн хэмжээ
1	Тэмээн нүүдэл	Ховд аймаг Манхан сум	2018.09.25	00:16:54	2,64 gb
2	Бэсрэн наадам	Ховд аймаг Манхан сум	2018.09.25	00:03:01	483mb
3	Сулийн гурил ургалт	Говь-Алтай аймаг Хөх морьт сум	2018.09.26	00:11:30	1.78gb
4	Суль болон сулхирын гурил боловсруулалт	Говь-Алтай аймаг Хөх морьт сум	2018.09.26	00:31:41	4,96gb
5	Сулхирын гурил ургалт	Говь-Алтай аймаг Хөх морьт сум	2018.09.26	00:03:44	595mb
6	Хөөмийн наадам 1 шат гоцлол хэсэг	Ховд аймаг Ховд хот	2018.09.27	00:33:54	5.32gb
7	"Цайны зам" албан ёсны нээлт	Ховд аймаг Ховд хот	2018.09.27	00:25:56	4.06gb
8	Хөөмийн тухай хэлэлцүүлэг уулзалт	Ховд аймаг Ховд хот	2018.09.27	03:05:31	29,1gb
9	Хөөмий наадмын 1 шат үргэлжлэл	Ховд аймаг Ховд хот	2018.09.27	01:19:03	12,4 gb
10	Хөөмий наадам 2р шат	Ховд аймаг Ховд хот	2018.09.28	01:05:53	10,3 gb
11	Хөөмийн наадмын хаалтын ажиллагаа шагнал гардуулалт	Ховд аймаг Ховд хот	2018.09.28	01:43:34	16,2gb
12	Гэр буулгалт Тэмээн нүүдэл	Ховд аймаг Манхан сум	2018.09.29	01:17:01	12 gb
13	Гэрэл зураг		09.25-30	220 ширхэг	35,3 gb
		<b>Нийт</b>			135.1 gb

***"Язгуур урлагийн наадам"-ыг баримтжуулсан ажлын тайлан Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 2018.04.25-27***

Өмнөговь аймгийн 2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны "Бид хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2018 оны 4 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Даланзадгад суманд "Язгуур урлагийн наадам"-ыг Ерөөл болон аялгуут магтаал, Морин хуур, Уртын дуу гэсэн 3 төрлөөр зохион байгуулав.

Өмнөговь аймгийн Боловсрол соёл урлагийн газраас 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр ирүүлсэн 155 тоот албан бичгийн УНБМСанд баримтжуулан үлдээх тухай хүсэлтийг үндэслэн Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал, Мэдээллийн технологи аюулгүй байдлын газрын зураглаач Т.Даваа-Очир нар гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулан УНБМСанд авч архивлан хадгалав.



Гэрэл зураг, дүрс бичлэгийн жагсаалт:

№	Үйл ажиллагаа, нэрс	Хугацаа	Бичлэгийн хугацаа	Тоо ширхэг	Бичлэгийн хэмжээ
1	Ерөөл магтаалчдын уралдааны дүрс бичлэг	2018.04.25	07:40:38		72,2 gb
2	Ерөөл магтаалчдын уралдааны гэрэл зураг				560 ширхэг
3	Морин хуурын уралдааны дүрс бичлэг	2018.04.26	06:59:39		65.85gb
4	Морин хуурын уралдааны гэрэл зураг				227 ширхэг
5	Уртын дууны уралдаан дүрс бичлэг	2018.04.27	02:41:30		25,3gb
6	Уртын дууны уралдааны гэрэл зураг				106 ширхэг
7	Нийт		17:21:47	893	183,339 GB

## ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТ ХИЙГДСЭН АЖЛУУД

### Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах чиглэлээр

#### **Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын дүн шинжилгээ**

Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж 2018 оны 11 дүгээр сард Боловсрол, Соёл, шинжлэх ухаан Спортын яамны Соёл, урлагийн бодлогын газарт хүргүүлсэн.

Агуулга:	
НЭГ. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ТУХАЙ .....	2
1.1.Соёлын биет бус өвийн тухай товч танилцуулга.....	2
ХОЁР. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА .....	7
2.1.Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын ерөнхий арга хэмжээ.....	7
2.2.Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын эрх зүйн орчин.....	11
2.3.Соёлын биет бус өвийн бүртгэл.....	21
2.4.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны бүртгэл.....	23
2.5.Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт.....	25
2.6.Соёлын биет бус өвийн сургалт, сурталчилгаа.....	38
2.7.Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадвар.....	43
Дүгнэлт.....	46
Ашигласан материал.....	49

#### **Баруун халхын мартагдаж буй уртын болон ардын дууг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах ажил**

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/10 тоот тушаалыг үндэслэн уртын дуучин, ардын авьяастан Будхүү овогтой Төрмөнхтэй 2018 оны 02 сарын 28 өдөр байгуулсан 01/01 тоот гэрээг удирдлага болгон Баруун халхын мартагдаж буй Уртын болон ардын дууг Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд дуу, дүрс бичлэгээр баримтжуулан үлдээх ажлыг Театрын музейд

зохион байгуулсан.

Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын зураглаач Т.Даваа-Очир нар дараах дуунуудыг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, дууны үгийг цаасан хэлбэрээр хавсарган УНБМСанд архивлан хадгалах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Уртын дуу 5, бэсрэг уртын дуу 1, ардын дуу 15 нийт 21 дууг дүрс бичлэгээр баримтжуулав.

Уртын дуу

1. Арын өндөр
2. Газрын дундаас гүйдэлтэй алтан шарга морь
3. Оломгүй далай
4. Хөвчийн өндөр
5. Эрдэнийн баахан шарга
6. Гандан уулын цэцэг /бэсрэг уртын дуу/

Ардын дуу богино дуу

1. Аяны дайлан
2. Авгийн цагаан уул
3. Дунд голын ногоо
4. Жаавай
5. Орлой гурван зээрд
6. Хонгор морь
7. Хонин жороо морь
8. Сандуутай мод
9. Лоолой
10. Замагтай нуур
11. Замбага ягаан цэцэг
12. Хөх торгон цамц
13. Хошингоо
14. Ботго
15. Минжийн хангай

### ***“Нүүдэлчин Монгол 2018” Соёлын биет бус өвийн их наадамд ажилласан тухай***

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенци, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, дэмжин хөгжүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготой Нүүдэлчин Монгол наадам 2018 оны 8 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд болж амжилттай өндөрлөсөн.



“Нүүдэлчин Монгол 2018” Соёлын биет бус өвийн их наадмын зохион байгуулалтад Соёлын өвийн үндэсний төвийн захиралын 2018 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн А/57 тоот тушаалын дагуу дараах бүрэлдэхүүнтэй ажилласан болно.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Цэцэнбилэг /Бүртгэл, судалгааны газрын дарга/.

Гишүүд:

Б.Энхнасан /Сан, хөмрөг, бичиг хэрэг/,

Т.Даваа-Очир /Зураглаач/,

Д.Нарантуяа /Бүртгэл, судалгааны газрын ахлах мэргэжилтэн/,

Ж.Насанжаргал /Бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн/,

Г.Бүрэнтөгс /Бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн/,

Н.Жамбал /Сэргээн засварлах газрын мэргэжилтэн/,

Б.Мягмарсүрэн /Сэргээн засварлах газрын мэргэжилтэн/,

Г.Ууганчимэг /Сэргээн засварлах газрын мэргэжилтэн/,

Т.Сүхбаатар /Сэргээн засварлах газрын мэргэжилтэн/.

“Соёлын биет бус өвийн их наадам”-ын анхан шатны шалгаруулалт сум, дүүрэг, аймаг, нийслэлд энэ онд зохион байгуулагдсан ба II шатны шалгаруулалт буюу Хүй 7 худагт болсон “Нүүдэлчин Монгол” наадамд 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 700 гаруй ардын авьяастан, гар урчууд болон 2000 орчим үндэсний спортын тамирчид нутаг нутгаараа отоглон бууж өрсөлдсөн юм.


Нээлтийн үеэр БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа, “Өв соёлөө өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах нь аль ч улс орны өмнө тулгамдсан асуудал болоод байна. Монгол Улс өнгөрсөн онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг баталсан. Ингэснээр өв соёлоо хамгаалах томоохон боломж нээгдсэн юм. Энэхүү наадам Монгол түмний соёлын өвийг хойч үедээ түгээн дэлгэрүүлэхэд томоохон түлхэц үзүүлэх болно” хэмээв.



Соёлын өвийн үндэсний төвийн ажилтнууд Соёлын өвийн үзэсгэлэн, Өвлөн уламжлагчдын бэсрэг тоглолтыг хувиарлагдсан 10 ханатай гэрт 3 өдрийн турш зохион байгуулав. Мөн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн арын албанд нэгдсэн зохион байгуулалтан дор өөрсдийн үүрэгт ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

**“СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ИХ НААДАМ – 2018” (мэдээ, мэдээлэл, гэрэл зургийн цомог) ном бүтээсэн ажил.**

Соёлын биет бус өвийн их наадам – 2018-ын дүнгээр, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенц, салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд СББӨ-ийг хадгалж хамгаалах, дэмжих, хөгжүүлэх, судалж сурталчлах, 5 ай савын хүрээнд СББӨ-



ийн зүйлүүд, өвлөн уламжлагчдыг тодруулан алдаршуулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндсэний төв хамтран 2018 оны 10 дугаар сард “Соёлын биет бус өвийн их наадам-2018” (мэдээ, мэдээлэл, гэрэл зургийн цомог) номыг хэвлүүлэн гаргав.

### Сургалтын чиглэлээр

*“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхдугаар чуулган”:* (Хөвсгөл аймаг, Мөрөн хот, 2018.05.11-12)

Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас Соёлын биет бус өвийг өндөр түвшинд өвлөсөн ардын авьяастан, өвлөн уламжлагчдыг сурталчлах, алдаршуулах, тэднээр дамжуулан соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, уламжлан хөгжүүлэх, бүртгэн баримтжуулах зорилгоор “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхдугаар чуулган”-ыг 2018 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус чуулганд:

- Хөвсгөл аймгийн 23 сумаас тус бүр 5 оролцогч /сумдын засаг дарга нар, соёлын төвийн эрхлэгч, ардын авьяастан-3 /
- Мөрөн сумын ЗДТГ-3, ардын авьяастан 10
- ХДТ-ын ахмад уран бүтээлч -5
- Аймгийн удирдлага, зохион байгуулагчид -15, нийт 150 хүн хамрагдсан болно.

Соёлын өвийн үндэсний төвөөс Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал “Соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа”, “Соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” сэдвээр мэдээлэл хийж арга зүйн сургалтыг өгсөн.

Хөвсгөл аймгийн 23 сумдаас оролцсон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 44 хүнийг Хөгжимт драмын театрын тайзнаа баримтжуулсан ба Аймгийн ИТХ-ын 2017 оны 56-дугаар тогтоолын дагуу Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн 10 ахмад авьяастанд “Батламж”, энгэрийн тэмдэг, мөнгөн шагнал (100.000 төгрөг) олгосон.

Шагнагдсан авьяастны нэрс:

- Ч.Дугарсүрэн Рашаант сум /Эх хэл аман уламжлал/
- Д.Д.Хүрэл-Очир Мөрөн сум /Уламжлалт анагаах ухаан/
- Б.Дуламсүрэн Тариалан /Ардын язгуур урлаг/
- Н.Цогбадрах Улаан-Уул /Ардын язгуур урлаг/
- Р.Лхамжав Мөрөн /Ардын язгуур урлаг/
- О.Лхагваажий Мөрөн /Ардын язгуур урлаг/
- Ц.Бямбажав Мөрөн /Ардын гар урлал/
- Х.Баян-Очир Мөрөн /Ардын гар урлал/
- Л.Галбаабадраа Мөрөн /Уламжлалт анагаах ухаан/
- Д.Доржпагма Мөрөн /Уран бичлэг/

Мөн чуулганд оролцогчдоос СББӨ-ийг өвлөн уламжилж, түүнийгээ хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд амжилт гаргаж яваа ахмад ардын авьяастнуудад МУЗГ-ын шагнал “Соёлын тэргүүний ажилтан”, “Тэргүүний ардын авьяастан”, БСШУСЯ-ны “Жуух бичиг”, Хөвсгөл аймгийн “Тэргүүний ажилтан”, Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 17 ахмад настанг шагнасан.

Үйл ажиллагааны зураг:





**“СОЁЛЫН ӨВИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ” СУРГАЛТ (Ховд аймаг, Жаргалант сум, 2018.05.22-23.)**

Ховд аймгийн БСУГ-аас БСШУСЯ, Соёлын өвийн үндэсний төв, Соёл урлагийн удирдлага менежментийн институттэй хамтран “Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд нутгийн удирдлагын ордны иргэний танхимд зохион байгууллаа. Энэхүү сургалтад аймгийн Музей, Нийтийн номын сан, ХДТ-ын ажилтнууд болон сумдын соёлын төвийн ажилтнууд, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага иргэдийн төлөөлөл нийт 40 гаруй хүн оролцов.

Тус сургалтаар Соёлын биет бус өвийн талаар баримтлах бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх арга зүй, соёлын статистик-шинэчлэл, соёлын үл хөдлөх дурсгалын өнөөгийн байдал хадгалалт хамгаалалт зэрэг сэдвүүдээр мэдээлэл хүргэж, энэ чиглэлээр чөлөөт ярилцлага өрнүүллээ.

Ардын хөгжмийн зэмсэг лимбэ хөгжмийг тоглох техник, хэлний, уруулын, амьсгааны гэх мэт хичээлээр лимбэ хөгжим тоглох битүү амьсгааг заалган сурч, өвлүүлэн уламжлуулж байгаа өвлөн уламжлагч Ч.Ваша, Урианхай бий биелгээг өвлөн уламжлагч Пүрэвийн Мөнхцоож, Захчин бий биелгээг өвлөн уламжлагч н.Отгонхишиг нарын урьж ирүүлэн сургалтад оролцогчдыг 3 багт хувааж, өвлөн уламжлагчдыг маягтын дагуу бүртгэн баримтжуулах ажлыг хийлгэн, өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулсан талаарх мэдээллээ баг тус бүр танилцуулж, харилцан ярилцаж холбогдох мэргэжилтэн зөвлөгөө өгч эхний өдрийн сургалт өндөрлөв.



“Соёл, урлагийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт” (Архангай аймаг, Цэцэрлэг хот, 2018.04.19-20)

Архангай аймгийн 19 сумын Соёлын төвийн эрхлэгч, Өв хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Соёлын өвийн үндэсний төвийн Үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа Түүх соёлын үл хөдлөх дурсгалын ерөнхий ойлголт, ТСҮХДурсгалын Бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх арга зүй сэдвээр, СӨҮТ Соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал СББӨвийн ерөнхий ойлголт, СББӨвийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх арга зүй, Дадлага хичээл орж амжилттай зохион явуулсан.



### **Соёлын биет өвийг хадгалж хамгаалах чиглэлээр**

*РСН-д бүртгэгдсэн дурсгалын бүртгэл.*

2018 оны эхний хагас жилийн байдлаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн РСН програмд музейнүүдээс нийт 3089 дэсийн 16947 ширхэг үзмэр бүртгэл хийгдсэн байна. Монгол үндэсний музей, Эрдэнэ Зуу музей, Архангай аймгийн музей, Завхан амйгийн музейн бүртгэлээ идэвхтэй бүртгэсэн ба нэр бүхий 15 музейгээс бүртгэлээ нэмж хийгээгүй байна.

№	Байгууллага	РСН програмд бүртгэлтэй нийт үзмэрийн тоон дүн		2018 оны эхний хагас жилд нэмэгдсэн үзмэрийн бүртгэлийн тоон дүн	
		Дэс	Тоо/ш	Дэс	Тоо/ш
1	Богд хааны ордон музей	4101	4102	1	1
2	Чойжин ламын сүм музей	1138	6193	0	0
3	Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей	3685	4801	165	306
4	Монголын үндэсний музей	8885	20076	63	6874
5	Байгалийн Түүхийн музей	6366	7251	212	239
6	Эрдэнэ Зуу музей	1749	7348	549	4897
7	Уран Зургийн галерей	2394	2665	369	387
8	Монголын Театрын музей	4448	5267	34	37
9	Монгол улсын үндэсний номын сан	630	1122	0	0
10	БХЯ-ний харьяа Монголын цэргийн музей	330	331	0	1
11	ШУА-ийн харьяа Палеонтологийн төв	67	69	0	0
12	ШУА-ийн Археологийн хүрээлэн	759	2447	0	0
13	Улаанбаатар хотын музей	407	611	0	0

14	Архангай аймгийн музей	1743	2570	908	1041
15	Баян-Өлгий аймгийн музей	925	2458	0	0
16	Баянхонгор аймгийн музей	1851	7543	0	0
17	Булган аймгийн музей	2274	4083	0	0
18	Говь-Алтай аймгийн музей	1768	1918	64	64
19	Говьсүмбэр аймгийн музей	424	424	-39	-76
20	Дархан-Уул аймгийн музей	905	905	39	39
21	Дорноговь аймгийн музей	2159	5356	0	0
22	Дорнод аймгийн музей	1403	3225	0	0
23	Дундговь аймгийн музей	3126	3814	351	602
24	Завхан аймгийн музей	1785	4011	104	2169
25	Орхон аймгийн музей	659	660	1	1
26	Өвөрхангай аймгийн музей	598	1094	0	0
27	Өмнөговь аймгийн музей	1064	1618	51	51
28	Сүхбаатар аймгийн музей	939	1235	143	192
29	Сэлэнгэ аймгийн музей	1096	1114	34	34
30	Төв аймгийн музей	1487	1824	0	0
31	Увс аймгийн музей	1973	4028	19	41
32	Ховд аймгийн музей	192	192	0	0
33	Хөвсгөл аймгийн музей	1853	4051	9	16
34	Хэнтий аймгийн музей	1337	1911	0	0
35	Төрийн түүхийн музей	645	804	0	0
36	Хөшөөцайдам музей	37	90	0	0
37	Хархорум музей	734	1304	9	31
38	Данзанравжаа музей	7	7	0	0
	<b>Нийт</b>	<b>65943</b>	<b>118522</b>	<b>3086</b>	<b>16947</b>

### **Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн бүртгэлийн бүрдүүлэлтийг хангав**

дурсгалт зүйлийн Соёлын өвийг хамгаалах тухай хуулий 8.3; 13.1.8-д заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр 1995-2015 онд түүх, соёлын хосгүй үнэт 777 дурсгалт зүйлийн бүртгэлийг хангуулахаар ажилласан. Энэ ажлын хүрээнд түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад бүртгэгдсэн Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Эрдэнэсийн сан, Гандантэгчэнлин хийд, Эрдэнэ Зуу музей, Уран зургийн галерей, Архангай, Ховд, Сүхбаатар, Төв, Дорноговь, Хэнтий аймаг зэрэг музейн сан хөмрөг дэх түүх, соёлын хосгүй үнэт бүртгэлийг бүрдүүлэх ажлыг ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар хариуцан гүйцэтгэж байна.

Музейнүүдээс ирүүлсэн хосгүй үнэт дурсгалт зүйлийн бүртгэл бүрдүүлэлтийн байдлаас үзэхэд зарим музейн “тодорхойлолт”, “товч түүх”, “судлагдсан байдал”-ын тухай мэдээлэл дутуу байна. Эрдэнэсийн сан, Гандантэгчэнрин хийд, Шанхын баруун хүрээ хийд (Өвөрхангай аймаг), Баруун Чойрын хийд (Дундговь аймаг) зэрэг газруудад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн RCH бүртгэлийн програм суугаагүй тул цаашдаа RCH програмын нэмэлт хөгжүүлэлтийг (update) хийгдсний дараа эдгээр газруудад суурилуулах шаардлагатай байна.

Түүх, соёлын хосгүй үнэт 777 дурсгалын гэрэл зургийн цахим сан архивыг бүрдүүлэх ажлыг техникч П.Чинбат хариуцан ажиллаж байна. Одоогийн байдлаар Засгийн газрын 2010 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан Палеонтологийн хосгүй үнэт 25 дурсгалын, Засгийн газрын 2011 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан Баруун Чойрын хийдийн 1 хосгүй үнэт дурсгалын гэрэл зургийн бүрдэл дутуу байна.

### **“Хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн боловсруулав**

Засгийн газрын 2017 оны 239 дүгээр тоот тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/295 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж байгууллагын шинэ бүтэц, зохион байгуулалттай уялдуулан тус төвийн ажилтнуудтай хийх “Хөдөлмөрийн гэрээ”-г ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэн, үндэсний төвийн захиргаанд хүлээлгэн өгсөн.

### **Мэргэжил арга зүйгээр хангав**

2018 оны оны 2 дугаар сарын 28-ны өдөр Дундговь аймгийн музейн ажилтнууд тус үндэсний төв дээр ирж, музейн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт чиглэлээр мэргэжил арга зүйгээр зөвлөлгөө авсан. Ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа “Дундговь аймгийн музейн бүртгэл, төрөл зүйлийн сонголтын байдал ба РСН бүртгэлийн програмын бүрдүүлэлт”, СББӨ-ийн мэргэжилтэн Жаргалсайхан “Соёлын биет бус өвийн хамгаалалт”, ТСҮХД-ын мэргэжилтэн Бүрэнтөгс “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт” сэдвээр зөвлөгөө өгч ажилласан.

2018 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хүсэлтээр тус газрын ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа “РСН бүртгэлийн програм хангамжийн бүрдүүлэлт, түүнд тавих хяналт” сэдвийн хүрээнд тус газрын боловсрол, соёл хариуцсан мэргэжлийн хяналтын байцаагч нарт музейн үзмэрийн бүртгэл бүрдүүлэлтэд тавих хяналт талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч лекц уншив.

2018 оны 5 дугаар сарын 31-ний өдөр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн “РСН” програмын бүртгэл, бүрдүүлэлтийг сайжруулах, чанаржуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын 12 музейн бүртгэл, мэдээллийн санч нарт мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтаар ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа “РСН програмын бүртгэл, бүрдүүлэлтийн байдал”, мэргэжилтэн Ш.Энхтуяа “Музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтын орчны судалгаа”, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын мэргэжилтэн Ж.Даваацэрэн “Соёлын өвийн цахим архивын бүрдүүлэлт” сэдвүүдээр хичээл зааж, мэргэжил арга зүйгээр хангав.

### **Үзмэр шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулав**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн А/06 дугаар тоот тушаалд заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын прокурорын газарт эрүүгийн 201610010027 дугаартай хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан Баян Намсрай, Данжин, Ногоон дара эх, Гомбо, Тойниг дин-аа нэртэй зурмал бурхан, Намсрай нэртэй зэс гууль, хэвлэмэл шавар баримал, Хаш тээг иж бүрдэл дутуу, Жанрайсиг, суурьтай бурхан, Очирваань иж бүрдэл дутуу, Додэжаджава судар /хятад зэс бар, зүүлт унжлагны хэсэг/ зэрэг 11 ширхэг эд өлгийн зүйлийг Өмнөговь аймгийн музейн сан хөмрөгт шилжүүлэх ажлыг 2018 оны 3 дугаар сарын 21-нд хийж гүйцэтгэлээ. Үзмэр хүлээлцэхэд Соёлын урлагийн газрын музей, соёлын өв хариуцсан мэргэжилтэн Ч.Нацагням, Өмнөговь аймгийн музейн захирал Д.Отгонтуяа, тус музейн бүртгэл, мэдээллийн санч болон ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар хамтран зохион байгуулан ажиллаж, зохих журмын дагуу хүлээлцэх акт, ажлын тэмдэглэл хөтлөн, гэрэл зургаар баримтжуулан ажилласан. Үндэсний төвөөс Өмнөговь музейн сан хөмрөгт шилжүүлж буй үзмэрүүдэд хайрцаг, сав баглаа хийж хүлээлгэн өгсөн.

### **Шинжээчийн дүгнэлт гаргав**

- Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газар, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст хураагдсан, гэмт хэрэгт холбогдож шалгагдаж байгаа 15 ширхэг нэр төрлийн эд өлгийн зүйлд түүх, соёлын дурсгалт зүйл мөн эсэх тухай шинжээч томилон дүгнэлт гаргуулахаар манайд хандсаны дагуу ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа, сэргээн засварлагч-судлаач Н.Жамбал нар шинжлэн судлахад эдгээр 15 ширхэг эд зүйл нь түүх, соёлын дурсгалт зүйл мөн болох бөгөөд дүгнэлт гарган тус газруудад



хүргүүлсэн болно. Үүнд:

№	Хүсэлт гарсан байгууллага	Түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр	Тоо ширхэг
1	Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай" Мөрдөгчийн тогтоол	Ногоон дарь эх	1
		Аюуш бурхан	1
2	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 38а /3-8/5 тоот албан бичиг, шинжээч томилж шинжилгээ хийлгэх тухай 2018 оны 06-р сарын 19-ний өдрийн Мөрдөгчийн тогтоол	Цар	4
		Гадар	3
		Данх	1
		Домбо	1
		Хөөрцөг	1
		Дашмаг	1
		Хувин	1
		Сав	1

- Гаалийн ерөнхий газрын гаалийн төв лаборатороос ирсэн 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 07/461 тоот албан хүсэлтийн дагуу гаалийн байгууллагад саатуулагдсан 21 ширхэг эд зүйлд түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах эсэх дүгнэлийг Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа, Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч, судлаач Н.Жамбал гаргасан.
- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 4/9981 тоот албан хүсэлтийн дагуу Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 310 дугаар шийтгэх тогтоолоор эд мөрийн баримтаар хураагдсан Баян Намсрай бурханд түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарахгүй тухай тодорхойлолтыг Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа гаргасан.
- Баянзүрх дүүргийн иргэн Нямсүрэн овогтой Орхон /РД: ХЕ80031079/ -ны хүсэлтийн дагуу түүний өмчлөлийн хэмээх "Баян Намсрай" гууль цутгамал бурхан, мөнгөөр тоногтой "Эвэр хундага"-ны тодорхойлолтыг Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа, Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч, судлаач Н.Жамбал нар гаргасан.

#### **Соёлын өвийн бүртгэл баримтжуулалт, хамтын ажиллагааны хүрээнд:**

- Заяын хүрээний Цогчин дуганы (Архангай аймаг, Эрдэнэбулган сум) барилгын 3D хэмжилт судалгааны ажлын тайланг хэвлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус газрын ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа "Цогчин дуганы ашиглалт, өнөөгийн байдал" судалгааны өгүүлэл бичиж бэлтгэн 2017 оны 4 дүгээр сард хүлээлгэн өгсөн. Заяын хүрээний шашны холбогдох баримт бичиг, эх сурвалжийн талаар доктор О.Алтанзаяа, уг хүрээний барилга архитектурын ур хийц, сэргээн засварлалтын ажлын түүхэн судалгааг доктор З.Оюунбилэг нар тус тус бичиж бэлтгэсэн. БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгээс Заяын хүрээний Цогчин дуганы тайлан 2018 оны 12 дугаар сард хэвлэгдэх юм.
- 2018 оны 2 дугаар сард БНСУ-ын Соёлын өвийн судалгааны хүрээлэнгээс 2017 онд хийгдсэн Үнстийн хийд (Дундговь аймаг, Эрдэнэдалай сум)-ийн Цогчин дуган, Майдарын дуганы барилга архитектурын 3D хэмжилтийн зураг төслийн ажлын тайланг ном болгон хэвлүүлэн манайд ирүүлснийг хүлээн авсан. Судалгааны ажлын тайланг солонгос, монгол, англи хэлээр бэлтгэн ном болгох хэвлүүлсэн нь соёлын өв дурсгалт барилга архитектурын хадгалалт хамгаалалт, бүртгэл баримтжуулалтын гарын авлага болсон.

“Үнстийн хийд” нэртэй энэхүү номыг Улаанбаатар хотын болон 21 аймгийн музей, номын сангууд, соёлын өв, барилга архитектурын чиглэлийн их, дээд сургуулиудын номын сан, эрдэм шинжилгээний хүрээлэн, судлаачдад үнэ төлбөргүй тараасан. “Үнстийн хийд”-ийн Цогчин дуган, Майдарын дуганы барилга архитектурын 3D хэмжилтийн зураг төслийн ажлын тайлан 12 GB хэмжээтэй цахим файлыг БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Дурсгалт барилга архитектурын хэлтсээс энэ оны 6 дугаар сард хүлээн авч, УНБМСанд архивлан хадгалав. 2018 оны 6 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан 2017-2030 он хүртэлх Үндэсний тогтворын хөгжлийн бодлогын хүрээнд “Соёл, урлагийн байгууллагуудын тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох” сэдэвт хэлэлцүүлэгт ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа оролцон, бусад холбогдох соёлын байгууллагуудын мэргэжилтэнгүүдтэй хамтран ажилласан.

- 2018 оны 6 дугаар сарын 15-нд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын урлагийн газраас холбогдох яамтай хамтран хийж буй Соёлын байгууллагын ажилтнуудын цалингийн жишигт баримтлах ажлын байрны нэр томъёо, зэрэг дэвийн тухай санал, судалгааны ажилд ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа оролцон, бусад музейн ажилтнуудтай хамтран ажилласан.
- Халхгол сумын “Ялалт” музейн хамт олон “Халхын голын дайны хээрийн үзүүлэлэг”Халхын голын түүхэн Ялалтын 80 жилийг ойг угтан Цэргийн гавъяаны улаан тугийн одонт Халхгол сумын “Ялалт” музейн хамт олон “Халхын голын дайны хээрийн үзүүлэлэг” төслийн нээлтийн арга хэмжээг 2018 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа. “Халхын голын дайны хээрийн үзүүлэлэг”-т дайны ул мөрийг гэрчлэх баримт, эд өлгийн зүйлүүдийг олон улсын болон үндэсний музейчдэд дэлгэж, хэлэлцүүлэг зохион байгуулан санал хүсэлт, зөвлөмжийг авч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгахаар төлөвлөж, музейн сан хөмрөгийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа аж. Халхгол сумын “Ялалт” музейн хамт олны санаачилгаар хэрэгжиж буй “Халхын голын дайны хээрийн үзүүлэлэг” төслийн нээлт олон улсын болон Монгол эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татаж, хамтран ажиллах талаар хэлэлцэж, цаашид амжилттай хэрэгжих үндэс, суурь боллоо.
- БНСУ-ЫН Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хэлтсийн судлаачидтай хамтарсан хээрийн тандалт судалгааны ажил:Соёлын өвийн үндэсний төвийн хээрийн судалгааны баг, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны хүрээлэнгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хэлтэстэй хамтран Монгол улсын архитектурындурсгалынаюулгүйбайдал,гамшгаасхамгаалахтайхолбогдолтой хээрийн тандалт судалгааны ажлыг Булган, Архангай, Өвөрхангай аймгийн нутагт 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 16-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Судалгааны багийн бүрэлдэхүүнд Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг, Авран хамгаалах газрын Соёлын биет өвийн авран хамгаалах үйл ажиллагаа зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Г.Анхсанаа, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын техникч П.Чинбат, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хэлтсийн дарга, доктор Ким Дог Мүн, туслах судлаач, инженер, сэргээн засварлагч Пак Чан Мин нар оролцсон бөгөөд Улаанбаатар Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Талын улаан хэрэм, Дашинчилин сумын нутагт орших Цогтын Цагаан байшингийн туурь, Чин толгойн балгас, Хар бухын балгас, Архангай аймгийн Өлзийт сумын нутаг “Өөлд бэйсийн хүрээ”, Өгийнуур сумын нутагт орших Чилэн балгас, Хотонт сумын нутагт орших Хар балгас, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших “Эрдэнэ зуу хийд”, Хужирт сумын нутагт орших Шанхын баруун хүрээ,

- Улаанбаатар гэсэн маршрутаар ажиллав.
- Хээрийн тандалт судалгааны явцад Монголын талын судлаачид өөрийн орны нийт дурсгалуудын онцлог, судалгааны тойм зэргийг танилцуулан. Цаашид хамтарсан судалгаа хийх чиглэлийг тодорхойлов. Мөн Солонгосын талын судлаачид Монголын архитектурын дурсгалууд тэдгээрийн онцлогтой танилцаж, тэдгээрт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг өөрийн орны адил төрлийн дурсгалын сөрөг хүчин зүйлстэй газар дээр нь харьцууллаа. Хээрийн судалгааны ажлын үр дүнд Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хэлтсийн судлаачид 2019 оноос 5 жилийн хугацаатай хамтарсан судалгаа хийх санамж бичиг, гэрээ байгуулан ажиглахаар болов.
  - “Монголын биет бус соёлын өв: нүүдлийн соёлын эрхэмсэг оршихуйн увидас” баримтат 10 киноны нээлт: Байгаль, соёлын өвийг хамгаалах сан ТББ нь ЮНЕСКО-ийн Ази-Номхон далайн бүс нутгийн Соёлын биет бус өвийн олон улсын мэдээлэл сүлжээний төв (ICHCAP)-ийн дэмжлэгтэйгээр эрдэмтэн судлаач, уран бүтээлчидтэй хамтран Монголчуудын соёлын биет бус өвийн 10 төрөл зүйлээр баримтат кино бүтээсэн бөгөөд нээлтийн ёслолыг 6 дугаар сарын 20-ны өдөр Монголын уран зургийн галерейд зохион байгуулав. Нээлтийн ёслолд Гадаад харилцааны сайд, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын дарга Д.Цогтбаатар, БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Сэргэлэн, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Ардын багш С.Дулам, Ардын уран зохиолч Т.Галсан нар оролцож үг хэлэв. Нээлтийн үеэр Байгаль, соёлын өвийг хамгаалах сан ТББ нь МҮОНРТ болон СӨҮТ-тэй тус тус санамж бичигт байгуулж, 10 төрөл зүйлийн баримтат киног хүлээлгэн өгөв.
  - Монгол Улсаас 2017 онд ЮНЕСКО-д бүртгэгдсэн “Уул өвөө тахиx Монгол зан үйл” өвийн батламжийг гардан авав: ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын 55 жилийн ойг тохиолдуулан 2017 онд ЮНЕСКО-д бүртгэгдсэн Дагуурын ландшафт, Данжуурын гэрэлт хөшөө, Уул овоо тахиx Монгол зан үйл хэмээх 3 өвийн батламж гардуулах ёслол өнөөдөр буюу 2018 оны 3 дугаар сарын 6-ны өдөр Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” танхимд болов.
  - Уг ёслолыг Гадаад харилцааны сайд, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын дарга Д.Цогтбаатар нээж ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Уул овоо тахиx Монгол зан үйл болон Дэлхийн дурсамж хөтөлбөрийн Баримтат өвийн олон улсын жагсаалтад бүртгэгдсэн Данжуурын гэрэлт хөшөөний батламжуудыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаад, Дэлхийн байгалийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Дагуурын ландшафтын батламжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлд болон батламжуудын хувийг холбогдох байгууллагуудын төлөөлөгч нарт гардуулсан юм. Энэхүү арга хэмжээнд СӨҮТ-ийн Захирал Г.Энхбат, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг нар оролцож “Уул овоо тахиx Монгол зан үйл” өвийн батламжийг гардан авав.

#### **Бусад:**

- ЮНЕСКО-гийн Хүн Төрөлхтний Соёлын биет бус өвийн жагсаалтад 2013 онд бүртгэгдсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийн хэрэгжилтийн тайланг бэлтгэх ажлыг “Монгол гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо” ТББ, эрдэмтэн судлаач нартай хамтран хийж орчуулан ЮНЕСКО-ийн МҮК-т хүлээлгэн өгсөн.
- “Хөхүүрийн айраг исгэх уламжлалт зан үйл”-ийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх ажлын хүрээнд хийгдэж байгаа өвлөн уламжлагчдын бүртгэл, судалгааг баяжуулах мэдээлэл цуглуулах, УНБМСанг баримтат кино, дүрс бичлэгээр баяжуулах

үйл ажиллагааг “Айрагны нутгаар” ТББ-тай гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж Бүртгэл судалгааг 11 аймагт албан тоот хүргүүлсэн. Холбогдох тушаал, “Айрагны нутгаар” ТББ-тай хийх гэрээ хийгдэхээр хүлээгдэж байна.

- Соёлын өвийн үндэсний төвийн авилгын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг гаргаж батлуулав.
- 2018.01.26-н, 02.14-нд Богдын музейн Туульхайлахаргахэмжээг баримтжуулав.
- Дэлхийн өв “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлэх тахилгат газар нутаг”-ийн хадаглалт хамгаалалттай холбогдолтой 2015-2018 онд хийгдсэн ажлын тухай тайланг боловсруулан, англи хэлнээ орчуулж 12 дугаар сарын 01-ний өдөр ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисст хүргүүлэв.
- MGL радиогийн Түүхийн жимээр нэвтрүүлгийн Завхан аймгийн нутагт ажилласан 2018 оны дугаарт Соёлын өвийн үндэсний төвийн, Соёлын өвийн бүртгэл судалгааны газрын Үл хөдлөх дурсгалт зүйл хариуцсан мэргэжилтэн Г.Бүрэнтөгс миний бие тус төвийн мэдээлэл технологийн газрын зураглаач Т.Даваа-Очирын хамт 2018 оны 06 сарын 25-ны өдрөөс 2018 оны 07 сарын 15-ны өдрийг хүртэл Завхан аймгийн 19 сумаар нийтдээ 20 өдөр ажиллаж 78:05:55 хугацааны байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудын бичлэг хийж СӨҮТ-ийн УНБСанд хүлээлгэн өгсөн. Очсон сумдууд дахь байгалийн үзэсгэлэнт газар /нуур, гол, хайрхан/, түүх соёлын дурсгалт /хөшөө, чулуу, булш, хиргисүүр/ газрууд, нутгийн удирдлагын төлөөлөгчид, алдарт уяач нараас яриа авч ахуй орчны гэх мэт зураглал, дүрс бичлэг хийн ажиллав.
- “Байгаль соёлын өвийг хамгаалах сан” ТББ-тай хамтран “Хүрлийн үеийн буган хөшөө цогцолбор, дурсгалт газар” баримтат киноны зураг авалтаар Архангай аймгийн Хойд тамирын хөндий, Жаргалантын амын буган хөшөө цогцолбор газруудаар, Хөвсгөл аймгийн Уушгийн өвөрийн буган цогцолбор газруудаар тус тус 2018 оны 5 дугаар сарын 20-25 өдрүүдэд ажиллаж, 02:57:40 сек-ын 362 shirheg 27.6gb дүрс бичлэг хийж видео бичлэгийн сан бүрдүүлэлт хийн эвлүүлж 15 минутын баримтат кино болгосон. /Жич: Англи хэл дээр/
- Мөн “Байгаль, соёлын өвийг хамгаалах сан” ТББ-тай хамтран “Алтай таван богдын ойр орчмын сав газрыг дэлхийн өвийн түүх соёлын дурсгалт газарт бүртгүүлэх” баримтат киноны зураг авалтаар Баян-Өлгий аймгийн Улаан хус, Сагсай сумуудын нутаг дэвсгэрт дэхь Хөшөө чулуу, хүн чулуу, булш хиргисүүр, Хадны зураг, байгалийн цогцолбор газруудаар явж 09:10:33 сек 1479 ширхэг 85,7gb дүрс бичлэг хийн баримтжуулан СӨУНБМСанд эх хэрэглэгдэхүүнийг хадгалав. Дүрс бичлэгийг эвлүүлэн 6 минутын болон, 10 минутын зураглал хийсэн болно.
- Үндэсний төвийн захирлын үүрэг болгосны дагуу 2018 оны 9-11 сард ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн археологийн сан хөмрөгийн дотоод тооллогын ажилд ахлах мэргэжилтэн Д.Нарантуяатай хамт оролцон ажилласан. Тус хүрээлэнгийн дотоод тооллонын ажлыг зохион байгуулах тооллогын удирдамж, бүртгэлийн хүснэгт загварыг боловсруулах болон бүртгэл хөтлөлтийн талаар арга зүйн зөвлөмж өгч, тооллогын ажилд биечлэн оролцон ажилласан.

## 2.0. “СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ ГАЗАР”-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:


### 2.1. ДӨ-Монгол алтайн хадны зургийн хадгалалт, хамгаалалт, Чулуулгийн бүтцийн судалгаа хийх, Хадны зурагт нөлөөлөх эрсдлийн судалгаа хийх, Вандализмд өртсөн зарим хадны зургийг сэргээх

Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газар нь соёлын ангиллаар (2011 он) дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газар бөгөөд Соёлын өвийг хамгаалах хуулийн 42.3-т Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна хэмээн заасан байдаг.

Соёлын өвийн төвөөс 2017 оноос Монгол Алтайн нурууны хадны зургийн хадгалалт хамгаалалтыг сурталчилгаагаар дамжуулан сайжруулах. Орон нутгийн иргэдийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, олон нийтэд Монгол Алтайн хадны зургийг хүртээмжтэй байдлаар цахим орчинд сурталчлах ажлыг хийхээр төлөвлөж, дурсгалт газарт хээрийн судалгааг хоёр дахь жилээ хийлээ.

Хээрийн судалгааны баг 2018 оны 8 дугаар сарын 01-ноос 8 дугаар сарын 23 хүртэл 23 хоногийн хугацаанд Соёлын өвийн үндэсний төвийн авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын техник хариуцсан мэргэжилтэн П.Чинбат, Сэргээн засварлах газрын ахлах сэргээн ахлах сэргээн засварлагч Д.Нямдорж, сэргээн засварлагч А.Мөнгөнцоож, Баян-Өлгий аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч И.Эркабулан нарын бүрэлдэхүүнтэй ажиллаа.

2018 оны Монгол Алтайн нурууны хадны зургийн хээрийн судалгаа нь тухайн бүс нутгийн улс аймгийн хамгаалтад байдаг дурсгалуудын бүртгэн баримтжуулалтыг сайжруулах, хадны зурагт сөргөөр нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлах, хадны зураг дээр сийлсэн хэсгийг нөхөх, түүнд тохирох материал, аргачлалыг турших, зарим ач холбогдол бүхий хадны зургаас дардас авах зэрэгт анхаарч ажиллав.



Бид 2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогод хамрагдсан өмнө нь судалгааны эргэлтэд ороогүй зарим ач холбогдол бүхий чухал гэсэн дурсгалуудыг Монгол Алтайн явах замдаа дахин нягталж, давтан бүртгэн баримтжуулалт хийсэн болно.

**Ар цайрын хүн чулуун хөшөө:** Завхан аймгийн нутагт нэгэн эртний хүн чулуун хөшөө бүртгэгдсэн бөгөөд үүнийг олж дахин баримтжуулалт хийв. Тус хүн чулуун хөшөө нь тус аймгийн Эрдэнэхайрхан сумын Мөсөн багийн нутаг Ар цайр хэмээх газар

нэгэн дугуй хүрээтэй хиргисүүрийн өмнө талд газар баруун урагш налж унасан байдалтай оршиж байна. Хүн чулуун хөшөөг цайвар ягаан өнгийн боржин чулуугаар үйлдсэн бөгөөд 79 см өндөр хэмжээтэй. Монгол орны өнөөгийн нутаг дэвсгэрт өмнө нь илэрч, судлагдсан хүн чулуун хөшөөдөөс нэлээд өвөрмөц бөгөөд, хүрлийн үед холбогдуулж үздэг хөшөөдтэй илүү төсөөтэй байна. Бид дээр хүн хөшөөг товч тодорхойлж, гэрэл болон гар зургаар баримтжуулж авлаа.



**Тэрэм хадны зосон зураг:** Увс аймгийн Ховд сумын Халиун булаг нэртэй 1-р багийн нутаг, Тэрэм хэмээх уулын баруун урагш харсан боржин ханан хадны дээд хэсэгт улаан өнгийн зосоор зурсан 4 ширхэг Х маягийн тэмдэг, үүний доод талд дээш харсан 25 см орчим урттай, доод талдаа сүүлийг шовгор үзүүр гарган дүрсэлсэн нэгэн яст мэлхийг зурсан байна. Мөн дээрх зосон зургийн урд талд ханан хадны ёроолд дээшээ харсан 10 см хэмжээтэй шувуу маягийн зүйл дүрсэлсэн хадны зосон зураг орших бөгөөд он удаан цаг хугацааны уртад дүрслэл нь ихэд бүдгэрсэн байна.



Хадны дээд булан дахь зураг



Хадны дээд булан дахь зургийн гар зураг



Хадны доод булан дахь зураг




Хадны доод булан дахь зургийн гар зураг

**Цагаан голын буган хөшөөд:** Тус буган чулуун хөшөөд нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт орших бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолоор улсын хамгаалтад авсан дурсгал болно. Тус буган чулуун хөшөөд нь Цэнгэл сумын төвөөс чанх баруун хойш 6.5 км-т Цагаан голын хойд дэнж дээр хоёр буган хөшөө оршдог бөгөөд улс аймгийн хамгаалтад байдаг ба буган чулуун хөшөөдийг 12 м голчтой, дүгрэг хиргисүүрийн төвд хооронд нь бараг шүргүүлэн босгожээ.

Энэхүү хоёр хөшөөний түүх, соёл, шинжлэх ухааны онцлог нь анх байрлуулж

тавьсан байдлаараа байгаа бөгөөд ингэж хоёр хөшөөг нэг доор байрлуулдаг заншлыг судлаачид нэг гэр бүлийн эр эм хоёрын дурсгалд зориулагдсан гэж үздэг. Тэгэхдээ булш оршуулгыг нь өөр газар мөн адил хосоор нь үйлддэг байсан бололтой. Хийц дүрслэлийн хувьд эдгээр хөшөө, бугыг хийсвэрлэн дүрслэх аргаар үйлдсэн бөгөөд нэг онцлог нь хөшөөний доод хэсэгт бүс болон бүснээс зүүсэн эд хэрэглэл, зэр зэвсгийн зүйлс дүрслээгүй байлаа. Бугыг ийнхүү хийсвэр байдлаар дүрсэлсэн хөшөөг ихэнх судлаачид буган хөшөөний хөгжлийн эхэн нтө II мянган жилийн үе буюу хүрэл зэвсгийн үед холбон үздэг. Цагаан голын эдгээр буган хөшөөдийг дөрвөн хиргисүүр, 10 дүгрэг булш тойрон байрласан байх бөгөөд бид дээрх дурсгалт газрын зургийг дрон-оор хийж, protogrammar зураг авч, товч тодорхойлолт хийлээ.




1-р буган хөшөө. Ногоовтор туяатай хөх саарал өнгийн нимгэн хавтгай урт чулуугаар хийсэн. Өргөн хоёр талын оройн хэсэгт тус бүр нэжгээд цагариг сийлсний голч 18 см. Түүнээс доош газарт зоогдсон хэсгийг хүртэл нэлэнхийдээ бугын дүрс сийлсэн байсан нь өдгөө бараг мэдэгдэхгүй болтлоо элэгдэн бүдгэрчээ. Газраас цухуйсан өндөр нь 238 см, өргөн нь 54 см, зузаан нь 12-19 см.

2-р буган хөшөө. Нэг дэх буган хөшөөний баруун талд тун ойрхон зэрэгцэж урт нарийхан, цайвар боржин чулуун энэ хөшөө оршино. Оройн хэсэгт хүний нүүрийг их биеэс нь товойлгон гаргаж урлажээ. Гонзгой урт нүүртэй, шулуун жирвэгэр хөмсөгний уулзвараас доош хамрыг шууд үргэлжлүүлэн товгор шулуунаар гаргасан агаад нүд ам нь элэгдэн бүдгэрчээ. Баруун шанаанд нь 15 см голчтой онгин дүрс үзэгдэх бөгөөд зүүн хажуугаараа нөгөө хөшөөтэй шахаж байрласан тул ямар зураг дүрстэй нь тодорхойгүй. Хөшөөний өндөр нь газраас цухуйсан байдлаар 240 см, өргөн нь 22-24 см, зузаан нь 18-24 см.

Энэ удаа бид өмнөх жил явсан замын эсрэг буюу Арал толгой, Шивээт хайрхан, Цагаан салаа/Бага ойгур, Хар ямаат гэсэн чиглэлд ажиллаа.


**Арал толгой:** Алтай таван богдын өвөр биеэс эх аван урсах Хар салаа, Цагаан салаа голын уулзварт орших Хурган нуур, Хотон нуур хэмээх хоёр залгаа нуурын хойд талд орших жижиг толгойг Арал толгой гэнэ. Тус дурсгалт газар нь Цэнгэл сумын төв Хөшөөт сууринаас 150 орчим км зайд, хилийн заставын орчим байрлана. Арал толгойн







дурсгалт газар нь үндсэн талбай 200 га, хамгаалалтын бүс 800 га, нийт 1000 га бөгөөд хамгийн бага талбайг хамарна. Энэ орчимд 170 орчим хаднаа зураг сийлжээ. Адуутай хамт зурсан адуу шиг том биетэй хэдэн шувуудын зураг сонирхолтой байна. Монгол нутагт мезолитийн үед амьдарч байсан тэмээн хяруулын өндөг олдож байсан бөгөөд адуу шиг том биетэй шувууны энэ зургийг тэмээн хяруулын зураг бололтой гэж үздэг байна.

Монгол нутагт одоо нутаглаж буй баганаас өвөрмөц эвэртэй хэд хэдэн буга дүрсэлсэн нь онцлог бөгөөд судлаачдын сонирхлыг татаж байна. Мөн энд бодон гахайг хэд хэдэн янзаар дүрсэлсэн байх ба шувууны их бие дотор өндгийг дүрсэлсэн нь хадны зураг зурах арга барилд тохиолдож байгаагүй онц сонирхолтой арга барил юм. Он цагийн хувьд Арал толгойн хадны зураг нь мезолит, неолит, хүрэл зэвсгийн үед холбогдох бөгөөд түүх, соёлын ач холбогдлоороо гайхамшигтай дурсгал хэмээн олон орны судлаачид хүлээн зөвшөөрдөг.



Өмнө өгүүлсэнчлэн Арал толгойн хадны зураг нь он цагийн хувьд эрт үед холбогдох бөгөөд ихэнх хадны зургууд нэлээд бүдгэрсэн байдалтай, хаг, хөвд бараг бүх зураг дээр ургажээ. Учир нь энэ орчимд нэлээд чийглэг уур амьсгал зонхилно.

Харин хадны зургууд дээр хүний нөлөөлөлд харьцангуй бага өртсөн бөгөөд хилийн цэргийн заставыг хажууд тул тэр орчмын айлуудын малыг оруулдаггүйтэй холбоотой аж.




**Шивээт хайрхан:** Цэнгэл сумын нутаг Шивээт Хайрхан уул, түүний хоёр талаас урсах Цагаан салаа, Хар салаа хоёр голын савд орших Хөх чулуу, Хар чулуу зэрэг газарт нийт 240 гаруй хаданд зурсан зохиомж байдаг. Тус дурсгал Цэнгэл сумын төв Хөшөөт сууринаас 80 орчим км зайд орших бөгөөд үндсэн талбай 9,000 га, хамгаалалтын бүс 6,300 га, нийт 15,300 га талбайг хамарна.



Нэгэн хаднаа 10-аад хүнийг дүрсэлсэн нь хүмүүсийн нас хүйсээс хамааран өөр өөр хувцас өмсөж байсан нь харагддаг. Мөн өөр нэгэн хаднаа хоёр хүн гараа зангидан бие биенийгээ цохих, зодолдохоор завдсан байдлыг үзүүлсэн сонирхолтой дүрслэл бий. Өөр нэг хаднаа дугуй тойрог дотор хоёр эр гараа занган мөн тулалдаж буй байдлыг үзүүлжээ. Эдгээр хүмүүс нь урт нарийхан гээгтэй булчинлаг бүдүүн гартай, сүрлэг хүчирхэг дүртэй юм. Нэг гартаа урт иштэй далбаа барьсан нөгөө гартаа том дугуй бамбай барьсан, бүсэндээ сум зүүгээд морь унасан хүний морийг баруун гартаа урт таяг мэт зүйл барьсан явган хүн жолоогоор нь хөтөлж явна. Ийм зураг урд өмнө нь хадны зурагт тохойлдож байгаагүй сонирхолтой зураг бөгөөд тухайн овог аймгийн тэргүүн заларч яваа байдлыг үзүүлсэн бололтой.



Нэгэн хаднаа олон тооны ачаатай үхэр болон хүн амьтадыг дүрсэлжээ. Эдгээрийн дотор нум сумаар харвалдан тулалдаж буй хүмүүс байна. Үхрийн сүүлийг том дугуй дүрсээр чимж үзүүлсэн нь сонирхол татахуйц утгатай юм.



Монгол Алтайн нуруунаас морин тэрэгний зураг 100 орчим олдоод байгаа бөгөөд Шивээт хайрхны нэгэн хаднаа том жижиг хэмжээтэй янз бүрийн хийцтэй 9 морин тэрэгний зураг олдсон нь эртний морин тэрэг судлалд чухал хэрэглэгдэхүүн бөгөөд ийм сонирхолтой олон тэрэгний зураг нэг дороос олдож байгаагүй аж. Бас нэг хаднаа хос морь хөтөлсөн хоёр том дугуйтай тэргэн дээр зогсож яваа хүнийг гээг үс, зэр зэвсэг, хувцас зэргийг маш нарийнаар дүрсэлж үзүүлсэн нь судалгааны чухал хэрэглэгдэхүүн болно.

Бид Шивээт хайрхны хадны зургийн дурсгалт газарт орших хүн чулуу, Хар салаа орчмын зэрэг 4 газарт панорамма хийв. Мөн Шивээт хайрхны хадны зургаас содон дүрслэлтэй хадны зургуудын 35 ш дардас авсан бөгөөд тэр орчимд сийлсэн бичээсний нөхөлт хийлээ.

Манай хээрийн судалгааны багийн ажлын хүрээнд Цагаан салаа/Бага ойгор, Шивээт хайрхан орчмын хадны зургууд дээрх гэмтэл буюу өнөө цагт хүмүүсийн гараар сийлсэн, бичсэн бичгүүдийг сэргээн засварлаж тухайн дурсгалын эх байдал, төрхийг хадгалах ажлыг хийх зорилт байсан.

Уг ажлын хүрээнд Шивээт хайрхны хадны бүлэг зургууд бүхий хавтан



чулууны зүүн урд хэсэгт байх томоохон хэмжээний морины дүрслэл бүхий зургийн доод хэсэгт 20см урт 3см өргөнтэй “СЕКУ-АЙНУ” гэж 3-4 мм өргөн зураас гаргаж 1-3 мм орчим гүн сийлж бичсэн байсан. Энэ нь дурсгалын үзэмж үнэ цэнийг алдагдуулж үндсэн дүрслэлийг бүдгэрүүлж байсан тул энэ хэсэгт сэргээн засварлах туршилт ажлыг хийхээр шийдсэн.



Сэргээн засварлах ажлыг эхлэхээс өмнө гэрэл зургаар уг дурсгалыг сүйтгэж гэмтээсэн хэсгийг баримтжуулж авсан ба этанол болон ацетон зэрэг химийн бодис хэрэглэн цэвэрлэгээ хийж уг хавтан хадтай ижил төрлийн, мөн ижил өнгийн чулууг ойр орчмоос хайж олон бутлаж нунтаглан ухаж сийлсэн хонхорхойг дүүргэх чигжээсэнд ашиглахаар бэлдэв.

Сэргээн засварлах ажлын хэрэгцээнд Орос улсад үйлдвэрлэсэн Moment эпокси цавуу болон Австри улсад үйлдвэрлэсэн Акерох2010 чулууны сэргээн засварлалтын ажилд хэрэглэдэг зориулалтын эпокси цавууг хэрэглэн нөхөлт хийсэн.





Дурсгалын гадаргууг сайтар цэвэрлэж хатаасны дараа эпокси цавуу/55-60%/нд чулууны нунтаг үйрмэг/35-40%/ болон Баян-Өлгий аймгийн Булган сумаас олборлож байсан цэвэр байгалийн гаралтай хуурай пигмент/5%/ ийг өнгө будгийг ойртуулах, дөхүүлэх зорилгоор хольж зууран хонхойлгон сийлсэн хэсэгт нарийн гар багаж ашиглан шавж, нөхөлт хийж сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэв.



Уг дурсгал орших тус газар нь 2450 м өндөрт орших ба байгаль цаг уурын онцгой ширүүн бүсэд байрлаж байгаа нь сэргээн засварлах ажилд хэрэглэсэн материалын чанарыг шалгах онцгой нөхцөл юм.

**Цагаан Салаа / Бага Ойгор:** Тус хадны зургийн дурсгалт газар нь аймгийн төвөөс баруун хойш 140 км орчим зайд орших бөгөөд үндсэн талбай 2100 га, хамгаалалтын бүс



3600 га, нийт 5700 га талбайг хамарна. Цагаан салаагийн гол, Бага Ойгурын голын савд

нийт арван мянга орчим тусгай хаданд дүрсэлсэн зохиомжийг олж бүртгэсэн бөгөөд нэг зохиомжид 1-100 хүртэлх хүн, амьтан дүрсэлжээ. Нийт хадны зургийг Цагаан салаа 1-5, Бага ойгор 1-5 гэсэн 10 хэсэг болгон хувааж тэмдэглэсэн байна. Эдгээрээс хамгийн эртний буюу дээд палеолитын (20 мянга орчим жилийн тэртээ) үед холбогдох цөөн тооны арслан зааны (Мамонт) зураг байдаг. Арслан зааныг ганц нэгээр нь, нэг тохиолдолд хоёр арслан зааныг өөд өөдөөс нь харуулан дүрсэлсэн байна. Арслан зааны урт хошуу, том сүрлэг зузаан бие, богино сүүл зэргийг тод гарган үзүүлжээ. Ийм арсан зааны зураг умард Азид ховор тохиолддог. 2018 онд Цагаан салаа/Бага ойгор дурсгалт газар, өмнө жил үлдсэн цэгүүдээс 2 газар панорамма хийв. Мөн хадны зургийн дурсгалт газрын бүст байгаа малчдын хаваржаа, намаржаа, өвөлжөө зэргийн байршлыг тогтоох ажлыг хийв.

Эдгээр байршлыг хадны зургийн дурсгалтай давхцуулан газрын зурагт буулгахад ихэнх вандализмд өртсөн хадны зургууд айлын өвөлжөө, хаваржаа, намаржааны ойр орчимд байгаа нь ажиглагдлаа.



Тиймээс хадны зурагт сөргөөр нөлөөлж байгаа хүний хүчин зүйлс нь ихэвчлэн нутгийн малчдаас үүдэлтэй байгаа нь харагдаж байна. Үүнд, ихэвчлэн хадны зураг дээр өөрсдийн нэр, он сар, элдэв зураг зурж сараачих, хадны зурагтай хадыг малын болон өвсний хашаа, хороо, байшин сууцандаа зөөж ашиглах зэрэг сөрөг үйлдлүүд хийж байна.

**Хар ямаатын хүн чулуун хөшөө:** Уг дурсгал нь Хул Алаг хэмээх уулын тэгш дэнжид байх гадуураа дугуй овгор шороон далан, төв хэсэгтээ хайрцаглан босгосон дөрвөлжин тахилын чулуун байгууламж түүний зүүн талд буй босоо хүн чулуун хөшөө, түүнээс зүүн зүг рүү цувуулан босгосон зэл чулуудаас бүрдэх бөгөөд Хүн чулууг азимутын 119 хэм чиглэлд зүүн урагш хандуулан газарт зоосон бөгөөд толгойн дээд хэсэг ихэд гэмтэн эвдэрчээ.



Хүн чулуун хөшөөг анх 1989 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн археологийн карт зохиолгохоор томилон явуулсан хээрийн шинжилгээний ангийнхан илрүүлэн олж судлан хүн чулуун хөшөө болон тахилын онгоны талаарх эрдэм шинжилгээний тодорхойлолтыг хийсэн байна.


Хүн чулуун хөшөөг анх 1989 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн археологийн карт зохиолгохоор томилон явуулсан хээрийн шинжилгээний ангийнхан илрүүлэн олж судлан хүн чулуун хөшөө болон тахилын онгоны талаарх эрдэм шинжилгээний тодорхойлолтыг хийсэн байна.

Түүнчлэн 2004-2005 онд Соёлын өвийн төвийн судлаачид Баян-Өлгий аймгийн нутгт ажиллахдаа тус хүн чулууны хуулбарыг хийж, ойр орчмоос нь баруун мөрний жижиг хагархай, зүүн нүд, хөмсөгний хэсгийг олж илрүүлэн эвлүүлэн наасан байдаг. Гэвч тухайн сэргээн засварлах ажилд хэрэглэсэн чулууны цавууны чанар муу байдлаас болж эвлүүлж наасан хэсгүүд дахин салж унасан байсныг 2017оны ажлын үеэр цуглуулж Соёлын өвийн үндэсний төвд түр хадгалж байсан. Эдгээр хэсгүүдийг дахин сэргээн засварлаж нааж бэхжүүлэхээр төлөвлөж 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан.

Хүн чулуу болон хагарч салсан хэсгүүдэд механик хуурай цэвэрлэгээ болон этанол болон усны 40% уусмалаар цэвэрлэгээ хийж хатаасны дараа Австри улсад үйлдвэрлэсэн Аке-рох2010 эпокси цавуугаар нэг бүрчлэн эвлүүлэн нааж бэхжүүлэв.



Хар ямаатын хүн чулууны үндсэн чулуу нь боржин чулууг бодвол нэлээд нягт хатуу бүтэцтэй, ур хийц нарийн чимхлүүр, хагарч салсан деталь хэсгүүдийн хэмжээ харьцангуй жижиг, өрөмдөж нүхэлж шаантаг бэхэлгээ хийхэд хагарч гэмтэх эрсдэл учирч болзошгүй тул



тус хүн чулууны хагарч салсан хэсгүүдийг эвлүүлж наахдаа өрөмдөж холбоос шаантаг хийхээс зайлсхийж эвээр нийлсэн хэсгүүдийг шууд эпокси цавуугаар нааж бэхжүүлэв.

Дурсгалын салсан хэсгүүд болох толгойн хэсэг болон нурууны ар хэсгүүдээс гадна дурсгалын эргэн тойронд дахин хайгуул хийж хүн чулууны ар хэсгийн жижиг хэсгийг шинээр олж эвлүүлж наав.

Мөн дурсгалын толгойн орой хэсгийн нэг ширхэг хагарч унасан деталь хэсэг нь үндсэн хэсэгтэйгээ холбогдох зааг хэсгийн хооронд нийлэх хэсэг дутаж байгаагаас эвлүүлж наах боломжгүй болсон тул уг хэсгийг буцаан Соёлын өвийн үндсний төвд авч ирсэн болно.

**Согоогийн гол (Багалзуур)-ын хүн чулуун хөшөө:** Өмнө өгүүлсэнчлэн монгол орны хүрлийн үед холбогдох хүн чулуун хөшөө судлаачдын лавтай тогтоосноор 3 ширхэг тэмдэглэгдсэний нэг Баян-Өлгий аймгийн нутагт байдаг боловч улсын бүртгэлд ороогүй байдаг. Тиймээс бид энэ удаа дээр хүн чулуун хөшөөг олж, бүртгэлд хамруулсан болно.

Тус хүн чулуун хөшөө нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 2-р багийн нутаг Согоогийн голын Багалзуур хэмээх газар оршдог (N 49 15 44.7 E88 59 12.5 alt 1990 m) аж. Хүн чулууг 124 см өндөр цайвар өнгийн урт нарийн боржин чулууг ашиглан, зөвхөн нэг талыг засаж хүний нүүрний хэлбэрийг гаргаж, хамар, ам, нүд зэргийг мэдэгдэх төдий сийлжээ.

Энэ жилийн хээрийн судалгаагаар Алтайн нурууны хадны зураг, тэр орчмын дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн анхан шатны судалгааг хийж, газрын зурагт тэмдэглэв. Мөн Шивээт хайрхны орчимд (вандализмд өртсөн) хадны зураг дээр сараачсан хэсгийг нөхөх, хар ямаатын хүн чулууг нааж материал хэрэглэгдэхүүнийг турших, арга зүй боловсруулсан болно. Тэрчлэн, Монгол Алтайн хадны зураг болон дурсгалуудын газар зүйн солбицлыг нарийвчлан тогтоож, зарим дурсгалуудыг шинээр болон давтан бүртгэн баримтжуулж авлаа.

Монгол Алтайн хадны зургийн хадгалалт хамгаалалтыг сурталчилгаагаар дамжуулан сайжруулах. Орон нутгийн иргэдийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, олон нийтэд Монгол Алтайн хадны зургийг хүртээмжтэй байдлаар сурталчлах цахим хуудас болон хэвлэмэл бүтээгдэхүүнд орох мэдээллийг цуглуулж авсан ба эдгээр мэдээллийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалсан болно.

## **2.2. Эрсдэл бүхий соёлын өвийг хамгаалах арга хэмжээ.**

- Увс аймгийн Давст сумын Шүдэн уулын олдворын хамгаалах арга хэмжээ авах,
- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Цагаан хаалга”-ны хадны оршуулгын дурсгалыг хамгаалах арга хэмжээ,
- Улс, аймгийн музейн үзмэр, музейн хадгалалт хамгаалалтын орчны үзлэг, дүгнэлт өгөх ажил. /Бүртгэл, судалгааны газрын тайланд дэлгэрэнгүй байгаа/
- СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын арга хэмжээ (Улаанбаатар хотод ирж суурьшсан СББӨ-ийг өвлөн уламжлагчдын судалгаа)






Увс аймгийн Давст сумын Шүдэн уулын олдворын хамгаалах арга хэмжээ авах.

Увс аймгийн Давст сумын нутаг Шүдэн ууланд 2017 оны 12-р сарын 4-ний өдөр хувиараа давс олборлолт явуулж байсан иргэд газрын гүнээс эртний хатмал шарил болон модон багажууд илэрснийг аймаг, сумын холбогдох байгууллагуудад мэдээлсний дагуу Давст сумын Засаг даргын захирамжаар дээрх олдворыг хамгаалалтад авч, ажлын хэсэг байгуулан дурсгалт газрын ойр орчмоос олдсон зарим олдвор хэрэглэгдэхүүнийг баримтжуулан сумын Соёлын төвд шилжүүлсэн байв.

Дээрх шарил болон олдворыг Увс аймгийн Засаг даргаас БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газар, Соёлын өвийн төвөөс мэргэжлийн баг ирүүлж нөхцөл байдалтай танилцаж, тодорхой дүгнэлт гаргаж, дараагийн шатны арга хэмжээг авч ажиллахыг санал болгосон 1/1413 тоот албан бичгийг аймаг, сумын Засаг даргын захирамж, ажлын хэсгийн тэмдэглэл, гэрэл зургийн хавсралтын хамт 2017 оны 12-р сарын 11-нд БСШУСЯ-ны сайд Ц.Цогзалмаад хандан ирүүлсэн байна.

Тус албан бичгийн дагуу Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн Түүх, археологийн



хүрээлэнгээс хамтарсан хээрийн шинжилгээний анги зохион байгуулж 2018 оны 1-р сарын 05-наас 12-ны хооронд 7 хоногийн хугацаатай Увс аймгийн Давст сумын нутаг Шүдэн ууланд ажиллав. Хээрийн шинжилгээний ангид Соёлын Өвийн Үндэсний төвийн мэргэжилтэн Г.Анхсанаа, сэргээн засварлагч Н.Бат-Эрдэнэ, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн мэдээллийн сан ба авран хамгаалах судалгааны салбарын

эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б. Б а т д а л а й , Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г. О д м а г н а й , УАЗ Пургон автомашины жолооч Л.Ойдовдагва нар оролцов. Мөн Увс аймгийн ОНС музейн бүртгэл мэдээллийн санч О.Мянганбуу, эрдэм шинжилгээний ажилтан н.Дүгэр болон Давст сумын Соёлын төвийн эрхлэгч С.Батмагнай нар хамтран ажиллалаа.



Шүдэн уулын урд энгэрт давс олборлож байсан талбайн гол хэсэгт газрын хөрснөөс доош 4.7 м гүнд эртний дарагдсан хүний хатмал шарилын хэсэг цухуйсан байдалтай байв. Тус шарилыг малтан гаргаж, түүний ойр орчмоос олдсон модон багажуудыг хамт Улаанбаатар хотод тээвэрлэн авчирсан бөгөөд авран хамгаалах судалгааны тайланг бичиж, орон нутагт нь хүргүүлсэн болно.

Хатмал шарил болон модон багажуудыг Соёлын өвийн үндэсний төвд цэвэрлэж, рентген, томографын шинжилгээ хийлгэсэн бөгөөд одоо ШУА-Түүх, археологийн хүрээлэнд нарийвчилсан судалгааг хийж байна.

*Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Цагаан хаалга”-ны хадны оршуулгын дурсгалыг хамгаалах арга хэмжээ.*

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2-р багийн нутаг “Цагаан хаалга” гэдэг газар орших хадны оршуулга тоногдсон гэсэн мэдээлэл 2017 оны 10 дугаар сард Тагнуулын ерөнхий газарт ирсний дагуу аймгийн тагнуулын хэлтэс, музейн хамтарсан ажлын хэсэг газар дээр нь очиж шалгаад, хадны оршуулга байгааг тогтоосон байна. Тус дурсгалт газар нь сумын төвөөс 22 км орчим зайд, ойр орчимд айл байхгүй, төв зам дагуу байрлалтай бөгөөд орон нутгийн хамгаалалтад авах боломжгүй тул яаралтай авран хамгаалах судалгаа хийлгэх хүсэлтийг аймгийн музейгээс Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд 2017 оны 11 дүгээр сард 121 тоот албан бичгээр, Соёлын өвийн үндэсний төвд 2018 оны 01 сарын 5 өдрийн 01 тоот албан бичгээр тавьсан болно.

Иймээс дээрх хадны оршуулга болон тэр орчимд яаралтай авран хамгаалах судалгааг зохион байгуулж, дурсгалыг малтан судалж, түүнд холбогдох олдвор, эд өлгийн зүйлсийг цаг алдалгүй баримтжуулан авах, сэргээн засварлах, тухайн олдворт газрыг нарийвчлан шалгах хээрийн судалгааны багийг Соёлын өвийн үндэсний төвөөс Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимтэй хамтран зохион байгуулж 2018 оны 01 дүгээр сарын 27-ноос 30-ны хооронд газар дээр нь ажиллав. Авран хамгаалах ажлын багийн бүрэлдэхүүнд; Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах газрын мэргэжилтэн Г.Анхсанаа, Сэргээн засварлах газрын сэргээн засварлагч Н.Бат-Эрдэнэ, Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн эрхлэгч, профессор

Д.Эрдэнэбаатар нар ажиллав. Орон нутгаас Баянхонгор аймгийн музейн ажилтан Д.Насантогтох, Шинэжинст сумын Соёлын төвийн эрхлэгч Ш.Мөнх-Эрдэнэ нар оролцлоо. Агуйгаас анатомийн байрлалаа алдаж, эмх замбараагүй болсон хүний гавалын яс, эрүүний хамт, хавирга (баруун, нэгдүгээр хавирганы мөгөөрсөн хэсэг буюу эгэмтэй уулзах хэсгээс бусад нь байна), баруун бугалга буюу атгаал чөмөг (бүтэн хэмжиж болохуйц), сүүжний яс гарлаа. Эдгээр ясны байрлал, хадгалалтын байдал зэргээс харвал хадны оршуулгыг өмнө нь нэг биш удаа тонож, агуйд буцаан хийсэн бололтой байна. Эндээс доош малтахад ямар нэгэн эд өлгийн зүйл илэрч олдоогүй тул малтлагыг дуусгав. Хүний ясыг Улаанбаатарын их сургуулийн Археологийн тэнхимийн Антропологийн лабораторид АТ-201801 дугаар дээр бүртгэн, хадгалав.

Авран хамгаалах судалгааны явцад Цагаан хаалга орчмоос (44.458620, 99.340035) нурсан чулуун байгууламж болон байгууламжийн арын хаднаас хоёр адууны дүрслэл бүхий хадны зураг шинээр илрүүлэн оллоо.

Мөн Шинэжинст сумын нутаг Хан уулын хадны зураг, булш, хиргисүүр бүхий дурсгалт дугуй дараастай 3 булшийг ойрын хугацаанд тонож сүйтгэсэн байлаа. 2015 оны үзлэг, тооллогод хамрагдсан бөгөөд тухайн үед бүрэн бүтэн байсан байжээ.



Авран хамгаалах судалгааны ажлын дэлгэрэнгүй тайланд дээрх дурсгалуудын тодорхойлолт, гэрэл зургийг хавсарган, шинээр илрүүлсэн хадны зургийн дурсгалыг аймгийн бүртгэл мэдээллийн санд холбогдох журмын дагуу бүртгэж авах, хууль бусаар тоногдсон тоносон дурсгалын талаар орон нутгаас холбогдох хуулийн дагуу тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгөв.

#### Улаанбаатар хотын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын эрсдэлийн судалгааны тайлан

Энэхүү судалгааг нийслэл хотын 60 дээш насны Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын шилжилт хөдөлгөөн, амьжиргааны түвшин (орлогын эх үүсвэр), эрүүл мэнд, тэдгээрт хүргэх эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хүчин зүйлсийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой явууллаа.

Судалгааг 2018 оны 12 дугаар сарын 03-21-ны хооронд Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа, Бүртгэл судалгааны газрын соёлын биет бус өвийн шинжээч Ж.Насанжаргал, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын техникч П.Чинбат, Захиргаа, удирдлагын газрын нярав С.Сайнзолбоо нар хийж гүйцэтгэсэн бөгөөд мөн нийслэлийн соёл, урлагийн газрын соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Ууганцэцэг, Багахангай дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн Н.Дэлгэр, Багануур дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн Н.Алтансүх, Баянгол дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн Э.Халиун, Баянзүрх дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн н.Цэцэгмаа, Налайх дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн н.Арьяабал, Сонгинохайрхан дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн А.Алтаншагай, Сүхбаатар дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн Ч.Золзаяа, Хан-Уул дүүргийн соёл




хариуцсан мэргэжилтэн Ц.Наран-Эрдэнэ, Чингэлтэй дүүргийн соёл хариуцсан мэргэжилтэн н.Эрдэнэ нар оролцов.

Дээрх судалгаанд зориулан 4 үндсэн хэсэг бүхий 22 асуулга бүхий анкет боловсруулан бөгөөд судалгаа явуулахаас өмнө дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд нийслэлийн соёл, урлагийн газартай хамтран нэг өдрийн сургалт хийж, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, соёлын биет бус өв, судалгааны анкетын талаар мэдээллээр хангасан болно

Судалгаагаар нийт Багахангай дүүргийн 5, Баянгол дүүргийн 12, Багануур дүүргийн 17, Баянзүрх дүүргийн 22, Налайх дүүргийн 16, Сонгинохайрхан дүүргийн 4, Сүхбаатар дүүргийн 8, Хан-Уул дүүргийн 13, Чингэлтэй дүүргийн 20 нийт 118 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг анкет ирүүлснээс 60 дээш насны 96 хүний анкет шаардлага хангаж байна.

**Ерөнхий мэдээлэл:** Судалгаанд хамрагдсан 96 хүмүүсээс 50, 52% эрэгтэй, 46, 48% эмэгтэй хүмүүс эзэлж байна (Диаграмм 1). Үүнээс Халх 72, Буриад 7, Казах 4, Захчин 3, Урианхай 2, Сартуул 2, Дөрвөд 2, Дархад 1, Баяд 1, тооны угсаатан байна (Зураг 1).

Дээрх цуглагдсан мэдээллийн 22 асуулга тус бүрээр тоон статистик гаргаж, амьжиргааны түвшний бодит нөхцөл байдлын тухай мэдээллээр Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан хадгалах ажлыг хийж байна. Ингэснээр Улаанбаатар хотын Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын талаар анхан шатны эрсдэлийн судалгааны аргачлалын туршлага бий болж, цаашид авах арга хэмжээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх судалгааны хэрэглэгдэхүүн бий боллоо.




Зураг 1




Зураг 2

Судалгаанд хамрагдсан дүүргүүдээс Багануур дүүргээс 15, Багахангай дүүрэг 5, Баянгол дүүрэг 6, Баянзүрх дүүрэг 19, Налайх дүүрэг 16, Сүхбаатар дүүрэг 4, Сонгинохайрхан дүүрэг 1, Хан-Уул дүүрэг 11, Чингэлтэй дүүрэг 18, өндөр настнууд судалгаанд оролцсон (Зураг 3).




Зураг 3.

Насны бүтцийн хувьд дийлэнх нь 62-оос 66 насны өндөр настнууд эзэлж байна



Зураг 4.

Нийт судалгаанд оролцогчдын олонх нь (хөгжмийн) багш, жолооч, оёдолчин зэрэг орж байна (Зураг 5).




Зураг 5.

Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд дийлэнх хувийг эзэлж байгаа ба эсрэгээрээ бага, бүрэн дунд тусгай боловсрол эзэмшиж байгаа иргэд цөөн тоогоор судалгаанд оролцсон байна (Зураг 6).



Зураг 6.

Судалгаанд хамрагдсан дүүрэг хороодын өндөр настай хүмүүсийн дийлэнх нь буюу 77.84% нь Тэтгэвэрт гарсан ба зарим өндөр настнууд хувиараа ажил эрхэлж байна (Зураг 7).




Зураг 7.

**Шилжилт хөдөлгөөн:** Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид нь Улаанбаатар хотод 1943 оноос 2003 оны хооронд шилжин ирсэн өндөр настнууд байгаагаас 1970-1973 онд судалгаанд хамрагдагчид хамгийн их шилжин ирсэн байгаа юм (Зураг 8).



Зураг 8.

Судалгаанд оролцогчдын шилжин ирсэн шалтгааны ихэнх нь хамаатан саднаа түших, гэрлэлт, ажлын шалтгаан, мэргэжил боловсрол эзэмших, хүүхдүүдээ сургуульд сургах зэрэг нь дийлэнх судалгаанд оролцогчдыг эзэлж байна (Зураг 9).




Зураг 9.

Судалгаанд хамрагдсан иргэдийн олонх нь Улаанбаатар хотоос оор аймаг сум руу шилжилт хөдөлгөөн хийхгүй гэсэн хариулт өгсөн байна (Зураг 10).



Зураг 10.

**Амьжиргааны түвшин:** Өвлөн уламжлагчийн судалгаанд хамрагдсан өндөр настнуудын хувьд ихэнх нь нэгээс дөрвөн ам бүлтэй хамтран амьдардаг (Зураг 11).



Зураг 11.

Манай улсын эдийн засгийн өнөөгийн байдалд үнэлгээ өгөхдөө судалгаанд оролцогчдын ихэнх хувь буюу 39.4% нь муу гэсэн үнэлгээ өгч байгаа нь өнөөгийн эдийн засаг сул муу байгаа нь харагдаж байгаа юм (Зураг 12).



Зураг 12.

Орлогын эх үүсвэрийн хувьд тэтгэвэр тэтгэмж ихэнх буюу 76% хувийг эзэлж байгаа ба үлдсэн хувьд нь бизнес, цалин, гар аргаар орлого олох зэрэг орж байна (Зураг 13).




Зураг 13.

Өрхийн орлогын хувьд эдийн засгийн байдал цалин тэтгэмж хөдөлмөр эрхлэлтээ дагаж байгаа үзүүлэлттэй байгаагийн судалгаанд оролцогчдоос ихэнх буюу 39.5% 38 иргэн хоёр зуун мянгаас таван зуун мянган төгрөгийн өрхийн орлоготой байна (Зураг 14).



Зураг 14.

Харин сарын орлогын хувьд тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ, хувиараа ажил эрхлэлт, шагнал урамшуулал, эдийн засгийн өсөлт бууралтаас хамааран судалгаанд оролцогчдын 58% нь 200000-500000 төгрөг, 26% нь 500000-750000 төгрөгийн сарын орлоготой иргэд ихэнх хувийг эзэлж байна (Зураг 15).



Зураг 15.

Судалгаанд хамрагчдын 48% буюу 45 нь орон сууц 32% буюу 30 нь хашаа байшинд суудаг үлдсэн хувь нь төрөл бүрийн байр орон сууцанд амьдардаг байна (Зураг 16).




Зураг 16.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь өөрийн өвийг г ашиглан орлого олох 17% нь тийм, 59% үгүй, 20% хааяа, 4% бусад төрөлд орж байна (Зураг 17).




Зураг 17.

Судалгаанд оролцогчдын нийгмийн халамж хүртэж байсан байдал тал дээр 56.6% хүртэж байгаагүй, 37.4% хүртэж байсан байна (Зураг 18).




Зураг 18.

**Эрүүл мэнд:** Нийт судалгаанд оролцогч иргэдийн 39 нь эрүүл мэнддээ анхаарч чаддаг, 27 нь дунд зэрэг, 13 нь бага зэрэг, 12 нь бүрэн анхаарч чаддаг, 5 нь бага зэрэг эрүүл мэнддээ анхаардаг гэсэн байна (Зураг 19).




Зураг 19.

Эрүүл мэнддээ хэр анхаардгаас шалтгаалан идэвхтэй дасгал хөдөлгөөний хувьд 33.35% үгүй (дасгал хөдөлгөөн хийдэггүй), 32.33% хааяа, 31.32% тийн дасгал хөдөлгөөн хийдэг байна (Зураг 20).



Зураг 20.

Харин судалгаанд оролцогчдын хууч өвчний хувьд 38 нь даралт ихсэх, 17 нь бусад өвчин, 14 нь гар болон хөлөөр өвдөх, 12 нь толгой өвдөх, 5 нуруугаар өвдөх, 5 зүрх өвдөх, 3 элэг уушгины хууч өвчтэй байна (Зураг 21).



Зураг 21.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бие чилээрхэж өвдөх үед хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авах 62 эмчээс, 17 гэр бүлээс, 10 уламжлалт эмнэлэг, 3 хорооны хэсгийн эмнэлэг, 1 эмийн санчаас авдаг байна (Зураг 22).



Зураг 22.


Харин эмнэлгийн үйлчилгээнд хэр хугацаанд хамрагдах сүүлд хамрагдсан байдал 2018 оны 12 сар 11 сард эмнэлгийн үйлчилгээг ихэнх иргэд авсан байна (Зураг 23).



Зураг 23.




Дээрх үйлчилгээ авсан хамрагдсан байдлыг харгалзан эрүүл мэндийн байгууллагаар үйлчилгээ авсан зардлын хувьд 11000-50000 төгрөг, 51000-100000 төгрөгийн хооронд үйлчилгээ авсан нь давамгайлж байна (Зураг 24)



Зураг 24.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн судалгаанд хамрагдсан иргэдийн жилд хэдэн удаа урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагддагт 22.23% нэг удаа, 27.29% хоёр удаа, 10.11% гурван удаа 35.37% хамрагддаггүй гэсэн судалгаа гарсан (Зураг 25).



Зураг 25.

**СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын арга хэмжээ (Улаанбаатар хотод ирж суурьшсан СББӨ-ийг өвлөн уламжлагчдын судалгаа)**

Энэхүү судалгаа нь нийслэл хотод бүртгэлтэй Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын шилжилт хөдөлгөөн, амьжиргааны түвшин (орлогын эх үүсвэр), эрүүл мэнд, тэдгээрт хүргэх эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хүчин зүйлсийн судалгааг хийж нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой бөгөөд 9 дүүргийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байгаа 1432 өвлөн уламжлагчаас 60-аас дээш насны хүмүүсээс социологийн үндсэн арга зүй болох тоон судалгааны аргад тулгуурлан социометрын асуулгаар түүвэрлэн анкет боловсруулан авлаа.

Судалгаагаар нийт 9 дүүргийн 180 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын амьжиргааны түвшний бодит нөхцөл байдлын тухай мэдээллээр Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан баяжуулсан бөгөөд Улаанбаатар хотын Соёлын биет бус өвийг өвлөн

уламжлагчдын талаар анхан шатны эрсдэлийн судалгааны аргачлал бий болж, цаашид авах арга хэмжээг тодорхойлоход ашиглах дэмжлэг үзүүлэх судалгааны хэрэглэгдэхүүн бий болов.

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН,  
АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ЭРҮҮЛ МЭНДИЙН СУДАЛГААНЫ АНКЕТ

Өвийн нэр .....  
Овог: .....  
Эцэг(эх)- ийн нэр: .....  
Өөрийн нэр: .....  
Хүйс: .....  
Яс үндэс: .....  
Төрсөн он сар өдөр:.....  
РД: .....  
Үндсэн: .....  
Захиргаа: .....  
Оршин суугаа хаяг: .....  
Мэргэжил: .....  
Боловсрол: .....  
Одоо эрхэлж буй ажил:.....  
Хуучнаар аль аймаг, хошуу: .....  
Алдар цол, гавьяа шагнал: .....  
Холбоо барих гар утас,  
гэрийн болон ажлын утас:.....

**Нэг. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН**

**1. Та Улаанбаатар хотод хэдэн онд шилжиж ирсэн вэ?**

1. ....он
2. **Хаанаас шилжиж ирсэн бэ? (Нөхөж бичих)**  
Аймаг/хот.....сум:.....
3. **Шилжин ирсэн шалтгаан ? (3 хүртэлх хариулт сонгож болно)**

1. Гэрлэлт
2. Сургууль төгссөний дараа хуваарилагдсан
3. Мэргэжил, боловсрол эзэмшихээр
4. Хүүхдээ сургуульд сургахаар
5. Ажлын шалтгаанаар
6. Ажил хайж
7. Хамаатан, садныгаа түшиж
8. Орон сууц-ахуйн нөхцөлөө дээшлүүлэх
9. Эрүүл мэндийн шалтгаанаар
10. Амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор
11. Бусад (бичнэ үү).....  
.....  
.....

**4. Ойрын хугацаанд өөр газар шилжин суух төлөвлөгөө байна уу?**  
(Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)

1. Тийм, хот дотроо нүүнэ
2. Тийм, аймаг руу
3. Тийм, сум руу
4. Тийм, хөдөө мал дээр гарах төлөвлөгөөтэй

5. Шилжихгүй, эндээ байна
6. Мэдэхгүй

**5. Шалтгаан нь юу вэ?** (Дараах зүйлсээс тохирч буй бүгдийг тэмдэглэнэ үү)

1. Амьдрахад илүү тааламжтай газар
2. Эрүүл орчинтой
3. Үр хүүхдээ сургах таатай
4. Нийгмийн үйлчилгээнд ойр
5. Амьжиргааны хувьд илүү таатай
6. Ажил олох боломжтой
7. Тайван амгалан
8. Эцэг эх, ах дүү нартайгаа ойр амьдрах гэж
9. Танил хүмүүс, дассан орчинтой учир
10. Гэр бүлийн гишүүдийн хамтын шийдвэрээр
11. Бусад.....

Хоёр. АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

**6. Танай ам бүлийн тоо?** .....

**7. Манай улсын эдийн засгийн өнөөгийн байдалд Та ямар үнэлгээ өгөх вэ?** (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)

1. Маш сайн
2. Сайн
3. Сайн ч биш, муу ч биш
4. Муу
5. Маш муу
6. Мэдэхгүй

**8. Таны орлогын эх үүсвэр?** (Хэдэн ч хариулт сонгож болно)

1. Цалин
2. Түр ажил хийдэг (төсөл, цагийн ажил)
3. Тэтгэвэр/тэтгэмж
4. Бизнес, наймааны ашиг
5. Малын үүлдрийг сайжруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлдэг
6. Ноос, ноолуурын орлого
7. Сүү цагаан идээгээ боловсруулж зардаг
8. Гар аргаар юм хийж зардаг (хоол, гар урлалын эд зүйлс)
9. Ногоо, тариа тарьдаг
10. Байр сууц, хашаа, зуслан түрээслүүлдэг
11. Хүмүүст мөнгө зээлүүлдэг
12. Хувьцаа, хадгаламжийн ашиг
13. Гар аргаар ашигт малтмал (жонш, нүүрс, алт г.м) олборлох үйл ажиллагааны ашиг
14. Гадаадад хөдөлмөр эрхэлдэг өрхийн гишүүний гуйвуулга
15. Хамаатан садан, бусад хүний бэлэг, туслалцаа авдаг
16. Тээвэр, таксинд явж олсон ашиг
17. Байгалийн баялаг (жимс, ан агнуур, загас)
18. Мод тарьдаг, цэцэрлэгжүүлэлт хийдэг
19. Мод бэлтгэдэг
20. Улирлын чанартай ажил
21. Бусад (нөхөж бичиж болно).....

.....  
.....

**9. Танай өрхийн сарын орлого хэд вэ (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. 0-190,000 төгрөг
2. 200,000-500,000 төгрөг
3. 501,000- 750,000 төгрөг
4. 751,000- 900,000 төгрөг
5. 901,000-1,5 сая төгрөг
6. 1,5 саяас дээш төгрөг

**10. Таны сарын орлого хэд вэ? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. 0-190,000 төгрөг
2. 200,000-500,000 төгрөг
3. 501,000- 750,000 төгрөг
4. 751,000- 900,000 төгрөг
5. 901,000-1,5 сая төгрөг
6. 1,5 саяас дээш төгрөг

**11. Танайх ямар сууцанд амьдардаг вэ? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. Хувийн байшин (Хаус)
2. Орон сууц
3. Хашаа байшин
4. Гэрт
5. Нийтийн байр
6. Түрээсийн байр
7. Бусад.....

**12. Та өөрийн өвлөн уламжилсан соёлын биет бус өвийг ашиглан орлого олж чаддаг уу? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. Тийм (төлбөртэй шавь сургалт явуулдаг г.м)
2. Хааяа (айлын найр, хуримд уригддаг г.м)
3. Үгүй

**13. Та ямар нэгэн байдлаар нийгмийн халамж хүртэж байсан уу? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. Тийм, Тийм бол ямар төрлийн халамж.....
2. Үгүй

Гурав. ЭРҮҮЛ МЭНД

**14. Та өөрийн эрүүл мэндийг хэрхэн үнэлэх вэ? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. Маш сайн
2. Сайн
3. Дунд
4. Муу
5. Маш муу

**15. Та өөрийгөө эрүүл мэнддээ хэр их анхаарч чаддаг гэж боддог вэ? (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)**

1. Бүрэн анхаарч чаддаг
2. Анхаарч чаддаг
3. Дунд зэрэг анхаардаг
4. Бага зэрэг анхаардаг

5. Огт анхаардаггүй

**16. Та идэвхтэй дасгал хөдөлгөөн, биеийн тамираар хичээллэдэг үү?**  
(Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу, бичиж болно)

1. Тийм бол ямар.....
2. Үгүй
3. Хааяа

**16. Танд ямар нэгэн өвчин бий юу?** (Хэдэн ч хариулт сонгож болно)

1. Толгой өвдөх
2. Даралт ихсэх
3. Зүрх өвдөх
4. Бөөр болон давсгаар өвдөх
5. Нуруугаар өвдөх
6. Гар болон хөлөөр өвдөх
7. Ходоодны шархлаа
8. Элэг, уушги
9. Бусад.....

**17. Таны бие чилээрхэж өвдөх үед та хэнд ханддаг вэ?** (Тохирох 1 хариултыг сонгож дугуйлна уу)

1. Гэр бүл
2. Эмч
3. Эмийн санч
4. Бөө
5. Лам
6. Уламжлалт эмнэлэг
7. Бусад.....

**18. Та хамгийн сүүлд хэзээ эмнэлгийн үйлчилгээ авсан вэ?**

1. ....(сар, жилээр)

**19. Та эрүүл мэндийн үйлчилгээ хаанаас авдаг вэ?** (Тохирох хариултыг сонгож дугуйлна уу)

1. Өрхийн эмнэлгээс.
2. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, амбулаториос
3. Мэргэжлийн эмнэлэг, (нарийн шинжилгээ)-ээс
4. Хувийн эмнэлгээс

**20. Та эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд нэг удаад хэр их мөнгө зарцуулдаг вэ?**

1. Мөнгө зарцуулдаггүй
2. 0-10,000 төгрөг
3. 11,000-50,000 төгрөг
4. 51,000- 100,000 төгрөг
5. 10,1000- 200,000 төгрөг
6. 20,1000 дээш төгрөг

**21. Та жилд хэдэн удаа урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагддаг вэ?**

1. Тоог бичнэ үү.....
2. Хамрагддаггүй

**22. Хамрагддаггүй бол Та ямар үед эмчийн хяналтад ордог вэ?** (Тохирох

хариултыг сонгож дугуйлна уу)

1. Эрүүл мэнддээ анхаарч урьдчилан сэргийлэх үүднээс
2. Биед ямар нэг зовуурь илрэх үед
3. Хүндээр өвдсөн үед
4. Бусад.....

### 2.3.Соёлын өвийг авран хамгаалах, ашиглах үндэсний сүлжээ болон оролцогч талуудын хамтын ажиллагааны систем бий болгох.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нэгдсэн систем бий болгох зөвлөлдөх уулзалт”-ыг хоёр үе шаттай хийв. Эхний зөвлөлдөх уулзалтыг палеонтологи, археологийн чиглэлээр судалгаа явуулдаг ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологи, геологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, ШУТИС-ийн БуХИС-ийн Хүмүүнлэгийн салбар, Улаанбаатарын Их сургуулийн археологийн тэнхим зэрэг мэргэжлийн байгууллагуудын 2018 оны -р 5 сарын 11, 15-нд хоёр удаа зохион байгууллаа. Уулзалтаар оролцогч байгууллагууд хамтран үндэсний сүлжээний бодлогын даалгавар боловсруулах, хийгдэх үйл ажиллагааны талаар танилцуулж, талуудын байр суурийг сонслоо.



Хоёр дахь уулзалт зөвлөгөөнийг 2018 оны 11 дүгээр сарын 16-нд газрын харилцаа, бүтээн байгуулалт болох уул уурхайн хайгуул, ашиглалт, төмөр ба авто зам, суурьшлын бүс газар олголт, газар тариалан, аялал жуулчлалтай холбоотой бодлого, төлөвлөлтийг хийдэг төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан зохион байгууллаа.



Тус зөвлөлдөх уулзалтад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Д.Батбаяр, Барилга, хот байгуулалтын яамны, Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн С.Оюунжаргал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн С.Энхтуяа, Газар зохион байгуулалт, зураг зүйн газрын ахлах мэргэжилтэн Э.Ариунцэцэг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Ч.Нацагням, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Р.Сийлэн, Газрын тос, ашигт малтмалын газрын төлөөлөл Н.Батсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Соёлын хяналтын улсын байцаагч Д.Отгонбаяр, Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгийн мэдээллийн сан, авран

хамгаалах салбарын эрхлэгч, доктор Ч.Амартүвшин, Өвөрхангай аймгийн, Хархорин сумын нутгийн зөвлөлийн дарга О.Чимгээ, экологич Д.Туяа болон холбогдох албаны хүмүүс, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцсон бөгөөд Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам (Төрийн албаны шалгалт давхацсан тухай Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн н.Амарзаяа утсаар мэдэгдсэн), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (Төрийн албаны шалгалт давхацсан тухай мэргэжилтэн н.Баярсайхан утсаар мэдэгдсэн), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас төлөөлөл ирээгүй болно.

Уулзалтыг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нээж, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын өнөөгийн байдал, нэгдсэн системийг бий болгох арга зам, урьдчилсан үр дүн” сэдвээр танилцуулга хийлээ.

Илтгэлийн дараа уулзалтад оролцогчид өөрсдийн салбарын бодлого, үйл ажиллагаа, онцлогтой холбогдуулан соёлын өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын талаар саналаа хэлэв. Үүнд, Соёлын өвийн хадгалалт хамгаалалт талаарх ууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, журам боловсруулж батлуулах, салбар хоорондыг бодлого, үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зэрэг асуудлыг хөндлөө.

Цаашид уулзалтаар хөндөгдсөн асуудлуудыг илүү нарийвчлан авч үзэх, салбар бүртэй тусгайлан уулзалтыг хийж, төлөөллүүдийн гаргасан саналыг тусгах талаар ажиллах нь зүйтэй хэмээн үзэв.

Энэ удаагийн зөвлөлдөх уулзалтаар Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын

өнөөгийн байдлын талаар оролцогчдод мэдээлэл өгч, салбаруудын цаашдын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд соёлын өвийн хадгалалт хамгаалалтын асуудлыг хэрхэн уялдуулах, дурсгалыг авран хамгаалах талаар нэгдсэн систем бий болгох арга замыг оновчтой тодорхойлох, бодит үйл ажиллагааг эхлүүлэх эхний алхмыг хийлээ. Тиймээс Соёлын өвийн үндэсний төвөөс ирэх оны эхний улиралд багтаан дараагийн уулзалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



### **Соёлын Өвийн Үндэсний төвийн ажилтнууд нь ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран Содномдаржаа ууланд байрлах өвгөн Гэсэр лам Ц.Чүлтэмжамцын занданшуулсан шарилд археологийн малтлага судалгаа хийсэн тухай**

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Соёлын Өвийн Үндэсний төвийн ажилтнууд нь Цахир сумын Хан-Уул багийн нутаг Хөх нуурын Содномдаржаа ууланд байрлах ард олноо “Өвгөн Гэсэр Лам” хэмээн өргөмжлөгдсөн Ц.Чүлтэмжамцын занданшуулсан шарилд археологийн малтлага судалгааны ажил хийв.

Уг дурсгал нь цагаан өндөр суварганы дотор талд байрласан углуурга гарган модон шургаагнуудыг зангидаж хийсэн модон бунхан (120см х 130см) хэмжээтэй байлаа. Модон бунханы дээр тавигдсан дараас банзнуудыг авахад модон бунханы дотор талд нь дөрвөлжин хэлбэртэй модон хайрцагны ирмэг цухуйсан бөгөөд дээд талын дараас шороог авч байхад хүний хавирганы яс 1ш, зүүн талын хайрцагны ирмэг орчмоос хүний хөлийн хурууны яс 1ш тус тус илэрч олдсон. Модон хайрцагны (94,5см х 83см хэмжээтэй) дотор хулгана жижиг мэрэгч амьтдын хөлөөр зарим нэг яснууд нь зөөгдөж байрлал нь өөрчлөгдсөн байна (хөлийн хурууны үены яс, нурууны нугалам, хавирганы яс гэх мэт).

Хайрцаг нь доторх шороо нь харавтар өнгийн хатаж дагтаршаагүй чийгтэй байсан ба малтлага хийж байхад хөх өнгийн нилээн муудаж сэмэрч бөөгнөрсөн хадагны хэсэг мөн сүүлийн үеийн төмөр зоосон мөнгө, жижиг хэмжээтэй шар өнгийн ембүү, шилны

хагархай, төрөл бүрийн чихрийн цаасны хэсэг, ундааны бөглөө, төмөр боолт, цаасан мөнгөны тасархай, цөгц, ногоон өнгийн жижиг бөөрөнхий дүү чулуу зэрэг зүйлс гарч байлаа.

Малтлагын ажлыг үргэлжлүүлж байхад модон хайрцагны зүүн талаас 3 ширхэг улаан өнгийн будагтай хайрцагны тагны банз (урт 76 см, өргөн 19 см орчим) доош цөмөрч унасан бололтой. Дараас банзны хажуу талаас 1 ш хүний хавирганы яс олдлоо. Хайрцагны таг бололтой 3 ш банзыг гаргаж авахад хүний биеийн ясны хэсгүүд цухуйж байв. Малтлага хийх үед ургамлын үндэсэрхүү маягийн хатуу бор иштэй зүйл (хатсан арц) их хэмжээгээр малын шагай 1 ш (богийн) цөгц, балны гэр, эрхи 1 ш (улаан өнгөтэй) зэрэг эдлэл гарав.

30 орчим см-ийн гүнээс хүний биеийн гар, хөл мөчдийн, нурууны, далны, толгойн яснууд илэрсэн бөгөөд малтлага цэвэрлэгээг хийхэд урагш харан завилж суусан, нуруугаараа урагш доошоо бөгтийсөн толгой нүүр хэсгээрээ газар харан унаж шороонд дарагдсан хүний биеийн зарим нэг ясыг эс тооцвол (хуруу, хавирганы яс) огт хөндөгдөж хөдөлгөөгүй үндсэн байрлалаараа байгаа хүний биеийн бүтэн яс илэрлээ.

Зүүн гарын мөчдийн ясны доод талаас шар өнгийн даавууны хэсэг очир 1 ш, хонх 1 ш, аяга 4 ш, дөрөвөлжин хэлбэртэй модон эдлэл 1 ш зэрэг шашны эдлэл хэрэглэл зэрэг зүйлс хайрцагны баруун хойд хэсгээс хүний шүд 1 ш олдлоо. Малтлага судалгааг үргэлжлүүлэн хийхэд улаан өнгийн даавуун эдлэлийн (хувцас) хэсгүүд хайрцагны ёроол болох шалан дээрээс илэрч олдлоо. Хүний биеийн ясыг цэвэрлэж, гэрэл зураг авч баримтжуулж авсны дараагаар хүний биеийн бүх яснуудыг цуглуулж авахд хамгийн доод талаас ямар эд эдлэл болох нь сайн мэдэгдэхгүй хурц эвгүй үнэртэй (50 см х 30 см хэмжээтэй) зөөлөн эд гарав. Ёроолын шал гарч ирснээр малтлага судалгааны ажил дуусав. Энэхүү малтлага судалгааны ажлыг цаг агаарын хүнд нөхцөлд хүчтэй салхи цасан шуургатай үед, мөн суварган дотор байгалийн гэрэлтүүлэг, харагдах орчин амьсгалах агаар муу маш их тоосжилттой цаг хугацаа давчуу зэрэг хүнд нөхцөлд малтлага судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэхүү малтлага судалгааны ажилд олон байгууллагын хүмүүс оролцож ажиллав.

Модон хайрцагнаас гарсан шашны гаралтай хэрэглэгдэхүүн:

№1. Хонхны ерөнхий урт 14,5 см, голч нь 9,1 см. иш нь 7,9 х 1,7 см

№2. 9,7 х 4,6 см харьцаатай модон эдлэл. 1 см тойрогтой 3 ширхэг нүх гаргаж үйлдсэн зориулалт нь тодорхойгүй.

№3. Цөгцний тойрог 4 см орчим, Суурийн 2,6 см ишний 0,7 см суурийн урт 2,3 см ерөнхий урт 4,6 см-тай 3 ширхэг цөгц олдлоо.

№4. 15 ширхэг элдэв төрлийн өнгийн чулуу, эрхи байх бололтой.

№5. Аяга. 6,9 см диаметртэй 3 ширхэг аяга. 1 эвдэрсэн аяга.

№6. Очир 9,6 х 2 см харьцаатай 1 ширхэг.

Модон хайрцагнаас гарсан сүүлийн үеийн зоосон мөнгө

№1. Зоосон мөнгө 5-тийн мөнгөн дэвсгэрт 2,3 см диаметртэй 6 ширхэг зоосон мөнгө, 2-тийн мөнгөн дэвсгэрт 2 см диаметртэй 4 ширхэг зоосон мөнгө, 50-тийн мөнгөн дэвсгэрт 2,8 см диаметртэй 1 ширхэг зоосон мөнгө, 15-тийн мөнгөн дэвсгэрт 2,5 см диаметртэй 2 ширхэг. 20-мөнгөн дэвсгэрт 2,5 см диаметртэй 1 ширхэг зоостой хамт, 2,2 см уртай ембүү олдсон байна.

№2. Шагай 2,8 х 2,9 х 1,8 см 1 ш.

## **ДҮГНЭЛТ**

Энэхүү археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын үр дүнд Архангай аймгийн Цахир сумын нутаг Содномдаржаа ууланл байрлах Өвгөн Гэсэр Лам Ц.Чүлтэмжамцын занданшуулсан гэх шарилд малтлага судалгааны ажил хийхэд модон бунханы дотор байрлах модон хайрцаганд хөндөгдөж эвдрээгүй завилж суусан хүний бүрэн бүтэн яс, шашны эдлэл хэрэглэл болох хонх 1 ш, аяга 4 ш (1 нь суурь хэсгээрээ хагарсан) очир 1 ш дөрвөлжиндүү модон эдлэл (3 нүхтэй), улаан өнгийн даавуун эдлэл (хувцас байж магадгүй) шар өнгөтэй даавуун эдлэл, суудлын дороос гарсан юу нь сайн мэдэгдэхгүй зөөлөн эд, хатуу бор ишүүдтэй (арц) төрөл бүрийн өнгийн жижиг чулуу, эрхи 15 ш, шагай 1 ш (богийн) орчин цагийн төмөр зоосон мөнгөнүүд, цөгц, цаасан



мөнгөний тасархай, төмөр халбага 1ш, балны гэр, төмөр боолт, төрөл бүрийн чихрийн цаас, хөх өнгийн хадагны хэсэг, шилны хагархай, ундааны бөглөө зэрэг эд өлгийн зүйл илэрч олдсоныг гэрэл зургийг нь авч баримтжуулан бүртгэж авлаа. Уг дурсгалд бороо цасны ус нэвтэрэн орсноор нойтон чийгтэй болж, хулгана мэрэгч амьтад дотор нь орж үүр хөөөөгөө засаж үүрлэн доторх хүний биеийн яс болон бусад эд өлгийн зүйлийг зөөж хөдөлгөн, зөөлөн эдийг мэрж идэн устаж хэмхрэх аюул ойрхон байсан байна.

## САНАЛ

1. Малтлага судалгаагаар илэрсэн хүний яс нь бүрэн бүтэн олдсон ба нас, хүйс, өндөр, паталогийн (эмгэг өөрчлөлт) гэх мэт палеоантропологийн хэмжилт судалгаа болон лабораторийн нарийн шинжилгээ судалгаа хийх. Уг дурсгалд бороо цасны ус орж нойтон чийгтэй хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдаж байсан учраас хэврэг болсон учир эвдэрч хэмхрэх аюулаас сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй.

2. Улаан өнгийн даавууны хэсэг, шар ангийн даавууны хэсгүүд илэрч олдсон бөгөөд ямар материалаар хийсэн яг ямар хувцас болохыг олж тогтоон сэргээн засварлах шаардлагатай байх. Мөн жижиг хэмжээтэй чулуу, эрхи зэргийг ямар үнэт чулуу болохыг нэр төрлөөр тогтоож судлах.

3. Хамгийн доод талаас гарсан зөөлөн эд 50 см х 30 см хэмжээтэй, мөн хар өнгөтэй зөөлөн эд энэ хоёр дурсгалыг лабораторийн шинжилгээ хийж яг ямар эд хэрэглэл болохыг нь тогтоосны дараа цаг алдалгүй нэн даруй хатаж муудахаас нь өмнө холбогдох байгууллагад нь хандаж сэргээн засварлах хэрэгтэй.

4. Малтлагаас гарсан модон хайрцаг, арцыг ямар нэр төрөл зүйлийнх болохыг нь тогтоох хэрэгтэй. (Нутгийн иргэдийн аман мэдээгээр хайрцагийг хуш модоор хийсэн гэдэг). Малтлага судалгаагаар илэрсэн дурсгал нь эртний түүхийн чухал дурсгал бөгөөд эдгээрийг судалж шинжлэх, хадгалж хамгаалахад хамтран ажиллана гэдэгт итгэж байна.



*Судалгааны ажил хийхэд оролцсон бүрэлдэхүүн*



*Цагаан суварганы гаднах байдал*

## **ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТ ХИЙГДСЭН АЖЛУУД**

Завхан аймгийн Нөмрөг сумын Хөдрөг багийн нутаг Өвөр шивэртэйн голын усанд унасан буган чулуун хөшөөдийг голын уснаас гаргаж, авран хамгаалах тухай албан бичгийг, зөөж тээвэрлэх тухай зөвлөмжийн хамт боловсруулан хүргүүлэв (Д.Нямдоржийн хамт)

- 2018 оны 4-р сарын 6-нд зохион байгуулсан улс, аймгийн музейн захирлуудтай хийсэн уулзалт зөвлөгөөнд “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, судалгаа” гэсэн сэдвээр танилцуулга хичээл боловсруулан уншив.
- 2018 оны 2-р сард “Чулуун соёлын өв” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнөх нөхцөл байдлын дүн шинжилгээг боловсруулан
- 2018 оны 2-р сард Газарзүйн мэдээллийн санд суурилсан цахим удирдлагын системийг соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын стратегид нэвтрүүлэх нь (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жишээн дээр) төслийг боловсруулав (М.Цэцэнбилэгийн хамт).
- 2018 оны 4-р сарын 18-наас 21-ны хооронд Архангай аймгийн ЗДТГ болон аймгийн музейгээс сумдын соёлын төвийн эрхлэгч, соёлын өвийн ажилтан нарын дунд зохион байгуулсан “Соёл, урлагийн ажилтнуудыг чадавхжуулах” сургалтад “Архангай аймгийн нутаг дах түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт” гэсэн сэдвээр хичээл бэлтгэж оролцов.
- 2018 оны 5-р сарын 17-ноос 28 хооронд Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын шороон бумбагар орчимд археологийн хайгуулын ажлын судалгааны ажлыг хийж гүйцэтгэн тайлан бичиж хүлээлгэн өгөв.
- 2018 оны 5-р сарын 30-31 нд Монгол Алтай нурууны хадны зургийн хадгалалт хамгаалалтын талаар хийж байгаа цахим хуудасны танилцуулга бичвэрийг боловсруулан хүлээлгэн өгөв.
- 2018 оны 6-р сарын 13-наас 16-ны хооронд БНСУ-ын Соёлын өвийн судалгааны хүрээлэнгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын хэлтэстэй хамтран Монгол улсын архитектурын дурсгалын аюулгүй байдал, гамшгаас хамгаалахтай холбогдолтой хээрийн тандалт судалгааны ажлыг Булган, Архангай, Өвөрхангай аймгийн нутагт хийв (М.Цэцэнбилэг, П.Чинбат нарын хамт).
- 2018 оны 6-р сарын 8-нд Нийслэлийн соёл, урлагийн газраас 9 дүүргийн соёлын ордны захирлуудын дунд зохион байгуулсан сургалтад “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэл” сэдвээр хичээл бэлтгэж заав.
- 2018 оны 6-р сараас 6 сарын хооронд нийт 8 удаа хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллагад лавлагаа, мэдээлэл бэлтгэн гаргаж өгсөн болно.
- 9-р сард Монгол банкны эрдэнэсийн сантай хийсэн гэрээний дагуу “Ховдын экспедиц”-ийн археологич Д.Навааны 1990 онд Алтай хот орчмоос олж илрүүлсэн эртний булшнаас олдсон мөнгөн бүсний он цаг, түүхэн ач холбогдол зэргийг тодорхойлох ажлын хэсэгт оролцож ажилласан (Г.Энхбат, У.Эрдэнэбат нарын хамт).
- 9-р сарын 17-ноос 25 хооронд Дундговь аймгийн нутагт орших Их газрын чулуу байгалийн цогцолбор газрын хамгаалалтын бүст Соёлын өвийн бүртгэл судалгааны ажил хийсэн бөгөөд тус бүртгэлийн ажлын хүрээнд 13 төрлийн 216 дурсгалын шинээр болон давтан бүртгэн баримтжуулж, тайлан, мэдээг СӨУНБМС хамгаалалтын захиргаа болон шат шатны бүртгэл мэдээллийн санд хадгалуулсан болно (Ц.Жаргалсайханы хамт ажилласан).
- 10-р сарын 18-д зохин байгуулагдсан Соёлын өвийн анхдугаар зөвлөгөөнд Г.Энхбат, Д.Нарантуяа, Ш.Энхтуяа нарын хамт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болон үл хөдлөх дурсгалын хамгаалалтад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс ба хадгалалт хамгаалалтын менежмент” сэдвээр илтгэл боловсруулж оролцов.
- 10-р сарын 25-31 хооронд Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт Соёлын өвийн бүртгэл судалгааны ажил хийсэн бөгөөд тус бүртгэлийн ажлын хүрээнд 10 төрлийн 155 дурсгалын шинээр болон давтан бүртгэн баримтжуулж, тайлан, мэдээг СӨУНБМС болон шат шатны бүртгэл мэдээллийн санд хадгалуулсан болно.
- 11-р сарын 12-нд Монголын соёлын ажилтны “Хөгжлийн эрин” холбооны санаачилгаар Монголын үндэсний музейгээс зохион байгуулсан “Соёлын өвд суурилсан орон нутаг

судлах танхимын үйл ажиллагаа” сэдэвт анхан шатны мэргэшүүлэх сургалтад “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт” сэдвээр лекц боловсруулан, уншив.

- 11-р сарын 19-нд Орхоны хөндийн соёлын дурсгалт газраас зохион байгуулсан “Соёлын өвийг хамгаалахад бидний оролцоо” сэдэвт сургалтад Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт” сэдвээр лекц боловсруулан, уншив (Ж.Насанжаргалын хамт явсан).
- 11-р сарын 20-нд Өвөрхангай аймгийн төв Арвайхээр сумын ойролцоо орших “Буга согоот”-ын хадны зургийн эрсдэлд орсон 3 хэсэг зурагтай хадыг аймгийн музей, сумын тамгын газар, мэргэжлийн хяналтын газартай хамтран аймгийн музейн байранд зөөж байрлуулах ажлын зохион байгуулж гүйцэтгэв (Т.Сүхбаатарын хамт явсан).
- Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу газрын харилцаа, бүтээн байгуулалт болох уул уурхайн хайгуул, ашиглалт, төмөр ба авто зам, суурьшлын бүс газар олголт, газар тариалан, аялал жуулчлалтай холбоотой бодлого, төлөвлөлтийг хийдэг төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн байгууллагуудыг оролцуулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нэгдсэн систем бий болгох зөвлөлдөх уулзалт”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 16-нд зохин байгууллаа.
- 11-р сарын 30-нд Г.Энхбатын хамт Байгаль, орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Аялал жуулчлалын судалгаа-2018” эрдэм шинжилгээний хуралд “Соёлын өв-Аялал жуулчлал” сэдэвт илтгэлийг боловсруулж, оролцсон.

### Нийтлүүлсэн бүтээл

**Г.Анхсанаа.** Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийн тухай // *Монгол улсад археологийн дурсгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх боломж (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)* Редактор: Ч.Амартүвшин. Улаанбаатар, 2017. т.14-24

**Г.Анхсанаа.** Олон индэртийн тамга тэмдгийн дүрслэлүүд // *Orhun' dan anadolu' ya uluslarasi türkoloji Sempozyumu. 1-7 Haziran 2018 Ulanbator-Moğolistan. Bildiriler kitabi. 1.CİLT. Editörler: Doc. Dr Saban Doçan. Istanbul, 2018. p.145-151.*

**Г.Энхбат, Г.Анхсанаа.** Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлс, нөлөөллийн зэрэглэлийг тогтоох асуудалд // Монголын соёл, урлаг судлал. Том 28. Fasc 8. УБ., 2018. т.107-117.

**Г.Энхбат, Г.Анхсанаа, Э.Батжаргал.** Соёлын өвийн үндэсний төвөөс Монгол нутаг дахь эртний түрэгийн үеийн дурсгалуудыг хадгалж хамгаалах талаар хийсэн ажлын тухай // *Orhun' dan anadolu' ya uluslarasi türkoloji Sempozyumu. 1-7 Haziran 2018 Ulanbator-Moğolistan. Bildiriler kitabi. 1.CİLT. Editörler: Doc. Dr Saban Doçan. Istanbul, 2018. p.687-692.*

**G.Ankhsanaa.** Overview of the archaeological survey done in western part of Khangai mountains (in the case of Zavkhan province) // Древние культуры Монголии, Байкальской Сибири и Северного Китая. Материалы IX Международной научной конференции (г. Улан-Удэ, 10–14 сентября 2018 г.) Том I. С.73-82.

**Г.Анхсанаа, Г.Батболд, Б.Амгаланбат.** VII зууны үеийн нанхиад бичээстэй нэгэн гэрэлт хөшөөний тухай // *Altaica XIV (Алтай судлал): Алтай судлалд зориулсан эрдэм шинжилгээний цуврал.* УБ., 2018. т.213-217.

**G.Enkhat, G.Ankhsanaa.** Mapping The Risk Assessment of Negative Impact Factors onThe Architectural Heritage in Territory of Mongolia // *The International Symposium on Earthquake Response for Architectural Heritage. (34122) □□□□□ □□□ □□□ 132. □□□ 2018□ 11 □ 14□ Pp.204-247.*

**Г.Анхсанаа, Э.Мижиддорж.** Хиргисүүрийн оршуулгын зан үйлтэй холбогдох хадны зураг // Монголчуудын хойлгын зан үйл:Уламжлал-орчин үе-чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын материал. УБ., 2018. т.47-54.

### 3.0. “СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗАР”-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

#### 3.1 Музейн, эрдэм шинжилгээний байгууллагад хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлсийг бэхжүүлэх, сэргээн засварлах

Улс, аймгийн 12 музейн 57 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах.

Баян-Өлгий музейн А.Айшагүл захирлын А/12 тоот тушаалаар 2018.03.30 өдөр 6 ширхэг үзмэр, Хөвсгөл аймгийн музейн Б.Ганзориг захирлын А/03 тоот тушаалаар 2018.03.09 өдөр 3 ширхэг үзмэр, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн У.Сарантуяа захирлын А/39 тоот тушаалаар 2018.04.11 өдөр 7 ширхэг үзмэр, Говьсүмбэр аймгийн музейн А.Ундармаа захирлын А/30 тоот тушаалаар 2018.01.30 өдөр 3 ширхэг үзмэр, Дорнод аймгийн музейн Н.Энхбаяр захирлын А/21 тоот тушаалаар 2018.03.30 өдөр 6 ширхэг үзмэр, Өвөрхангай аймгийн музейн Д.Тогтох захирлын А/02 тоот тушаалаар 2018.01.31 өдөр 2 ширхэг үзмэр, Хэнтий аймгийн музейн захирал Н.Нямсүрэн захирлын А/43 тоот тушаалаар 2018.03.20 өдөр 3 ширхэг үзмэр, Завхан аймгийн музейн Ж.Юнрэндорж захирлын А/06 тоот тушаалаар 2018.03.30 өдөр 1 ширхэг үзмэр, Монголын уран зургийн галерейн А.Янжив захирлын А/06 тоот тушаалаар 2018.03.01 өдөр 4 ширхэг үзмэр, Батлан хамгаалах яам Монгол цэргийн музейн З.Баярмагнай захирлын А/13 тоот тушаалаар 2018.02.28 өдөр 8 ширхэг үзмэр, Говь-Алтай аймгийн музейн Ц.Оюунзул захирлын А/23 тоот тушаалаар 2018.03.29 өдөр 2 ширхэг үзмэр, Монголын театрын музейн Д.Наранжаргал захирлын А/41 тоот тушаалаар 2018.03.29 өдөр 2 ширхэг үзмэр, Эрдэнэ-Зуу музейн ширхэг 10 ширхэг үзмэр нийт 57 үзмэрийг тус тус хүлээн авсан.

#### 2018 онд сэргээн засварлахаар төлөвлөсөн улс аймгийн музейн үзмэрүүд, музей болон төрөл зүйлээр ангилсан байдал

№	Үзмэрийн төрөл Музейн нэр	Баримал	Даавуу зөөлөн эдлэл	Модон эдлэл	Металл эдлэл	Уран зураг	Танка зураг	Цаас	Археологи	Нийт
1	Монгол цэргийн музей					6		1	1	8
2	Дүрслэх урлагийн музей		7							7
3	Хэнтий аймгийн музей	2				1				3
4	Баян-Өлгий аймгийн музей			6						6
5	Монголын театрын музей					2				2
6	Завхан аймгийн музей		1							1
7	Хөвсгөл аймгийн музей	1	1	1						3
	Говь-Алтай аймгийн музей		1	1						2
8	Өвөрхангай аймгийн музей		2							2
9	Монголын уран зургийн галерей	4								4
10	Дорнод аймгийн музей						5	1		6
11	Говьсүмбэр аймгийн музей						3			3
12	Эрдэнэ-Зуу музей				10					10
	Нийт	7	12	8	10	9	8	2	1	57

2018 онд улс аймгийн 12 музейн 57 ширхэг үзмэрийг сэргээн засварлахаар төлөвлөн ажилласан бөгөөд үүнээс 38 ширхэг үзмэрийн сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Эдгээрээс сэргээн засварлалтын ажилд хамрагдаагүй үлдсэн 19 ширхэг үзмэр, мөн 2016, 2017 оноос он дамжин сэргээн засварлалтын ажил хийгдэж байгаа болон хийхээр хүлээгдэж байгаа Эрдэнэ-Зуу музейн 5н Майдар, Чойжин ламын сүм музейн Аюуш, Жүгдэрнамжил, Цагаан дарь эх зэрэг томоохон хэмжээний танка зураг болон Улаанбаатар хотын музейн Монгол зөвлөлтийн найрамдал, Өвөрхангай аймгийн музейн Цахиур буу, Увс аймгийн музейн Дөрвөд цэгдэг тэрлэг зэрэг их хэмжээний гэмтэл бохирдол, сэргээн засварлалтын ажлын цаг хугацаа шаардсан үзмэрүүд, 2018 онд Хар балгасын археологийн малтлагаас олдсон олдворуудыг 2019 онд улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод хамрагдсаны дараа мөн оны эхний хагас жилд багтаан сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажилд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн 2018 онд нэмэлтээр ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээс шаазан ваар 2 ширхэг, даавуу зөөлөн эдлэл 5 ширхэг, үйсэн бичээс 23 ширхэг, Чойжин ламын сүм музейн Богдын тохойвч 2 ширхэг, Богдын сэнтийний лавир 1 ширхэг, Дундговь аймгийн музейн Жанч 1 ширхэг, Морин хуур 1 ширхэг, Орхон аймгийн музейн Балдан Лхам танка зураг 1 ширхэг, Баян-Өлгий аймгийн музейн Баатрын хөө хуяг 2 ширхэг нийт 5 байгууллагын 38 ширхэг үзмэрт сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажлыг хийхээр хүлээж авснаас 36 үзмэрийн сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн 2ш буюу Дундговь аймгийн музейн Жанч 1 ширхэг, Морин хуур 1 ширхэг үзмэрүүдийг 2019 оны эхний хагас жилд багтаан сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

2018 онд үр дүнгийн гэрээнд тусгагдсан 38 ширхэг үзмэр, нэмэлтээр 36 ширхэг үзмэр, археологийн олдвор нийт 74 ширхэг үзмэр, олдворт сэргээн засварлах, бэхжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн бол 2019 оны эхний хагас жилд сэргээн засварлалт, бэхжүүлэлтийн ажил хийгдэх нийт 32 ширхэг музейн үзмэр болон 47 орчим багц археологийн олдворууд байна.

Үзмэрүүдийн зонхилох хэсэг нь даавуу зөөлөн эдлэл, модон эдлэл, металл эдлэл, танка зураг зэрэг угсаатны зүйн эдлэл хэрэгсэл болон шашны эд агуурс байсан ба эдгээр үзмэрийн гэмтлийн зонхилох шалтгаан нь он удаан жилийн эдэлгээнээс үүдэлтэй хэрэглээний гэмтэл мөн музейн орчны хадгалалтын горим алдагдсанаас үүдэлтэй гэмтлүүд байна.

#### Чий будагтай аяганы материалын найрлагыг судлах ажлын тайлан

Энэ төрлийн судалгааг ШУА-ийн Физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Сарантай хамтран хийсэн ба дараах үр дүн, зөвлөмжийг боловсруулан ажиллаж байна.

Чий будагтай аягыг өнгөлөх, будах, хэвлэх, сийлбрлэх, сийлбэр хийх, шатаах үе шатуудын дараа алт эсвэл мөнгөөр өнгөлдөг ба будагч бодис нь чимэглэл болон хамгаалалтын үүргийг давхар гүйцэтгэнэ. Чий будгийн түүхий эд нь маш сайн байгалийн давирхай ба сүү-цагаа эсвэл сааралдуу цагаан өнгөтэй бөгөөд ердийн орчинд өнгө нь хувирдаг. Байгалийн давирхайг бүрхүүлт үрт ангилалд хамаарах модны судлуудаас гарган авдаг. Энэхүү мод нь ихэнхдээ уулархаг, дов толгод ихтэй шугуйд ургадаг. Түүхий давирхайг халааж усны агуулгыг бууруулсныг дараа тостой (tung-oil, тунг модны самрын тос) хольж, улмаар зарим пигментүүдтэй (эрдэст будаг, өнгө оруулагч) нэгдсэнээр өнгөтэй болохын зэрэгцээ элэгдэж, хүчилд тэсвэртэй, ус нэвтрүүлдэггүй, барьцалдах зэрэг шинж чанартай чий будаг болдог. Чий будгийн суурь ихэнхдээ модон эдлэл байдаг. Мод нь агаарт эвсэл газрын гүнд байгаагаас хамааран өөр хурдтай үхэждэг органик бодис юм. Үхжин процесст ялзрах, өмхрөх, хөгцрөх, өнгө хувирах, морин шоргоолж үүрлэх, хуурайших, илжрэх зэрэг хамаарна. Хэрэв мод нь удаан хугацааны турш чийг ихтэй хөрсөнд буюу намагт байвал илжрэх процесс явагддаг ба археологийн малтлагаар цус шингээлт нь 100-400% заримдаа 700%-д хүрсэн дээж малтан гарган авах элбэг байдаг.

Иймд чий будагтай аягыг хатаах процесс нь маш нарийн горимд явагдах ёстой. Чий будагтай аяга хэдэн мянган жил газар дор маш сайн хадгалагдсан байдаг. Зарим эдлэл нь температур, чийгшил, чийгийн хүчиллэг, хөрсний химийн шинж чанар болон булшин дахь агаарын чанараас хамаарч амьдрах хугацаа нь харилцан адилгүй байдаг. Хан гүрний үед хамаарах зарим булшнаас сав олон тооны чий будагтай аяга сав олддог бол зарим булш нь 6м гүнд хадгалагдаж, авсны температур нь 15-20С бол булшны гадна температур нь 18С байжээ. Бага температурын үйлчлэлд гэрлийн нөлөө, хүчилтөрөгчийг нэвтрүүлэхгүйгээр тогтмол чийгшилтэй, бактери үржих боломжгүй орчинд Чий будагтай аяга маш сайн хадгалагдаж байжээ. Малтаж гаргаж ирэнгүүт гадна агаарын нөхцөл харьцангуй тогтвортой орчныг сүйтгэж үүний үр дүнд лак маш богино хугацаан хагарч эхэлнэ. Зарим эдлэл гүний усанд нэвчихсэн байдаг учир чий будагтай аягыг хатаах болон хадгалахад анхаарах шаардлагатай.

Музейд чий будагтай аяга савыг тохиромжтой нөхцөлд хадгалах шаардлагатай байдаг. Тухайн эдлэлийн өнгө бүдгэрч, хуучрах, хүчилтөрөгчгүй болж хатах, гэрлийн нөлөөлөл, бохирдол зэрэгт байгалийн олон хүчин зүйлс нөлөөлж байна. Чий будагтай аяга чийгээр ханах тусам эзлэхүүн тэлэх хандлагатай байдаг. Энэ нь хуурайшилт, чийгшилтэй холбоотой байдаг. Эдлэлийг 12С температуртай, 60-65% -ийн чийгшилтэй, гэрлийн тусгал үл нэвтрэх чийггүй орчинд хадгалахад тохиромжтой бөгөөд чий будагтай аяга эдлэлийн гаднах хамгаалалтыг хэлтлэх, ан цав үүсэх зэрэг тохиолдлуудад тухайн эдлэл гэмтэх аюултай. Иймд эртний эдлэлийг хэвээр хадгалж бэхжүүлэхийн тулд тохиромжтой нөхцөлд хадгалж, хамгаалах хэрэгтэй. Чий будагтай аяганы /наалдамхай давирхай/ давхарга нь чийг үл нэвтрүүлэх давуу талтай ба тухайн олдворуудыг хадгалан хамгаалах туршилт судалгааны ажлыг дараах чиглэлээр явуулдаг.

Нэгдүгээрт: Чий будагтай аяганы модны чийгийг бууруулах явцад уг эдлэл анхны хэлбэрээ хадгалж буй эсэхийг судалсан.

Хоёрдугаарт: Лакан материалын бат бөх, эдэлгээ даах чанарыг сайжруулахад шаардлагатай материалыг сонгоход анхаарах. Анхдагч лакан материал эвдрэлгүй сайн хадгалагдсан тохиолдолд шинэ материал судлах шаардлагатай. Эдлэлийн чийгийг тогтмол бууруулсан сайн хадгалах хэрэгтэй. Хэрвээ лак муудаж хагарсан бол шинэ материалаар дүүргэж бэхжүүлдэг. Шинэ бүрэх материал нь чанарын хувьд анхныхтай ижил байх ёстой.

Чий будагтай аяга эдлэлийн чийгийг доорх аргуудаар шингээнэ. Үүнд:

- Байгалийн аясаар хатаах
- Вакуум хатаалт
- Органик уусгагч
- Шингээлтийг ихэсгэх

### *1. Байгалийн аргаар хатаах*

Чий будагтай аяга савыг тусгай орчинд буюу байгалийн аясаар уриншуулж хатаах боломжтой бөгөөд орчны чийгшил хэвийн хэмжээнд байх ёстой. Байгалийн аясаар хатаах нь усны тэнцвэрт байдлыг алдагдуулж ууршуулах сайн талтай бөгөөд хэд хэдэн аргууд байдаг. Үүнд:

- Тусгай хатаах хайрцаг- Чий будагтай аяга эдлэлийг шилэн саванд байршуулж, аажмаар эдлэлд агуулагдах усыг ууршуулах.
- Ороох буюу битүүмжлэх- эдлэлийг битүүмжлээд хатаах саванд байршуулна.
- Савыг үе үе нээж, доторх конденсацыг арилгах.
- Чийгшил өндөртэй камерууд- Эдлэлийг харьцангуй өндөр 95% чийгшил бүхий камерт байрлуулахад усны нэгдлээ аажмаар алддаг. Харьцангуй чийгшил өндөртэй хэсгийн усыг ууршуулах процесс нэгээс гурван жилийн хугацаанд явагддаг.
- Бунхан -Бунханд том хэмжээний олдворыг нойтон элс эсвэл үртсээр булж хадгалдаг. Элс болон үртэсний чийглэгийг үе үе хэмжих шаардлагатай бөгөөд чийг ихэссэн тохиолдолд сольж болно. Ингэснээр хүрээлэн буй орчны чийгшлийг хянах, биетэд агуулагдах усны хэмжээг багасгахад чухал ач холбогдолтой юм.

- Тогтмол температур- Эдлэлийг тогтмол температур буюу 32C болон харьцангуй чийгшилтэй хайрцагт байршуулах. Дөрвөн цаг тутамд объектуудыг гаргаж авч 10 минутын турш нэрмэл усанд дүрнэ. Даар нь хайрцгуудыг солино. Энэ процессыг хэдэн сарын турш үргэлжлүүлснээр ус ууршина.
- Глицерил шүрших- Объектуудын гадаргууг чийгтэй байлгаж, усыг ууршуулахын тулд глицерилийг шүршинэ. Глицерил нь усыг шингээх үүрэгтэй. Lacquerware эдлэлийн гадаргуугийн температурыг тохиромжтой нөхцөлд хүргэхэд түүнд агуулагдах ус ууршдаг.
- Органик бус давсны уусмалаар усыг ууршуулах- органик бус давсны уусмалыг Lacquerware эдлэлийн харьцангуй чийгшлийг багасгах зорилгоор хэрэглэдэг. Үүнд:  $\text{CuSO}_4$ ,  $5\text{H}_2\text{O}$ ,  $\text{KNO}_3$ ,  $\text{KCl}$ ,  $\text{NaNO}_2$  мөн  $\text{Mg}(\text{NO}_3)_2$  гэсэн нэгдлүүд хамаарна. Нэгдлүүдийг өөр өөр саванд хийнэ. Давсны уусмал бүр харьцангуй чийгшлийн янз бүрийн түвшнийг үзүүлдэг бөгөөд энэ нь 59-98%-ийн хооронд байдаг. Эхлээд эдлэлийн харьцангуй чийгшил өндөртэй саванд байршуулсны дараагаар чийгшлийг багасгахын тулд давсны уусмалыг хийхэд эдлэлийн чийг аажмаар багасна.
- Силикагель- силкагель нь гигроскопийн нэг хэсэг юм. Силикагель төрөл болон хэмжээний хувьд өөр өөр байдаг. Эдлэлийг хуурай чийггүй саванд хийж силикагелийг байршуулж, түүнд агуулагдах усны хэмжээг багасгаж болно.
- Дээрх аргууд нь энгийн бөгөөд эдийн засагт сөрөг үр нөлөөгүй юм. Эдгээр аргуудын сул тал нь хугацаа их шаарддаг.

## 2. Вакуум аргаар хатаах

- Чийгтэй чий будагтай аягыг доорх аргаар вакуум орчинд хатааж усыг ууршуулдаг.
- Вакуум хатаалт чийгээр ханасан эдлэлийг вакуум камерт байрлуулна. Вакуум даралт нь 700 мм мөнгөн усны багана (6.7\*Па) болж багасна.
- Шатаалтай вакуум хатаалт – Вакуум камерын тасалгааны температур 70C Зориулалтын хөдөлгүүрээр тухайн эдлэлийн усыг ууршуулдаг.
- Хөргөгчтэй вакуум хатаалт – орчны бага температурт эдлэлд агуулагдах ус хөлдөж эхэлнэ. Үүний дараагаар объектыг вакуум камерт шилжүүлэн хөлдөөж хатаадаг байна. Хөргөгчийн температур хамгийн багадаа -20C байхад ус богино хугацаанд хөлдөнө. Энэхүү арга нь барзгар давхаргатай, нягт нойтон модон эсвэл эвдэрч өмхөрсөн модонд тохиромжтой юм.

## 3. Органик уусгагч

- Энэ нь усыг ууршуулахад зориулагдсан шалгарсан аргын нэг юм. Органик уусгагчтай усанд эдлэлийг дүрж, нэвт шингээж болно. Ингэснээр чий будагтай аяганы ус ууршина. Энэ аргын давуу тал нь богино хугацаанд явагддаг бөгөөд гөлгөр гадаргуутай, нимгэн биетэд тохиромжтой.
- Алкоголь буюу эфир – спиртээр солигдсон байдаг. Үүний дараагаар объектыг орчны температурт байршуулна. Диэтилийн эфир, пропан2 –  $\text{ol}$ , 2 метилпропан хэрэглэж болох бөгөөд эдгээрээс диэтилийн эфирийг түгээмэл хэрэглэдэг. Энэ арга нь илжирч, өмхөрсөн модон эдлэлд хамгийн тохиромжтой юм.
- Ацетонитрил - ацетонитрил нь ус шингээх чадвар сайтай бөгөөд эдлэлийн гадаргууг гэмтээхгүй давуу талтай. Эдлэлд агуулагдсан ацетонитрил нь диэтилийн эфирээр тус тус солигдсон байдаг. Үүний дараагаар чий будагтай аягыг орчны температурт эсвэл вакуум орчинд байршуулсан байгалийн аясаар диэтилийн эфирийг ууршуулдаг. Энэхүү арга нь хэврэг эдлэлүүдэд нэн тохиромжтой.

## 4. Шингээлтийг ихэсгэх:

- Органик болон органик бус полимер өндөртэй болон модны нүхжилтийг дүүргэх зорилгоор ашигладаг. Энэ арга нь модны ашиглалтыг саармагжуулах ба усанд нэвчсэн чий будагтай аяганд хэрэгддэг.
- $\text{ALK}(\text{SO}_4)_2 \cdot 12\text{H}_2\text{O}$  хөнгөн цагаан калийн сульфатын гидрат нь халуун усанд маш

амархан уусдаг. Тасалгааны температурт ч уурших чадвартай. Температурын өөрчлөлтөөр  $ALK(SO_4)_{12}H_2O$  конденсацын төлөв байдал өөрчлөгддөг. Өндөр температурт  $ALK(SO_4)_{12}H_2O$  нь чий будагтай аяга саван дахь усны нэгдлийг ууршуулдаг бол нам температуртай  $ALK(SO_4)_{12}H_2O$  нь эдлэлийг хатууруулж, кристалжуулдаг.

- Полимер өндөртэй материал
- Монимер шингээх чадвар
- Усгүй өндөр полимер шингээлт /байгалийн гаралтай полимер/
- Устай өндөр полимер шингээлт- эдлэл нь усанд уусдаг полимер материалаар ханахад тухайн ханасан усыг ууршуулж дараа нь хатууруулна. Үүнд: полиэтилин гликол, фенолын давирхай гэх мэт. Полиэтилийн нь хэрэглэхэд хялбар, хямд, хоргүй, цэвэр, шатамхай бус материал юм.
- Чий будагтай аяганы материалын FTIR болон SEM-EDX-ийн хэмжилтийн үр дүн:
- Чий будагтай аяганы хэсгүүдийг (гаднах үе буюу улаан, хар болон цагаан будагтай хэсэг болон хоорондын сүлжмэл даавуу хэсэг) инфра улаан гэрлийн спектрокопи (FTIR)-ийн хэмжилтийн тусламжтай судалсан. Дээж тус бүрээс сорицолж КВг-той ойролцоогоор 1:100 харьцаагаар хольж, гар прессийн тусламжтайгаар дарж шахмал хэлбэрт оруулан хэмжив. Хэмжилтийн үр дүнг тайлахад IRUG data base болон бусад судалгааны үр дүнг ашиглав.

### **3.2. Шороон бумбагарын дурсгалт газрын ханын зургийн цэвэрлэгээ, судалгааны ажил.**

**Шороон бумбагарын дурсгалт газар өвөл, хавар, зун, намрын цэвэрлэгээ, бичил цаг уур, орчны мэдээллийн судалгаа, дурсгалын ойр орчмын бүртгэл, тандалт судалгаа**

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунхант булшины хяналт, шалгалтыг тайлант хугацаандаа 2 удаагийн судалгааг дурсгалт газар хийлээ.

*Эхний удаагийн хяналт шалгалт судалгаа.* Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунхант булшны доторх модон бэхэлгээ хэсэгт үүссэн хөгц мөөгөнцрийн бохирдол, хананд үүссэн микро организм, өмнөх намар буюу 2017 оны 11-дүгээр сард хийсэн дулаалга битүүмжлэлийн нөхцөл байдлуудад хяналт, шалгалт хийх болон бунхан дотор мөн гадна байрлуулсан бичил цаг уурын хяналтын төхөөрөмжүүдээс мэдээлэл хуулах зорилгоор Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлагч, судлаач Э.Батжаргал болон Япон улсын Киотогийн их сургуулийн докторант, сэргээн засварлагч, судлаач О.Ангарагсүрэн нарын бүрэлдэхүүнтэй баг 2018 оны 01-р сарын 26-нд дурсгалт газарт ажиллав.

*Бунхны гадна болон дотор талын нөхцөл байдал.*

Бунхны гадна талд  $-32^{\circ}C$  градус, бунхны хамгаалалтын байгууламж дотор  $-13^{\circ}C$ , бунхан дотор  $-1^{\circ}C$  градус гэж хяналтын төхөөрөмжүүд зааж байв. Гаднах болон доторх температурын эрс тэс өөрчлөлтөөс хамаарч мөн бунхан дээр барьсан хамгаалалтын байгууламжийн дулаалга хангалттай биш байгаа зэрэг шалтгааны улмаас хамгаалалтын байгууламжийн таазанд цан маш ихээр үүссэн байв. Энэ үүссэн цан нь хавар болж гаднах температур нэмэх градуст шилжих үед хайлан бунхан доторх чийгийг их хэмжээгээр өсгөж нэгэнт үүссэн микро организмуудын өсөж үржих, ургах таатай нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй хөрсөнд шингэж бунхны зураг бүхий ханын гадаргаар ууршилт явагдсанаар давс дахин талстжих үзэгдлийг дэмжих аюултай байна.





*Дулаалгын хучлагыг сөхөн бунхан руу орох үед*

Дулаалгын хучлагыг сөхөх үед мөн байгууламжийн доторх градус болон бунхан доторх градус температурын зөрөөнөөс хучлага доор цан маш их үүссэн байв. Энэ нь мөн дээр дурдсанчлан дурсгалд маш аюултай.



Дурсгалын байдалтай танилцахад

Бунхны үүдэвчний үүдэн хэсгээр баруун болон зүүн хананд давс үргэлжлэн ургасан хэвээрээ бөгөөд жижиг нурултууд явагдсаар байна.





Үүдэвчний доод хэсэг болон 1-р өрх, 2-р өрх, 3-р өрх, 4-р өрх, бунхан хэсгүүдэд зургийн гадарга дээрх гэмтэл харьцангуй бага тогтвортой байдалтай байна.

- Микро организм болон модон байгууламжийн тухай

Бунхны хамгаалалтын модон байгууламжид үүссэн микро организм буюу мөөгөнцрийн хувьд харьцангуй бага байсан бөгөөд бунхан болон баруун, зүүн хоёр хөмөг хэсгүүдээр мөөгөнцөр ургаж эхэлж байгаа нь ажиглагдав.



Мөн үүдэвчний зүүн хэсэгт урьд өмнө нь харагдаж байгаагүй мөөгнүүд ургасан байв.

Дурсгалыг нурахаас сэргийлэн хийсэн модон бэхэлгээ нь дурсгалыг анх нээгдэхэд хийгдсэн ба 5 жилийн аюулгүй байдлын баталгааг тухайн үед бэхэлгээг хийсэн уурхайн



аврах ангийнхан өгч байсан бол өдгөө энэ хугацаа нь дууссан байгаа юм.

Бунхны хамгаалалтын бэхэлгээний харьцангуй ачаалал багатай хэсэг гэж үзэж болох энэхүү хөмөг хэсгийн бэхэлгээний мод ялзарч муудан нурж унаж эхэлж байгаа нь дурсгалын аюулгүй байдалд аюул нүүрлэж байгааг илтгэж байна. Иймд бунхны бэхэлгээг яаралтай шинэчлэх шаардлагатай байна.


Бунхан дотор болон гадна байрлуулсан хяналтын төхөөрөмжийн мэдээлэл.

Эдгээр хяналтын төхөөрөмжүүдийг 2017.03.09-нд Япон улсын Киотогийн Их сургуулийн багш нар болон тус сургуулийн докторант О.Ангарагсүрэн мөн Монголын соёлын өвийн төвийн сэргээн засварлагч, судлаач Д. Нямдорж, Э.Батжаргал, Н.Бат-Эрдэнэ нар явж байрлуулсан.


Энд 2017.09.01- 2018.01.29-ны хүртэл мэдээллүүдийг график зургаар оруулав.

Үүдэвч хэсгийн хамгийн урд байрлах Sensor-01


- Хар зураас нь °C буюу температур
- Хөх зураас нь PH% буюу харьцангуй чийг
- Ногоон зураас нь Pt, °F буюу шүүдэр




Үүдэвч хэсгийн дунд газар байрлах Sensor-02




Үүдэвч хэсгийн хамгийн хойно байрлах Sensor-03




1-р өрхөнд байрлах Sensor-04




2-р өрхөнд байрлах Sensor-05




3-р өрхөнд байрлах Sensor-06




4-р өрхөнд байрлах Sensor-07




Бунхан дотор газар Sensor-08




Бунханд таазнаас өлгөөтэй байрлах Sensor-09




Үүдэвч хэсгийн дунд дээр байрлах Sensor-10



Бунхны хамгаалалтын байгууламжийн дотор таазнаас өлгөөтэй байрлах Sensor-11




Бунханы байгууламжийн гадна талд байрлах Sensor-12




Мөн ЮНЕСКО-ийн МОНАКО дахь итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж буй “Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах нь” сургалтын үеэр 2017.04.13нд Итали багш нар хоёр хяналтын мэдрэгч тавьсан. Энэ хяналтын мэдрэгчүүдийг 2017.11.16-нд шалгах үед гурав хоног ажиллан зогссон байсан ба мэдээллийг хуулж аван хяналтын мэдрэгчүүдийг дахин эхлүүлсэн бөгөөд 2018.01.26-нд шалгах үед мөн гурав хоног ажилдаа зогссон байв. Эдгээр даталоггеруудын цуглуулсан мэдээллүүдийг хуулж аван дахин эхлүүлж тавив. Үүдэвчний хэсэгт байрлах хяналтын мэдрэгчийн мэдээлэл

- Улаан зураас нь °C буюу температур
- Шар зураас нь RH% буюу харьцангуй чийг
- Ногоон зураас нь Pt, °F буюу шүүдэр



Байгууламжин үүдэвчний баруун талд таазнаас өлгөөтэй байрлах мэдрэгч



Байгууламжин үүдэвчний баруун талд таазнаас өлгөөтэй байрлах мэдрэгч

Дүгнэлт:


Дурсгалыг нурахаас сэргийлэн хийсэн модон бэхлэлтүүд нь органик гаралтай учир чийг болон температурт урвалд орж, өгөршиж, муудаж, мөөгөнцөр үүсэн ургахад маш таатай нөхцөл болж байгаа.

Улмаар өгөршиж муудсан мод нь нурах эрсдэлтэй мөн мөөгөнцрүүд нь дурсгалын ханын зураг руу тархаж ханын зургийн хадгалалтад муугаар нөлөө үзүүлж байгаа учир эдгээр нурахаас сэргийлэн хийсэн модон бэхлэгээг, ЮНЕСКО-ийн МОНАКО дахь итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байсан “Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах нь” сургалтын үеэр мэргэжилтнүүдийн зөвлөснөөр даруй ган буюу зэвэрдэггүй металл хийц бүхий тулгуураар солих шаардлагатай байна.

Мөн давс урган ханын зургийг гэмтээж байгаа нь орчны чийг болон температур, хөрсний чийг болон температураас шууд харьцангуй хамаарч байгаа тул үүнд судалгаа хийж туршлагатай гадаад болон дотоодын эрдэмтэн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж дурсгалын хадгалалтын орчныг тогтвортой болгох, гэмтлийг зогсоох шаардлагатай гэж үзэж байна.

*Хоёр дахь удаагийн хяналт шалгалт, судалгаа.* Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын бунхант булшны дотоод хамгаалалтын модон хийц болон хананд үүссэн микро организмыг цэвэрлэх, бичил цаг уур, орчны тандалт судалгааны даталоггеруудаас мэдээлэл хуулж авах, дурсгалын цаг үеийн байдалтай танилцах ажлыг хийхээр Соёлын өвийн үндэсний төвийн СБӨСЗГазрын сэргээн засварлагч Э.Батжаргал, Т.Сүхбаатар, С.Даваадарь, Д.Нямдорж нарын бүрэлдэхүүнтэй баг 2018 оны 6-р сарын 20- 23-нд дурсгалт газар томилогдон очиж ажиллав.

Дурсгалын байдалтай танилцахад бунхны үүдэвч хэсэгт нэлээд чийгшил өндөр ханын зургийн дээд хучилтад их хэмжээний усны уураас үүдэлтэй чийг усан дуслууд




хуримтлагдаж тогтсон байсан ба энэ нь халуун дулааны улирал эхэлж гадаах огцом халалтыг хамгаалалтын байгууламж тусгаарлаж чадахгүй байгаатай холбоотой ба энэ халалт нь бунхны гүнээс гадагш чиглэх сэрүүн агаар хучилтын давхаргад мөргөлдөж конденсац явагдаж процесстой хамааралтай гэж үзэж байна.





Энэ хуримтлагдсан ус чийг доош дусаж ханын зургийн гадаргад бууж үүдэвч хэсгийн ханын зургийн зарим хэсгээр нийлээд хөндийрөл үүссэн байв.

Үүдэвч хэсгийн чийгшил өндөр байгаатай холбоотой давс талстжих үзэгдэл харьцангуй бага боловч үүпэвч хэсгийн хойд хэсгээр буюу бунхан тал руугаа зарим хэсгээр бага зэрэг давсны ширхэг үүссэн байв.



Хамгаалалтын модон байгууламж болон ханын зураг хэсэгт хөгц мөөгөнцөр харьцангуй бага боловч зарим хэсгүүдэд хөгц мөөгөнцөр бага хэмжээгээр үүссэн байв. Хөгц мөөгөнцөр харьцангуй бага байгаа нь өвөлжилтийн тогтвортой орчныг хангах зорилгоор хийсэн хучилт нь бунхан болон өрх, арктай дамжих хэсгүүд буюу гүний хэсэгт доторх бичил цаг уурын орчныг харьцангуй тогтмол байлгаж байсантай холбоотой гэж үзэж байна.



Бунхны хэсгийн зүүн урд хана, хойд хана, бунханд нэвтрэх хэсгийн арк зэрэг зарим хана болон нэвтрэх хэсгийн арк зэрэгт ханын үндсэн чулуулагт нуралт үүссэн ба зүүн талын хөмөгний модон бэхэлгээний моднууд ялзарч муудсаны улмаас хугарч унасан, нуралт үүссэн байдалтай байв.




Дурсгалыг нурахаас сэргийлэн хийсэн энэхүү модон бэхэлгээ нь дурсгалыг анх нээгдэхэд хийгдсэн ба 5н жилийн аюулгүй байдлын баталгааг тухайн үед бэхэлгээг хийсэн уурхайн аврах ангийнхан өгж байсан бол өдгөө энэ хугацаа нь дуусаж байгаа гэдгийг дахин дурдах нь зүйтэй юм.

Хийгдсэн ажлууд:

- Бунхны модон бэхэлгээ, ханын зурагт үүссэн хөгц мөөгөнцрийг хлорын 5%-8%-ийн усан дахь уусмалаар ариутгаж томоохон хэмжээний голомт бүхий хэсгүүдийг ариутгасны дараа механик аргаар цэвэрлэгээ хийв.

- Үүдэвч хэсэгт чийгний улмаас үүссэн өнгөн давхаргын хөндийрлийг зөөлөвч бүхий хийтэй резинэн бээлийгээр хийсэн жинтүүгээр буцааж зөөлөн дарж буулгав.

Үүдэвч хэсэгт чийг их хэмжээгээр хуримтлагдсан байсан тул үүдэвчний урд талаас дунд хэсэг хүртэл хучилтыг нээж ханын зургийн харалдаа дээд хэсгээр агаар солилцох, амьсгалах зай завсар гарган гол хэсгийг хэт хурдан хаталтаас хамгаалах зорилгоор хөөсөнцөр хавтангаар хааж тавив.



**3.3. Алтан овооны хүн чулуу, түүний дэргэдэх самбар танилцуулгыг хадгалж, хамгаалах.**

**Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Алтан овооний дэргэдэх хүн чулуун дурсгалт газар. Хүн чулуунд цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийх, дурсгалт газрын дэргэдэх Чулуун танилцуулга самбар эвдэрснийг шинээр засан сэлбэх**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Алтан овооны хүн чулуу, түүний дэргэдэх самбар танилцуулгыг хадгалж, хамгаалах мөн Ламтын хүн чулуудын биологийн болон бусад бохирдлыг цэвэрлэх, гэмтсэн буюу салсан хэсгүүдэд бэхжүүлэлт хийх, салсан хэсгийг буцааж наах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн дурсгалын хадгалалтыг сайжруулах ажлыг хийх хэмээн тусгагдсаны дагуу Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын ахлах сэргээн засварлагч Д. Нямдорж, А. Мөнгөнцоож, Н. Бат-Эрдэнэ, Э. Батжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг 2018 оны 6 дугаар сарын 28-аас 7 дугаар сарын 3-ны хооронд томилогдон дурсгал оршиж буй Сүхбаатар аймгийн Дарьганга суманд очиж ажиллав.

Алтан овооны хүн чулуу, түүний дэргэдэх самбар танилцуулгыг хадгалж, хамгаалах ажил.

Тус дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулах чулуун самбар байршуулсан газар нь элсэрхэг хөрстэй ба уг элсэн хөрс нь хаврын салхинд идэгдэж элэгдсэний улмаас

танилцуулга чулуун самбар нүүрэн талаараа газар унаж улмаар самбарын нүүрэнд байх танилцуулга бичигтэй хэсэг хагарсан ба тус танилцуулга самбарыг дахин өөр газар шинээр байрлуулж тавьсан гэж тус сумын соёлын төвийн ажилтан танилцуулав.



Хагарч унасан танилцуулга нь нэлээд олон хэсэгт хуваагдаж хагарсан байна.

*Иймд дурсгалын танилцуулга бичгийг дахин шинээр ижил хэмжээтэй захиалж хийлгэн авч очиж хагарч унасан хэсгийг нөхөж гүйцээв.*



### Ламтын хүн чулууны сэргээн засварлалтын ажил

Уг дурсгалт газар 2ш хүн чулуу байх ба нэг хүн чулууны толгой наасан хэсгээрээ салсан байна.

Уг дурсгалыг 2013 онд сэргээн засварлаж салсан толгой хэсгийг нааж байсан ба мөн үед хэрэглэсэн цавууны чанар муу, манай орны цаг уурын нөхцөл хатуу ширүүн гэх зэрэг шалтгаан, нөхцөл байдлын улмаас наасан хэсгээрээ салсан байна мөн баруун гарт барьсан аяганы нааш илүү гарсан хэсэг хагарч салж унасан байна.

Өмнөх сэргээн засварлалтад хэрэглэсэн цавуунаас маш бага хэсгүүд чулууны гадаргад наалдаж үлдсэн, жижиг хэсэгт хагарч үйрсэн шинж байдалтай үлдсэн байна.

Мөн чулуунд бага зэрэг хаг ургасан, мал шөргөөж хир тос тогтож халтартсан байв. Дурсгалын бохирдлыг ус, этанол болон толуол хэрэглэн цэвэрлэж ургасан хагийг механик аргаар цэвэрлэгээ хийв.



Цэвэрлэгээ хийсний дараа өмнө наахдаа өрөмдөж гаргасан нүхийг цэвэрлэж шинээр наахдаа хэрэглэх холбоос шаантаг хийхэд бэлдсэн ба хуучин нөхний ар хэсэгт дахин шинээр нэг шаантаг хийх нүх өрөмдөж гаргав.



Энэ удаагийн сэргээн засварлах ажилд Герман улсад үйлдвэрлэсэн Акерох 2010 чулууны эпокси цавуу хэрэглэн салсан хэсгүүдийг нааж сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэв.

### **3.4. “Их хөшөөт” чулуун дурсгалын хадгалалт хнамгаалалтын судалгааны ажил.**

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Их хөшөөт”-ийн дурсгалт газар 2017 онд хийсэн бэхжүүлэлтийн ажлын үр дүнг газар дээр нь очиж дүгнэх, бэхжүүлэлтийн ажлын үр дүнгээс шалгаалан цаашид авах хадгалалтын үйл ажиллагааг төлөвлөх.

Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах хэлтэс Австри улсын Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнтэй хамтран “Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт” сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 11-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгалыг түшиглэн, дараах хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Энэхүү сургалтын гол зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт өргөн тархсан чулуун соёлын өвийг хадгалж, хамгаалах, тэдгээрийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тодорхойлох, судалгаанд суурилсан хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын ажиллагаа явуулахад мэргэжил арга зүйгээр хангах болно. Мөн гэрэлт хөшөөнд хийгдэж байсан эрдэмтэдийн судалгааны ажлуудад судалгаа хийх, чулууны төрөл, бүтцийг тодорхойлох, өмнө нь хийж байсан бэхжүүлэлтийн ажлийн үр дүнг тандан судалж, гэмтэл, өгөршлийн шалтгааныг олох, гэмтэл, өгөршлийг цааш үргэлжлүүлэхгүй байх арга хэмжээг авах, цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийхийг зорьсон.

2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Монголын Уран зургийн галерейн хурлын танхимд зохион байгуулагдсан “Чулуун материал, түүний оношилгоо шинжилгээ” онолын танилцуулга хичээлийг Венийн Хэрэглээний Урлагийн их сургуулийн Хадгалалт хамгаалалтын хүрээлэнгийн чулуу судлаач Ёоханнэс Вэбэр удирдан явуулж байгалийн чулуулгийн бүтэц, шинж чанар, геологийн нэршил, чулуулгийн физик / механик болон химийн эвдрэл, өгөршил, ICOMOS буюу Хөшөө, Дурсгалт Газрын Олон Улсын Зөвлөлөөс эмхэтгэн гаргасан чулуун дурсгалын эвдрэл гэмтлийн тайлбар толь, чулуун дурсгал элэгдэж, эвдрэх явц, лабораторийн туршилт судалгаа, чулуун дурсгалд бэхжүүлэлт хийх зэрэг чиглэлээр илтгэл тавьсан юм.

Сургалтын дараагийн илтгэлийг Венийн Хэрэглээний Урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуун дурсгалын ахлах сэргээн засварлагч Мартина Хаселбергер “Их Хөшөөтийн дурсгалд 2016 онд хийсэн судалгаа” сэдвээр тавьж, 2016 онд дурсгалд хийсэн баримтжуулалт, дурсгалын чулуулгийн бүтэц, шинж чанар, эвдрэл гэмтэл зэргийг танилцуулав. Мөн дурсгалаас авсан дээжинд хийсэн микроскофийн анализ, шинжилгээний үр дүнг танилцуулж, цаашид дурсгалыг хадгалж хамгаалахад авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны дарааллыг мөн танилцуулав.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалтад Соёлын өвийн үндэсний төв, Монголын үндэсний музей, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Богд хааны Ордон Музей, Дүрслэх Урлагийн музей, СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Безнисиин Удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль зэрэг байгууллагын нийт 19 хүн оролцов (оролцогчдын дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хүснэгтээс харна уу).

Хүснэгт 1: Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургалтад оролцогчдийн нэрс.

Д/д	Овог нэр	Албан тушаал	Тайлбар
1	Д.Нямдорж	СӨҮТ-ийн ахлах сэргээн засварлагч, судлаач	
2	Ш.Энхтуяа	СӨҮТ-ийн мэргэжилтэн	
3	О.Оюунчимэг	СӨҮТ-ийн сэргээн засварлагч	
4	Г.Ангарагдөлгөөн	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан	
5	Р.Эрдэнэцэцэг	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн сэргээн засварлагч	
6	Н.Жамбал	СӨҮТ-ийн сэргээн засварлагч	
7	Н.Сэргэлэн	СУИС-ийн ДДУС-ийн тэнхимийн эрхлэгч	
8	С.Ганзам	ДДУС багш	
9	Г.Амарсанаа	ДДУС багш	
10	Н.Энхманлай	БХОМ сэргээн засварлагч	
11	Ю.Болдбаатар	ШУТИС багш	

12	Э.Туяа	МҮМ, сан хөмрөгийн эрхлэгч	
13	Б.Эрдэнэцэцэг	МҮМ, сан хөмрөгийн эрхлэгч	
14	Г.Энхжаргал	ДУМ бүртгэл мэдээллийн санч	
15	Д.Уранчимэг	ДУМ сан хөмрөгийн эрхлэгч	
16	Р.Чинзориг	Сэргээн засварлагч	
17	З.Адъяатөмөр	Сан хөмрөгч	
18	Б.Чогдон	Сан хөмрөгч	
19	Ж.Нямжаргал	СУИС-СС-төгсөгч /музей судлаач/	

### “Их Хөшөөт”-ийн цогцолбор дурсгалын тухай

Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Их Хөшөөт”-ийн цогцолбор дурсгал нь эртний Түрэгийн тахилга шүтээний томоохон дурсгалын нэг билээ. Энэхүү цогцолбор дурсгалыг түрэг судлалын зарим ном зохиолд Куль-чурт зориулан босгосон хөшөөний түрэг бичээс ч гэдэг. Хөшөөний өндөр нь 190 см, өргөн нь 61 см, зузаан нь 20 см. Дөрвөн талдаа бичээс бүхий байснаас хөшөөний зүүн зүг хандсан нүүрэн талд арван хоёр мөр, өмнө талд дөрвөн мөр, баруун талд арван гурван мөр, хойд талын бичээсүүд баларсан. Иймд одоо гурван талдаа нийт 29 мөр бүхий түрэг бичээстэй байна.

Хөшөөг анх В.Л.Котвич 1912 онд судалж бичээсийг нь А.Н.Самойловичийн хамт орчуулан, түүний түүхэн үндэслэлийг тодорхойлж нийтлүүлсэн нь уг дурсгалын талаар шинжлэх ухааны эргэлтэд орсон анхны бүтээл болсон. Түүнээс хойш Х.Н.Оркун, С.Е.Малов, Т.Т.Екин, Е.Трыяарский, Г.Айдаров нар судалснаас гадна 1979 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эртний түрэг судлалын анги газар дээр нь судалж, хэв авч, баруун талын мөрүүдийн доогуур хөндлөн бичсэн нэг мөр бичээс байсныг нэмэн олж тодруулан тайлжээ.

Эрдэмтэд хөшөөний арван дөрөвдүгээр мөрд байгаа “Сэцэн Куль-чур Тардуш түмнийг захиран суулаа” гэсэн өгүүлбэрт тулгуурлан энэхүү гэрэлт хөшөөг Куль-чур хэмээх ноёнд зориулан босгосон гэж үздэг. Уг бичээс маш их баларсан, утга төгссөн өгүүлбэр цөөвтөр, хөшөөний бичээсийг монгол хэлээр хараахан бүрэн орчуулаагүй болно. Гэрэлт хөшөөний гол агуулга нь “Чыкан Тонькук нэрийг өгсөн, Ышбара чыкан Күль-чур болсон” зэргийг хөшөөний нэг, хоёр, гуравдугаар мөрөнд тус тус өгүүлээд түүнээс хойшхи мөрүүдэд Күль-чурын аян дайн, хувцас хэрэглэл, тулалдаанд хурдан зээрд морь унаж явсан тухай, Йенчү голыг гаталж, Төмөр хаалганд, мөн Тежикт хүрч очсон, Есөн Огузад долоон удаа довтлон орсон, Хятад, Татабы, Харлуг зэрэгт хийсэн аян дайны тухай өгүүлсэн байна. Мөн гуравдугаар мөрд “Их Күл чур наян насандаа тэнгэрт хальсан”, хорин дөрөвдүгээр мөрд “...чур тегин, түүний хойноос дөрвөн тегин ирж Ышбара сэцэн Күль-чурыг оршуулсан...” гэж өгүүлснийг бусад түүхэн хэрэг явдалтай харьцуулан судлаад Куль-чурыг 721 онд нас барсан гэж тогтоосон.

*Дурсгалт газарт зохион байгуулсан сургалт дадлага ажил.* Улаанбаатар хотоос Төв аймгийн Лүн сум, Эрдэнэсант сум, Их хөшөөт дурсгалт газар, Дэлгэрхаан сум, Дуут хад Цогтын хадны бичиг дурсгалт газар, Дэлгэрхаан сум, Их хөшөөт дурсгалт газар, Эрдэнэсант сум, Лүн сумаас Улаанбаатар хот гэсэн маршрутаар явав.


Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагчид сургалт явуулах орчныг бүрдүүлж, кэмп байгуулсан. Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Их хөшөөт” цогцолбор дурсгалыг түшиглэн явуулсан сургалт 2018 оны 6 дугаар сарын 12-нд дурсгалт газарт эхлэв.

Сургалтыг Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн чулуун судлаач, чулуун сэргээн засварлагч нар удирдан явуулав. Үүнд:

- Вебер /Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн профессор/
- Марияя / Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн багш/
- Мартина / Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн багш/

Дурсгалт газарт явуулсан эхний өдрийн хичээлийг Венийн Хэрэглээний Урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуу судлаач Ёоханнэс Вэбэр, ахлах чулуу сэргээн засварлагч Мартина Хаселбергер нар Улаанбаатар хотод зохион явуулсан сургалтын хөтөлбөрийн дагуу орон нутгийн оролцогчидод зохион явуулав.

Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн чулуу сэргээн засварлах тэнхимийн профессор Вебер “Чулуун соёлын өвийг хадгалалж хамгаалалах, сэргээн засварлах” талаар болон дэлхийн чулууны бүтэц, төрөлүүд, шинж чанарын талаар болон чулуун соёлын өвүүдэд нөлөөлдөг байгалийн хүчин зүйлс, хэт авианы төхөөрөмжөөр чулууны нягтаршлыг тодорхойлох, халуун хүйтэн мэдрэгч аппратаар чулуунд хэрхэн судалгаа хийх, яаж бэхжүүлж, хадгалж хамгаалж байх талаар сургалт явуулав.



Зураг 1, 2: Венийн Хэрэглээний урлагийн хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуу судлаач, профессор Ёоханнес Вэбэрийн хичээл

Дурсгалт газарт явуулсан сургалтад Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлагч нараас гадна, СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн сэргээн засварлах ангийн 2 оюутан, Дундговь, Төв аймгийн музейн төлөөлөл оролцов. Сургалтад хамрагдсан оролцогчдын нэрсийг доорхи жагсаалтаас харна уу.

Хүснэгт 2: Дурсгалт газарт зохион байгуулагдсан сургалтад оролцогчдийн нэрс

д/д	Овог нэр	Албан тушаал	Тайлбар
1	Э.Батжаргал	СӨҮТ-ийн Монгол зургийн сэргээн засварлагч, судлаач	
2	Н.Бат-Эрдэнэ	СӨҮТ-ийн уран зургийн сэргээн засварлагч, судлаач	
3	А.Мөнгөнцоож	СӨҮТ-ийн Монгол зургийн сэргээн засварлагч, судлаач	
4	С.Даваадарь	СӨҮТ-ийн уран барималын сэргээн засварлагч, судлаач	
5	Г.Ууганчимэг	СӨҮТ-ийн даавуу, зөөлөн эдлэлийн сэргээн засварлагч, судлаач	
6	М. Бямбажав	Дундговь аймгийн музейн захирал	
7	А.Батжаргал	Дундговь аймгийн музейн жижүүр	
8	У.Мөнх-Эрдэнэ	Дундговь аймгийн музейн заал зохион байгуулагч	
9	Б. Сүхбаатар	Төв аймгийн музейн захирал	91991791
10	Э. Оюун	Арга зүйч	99206673
11	Т. Алтантөгс	Сан хөмрөгийн эрхлэгч	99733864
12	Г. Дагмидмаа	Бүртгэл мэдээллийн санч	89692129
13	Ц. Цэцэгжаргал	Эрдэм шижилгээний ажилтан	88858423
14	Б. Амгаланбат	Тайлбарлагч	89126969
15	Б. Мэндбаяр	Жолооч	95769916
16	Ц.Цолмон	СӨҮТ-ийн гадаад харилцаа, олон нийт хариуцсан мэргэжилтэн	

2018 оны 06 дугаар сарын 13-ний өдөр Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн чулуу сэргээн засварлах тэнхимийн багш Мартина Хаселбергер Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн захирал Габриала Крист, болон тус сургуулийн чулуу сэргээн засварлах тэнхимийн багш Сузанне Санднер, Мариса Лаурензи -Табассо нарын 2016 онд хийсэн хийсэн “Чулуун

соёлын өвийн хадгалалт, хамгаалалт 1” сургалт, судалгаа хийсэн ажлын тайлан, Австри улс руу шинжилгээнд авч явсан дээжинд хийсэн лабораторийн шинжилгээний хариу, тодорхойлолтыг танилцуулав. Мөн чулуун дурсгалыг сэргээн засварлаж, хадгалж хамгаалах ажлын дараалал, зайлшгүй хийх шаардлагатай судалгааны талаар хичээл оров.



Зураг 3, 4: Мартина Хаселберггегийн хичээл

Үдийн хоолны дараа сургалтын хуваарийн дагуу судалгааны багийхан Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Дуутын хад Цогтын хадны бичиг” дурсгалт газарт хүрэлцэн ирж дурсгалтай танилцан, дурсгалд нөлөөлж буй хүчин зүйлс, нөхцөл байдал, чулууны шинж чанар, ямар төрлийн чулуу болох талаар судалгаа хийв. Мөн Вебер, Мария нар чулууг тодорхойлохын тулд дээж авав.



Зураг 5, 6: “Дуутын хад Цогтын хадны бичиг” дурсгалын чулуун материалд судалгаа хийж, нөхцөл байдлыг ярилцав.

Энэ дурсгалт газар хийсэн судлаач багш нарын ярианаас тэмдэглэж авснаа дурьдвал: (Энэ хаданд он цагийн хуучрал явагдаж илүү их үзэмжтэй, үнэ цэнэтэй болгож байна. Энэ чулуун дурсгалуудын бичиг маш тод байна тиймээс тодруулсан байж магадгүй хэзээ гэдэг нь тодорхойгүй. Мөн хэн нэгэн 30-40 жилийн өмнө хагархай хэсгийг цавуугаар наасан байж болзошгүй шинж тэмдэг ажиглагдав. Тухайн цавуу наасан байж магадгүй хэсгээс Мария болон Э.Батжаргал, С.Даваадарь нар дээж авав. Зураг авсан). Анхан шатны судлагаагаар энэхүү дурсгалын чулууг галт уулын бялхмал чулуулаг тэр дундаа удаан царцсан чулуулаг байна хэмээн Австрийн Хэрэглээний урлагийн их сургуулийн чулуу сэргээн засварлах тэнхимийн профессор Вебер тодорхойлов.

Оройн хоолны дараа энэ сургалтын хуваарьт ороогүй боловч ч сэргээн засварлагч, судлаач бидэнд маш хэрэгтэй болох чулуун дурсгалуудад хэрхэн бэхжүүлэлт хийх талаар нэмэлт хичээл оров. Энэ хичээлд хагаралт болон нуралтуудыг дэлхийн сэргээн засварлагчид багаас их хүртэл нь 5 төрлөөр ангилж байгаа, ямар шалтгаанаас болж чулууны холбогч эдүүд муудан хагарч, үйрдэг, 1900 оноос эхлэн европт бэхжүүлэлт хийж эхэлсэн, одоогийн байдлаар хичнээн төрлийн бэхжүүлдэг бодиснууд ашиглагдаж байгаа, органик болон органик биш бэхжүүлдэг бодиснуудын хоорондын ялгаа, хэрхэн үйлчилдэг талаар болон олон чухал зүйлсийн талаар заав.





Зураг 7, 8: Мария Милчин "Чулуун дурсгалд бэхжүүлэлт хийх" сэдэвч хичээл зааж байгаа нь

2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр үзсэн онолуудаа практикт хэрэгжүүлэхээр гол дурсгал болох Их хөшөөт, Кульчурын хөшөөн дээрээ ажиллав. Эхлээд цэвэрлэгээ хийв. Цэвэрлэгээг хуурай болон нойтон гэж хоёр ангилдаг. Эхлээд хуурай цэвэрлэгээ хийх хэрэгтэй. Хуурай цэвэрлэгээг хийхдээ зөөлөн савхан модны үзүүрийг тэгш хэмээр зорж мөн багсаар том унаж болох бохирдолууд, наалдсан шувууны баас зэргийг унагаж цэвэрлэв. Дараа нь чийгтэй цэвэрлэгээ хийв. Чийгтэй цэвэрлэгээг хийхдээ эхлээд ямар нэгэн бодисгүй цэвэр усаар савх модонд хөвөн ороож цэвэрлэв.



Зураг 9, 10, 11, 12: Чулуун дурсгалын өнгөн давхарга дээрхи бохирдлыг цэвэрлэх дадлага ажил

Цэвэр усаар арилахгүй байгаа хэсэгт бид аяга таваг угаадаг угаалгын шингэн ашиглав. Тэгэхдээ 1л усанд 2 дуслыг хийв. Хутгаж үзэхэд бага зэрэг хөөсөрч байв. Хэрвээ хөөсрөхгүй бол дахиж дусаах хэрэгтэй.



Зураг 13, 14: Угаалгын шингэн ашиглан цэвэрлэгээ хийх явц

Ингээд бохирдол арилахгүй бол химийн бодис ашиглах шаардлагатай. Химийн бодиснууд ашиглахаас өмнө заавал туршилт хийх хэрэгтэй. Бид 5 төрлийн бодисоор туршилт хийв. Эхлээд -Surfactant (pic), дараа нь Aceton-100%, Etanol-100%, Patrol буюу бензин АИ92, Xylene-100% гэх мэт дарааллуулан цэвэрлэгээнд туршилтууд хийв. Эдгээр туршилтуудаас харахад энэ чулууны бохирдол нь усанд уусдаггүй бодисоор сайн цэвэрлэгдэж байв. (Aceton-100%, Patrol буюу бензин АИ92, Xylene-100%). Энэ 3 бодисноос бид ярилцаж байгаад хамгийн тохиромжтой байгаа Aceton-100%-оор цэвэрлэхээр шийдэв.



Зураг 15, 16: Химийн бодис ашиглан цэвэрлэгээ хийх тест



Зураг 17: Химийн бодис ашиглан цэвэрлэгээ хийх тестийн үр дүн



Зураг 18: Химийн бодис ашиглан цэвэрлэгээ хийсэн тестийн үр дүн

Цэвэрлэгээ хийж дууссаны дараа багш бидэнд дүүргэгч болон зуурмаг бэлтгэх талаар онолын хичээл оров.



Зураг 19, 20: Дүүргэгч, зуурмаг бэлтгэх дадлага ажил

Энэ хичээлээр бид шохой болон цементийг хэрхэн гаргаж авдаг, шохой бол зуурмагийн гол цөм болох, шохой олон төрлийн эрдэстэй (элс, шороо, гм..) хольж зуурмаг хийдэг мөн дангаараа ч зуурмаг болдог, шохойн зуурмаг нь сийрэг байдаг болохоор сэргээн засварлалтанд голдуу хэрэглэдэг, цемент нь хэтэрхий хатуу болдог тухай мөн өөр төрлийн эрдэс ашиглан зуурмаг, болон дүүргэгч бэлтгэх талаар маш онолын болон дадлагын хичээлийг заав.



Зураг 21, 22: Бэлдсэн зуурмаг, дүүргэгчийг турших явц

2018 оны 06 дугаар сарын 15-ний өдөр зуурмаг болон дүүргэгч бэлтгэх тухай үзсэн онолуудаа практикт хэрэгжүүлэхээр дурсгалтайгаа зохицох дүүргэгч болон зуурмагуудыг бэлтгэв. Хүн бүр туршилт хийж дурсгалтайгаа зохицох нэг дүүргэгч болон нэг зуурмагийг гарган авав. Дүүргэгчийг шахахаас өмнө чулуун дурсгалын ан, цав цуурал хир хэмжээтэй байгааг тодорхойлох зорилгоор этилийн спирт 50%ийн уусмалаар болон усны уусмал, мөн дан этилийн спиртийг чулуунд шахаж, ан цав цуурлыг тогтоов.



Зураг 23, 24: Ус+этилийн спирт болон дан этилийн спиртийг ашиглан чулууны ан цав, цуурлыг шалгаж байгаа нь

Ан, цав, цуурлыг шалгасны дараа дүүргэгчийг шпризээр соруулан нарийн хагарсан хэсгүүд рүү шахан холбож ахин цуурал томрохоос сэргийлэх зорилгоор ашиглав. Энэ дүүргэгчийн орц нь (цемент-49%, ледан-49%, пигмент-2%, цэвэр ус).



Зураг 25: Дүүргэгчийг чулууны ан цав, цуурлыг бөглөхөд ашиглаж байгаа нь



Зураг 26, 27: Дүүргэгчийг чулууны ан цав, цуурлыг бөглөхөд ашиглаж байгаа нь

Дүүргэгч хатсаны дараа бэлтгэсэн зуурмагаа дээр нь тавьж хагархай хэсгийг тэгшлэн борооны ус дээр хуримтлагдаж урсхааргүй болгож тавив. Энэ зуурмагийн орц нь (элс-60%, шохойн лагшин-20%, ледан-10%, trass powder-10%).



Зураг 28: Дүүргэгчээр чулуун дурсгалыг ан цав, цуурлыг нөхсний дараа



Зураг 29: Дүүргэгчээр чулуун дурсгалыг ан цав, цуурлыг нөхсний дараа

Зуурмагийг хийсний дараа байн байн усаар шүршиж, чийгийг хадгалахыг зорив. Орой хөшөөгөө жигд норгосны дараа мөнгөн цаас болон гялгар уутаар ороов. Ингэж ороох нь ус түргэн ууршихаас сэргийлж байгаа юм. Ус түргэн уурших нь зуурмаг хагарах аюултай байдаг.



Зураг 30: Нөхөлт, дүүргэлт хийсний дараа чулууг мөнгөлөг цаасаар бүрээ

Чулууг мөнгөлөг цаасаар бүрсний дараа чулууны суурийг цэвэрлэв. Мөн энэ өдөр багш нар бидэнд хагарч унасан чулуун дурсгалыг хэрхэн шаантаг хийн холбож наах талаар сонгон авсан жижиг чулуун дээр туршилт болгож практик хичээл оров.



*Зураг 31, 32, 33: хагарч унасан чулуун дурсгалыг хэрхэн шаантаг хийн холбож наах туршилт*

Энэ хичээл дээр эхлээд эвлэх хэсгээ сайтар цэвэрлэх шаардлагатай. Дараа нь эвдүүлж байгаад дөрвөн талын дунд хэсэгт тэмдэг тавин, дөрвөн зураасаа нийлүүлэхэд чулууны гол гарна. Голыг шингэн шохойн лагшингаар тэмдэглэн нөгөө хэсэгтэйгээ нийлүүлэхэд хоёр талд ижил тэмдэг гарна. Гарсан тэмдэг дээрээ өрмөөрөө тэгш өрөмдөх хэрэгтэй. Тэгш өрөмдөхийн тулд гурван хүнээр гурван талаас нь харуулж байгаад өрөмдвөл тэгш өрөмдөгдөнө. Энэ чулуунд бид АКЕРОХ 2010 гэдэг нэртэй чулуун дурсгал наахад тохиромжтой цавууг ашиглан наав. Цавуугаа найруулахдаа хатууруулагч болон цавуу хоёрыг 2/1 харьцаатай найруулж хэрэглэнэ. (2-цавуу, 1-хатууруулагч). Цавуугаа түрхэхдээ чулуунаасаа илүү гаргаж болохгүй.



*Зураг 34, 35: хагарч унасан чулуун дурсгалыг хэрхэн шаантаг хийн холбож наах туршилт*

**Дүгнэлт.** “Чулуун соёлын өвийн хадгалалт, хамгаалалт” сургалтыг Венийн Хэрэглээний урлагийн их сургуулийн Хадгалалт, хамгаалалтын хүрээлэнгийн чулуу судлаач, чулууны сэргээн засварлагчидтай хамтран зохион байгуулсан нь чулуун соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талбарт Монголын сэргээн засварлагчдын мэдлэг, туршлагыг тэлсэн, бататгасан чухал сургалт болов. Мөн орон нутгийн оролцогчдод чулуун соёлын өвийг хадгалж, хамгаалахад юуг анхаарах, тухайлбал химийн бус буюу механик, физик гэмтэл, өгөршил элэгдлийг бууруулахад орон нутгийн иргэд, соёлын өв хариуцсан ажилтнууд, музейн албан хаагчдын оролцоог тодорхойлсон үр өгөөжтэй сургалт болоо. Түүнчлэн орон нутгийн оролцогчдод дурсгалын элэгдэл, өгөршил, гэмтлийн таньж тодорхойлох, хуурай болон чийгтэй цэвэрлэгээ, химийн бус аргаар чулуун дурсгалыг цэвэрлэх анхан шатны мэдлэг, ойлголтыг өгсөн.

Чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт нь чулуулгийн бүтэц, шинж чанараас шууд хамааралтай. Ялангуяа чулуулгийн өгөршил, эвдрэл гэмтлийг лабораторийн нарийн шинжилгээ, туршилтаас гарсан үр дүнд тулгуурлан удаан хугацааны хяналт, ажиглалт дор тохиромжтой материал ашиглан сэргээн засварлах шаардлагатайг Австрийн сэргээн засварлагчид өөрсдийн туршлага дээр тулгуурлан бидэнтэй хуваалцсан юм. Сургалтын хүрээнд хийхээр төлөвлөсөн дурсгалд эвдрэл гэмтэл учруулахгүйгээр анхан шатны судалгаа хийх /чулууны нягтшил /tap test/, судал /striping test/, усны агууламж судлах сорил /contact sponge test/,

- Хугарч унасан болон хагарч цуурсан хэсэгт нөхөлт хийх арга зүйг туршилтаар танилцуулах

- Сонгосон хэсэгт тохирох материалыг тодорхойлон (холих харьцаа), хадгалж хамгаалах арга ажиллагааг хэрхэн хийхийг үзүүлэх Сонгосон дурсгал дээр хадгалалт, хамгаалалтын арга ажиллагааны дадлага хийх

- Наах / цавуу түрхэх

- Бэхжүүлэх

- Хугарч унасан хэсгийг эргүүлэн наах буюу нөхөх, хагарлыг нөхөх зэрэг ажлууд хөтөлбөрийн дагуу хийгдсэн ба 2019 онд “Их Хөшөөт”-ийн цогцолбор дурсгалын бичигт хөшөөнд ан цав, цуурлын хэмжээг тодорхойлох судалгааг хэт авианы багаж ашиглан хийхээр шийдэв. Мөн дурсгалын орчимд хэдэн хэсэг хагарч унасан хөшөөг шаантаг ашиглан эвлүүлж наах ажлыг ирэх жил хийхээр ярилцав. Түүнчлэн “Дуутын хад Цогтын хадны бичиг” дурсгалаас авсан дээжинд лабораторийн нарийвчилсан оношилгоо, шинжилгээ хийж, холбогдох хариуг Монголын талд мэдэгдэхээр харилцан тохиролцов.



Сургалтад оролцогчид

## ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ, НЭМЭЛТ ХИЙГДСЭН АЖЛУУД

### “Монгол болон Япон улсын Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын туршлага” уулзалт, семинар

2018 оны 09 дүгээр сарын 26-аас 29-ний өдрүүдэд Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбатын урилгаар Япон улсын Нара-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын төвийн дарга Ёосэй Козума тус төвд айлчиллаа. Энэхүү айлчлалын гол зорилго нь Монгол Улсын Соёлын өвийн үндэсний төв, Япон улсын Токио-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн, Нара-гийн Соёлын өвийн үндэсний хүрээлэн хооронд гурван талт хамтын ажиллагааны Гэрээ байгуулах, мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй музейн сан хөмрөгч, хадгалалт, хамгаалалт хариуцсан ажилтнуудад “**Монгол болон Япон улсын Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын туршлага**” уулзалт, семинарыг батлагдсан хөтөлбөрийн /хөтөлбөрийг хавсаргав/ дагуу зохион байгуулах байв.

2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр буюу айлчлалын эхний өдөр Соёлын өвийн үндэсний төв дээр мэдээлэл солилцох албан уулзалтыг хийв. Уулзалтын үеэр тус төвийн захирал Г.Энхбат Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагаа, байгууллагын шинэ бүтэц, зохион байгуулалт, Биет соёлын өвийг сэргээн засварлах газрын үйл ажиллагаа, Монгол Улсад соёлын өвийн сэргээн засварлагч бэлтгэж байгаа сургалтын системийн талаар танилцуулав.

Мэдээлэл солилцох уулзалтын дараа Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат Нара-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын төвийн дарга Ёосэй Козумад Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааг танилцуулав.



Зураг 1. Харилцан мэдээлэл солилцох уулзалтын явц



Зураг 2. Археологийн модон олдворын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалтай танилцаж байгаа нь



Зураг 3. Археологийн шавар сэргээн засварлалтын нөхцөл байдалтай танилцаж байгаа нь



Зураг 4. Уран зургийн сэргээн засварлалт, Монгол зургийн сэргээн засварлалтын ажилтай танилцаж байгаа нь

Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцсаны дараа Монгол Улсын Соёлын өвийн үндэсний төв, Япон улсын Токио-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн, Нара-гийн Соёлын өвийн үндэсний хүрээлэн хооронд Монголын соёлын өвийг судлахад харилцан туршлага солилцох, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр харилцан зөвшилцсний дагуу талууд гурван талт хамтын ажиллагааны Гэрээт гарын үсэг зурав.



*Зураг 5. Гарын үсэг зурсны дараа Гэрээ солилцож байгаа нь*

Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсны дараа хөтөлбөрийн дагуу Хан-Уул дүүрэгт баригдсан Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байрыг үзэж танилцав.



*Зураг 6. Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байртай танилцаж байгаа нь*

Айлчлалын 2 дахь өдөр “Монгол болон Япон улсын Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын туршлага” уулзалт, семинарыг Монгол Улсын Соёл, Урлагийн Их Сургуулийн Соёлын Сургууль дээр зохион байгууллаа. Уулзалт, семинарт СУИС-ийн Соёлын Сургуулийн төлөөлөл, Монголын Үндэсний Музей, Төрийн түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Богд Хааны Ордон музей, Чойжин Ламын сүм музей, Улаанбаатар хотын музей, Монголын Театрын музей, Монгол Цэргийн музей, Монголын Уран зургийн музей, Байгалийн түүхийн музейн сан хөмрөгч, үзмэр харагч ажилтнууд оролцлоо.

Семинарын эхний илтгэлийг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат



“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт” сэдвээр тавьж, уулзалт семинарын оролцогчидод музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтын эрхзүйн орчин, музейн үзмэрийн орчны хадгалалт, хамгаалалтын өнөөгийн байдал, музейн үзмэрийн сэргээн засварлалтын түүхэн тойм, өнөөгийн байдлыг Соёлын өвийн үндэсний төвөөс явуулсан судалгаа, сэргээн засварлалтын ажлын тайлан мэдээ, жишээ, баримттайгаар танилцуулж, ярилцлаа.



Зураг 7. Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбатын илтгэлийн явц

Тус илтгэлийн дараа Япон улсын Нара-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын төвийн дарга Ёосэй Козума “Япон улсын соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт” сэдвээр илтгэл тавьлаа. Тус илтгэлээр Япон улсын соёлын өвийн ангилал, хадгалалт хамгаалтын горим, соёлын өвийн гэмтэл муудлын шалтгаан, оношилгоо, сэргээн засварлах давтамж, туршлагаас семинарт оролцогчидод танилцуулж, ярилцав. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт нь шинжлэх ухаан, дэвшилтэт техник технологид суурилсан байхаас гадна уламжлалт мэдлэг, туршлага маш чухал үүрэгтэйг илтгэлдээ онцолж байв.



Зураг 8. Ёосэй Козума илтгэл тавьж байгаа нь



Зураг 9. Ёосэй Козума илтгэлийн хэсгээс

Семинарын сүүлийн илтгэлийг Япон улсын Киото Их сургуулийн Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын докторант О.Ангарагсүрэн “Япон улсын 6-7 зууны үеийн бунхны хадгалалт хамгаалалтын судалгаа: Хасугаикэ Ёкоана бунхны орчны шинжилгээ” сэдвээр тавьж, судалгааны ажлын үр дүнг танилцуулав.



Зураг 10. О.Ангарагсүрэнгийн илтгэлийн хэсгээс



Зураг 12. Асуулт, хариулт

Илтгэлийн дараа уулзалт, семинарт оролцогчид илтгэгчдээс асуулт асууж, нэмэлт мэдээллийг авсан юм.

**Дүгнэлт:** Япон Улсын Нара-гийн Соёлын Өвийн Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын төвийн дарга Ёосэй Козума-г Соёлын өвийн үндэсний төвд урьсан нь Монгол, Япон улсын соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, цаашид хэрэгжүүлэх боломжтой хамтарсан төсөл хөтөлбөр, судалгааны ажлыг тодорхойлоход нэг чухал алхам болов. Монгол Улсын Соёлын өвийн үндэсний төв, Япон улсын Токио-гийн Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн, Нара-гийн Соёлын өвийн үндэсний хүрээлэн хооронд байгуулсан гурван талт хамтын ажиллагааны “Гэрээ”-ний хүрээнд талууд чулуун дурсгалын хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт дээр түлхүү хамтарч ажиллахаар болов.

Тус “Монгол болон Япон улсын Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын туршлага”

уулзалт, семинар нь соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын шинжлэх ухаан нь орчны судалгаа, материалын судалгаа, эвдрэл гэмтлийн хүчин зүйлийн судалгаанд суурилж, уламжлалт болон дэвшилтэт арга технологи, материал хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж ашиглаж урт хугацааны туршид, давтамжтайгаар хийгддэг болох мэдээллийг Монгол болон Япон улсын соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын ажлын жишээн дээр тулгуурлан семинарт оролцогчдод Улаанбаатар хотын музейдын сан хөмрөгч, үзмэр харагч, Соёл, Урлагийн Их Сургуулийн багш, судлаач, оюутнуудад өгсөн юм.

2018 онд тус газрын сэргээн засварлагч Б. Даваадарь, Японд ажиллаж буй доктор Оюутулга нар 6 дугаар сард Орхон айгийн Айрагийн гозгорын дурсгалт газар, 2018 оны 8 сард Архангай аймгийн Хотонт сумын Уйгарын Хар балгасны археологийн малталтын үед газар дээр нь очиж, олдворын анхан шатны бэхжүүлэлт, сав баглаа боодлыг хэрхэн хийх тухай онол, практикийн сургалт, дадлага ажил хийсэн болно.


2018 оны 9 дүгээр сард Уйгарын хар балгасны олдворыг Соёлын өвийн үндэсний төвд бэхжүүлэлт, сэргээн засварлах зорилгоор авчирсан ба археологийн малталтыг монголын талаас ахлан ажилласан МУИС-ийн төлөөлөлтэй тохиролцсоны дагуу “Хонх” олдворыг Хархорум музейн сэргээн засварлах лаборатори руу түр шилжүүлсэн болно.

#### 4.0 “МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР”-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

##### 4.1. Соёлын өвийн УНБМСангийн цахим архивыг төгөлдөржүүлэх.

Нэг цогц системд оруулан хадгалах нь ашиглалт болон хадгалалтын хувьд илүү найдвартай өргөн боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим архивыг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд сангийн цаасан болон цахим суурьтай баримтын нэгдсэн ангилал, кодыг архивын зарчмыг баримтлан боловсруулж “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах” журмын төсөл боловсруулах ажил хийгдэж байна.



Хадгаламжийн шигр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-А. ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ</b>					
1	Соёлын өвийн бүртгэл, тодорхойлолт:				
1.1	Улс, орон нутгийн өмчийн музейн үзмэрийн бүртгэл	A1.1-1			а.Эзэмшигч байгууллага, б.Он цагаар
1.2	Төрийн өмчийн байгууллага, музейн түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл	A1.2-1			
1.3	Хувийн музей, байгууллага дах түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл	A1.3-1			
1.4	Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн бүртгэл	A1.4-1			а.Засгийн газрын тогтоол б.Он цагаар
1.5	Хувь хүний гар дээр хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалын бүртгэл	A1.5-1			а.Он цагаар

2	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:			
2.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулсан ажлын тайлан, ном, хэвлэлийн хамт	A2.1-1		а.Он цагаар
2.2	Аймаг, нийслэлийн соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сангийн хөдлөх дурсгалт зүйлийн баяжилтын тайлан	A2.2-1		а.Он цагаар
2.3	Хилийн чандад байгаа Монголын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	A2.3-1		
2.4	Хулгайд алдсан, солигдсон, дутагдсан үзмэрийн судалгаа, шалгалтын материал	A2.4-1		
3	Үзлэг, тооллого хийхэд хөтлөсөн баримт:			
3.1	Улсын тооллогоор хөтлөсөн баримт материал	A3.1-1		а.Эзэмшигч байгууллага, б.Он цагаар
3.2	Байгууллагын тооллогоор хөтлөсөн баримт материал	A3.2-1		а.Он цагаар
4	Дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт:			
4.1	АНУ-д гарсан үзэсгэлэнгийн condition report	A4.1-1		а.Сэдэв б.Он цагаар

Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-Б. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ</b>					
1	Соёлын өвийн бүртгэл, тодорхойлолт:				
1.1	Үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл	B1.1-1			а.Засаг захиргааны ангилал, б.Дурсгалын ангилал
1.2	Улсын хамгаалалтын үл хөдлөх дурсгалын бүртгэл	B1.2-1			а.Засгийн газрын тогтоол б. Он цагаар
1.3	Аймаг, сумын хамгаалалтын үл хөдлөх дурсгалын бүртгэл	B1.3-1			а.Аймаг, сумын ЗДТГ-ын шийдвэр б.Он цагаар
2	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:				
2.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан ажлын тайлан, ном, хэвлэлийн хамт	B2.1-1			а.Он цагаар
2.2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хэв хуулбар авсан ажлын тайлан, хэв, хуулбар, дардасны хамт	B2.2-1			а.Сэдэв, б.Он цагаар
2.3	Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль зэрэг тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын судалгаа шинжилгээний ажлын тайлан	B2.3-1			а.Байгууллага, б.Он цагаар
2.4	Аймаг, нийслэлийн соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сангийн үл хөдлөх дурсгалын баяжилтын тайлан	B2.4-1			а.Он цагаар
2.5	Хилийн чандад байгаа Монголын холбогдолтой түүх, соёлын үл хөдлөх дурсгалтын судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	B2.5-1			а.Сэдэв, б.Он цагаар

Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-Б. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ</b>					
1	Соёлын өвийн бүртгэл, тодорхойлолт:				
1.1	Үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл	Б1.1-1			а.Засаг захиргааны ангилал, б.Дурсгалын ангилал
1.2	Улсын хамгаалалтын үл хөдлөх дурсгалын бүртгэл	Б1.2-1			а.Засгийн газрын тогтоол б. Он цагаар
1.3	Аймаг, сумын хамгаалалтын үл хөдлөх дурсгалын бүртгэл	Б1.3-1			а.Аймаг, сумын ЗДТГ-ын шийдвэр б.Он цагаар
2	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:				
2.1	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан ажлын тайлан, ном, хэвлэлийн хамт	Б2.1-1			а.Он цагаар
2.2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хэв хуулбар авсан ажлын тайлан, хэв, хуулбар, дардасны хамт	Б2.2-1			а.Сэдэв, б.Он цагаар
2.3	Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль зэрэг тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын судалгаа шинжилгээний ажлын тайлан	Б2.3-1			а.Байгууллага, б.Он цагаар
2.4	Аймаг, нийслэлийн соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сангийн үл хөдлөх дурсгалын баяжилтын тайлан	Б2.4-1			а.Он цагаар
2.5	Хилийн чандад байгаа Монголын холбогдолтой түүх, соёлын үл хөдлөх дурсгалтын судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Б2.5-1			а.Сэдэв, б.Он цагаар
3	Үзлэг, тооллого хийхэд хөтлөсөн баримт:				
3.1	Улсын тооллогоор хөтлөсөн баримт материал	Б3.1-1			а.Он цаг, б.Засаг захиргааны ангилал, в.Дурсгалын ангилал
3.2	Аймаг, нийслэлээс зохион байгуулсан үзлэг тооллогын баримт материал	Б3.2-1			а.Засаг захиргааны ангилал, б.Он цагаар
3.3	Хууль бус малтлага, алдагдсан, солигдсон дурсгалын судалгаа	Б3.3-1			а.Дурсгалын ангилал, б.Он цагаар
4	Сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл,				

Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-В. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ</b>					
1	Соёлын өвийн тодорхойлолт:				

1.1	Соёлын биет бус өвийн бүртгэл	B1.1-1			а.ЗГ-ийн тогтоолоор
1.2	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл	B1.2-1			а.Оршин суугаа засаг захиргааны байшлаар б.Он цагаар
1.3	Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүдийн баримт, материал	B1.3-1			а.Өвийн ангилал, б.Он цагаар
2	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:				
2.1	Соёлын биет бус өвийн судалгаа шинжилгээ, сургалтын ажлын тайлан, ном, хэвлэлийн хамт	B2.1-1			а.Он цагаар
2.2	Аймаг, нийслэлийн соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет бус өвийн баяжилтын тайлан	B2.2-1			а.Он цагаар
3	Үзлэг, тооллого хийхэд хөтлөсөн баримт:				
3.1	Соёлын биет бус өвийн улсын наадмын тайлан, ном, хэвлэлийн хамт	B3.1-1			а.Он цаг, б.Засаг захиргааны ангилал, в.Дурсгалын ангилал
3.2	Аймаг, нийслэлээс зохион байгуулсан соёлын биет бус өвийн улсын наадмын тайлан	B3.2-1			а.Засаг захиргааны ангилал, б.Он цагаар
3.3	Хууль бус малтлага, алдагдсан, солигдсон дурсгалын судалгаа	B3.3-1			а.Дурсгалын ангилал, б.Он цагаар



Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-Г. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ</b>					
1	Соёлын өвийн тодорхойлолт:				
1.1	Соёлын биет бус өвийн бүртгэл	Г1.1-1			а.ЗГ-ийн тогтоолоор
1.2	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл	Г1.2-1			а.Оршин суугаа засаг захиргааны байшлаар б.Он цагаар
1.3	Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүдийн баримт, материал	Г1.3-1			а.Өвийн ангилал, б.Он цагаар
2	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:				
2.1	Соёлын биет бус өвийн судалгаа шинжилгээ, сургалтын ажлын тайлан, ном, хэвлэлийн хамт	Г2.1-1			а.Он цагаар
2.2	Аймаг, нийслэлийн соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн сангийн соёлын биет бус өвийн баяжилтын тайлан	Г2.2-1			а.Он цагаар
3	Үзлэг, тооллого хийхэд хөтлөсөн баримт:				

3.1	Соёлын биет бус өвийн улсын наадмын тайлан, ном, хэвлэлийн хамт	Г3.1-1			а.Он цаг, б.Засаг захиргааны ангилал, в.Дурсгалын ангилал
3.2	Аймаг, нийслэлээс зохион байгуулсан соёлын биет бус өвийн улсын наадмын тайлан	Г3.2-1			а.Засаг захиргааны ангилал, б.Он цагаар
3.3	Хууль бус малтлага, алдагдсан, солигдсон дурсгалын судалгаа	Г3.3-1			а.Дурсгалын ангилал, б.Он цагаар

Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-Д. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАЛТ</b>					
1	Судалгаа, шинжилгээний ажлын тайлан:				
1.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалын эрсдлийн судалгаа				
1.2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдлийн судалгаа				
1.3	Соёлын биет бус өвийн эрсдэлийн судлагаа				
2	Авран хамгаалах үйл ажиллагааны тайлан:				
2.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалыг авран хамгаалсан үйл ажиллагаа				
2.2	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг авран хамгаалсан үйл ажиллагаа				
2.3	Соёлын биет бус өвийг авран хамгаалсан үйл ажиллагаа				

Хадгаламжийн шипр	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт	Хадгаламжийн дугаар	Байршлийн код		Хадгалах зарчим
			Шүүгээний дугаар	Тавцангийн дугаар	
<b>ХӨМРӨГ-Д. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ</b>					
1	Сэргээн засварласан ажлын тайлан:				
1.1	Сэргээн засварласан ажлын тайлан 1996-2018	Д1.1-1			





#### 4.2.Музейн үзмэр, эд өдгийн зүйлийн бүртгэлийн RCH програмын хөгжүүлэлт

RCH программын мэдээллүүдийг нэгтгэх. RICH програмд хувь хүн болон цагдаа, гааль гэх мэт гуравдагч байгууллагын мэдээллийг оруулах мөн мэдээллийн баазуудыг холбох.

2018 оны 8-р сард “RCH” бүртгэлийн програмын Хувь хүний өмчлөлийн бүртгэх бүртгэлийн талбарын бодлогын даалгаврыг боловсруулсан. Хувь хүний бүртгэл RCH бүртгэлийн програмд тусдаа бие даасан талбар байх ба музей байгууллагын бүртгэлийн талбараас өөр байх онцлогуудыг нь тусган боловсруулсан.

Хууль хяналтын байгууллагад хураагдсан, өмчлөгч, эзэмшигч нь тодорхойгүй эд өлгийн зүйл нь соёлын өв мөн болох нь тогтоогдон, хуулийн дагуу өмчлөгч, эзэмшигчийг тогтоон шилжүүлэх хүртэлх хугацаанд “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн түр бүртгэл”-ийн бодлогын даалгаврыг боловсруулсан. Түр бүртгэлийг бүртгэх талбар нь RCH програмд тусдаа бие даасан талбар байна.

ХУВЬ ХҮНИЙ ӨМЧЛӨЛИЙН СОЁЛЫН ӨВИЙГ БҮРТГЭХ ТАЛБАР

Хувь хүний өмчлөлийн соёлын өвийг бүртгэх талбар нь БСШУ-ны сайдын 2010 оны 541-р тушаалаар батлагдсан “Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” буюу RCH-ийг баримтална.

RCH програмд тусдаа бие даасан талбар байх ба уг талбарт ирээдүйгээ харсан зарим нэгэн нэмэлт, өөрчлөлт хийгдэнэ.

Улсын Бүртгэл, мэдээллийн сангийн дугаар /УБМСангийн дугаар/ зарчим.

Хувь хүний өмчлөлийн соёлын өвийг бүртгэхэд УБМСангийн дугаар дараах 2 зарчмаар өгөгдөнө. Үүнд:

Бүртгэлийн түр дугаар: ХХӨ0000АР00000

УБМС-ийн дугаар: ХХӨ000000000

- Хувь хүний бүртгэх Бүртгэлийн түр дугаар нь: ХХӨ0000АР00000 бүтэцтэй, 14 тэмдэгтийн зай байна. Үүнд:

“ХХӨ” – СӨТ-ийн захирлын 2016 оны ...-р тушаалд заасан “хувь хүний өмчлөл” гэсэн үгийн товчлол,

“0000”- эхний 4 орон тухайн өв бүртгэгдсэн он, он нь автоматаар дугаарлагдана

“АР” – 21 аймаг ба нийслэлийн товчилсон үсэг /жагсаалтыг бэлдэж өгнө/

“00000” – дэсийн дугаар байх ба автоматаар дугаарлагдана. 21 аймаг, нийслэлийн БМСанд иргэний өмчлөлийн соёлын өвийг анхлан түр дугаар өгч, түр бүртгэнэ. Түр дугаар нь автоматаар өгөгддөг байна.

СӨУНБМСан дээр 21 аймаг, нийслэлийн БМСангуудаас ирүүлсэн хувь хүний өмчлөлийн түр бүртгэлийг үзэж дүгнээд, тухайн хүний бүртгүүлсэн эд зүйл соёлын өв мөн эсэхийг эцэслэн шийдэж гэрчилгээ олгогдоно. Иймээс 21 аймаг, нийслэлээс ирсэн бүртгэлүүдээс соёлын өв гэж баталгаажсан бүртгэлүүд нь Соёлын өвийн үндэсний төвийн толгой програмд нэгтгэгдэн УБМСангийн бүртгэлийн дугаар нь албан ёсоор дэс дараалалтай эрэмбэлэгдэн автоматаар шинээр дугаарлагдана гэсэн үг.

СӨУНБМСан дээр эцэслэн бүртгэгдэх УБМСангийн дугаар нь: ХХӨ000000000 / ХХӨ-хувь хүний өмчлөл, 0000-бүртгэгдсэн оныг, 00000-бүртгэгдсэн соёлын өвийн дэс дугаарыг илэрхийлнэ/ бүтэцтэй, 12 тэмдэгтийн зай байна.

СӨУНБМСан дээр эцэслэн бүртгэгдэх УБМСангийн дугаарт түр дугаарын 21 аймаг, нийслэлийн нэрийн үсгэн товчлол /АР г.м/ хасагдаж, тухайн онд бүртгэгдсэн оны дугаар, сүүлийн таван орон буюу дэс дугаараар автоматаар эрэмбэлэгдэн дугаарлагддаг байна.

21 аймаг, нийслэлээс ирүүлсэн хувь хүний бүртгэлээс соёлын өвд ороогүй бүртгэлүүд нь түр дугаараараа тухайн 21 аймаг, нийслэлийн БМСангийн програмд history болон хадгалагдан үлдэнэ.

СӨУНБМСангийн толгой програмд түр дугаараар бүртгэгдсэн бүртгэл хадгалагдахгүй.

1. Хувь хүний соёлын өвийн бүртгэлийн талбарт дараах

- Тухайн өмчлөгч иргэний “Овог нэр”-ээр, “Регистрийн дугаар”-аар, “Дурсгалт зүйлийн нэр”-ээр эрэл хайлт хийгддэг байна.

- Хувь хүний бүртгэлд “Хувийн дугаар”-ын талбарыг заавал бөглөх шаардлагагүй. Өөрийн өмчлөлийн өвийг дугаар өгөх нь тухайн хүний асуудал.

- Мөн “Төрөл зүйл”, “Он цаг”, “Иж бүрдлийн тоо”, “Нийт тоо ширхэг” зэрэг статистик үзүүлэлт гаргадаг үзүүлэлтүүд нь “Register” болон “RCH”-ийн адил байна.

- Бүртгэлд хавсаргах Гэрэл зураг Register, RCH-тэй адил нягтшил хэмжээтэй байна. Гэрэл зургийн тоог заахгүй ба хамгийн багадаа эд зүйлийг 1-4 талаас харуулсан зураг байна.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 32.2.3; 33.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд хувь хүний бүртгэлд “шилжилт хөдөлгөөн”-ий талбарыг шинэлэг байдлаар хийх шаардлага гарч байна. Хуулийн 32.2.3.-т заасан “бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн

шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх”, 33.2.3-т заасан “худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх” гэсэн байна.

Үүнтэй уялдуулан тухайн өв өмчлөл шилжигдсэн тохиолдолд “шилжилт хөдөлгөөны талбар”-т мэдээллийг оруулахад эхний бүртгүүлсэн өмчлөгчийн тухай мэдээлэл “history” болон идэвхгүй болж хадгалагдан, шилжсэн өмчлөгчийн тухай мэдээллийг “Өмчлөгч ба РД”, “Хамтран өмчлөгч ба РД”, “Эзэмшигч ба РД”, “Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг”, “Ашиглалтын байдал” зэрэг талбаруудад мэдээллийг нэмж оруулдаг байх хэрэгцээ шаардлагатай байна.

Он цагийн явцад нэг өв хэдэн ч удаа шилжигдэж, өмчлөгч нь солигдож болно. Тэгэхээр шилжилт хөдөлгөөны тухай мэдээллийг оруулах бүрд өмнөх өмчлөгч нарын мэдээлэл history-түүх болон хадгалагдаж шинэ өмчлөгчийн нэрээр дахин шинэчлэгдэн бүртгэгдэж байхаар програм зохицуулагдсан байна. */тухайлбал: эрүүл мэндийн, нийгмийн даатгалын дэвтрүүдэд шилжилт хөдөлгөөн тэмдэглэх хангалттай олон хуудас байдагтай адил гэсэн үг./*

Хувь хүний бүртгэлд “Бүртгүүлэх болсон шалтгаан”, “Хил гаалиар авч гарсан тухай тэмдэглэл”-ийн хэсэг нэмж оруулав.

БОДЛОГЫН ДААЛГАВАРТ:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын  
2010 оны 541 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН  
ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

Бүртгэлийн түр дугаар: ХХӨ0000АР00000 /21 аймаг, нийслэлийн БМСан/  
УБМС-ийн дугаар: ХХӨ000000000 /СӨУНБМСангийн түвшинд/

Өмчлөгч:	РД: АА00000000
(ургийн овог)	10 тэмдэгтийн
(эцгийн нэр)	зай байна. Үсгийг
(өөрийн нэр)	криллээр
/100 тэмдэгт бичих зай/	
Өмчлөгч иргэний нэрээр эрэл хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.	
РД-ээр эрэлт хайлт хийгддэг байна.	
Хамтран өмчлөгч:	
РД: _____	
(ургийн овог)	(эцгийн нэр)
(өөрийн нэр)	
РД: _____	
(ургийн овог)	(эцгийн нэр)
(өөрийн нэр)	
РД: _____	
(ургийн овог)	(эцгийн нэр)
(өөрийн нэр)	
Хэдэн ч хамтран өмчлөгч байж болох учир хамтран өмчлөгчийн ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр болон хажуу мөрний РД нь 1 мөрөнд байхаар зохицуулагдсан байна. Хамтран өмчлөгчийг бичихэд мөрийг "нэмдэг" "хасдаг" байх. Энэ хэсэгт 1500 хүртэл тэмдэгт бичих зай байна. РД нь 10 тэмдэгтийн зай байна. Үсгийг криллээр оруулдаг байна.	
Эзэмшигч:	РД:
/100 тэмдэгт бичих зай/	
Өмчлөгч иргэний нэрээр эрэл хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.	
20 тэмдэгтийн зай байна. Үсгийг криллээр оруулдаг байна.	

Дурсгалт зүйлийн оршин байгаа хаяг: Өмчлөгчийн Иргэний үнэмлэхэд бичигдсэн амьдран суугаа газрын хаяг байна. 200 хүртэл тэмдэгтийн зай.
Ашиглалтын байдал:  300 тэмдэгтийн зай.

Дурсгалт зүйлийн нэр: 300 хүртэл тэмдэгт бичих зай Дурсгалт зүйлийн нэрээр эрэл хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.	Хувийн дугаар: 15 хүртэл тэмдэгтийн зай Заавал бөглөгдөх шаардлагагүй.
Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр: 300 хүртэл тэмдэгт бичих зай	

Шилжилт хөдөлгөөн				
Хэлбэр	"+"	Шилжүүлсэн огноо	Шинэ өмчлөгчийн овог нэр	РД
Худалдсан	Мөр бүр 1 тэмдэгт зай	Мөр болгон 40 тэмдэгт зай	Мөр болгон 100 тэмдэгт зай	Мөр болгон 10 тэмдэгт зай
Бэлэглэсэн				
Өвлүүлсэн				
Солилцоо				

Эх бүтээл  Хуулбар

“Эх бүтээл” эсвэл “Хуулбар”-ыг сонгож дарахад “дугуй эсвэл дөрвөлжин тод тэмдэгт”-ээр идэвхждэг байх.

Зэрэглэл	"+" тэмдэглэх	Зэрэглэлийн шийдвэр:
Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл	1 тэмдэгтийн зай	Шийдвэр гаргагчийн нэр, огноо, баримт бичгийн нэр, дугаар бичигдэнэ. 150 тэмдэгтийн зай байна.
Түүх, соёлын үнэт дурсгалт зүйл	1 тэмдэгтийн зай	Шийдвэр гаргагчийн нэр, огноо, баримт бичгийн нэр, дугаар бичигдэнэ. 150 тэмдэгтийн зай байна.

Зэрэглэлд батлагдсан бол “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл”, Түүх, соёлын үнэт дурсгалт зүйл” гэсэн нь сонголтоор идэвхжидэг байна. Програмд энэ 2 үг сонгогдвол арын нүднүүд нь идэвхждэг байна. Энэ Зэрэглэл талбарыг заавал бөглөх шаардлагагүй хоосон орхино.

Төрөл зүйл: Программаас сонгодог байна. “Төрөл зүйл”-ээр эрэлт хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.
Он цаг: Программаас сонгодог, бас гараас бичиж оруулж болдог байна. 30 хүртэл тэмдэгтийн зай “Он цаг”-аар эрэлт хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.
Бүтээлч, сургууль хийц: 300 тэмдэгтийн “Бүтээлч”-ээр эрэлт хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сортлогддог байна.

Материал, арга ажиллагаа:  
 300 тэмдэгтийн зай  
 "Материал"-аар эрэлт хайлт хийгддэг байх. Эрэлт хайлт хийхэд эхний хэдэн үсгийг бичиж байхад Google шиг сорлогддог байна.

Дурсгалын аль хэсгийн хэмжээс болох	Өндөр	Урт	Өргөн	Зузаан	Голч	Жин
Мөр болгон 100 хүртэл тэмдэгтийн зай. Шаардлагатай бол мөрөө "нэмдэг" эсвэл "хасдаг" байна.	9 тэмдэгт зай	9 тэмдэгт зай	9 тэмдэгт зай	9 тэмдэгт зай	9 тэмдэгт зай	9 тэмдэгт зай. Жин бичих хүснэгт нийт жингийн хэмжээг бичихээр зохицуул сан байна.

Иж бүрдэл:	Тоо ширхэг	Нийт
Мөр болгон 100 хүртэл тэмдэгтийн зай байна. Шаардлагатай бол мөрөө "нэмдэг" эсвэл "хасдаг" байна.	5 тэмдэгт зай	5 хүртэл тэмдэгт зай

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн гэрэл зураг

(Register, RCH-тэй адил нягтшил хэмжээтэй байна. Гэрэл зургийн тоог заасахгүй ба хамгийн багадаа эд зүйлийг 1-4 талаас харуулсан зураг байна.			
өмнө тал	ар тал	хажуу тал	бусад

Анх цуглуулсан, нээж илрүүлсэн:

100 хүртэл тэмдэгтийн зай

Хамгаалалтад авсан шийдвэр:

100 хүртэл тэмдэгтийн зай

Ховор, түгээмэл байдал:  
нийтлэг

Энгийн  ор

нэн ховор

"Энгийн нийтлэг", "Ховор", "Нэн ховор"-ын аль нэгийг сонгож дарахад "дугуй эсвэл дөрвөлжин тод тэмдэгт"-ээр идэвхждэг байх.

Гэмтэл:  
10000 хүртэл тэмдэгтийн зай

Зориулалт:  
100 хүртэл тэмдэгтийн зай

Гарал үүсэл:  
100 хүртэл тэмдэгтийн зай

Тодорхойлолт:  
10000 хүртэл тэмдэгтийн зай

Товч түүх:  
10000 хүртэл тэмдэгтийн зай

Сэргээн засварлагдсан байдал:

10000 хүртэл тэмдэгтийн зай

Хуулбар хийгдсэн байдал; Хувилсан (мерчандайз) тухай мэдээлэл:

10000 хүртэл тэмдэгтийн зай

Судлагдсан байдал:

10000 хүртэл тэмдэгтийн зай

Хавсралт материалын тэмдэглэл:

10000 хүртэл тэмдэгтийн зай

Бүртгүүлэх болсон шалтгаан.

100 хүртэл тэмдэгтийн зай

Хил гаалиар авч гарсан тухай тэмдэглэл:

Хилээр авч гарсан хугацаа	Лицензийн дугаар	Буцаж ирэх огноо	Хугацаа хэтэрсэн эсэх
100 хүртэл тэмдэгтийн зай	100 хүртэл тэмдэгтийн зай	100 хүртэл тэмдэгтийн зай	20 хүртэл тэмдэгтийн зай Хугацаа хэтэрсэн тохиолдолд улаан ногоон гэрэл асаж хугацаа хэтэрснийг мэдэгдэнэ.

Бүртгэсэн:

/ \_\_\_\_\_ 40 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ 60 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ /  
/Овог, нэр/

/Албан газар, албан тушаал/  
/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Огноо бүр 2 тэмдэгтийн зай байна.

Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.
2	Негатив, слайд хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	Цахим тээгч		
5	Бусад		

Хүлээн авсан, бүрдүүлсэн:

/ \_\_\_\_\_ 40 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ 60 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ /  
/Овог, нэр/

/Албан газар, албан тушаал/  
/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Огноо бүр 2 тэмдэгтийн зай байна.

Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Гэрэл зураг	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.
2	Негатив, слайд хальс		
3	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
4	Цахим тээгч		
5	Бусад		

Хүлээн авсан, бүрдүүлсэн:

/ \_\_\_\_\_ 40 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ 60 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_\_\_ /  
/Овог, нэр/

/Албан газар, албан тушаал/  
/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/

Огноо бүр 2 тэмдэгтийн зай байна.

Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Хадгаламжийн дугаар
1	Судалгааны ажлын тайлан	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.	Мөр бүр 10 хүртэл тэмдэгтийн зай, гараас бичиж оруулна.
2	Гэрэл зураг		
3	Негатив, слайд хальс		
4	Дуу, дүрс бичлэгийн хуурцаг		
5	Цахим тээгч		
6	Бусад		

Улсын нэгдсэн бүртгэл,  
мэдээллийн санд хүлээн

авсан, бүрдүүлсэн: / \_\_\_30 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_ 60 хүртэл тэмдэгтийн зай \_\_\_ /  
(тэмдэг) /Овог, нэр/ /Албан тушаал/


/20.... оны ..... сарын ..... -ны өдөр/  
Огноо бүр 2 тэмдэгтийн зай байна.

### 4.3. ДӨ-Монгол Алтайн хадны зургийн дурсгалт газрын вэб сайт хийх.

Энэ бүс нутагт өмнө нь хийгдсэн хадны зургийн судалгаа, бүртгэл, мэдээллийг нэгтгэх. Дурсгалт газар очиж гэрэл зураг, дүрс бичлэг хийж баримтжуулах, зарим онцлог дурсгалын дардас, хуулгыг авах, хадны зургийн дурсгалт газар түүний ойр орчимд буй бусад үл хөдлөх дурсгалын төрөл болон дурсгалт газар амьдарч буй нутгийн ард иргэдийн уламжлалт өв соёлын талаарх мэдээллийг цуглуулна.

Урансофт ХХК -тай 04/01 дугаартай гэрээ байгуулан Дэлхийн өв Монгол Алтайн нурууны хадны зургийн талаар иргэдэд мэдээлэл олгох, сурталчилах зорилгоор “Алтайн хадны зургийн 360° панорама виртуал тур бүхий”-ийн цахим хуудсыг англи, монгол хэл дээр бэлтгэж дуусгав.

Монгол алтайн хадны зургийн дурсгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулж, соёлын өв, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих зорилгоор [www.mongolaltai.mongoluv.mn](http://www.mongolaltai.mongoluv.mn) веб сайтыг бүтээн онлайн байрлуулаад байна. Энэхүү веб сайтанд Монгол алтайн хадны зургийн цогцолбор дурсгалын шинжлэх ухааны болоод дэлхийн өвийн үнэ цэнийг тодруулан тайлбарласан тайлбар, судалгааны тойм, газарзүйн байрлал, олон сонирхолтой фото зургууд байрлуулсан. Түүнчлэн Цагаан салаа, Бага ойгор (23), Шивээт хайрхан (9), Арал толгой (5) зэрэг дурсгалт газруудыг 37 цэгээс 360-аар эргэн эргэн тойрныг панорама виртуал тур хэлбэрээр харах боломжтой юм.







## МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН ЦОГЦОЛБОР


Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор нь Монголын төдийгүй дэлхийд тооцогдох зургийн цогцолбор дурсгал (галерей) бөгөөд гүнэй нэгжлийн түүхийн олон үеийг нэг дор харуулж байдагараа онцлогтой хэмээн судлаачид үздэг. Энэ нь манай ард түмний эртний түүхийн нэгэн чухал сурвалж, тэр үеийн хүмүүсийн аж ахуй, нийгэм оюун санааны нэгжлийн олон талыг тусгаан археологийн дурсгал болгож, Энэхүү цогцолбор газар нь нийт 11300 га талбайг эзлэн 3 хэсэг газарт орши бөгөөд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Арал толгой, Шивээт хайрхан, Улаанхус сумын Цагаан салаа, Бага Ойгорын хадны зургийг хамардаг. Хадны зураглалын нутад бүсэд улсуудтай харьцуулахад талбай, тоо хэмжээ, уран сайны ялгарийллороо гаймжамдтай дурсгал хэмээн дэлгэд гадаад судлаачид хүлээн зөвшөөрөн болсон байна.

Аж 1994 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн Хуралтан, АНУ-ын Орегонгийн сургууль, ОХУ-ын ШХАУ-ийн Сиберийн салбарын Археологич, Этнографийн хурлолынхонь хамтарсан "Монгол Алтай" хэмээх төслийн судлаачид тухайлан судалж эхэлсэн билээ. Энэ төслийн хүрээнд Монгол Алтайн нурууны эртний Алтай Төвийн бод улсын нууц султас эх аян урсак Хар ямаан гол, Цагаан салаагийн гол, Бага Ойгорын голын сав, Цагаан голын эх, Шивээт хайрхан, Хак чулуу, Хар чулуу, Халуугийн гол, Катруугийн нуур, Хурган Котон ноёр нуурын сав, Арал толгой, Белуут зэрэг газраас олон тооны хадны зургийн цогцолборыг хэвсгэн байна.

## ЦАГААН САЛАА / БАГА ОЙГОР

Цагаан салаа/Бага ойгорын хадны зургийн дурсгалт газар нь аймгийн төвөөс баруун коой 140 км орчим зайд орши бөгөөд урдсэн талбай 2100 га, хамгаалалтын бүс 3600 га, нийт 5700 га талбайг хамарна. Цагаан салаагийн гол, Бага Ойгорын голын савд нийт арван мянга орчим тусгай хаданд дүрсэлсэн зооикомжийг олж бүртгэсэн бөгөөд нэг зооикомжинд 1-100 хуртлах хүч, амьтан дүрсэлжээ. Нийт хадны зургийг Цагаан салаа 1-5, Бага ойгор 1-5 гэсэн 10 хэсэг болгон хувааж тэмдэглэсэн байна.

Зад үерхэн хамгийн эртний буюу даад палеолитын (20 мянга орчим жилийн тэртэй) үед холбогдон цөөн тооны арслан зааны (Мамакт) зураг байдаг аж. Арслан зааныг гэнэ нэгээр нь, нэг токиолдолд хоёр арслан зааныг нэг өндөс нь харуулан дүрсэлсэн байна. Арслан зааны үрт хянуу, том судалж зузаан бие, болгоо суул зэргийг тэд гарган үзүүлжээ. Ийм арслан зааны зураг үнэнд Алд түн көвөр токиолддог.



## 360 Панорама "Цагаан салаа/Бага ойгор"



4.4 Чойжин ламын сүм музейн 3 хэмжээст бүртгэн баримтжуулалтын ажлыг хийх. БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн хооронд байгуулсан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох барилга архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Чойжин

### **ламын сүм музейн 3 хэмжээст бүртгэн баримтжуулалтын ажлыг хийнэ.**

БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнтэй 2015 онд байгуулсан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга, архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” тухай Хамтын Ажиллагааны Санамж Бичгийн хүрээнд 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Барилга, архитектурын дурсгалын судалгааны хэлтэстэй “Монголын дурсгалт уран барилгын бүртгэн баримтжуулалт ба хадгалалт хамгаалалт” уулзалтыг зохион байгуулав.

Тус уулзалтад Соёлын өвийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүд, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Барилга, архитектурын дурсгалын судалгааны хэлтэсийн удирдлага, мэргэжилтнүүд оролцон илтгэл тавьлаа. Уулзалтад БСШУСЯ, ЗГХАСУГ, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, “Сүлдпроект” ХХК, МУБИС, Монголын Архитекторын эвлэлийн төлөөллүүд оролцож санал солилцов.

Уулзалтын дүнгээр СӨҮТ-ийн Бүртгэл, судалгааны газар, БНСУ-ын СӨСҮХ-гийн Барилга, архитектурын дурсгалын судалгааны хэлтэстэй “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот дахь Чойжин Ламын сүм музейн дурсгалт уран барилгыг 3-н хэмжээст байдлаар баримтжуулах ажлын гэрээ”-г байгуулав. Энэхүү гэрээний хүрээнд Чойжин Ламын сүм музейн дурсгалт уран барилгыг 2018-2019 онд 3-н хэмжээст байдлаар баримтжуулахаар төлөвлөж байна.

Тус ажил нь 2018-2020 онд үргэлжлэх ба 2018 оны 6 дугаар сарын 8-аас 17-ны өдрийг хүртэл хугацаанд тус музейн Гол сүм (Занхан)-ийн сүмийн барилга дээр хийгдлээ. Энэ жилийн ажлын онцлог нь дурсгалт барилга архитектурын мэргэжлийн байгууллага, их дээд сургуулийн багш, оюутнуудыг татан оролцуулан ажиллуулсан явдал байлаа.



## **5. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

### **5.1. “Соёлын өвийг бүртгэх мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журам”-ын төсөл.**

2018 оны 1 ба 2 дугаар сард Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.1.13; 22.1-д заасны дагуу “Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн сан бүртгэх, мэдээллийг ашиглах тухай журам”-ыг тус газрын соёлын биет болон биет бус өв хариуцсан мэргэжилтэнгүүд тус тусын чиглэлийн дагуу хариуцан боловсруулсан. Уг журмын төсөлд шат, шатны бүртгэл, мэдээллийн сангийн чиг үүрэг болон хувийн өмчлөлийн соёлын өвийг бүртгэх, соёлын биет болон биет бус өвийн бүртгэлийн маягтыг шинэчлэх зэрэг асуудлууд тусгагдсан юм. “Соёлын өвийг бүртгэл, мэдээллийн сан бүртгэх, мэдээллийг ашиглах тухай журам”-ын төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлээд байна.

### **5.2. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмын төсөл боловсруулах**

**Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хүнийг олж тогтоох, таньж илрүүлэх, бүртгэх шалгуур үзүүлэлтийг тогтооно. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд журмын төслийг хүлээлгэн өгнө.**

“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам”-ын төслийн боловсруулалтыг эцэслэж 2018 оны 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яаманд хүргүүлэхэд бэлэн болоод байна.

### **5.3. Соёлын биет өвийн таньж тогтоох шинжээчийн зөвлөлийн үйл ажиллагаа**

**Соёлын биет өвийг таньж тогтоох Зөвлөлийн дүрэм батлах, Хил гааль, цагдаа зэрэг хууль хяналтын байгууллагад хураагдсан, бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн эд зүйлсийг соёлын өв эсэхийг тогтоох, бүртгэх.**

Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх саналыг боловсруулсан бөгөөд 2019 оноос бүрэлдэхүүнийг шинэчлэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөж байна.

“RCH” програмд бүртгэх хувь хүний өмчлөлийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг хийх Бодлогын даалгаврыг боловсруулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Төсөл

## **СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ТАНЬЖ ТОГТООХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга. Г.Энхбат. Соёлын өвийн үндэсний төвийн захирал

Зөвлөлийн нарийн бичгийн дарга. М.Цэцэнбилэг. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга

Гишүүд:

Палеонтологийн дурсгал:

Б.Майнбаяр. ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан,

Чулуун зэвсэг:

Я.Цэрэндавга. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн “Чулуун зэвсгийн үеийн судалгааны салбар”-ын эрдэм шинжилгээний ажилтан,

Археологийн хүрэл, төмөр эдлэл:

Г.Анхсанаа. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах

газрын дарга,

Ц.Төрбат. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн “Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбар”-ын эрхлэгч,

Д.Батсүх. ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн “Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбар”-ын эрдэм шинжилгээний ажилтан,

Урлаг судлал:

Др. Проф. Л.Батчулуун. Урлаг судлаач,

Дархны урлал:

Н.Жамбал. Соёлын өвийн үндэсний төв, Соёлын өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч судлаач,

Др. Ч.Энхдаваа. Дүрслэх урлагийн дээд сургуулийн дархны багш,

Чулуун эдлэл:

Г.Гонгоржав. Урлагийн гавъяат зүтгэлтэн, Химич, сэтгүүлч

Угсаатны зүйн эдлэл:

Ч.Нацагням. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын музей, соёлын өв хариуцсан мэргэжилтэн,

Ч.Туулцэцэг. Монголын Үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан,

Д.Нямдорж. Соёлын өвийн үндэсний төв, Соёлын өвийг сэргээн засварлах газрын дарга,

Б.Мягмарсүрэн. Соёлын өвийн үндэсний төв, Соёлын өвийг сэргээн засварлах газрын даавуу, зөөлөн эдлэл сэргээн засварлагч-судлаач,

Др.Б.Баатархүү. Угсаатны зүйч

Бурхан шүтээний чиглэл:

Д.Нарантуяа. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан ахлах мэргэжилтэн,

Д.Тулга. Бурханы шашны дээд сургуулийн урлахуйн тэнхимийн эрхлэгч, багш / зөвшилцсөнөөр/

Г.Ням-Очир. Үндэсний номын сангийн эрдэм шинжилгээний ажилтан, төвд судлаач,

Ш.Энхтуяа. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан мэргэжилтэн,

А.Мөнгөнцоож. Соёлын өвийн үндэсний төв, Соёлын өвийг сэргээн засварлах газрын сэргээн засварлагч судлаач,

Судар, номын чиглэл:

Т.Баярлах. Үндэсний номын сангийн Бодлогын албаны дарга,

Х.Түмэнбаяр. Үндэсний номын сангийн Бүртгэл, мэдээллийн санч, төвд судлаач,

Др. Н.Отгонбаатар. ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн ахлах эрдэм шинжилгээний ахлах ажилтан.

#### **5.4. Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөлийн үйл ажиллагаа**

**Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм, бүтцийн дагуу Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн таньж тогтоох шинжээчийн зөвлөлийн ажиллах дүрэм батлах, монголын үндэсний Соёлын биет бус өвийн онцлогт тохирсон шинжээч бүхий 5-8 дэд зөвлөлийг бий болгоно. Монгол үндэсний Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч хүний бүртгэлд шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн санал, зөвлөмж өгнө.**

Төсөл

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙГ ТАНЬЖ ТОГТООХ ШИНЖЭЭЧИЙН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга. Г.Энхбат. Соёлын өвийн үндэсний төвийн захирал

Зөвлөлийн нарийн бичгийн дарга. М.Цэцэнбилэг. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга

Гишүүд:

### 1. ЭХ ХЭЛ БОЛОН АМАН УЛАМЖЛАЛ, ИЛЭРХИЙЛЛҮҮД

1. С.Дулам - МУ-ын Ардын багш, доктор, профессор
2. Б.Катуу - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман өвийн тасгийн эрхлэгч, доктор, профессор
3. Т.Баясгалан - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор
4. А.Алимаа - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор

### 2. АРДЫН ЯЗГУУР УРЛАГ

1. Ж.Долгорсүрэн - СУИС-ийн Тайз дэлгэцийн урлагийн сургуулийн захирал, доктор, профессор
2. Ж.Энэбиш - Хөгжим судлаач, доктор, профессор
3. Дорждагва – НСИСХ, Уртын дуучин
4. Эрдэнэцэцэг – СУИС, Бүжгийн сургууль
5. С.Юндэнбат - СУС-ийн багш, судлаач
6. Ц.Пүрэвхүү - Монголын морин хуур төвийн гүйцэтгэх захирал
7. Д.Түвшинжаргал - МУГЖ, Уртын дууны холбоо
8. А.Цэдэн-Иш - МУУГЗ-“Монгол хөөмэй

### 3. УЛАМЖЛАЛТ БАЯР НААДАМ, ХУРИМ НАЙР, ТОГЛООМ НААДГАЙ

1. Д.Басхүү - МУСГЗ“Монгол шагайн харваа”
2. Б.Хүрэлбаатар - Монголын Үндэсний сурын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга
3. Ө.Түмэн-Өлзий - МУСГЗ
4. Т. Данзан - МҮБХолбооны дэд дарга
5. Г.Нандинбилэг - Судлаач, доктор
6. С.Дамбий - Ардын аман билэг судлаач

### 4. УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛ, ШҮТЛЭГ

1. С.Дулам - МУ-ын Ардын багш, доктор, профессор
2. Г.Гонгоржав - МУСГЗ, судлаач
3. С.Юндэнбат - СУС-ийн багш, судлаач
4. Д.Даваасүрэн - СУСХүрээлэн, доктор

### 5. МАЛ МАЛЛАХ АРГА УХААН

1. Н.Хүрэлбаатар – Судлаач
2. С.Юндэнбат - СУС-ийн багш, судлаач

### 6. БАЙГАЛИЙН БОЛОН САВ ЕРТӨНЦИЙН ТУХАЙ МЭДЛЭГ, ЗАНШИЛ

1. Н.Уртнасан - МУСГЗ, доктор, профессор
2. Г.Цэрэнханд - Угсаатны зүйч, доктор, профессор
3. Л.Батчулуун - Доктор, профессор
4. Л.Ганбаатар - “Монгол гэрийн хөгжил судлалын холбоо” тэргүүн

### 7. УЛАМЖЛАЛТ ГАР УРЛАЛ

1. Д.Батбаяр - Монгол уран бичлэгийн холбооны тэргүүн
2. З.Цэнгэлсайхан - Уран хатгамалч, Уран хатгамалчдыг дэмжих “Эгнэшгүй санаа” төвийн тэргүүн
3. Л.Батчулуун - Доктор, профессор
4. Д.Сувд - Доктор, профессор

**5.5. Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын үйл ажиллагаанд баримтлах мэргэжлийн ёс зүйн зарчмыг боловсруулах ажлыг эхлүүлэх.**

Археологийн олдворын хадгалалт, сэргээн засварлалтын хувь хэмжээг тогтооно. Соёлын биет өвийн эвдрэл гэмтлийн нөхцөл байдлаас хамаарч хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ болон гоо зүйн зохист харьцааг тогтооно.

Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт түүн дотроо археологийн малтлагаас гарч байгаа олдворуудын бүрэн бүтэн байдал, хадгалалтын горим, зарчмыг боловсруулах ажлыг эхлүүлж, холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдаар эхний хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд 2019 оны эхний улиралд хэвлэхээр төлөвлөн ажиллаж байна.

**5.6. Улс, аймгийн музейн захиргааны албан хаагчидтай Соёлын өвийн үндэсний төвийн хамтын ажиллагаа, соёлын өвийн хамгааллын тухай сургалт зохион байгуулах.**

Музей болон аймгийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголттой болох, Хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт, орчны судалгааны эргэлт хэрэгцээ, хэм хэмжээний талаар зохион байгуулах.

“Соёлын өвийн үндэсний төв болон музейн хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх нь” уулзалт, сургалт: Соёлын өвийн үндэсний төвийн шинэ бүтэц зохион байгуулалттай уялдуулан улсын болон аймаг орон нутгийн музейн захирал удирдлагуудтай 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ уулзалтад БСШУСЯ, ЗГХАСУГ, СӨҮТ, нийслэл, аймгийн музейн захирлууд нийт 60-н хүн оролцсоноос нийслэлийн 9-н музейн захирал, орон нутаг дахь 26 музейн захирлууд оролцов.

Уулзалт хэлэлцүүлэгийг Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нээж “Соёлын өвийн үндэсний төв болон музейн хамтын ажиллагааг төгөлдөржүүлэх нь”, Олон улсын музейн зөвлөлийн үндэсний хорооны гишүүн, Монголын музейн холбооны тэргүүн Д.Цэдмаа “Монголын музейн үзмэрийг бүртгэх, тодорхойлох тухай”, Бүртгэл, судалгааны газрын ахлах мэргэжилтэн Д.Нарантуяа “RCH програмын бүртгэл, бүрдүүлэлтийн байдал”, Соёлын өвийг авран хамгаалах газрын мэргэжилтэн Г.Анхсанаа “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, судалгаа”, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын Соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал “Соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа”, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын мэргэжилтэн Ж.Даваацэрэн “Соёлын өвийн цахим архивын бүрдүүлэлт”, Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын мэргэжилтэн Д.Нямдорж “Соёлын биет өвийн сэргээн засварлалт”, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэргэжилтэн Ш.Энхтуяа “Музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтын орчны судалгаа”, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга М.Цэцэнбилэг “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын Соёлын өвийн тухай гэрээ, конвенц” сэдвүүдээр тус тус илтгэл тавьсан.

Хэлэлцүүлэг уулзалтын явцад бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх



дурсгалт зүйлийн бүртгэлийн цахим хэлбэр “RCH” бүртгэлийг сайжруулах, бүртгэл хөтлөлтөд музейн удирдлагийн зүгээс тавих хяналтаа сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангах талаар ярилцаж зөвлөлдөв. Энэхүү уулзалтаар аймаг, орон нутгийн музейн захирлуудтай “RCH” бүртгэл бүрдүүлэлт, жилд улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд ирүүлэх бүртгэлийн талаарх гэрээг шинэчлэн байгуулсан.



## ДҮГНЭЛТ

Тус төв 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тусгагдсан соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалт, авран хамгаалах ажлын биелэлтийг бүрэн ханган биелүүлж ажиллалаа.

Ажлын гүйцэтгэлд хүмүүсийн орон тооны байдал, улирал цаг хугацааны байдлаас шалтгаалах зүйл байсан хэдий ч дотоод нөөц бололцоо, мэргэжилтнүүдийн хүчин чармайлтаар төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Соёлын биет өвийн хүрээнд:

- Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, БСШУС-ын сайдын 2018 оны А/648 тоот тушаалын 2 дугаар хавсралт Тооллогын ажлын Удирдамжийн хүрээнд улс, аймгийн музей, сумдын ОНС танхим, болон их дээд сургууль, шашны байгууллага хадгалагдаж буй музейн үзмэр, бурхан шашны эд зүйлс, археологийн олдворыг тоолох ажлыг програм хангамж, тусгай хэвлэмэл дэвтэр бүхий техник технологийн шийдэлтэйгээр богино хугацаанд, чанартай хийх байдлаар төлөвлөн ажиллав.

Тооллого хэрхэн хийх тухай сургалтын гарын авлагыг боловсруулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газартай хамтран сургалтыг 6 бүсэд хуваан орон нутагт нь зохион байгуулсан нь сургалтад оролцогчдод цэгцтэй мэдээлэл өгөх, хэт олон хүн хамрагдаж чанаргүй сургалт болохоос сэргийлсэн, ажилтнуудтай ойр дотно ажилласан зэрэг давуу талтай болов.

Орхон аймгийн Айрагийн гозгор, Архангай аймгийн Уйгарын Хар балгас зэрэг

газар археологийн малталтын үед олдвор эд өлгийн зүйлийг хамгаалах анхан шатны хамгаалалт хийх, баглаа сав боодлын талаар музейн ажилтнууд, археологчдод сургалт, дадлага ажил хийсэн нь онолын болоод практик ач холбогдолтой байв.

Соёлын биет бус өвийн хүрээнд:

- Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу “Соёлын биет бус өвийн Их наадам”-ыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан, наадмын үйл ажиллагаа нь урьд өмнө зохион байгуулагдаж байгаагүй отогийн хэлбэрээр, аймаг тус бүр өөрсдийн онцлогийг харуулсан СББӨ-ийн төрөл зүйлийг олон нийтэд танилцуусан нь өвөрмөц сайшаалтай байлаа. Их наадамд оролцож буй аймаг, өвлөн уламжлагдыг таньж тогтоох, шүүн тунгаах, байр эзлүүлэх зэрэг үйл ажиллагаанд СӨҮТ голлох үүрэгтэй оролцсон болно.

- СӨҮТ-д ирж буй сургалт авах хүсэлтүүдээс дүгнэхэд СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын сургалт нь орон нутгийн соёлын ажилтнуудад хүрч байгаа нь ажиглагдлаа.

- СӨБСГ-ын СББӨ-ийг хамгаалах үл ажиллагаанд гэрээнд тусгагдсан үйл ажиллагаанаас гадна нэмэлт үйл ажиллагаа ихээр орж ирдэг ба хүний нөөц хүрэлцэхгүй ажлын ачаалал хэт ихсэн тохиолдлууд цөөнгүй байна.

Цаашид Соёлын өвийг хамгаалах чиглэлээр одоогийн СӨҮТ-ийн бүтцийг өөрчлөх шаардлагатай. Ялангуяа Соёлын өвийн бүртгэл судалгааны газрыг Соёлын биет өвийн бүртгэл судалгааны газар, Соёлын биет бус өвийн бүртгэл судалгааны газар гэж хоёр салгах хэрэгцээ шаардлага байна. Дээрх 2 өвийн бүртгэлийн систем, бүртгэл хийх арга зүй, бүрдэл зэрэг нь өвөрмөц онцлогтой, нэг удирдлага чиглэлд ажил гүйцэтгэхэд хүндрэл гарч буй тохиолдлууд их ажиглагдав.

Соёлын өвийг бүртгэн баримтжуулахад дүрс бичлэгийн тоног төхөөрөмж, дронн, гэрэл зургийн аппарат, компьютер зэрэг нь мэргэжийн өндөр түвшний байх хэрэгцээтэй байна.

---oOo---